




ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН НЭГДСЭН ДҮН





МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ
2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГО

НЭГДЭСЭН ДҮН

ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

НЭГ. ХЯНАСАН

Аюушийн Ариунзаяа

Нийгэм судлал, түүх, улс төрийн шинжлэх ухааны магистр, Бизнесийн удирдлагын магистр
ҮСХ-ны дарга, Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын орлогч дарга

Чилхаасүрэнгийн Баянчимэг

Статистикч-Эдийн засагч, эдийн засгийн ухааны магистр
ҮСХ-ны дэд дарга

Авирмэдийн Амарбал

Эдийн засагч-Хүн ам зүйч, Хүн ам зүйн ухааны доктор
ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга, Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын нарийн бичгийн дарга

ХОЁР. БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Төмөрбаатарын Болор-Эрдэнэ

Эдийн засагч-Хүн ам зүйч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга

Төрбатын Уянга

Эдийн засагч-Хүн ам зүйч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны ахлах статистикч

Ичинноровын Цэрэндулам

Эдийн засагч-Статистикч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч

Очирбалын Өүжингэ

Эдийн засагч-Хүн ам зүйч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч

Төгсбатын Ариунсайхан

Эдийн засагч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч

Ренчиндоржийн Батхишиг

Эдийн засагч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч

Бүрэнжаргалын Мөнхжаргал

Программист
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны мэргэжилтэн

Батчулууны Ариунзаяа

Бизнес, эдийн засгийн менежмент
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны мэргэжилтэн

Машбатын Мишээл

Нягтлан бодогч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны мэргэжилтэн

Цэнхэрборын Эрдэнэмөнх

Программ хангамжийн инженер
ҮСХ-ны Мэдээллийн технологийн газрын ахлах референт

Дулмаагийн Лхагвацэрэн

Компьютерийн программ ба техник хангамжийн инженер
ҮСХ-ны Мэдээллийн технологийн газрын референт

Ганбаатарын Жаргал

Мэдээллийн системийн менежмент
ҮСХ-ны Мэдээллийн технологийн газрын референт

ISBN: 978-99978-758-7-7

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

АГУУЛГА

ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	8
ӨМНӨХ ҮГ	11
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИЛГЭЭЛТ	13
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ИЛГЭЭЛТ	15
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД, ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН ДАРГЫН ӨМНӨХ ҮГ	17
ТОВЧ ДҮГНЭЛТ	19
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	
ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ОНЦЛОГ, УДИРДЛАГА.....	29
ХОЁРДУГААР БҮЛЭГ	
ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ	39
ГУРАВДУГААР БҮЛЭГ	
УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС, УГСАА, ШАШИН	49
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	
ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ХОТЖИЛТ	65
ТАВДУГААР БҮЛЭГ	
ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН	75
ЗУРГААДУГААР БҮЛЭГ	
БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ	91
ДОЛООДУГААР БҮЛЭГ	
ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ	103
НАЙМДУГААР БҮЛЭГ	
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ.....	115
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ	
ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИД	127
АРАВДУГААР БҮЛЭГ	
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	133
АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ	
ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД.....	151
АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ	
ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ	164
ХАВСРАЛТ	181

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 2.1.	МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР.....	41
ХҮСНЭГТ 2.2.	ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2010-2020 ОН	42
ХҮСНЭГТ 2.3.	АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ХУВИАР, 1989-2000, 2000-2010, 2010-2020 ОН	43
ХҮСНЭГТ 2.4.	ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН	44
ХҮСНЭГТ 2.5.	ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН	46
ХҮСНЭГТ 2.6.	ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН	46
ХҮСНЭГТ 2.7.	ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ЗАРИМ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 1989, 2000, 2010, 2020 ОН	47
ХҮСНЭГТ 3.1.	МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН	51
ХҮСНЭГТ 3.2.	ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС, УГСАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	52
ХҮСНЭГТ 3.3.	ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	53
ХҮСНЭГТ 3.4.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	56
ХҮСНЭГТ 3.5.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	57
ХҮСНЭГТ 3.5.1	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН /УРГЭЛЖЛЭЛ/	58
ХҮСНЭГТ 3.6.	МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭД, УЛСААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	59
ХҮСНЭГТ 3.7.	МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	59
ХҮСНЭГТ 3.8.	МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМ, ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	60
ХҮСНЭГТ 3.9.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	61
ХҮСНЭГТ 3.10.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	62
ХҮСНЭГТ 3.11.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	62
ХҮСНЭГТ 3.12.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	62
ХҮСНЭГТ 3.13.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГ, ҮНДЭС, УГСАА, ШАШНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	63
ХҮСНЭГТ 4.1.	ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН	68
ХҮСНЭГТ 4.2.	ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН	68
ХҮСНЭГТ 4.3.	ХҮН АМЫН ТОО, БҮС, ХОТ, ХӨДӨӨ, БҮСИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	69
ХҮСНЭГТ 4.4.	ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	70
ХҮСНЭГТ 4.5.	ХҮН АМЫН НЯГТРАЛ, БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	71
ХҮСНЭГТ 4.6.	ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	72
ХҮСНЭГТ 4.7.	ХОТЫН ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	73

ХҮСНЭГТ 5.1.	ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧИД, ТӨРСӨН БҮСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	80
ХҮСНЭГТ 5.2.	ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧИД, ТӨРСӨН БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН....	81
ХҮСНЭГТ 5.3.	ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮСЭЭР, 2010, 2020 ОН.....	82
ХҮСНЭГТ 5.4.	ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮСЭЭР, 2010, 2020 ОН.....	82
ХҮСНЭГТ 5.5.	ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	83
ХҮСНЭГТ 5.6.	НЭГ ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮСЭЭР, 2010, 2020 ОН.....	84
ХҮСНЭГТ 5.7.	ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮСЭЭР, 2010, 2020 ОН.....	85
ХҮСНЭГТ 5.8.	ХҮН АМ, ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	85
ХҮСНЭГТ 5.9.	СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	87
ХҮСНЭГТ 5.10.	ТӨРСӨН БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	88
ХҮСНЭГТ 5.11.	НЭГ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	89
ХҮСНЭГТ 5.12.	ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	89
ХҮСНЭГТ 6.1.	АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	94
ХҮСНЭГТ 6.2.	АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	94
ХҮСНЭГТ 6.3.	АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	95
ХҮСНЭГТ 6.4.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	97
ХҮСНЭГТ 6.5.	ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	99
ХҮСНЭГТ 6.6.	ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	100
ХҮСНЭГТ 6.7.	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, НАС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН.....	101
ХҮСНЭГТ 7.1.	ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	105
ХҮСНЭГТ 7.2.	ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	106
ХҮСНЭГТ 7.3.	ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	106
ХҮСНЭГТ 7.4.	ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	107
ХҮСНЭГТ 7.5.	ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	108
ХҮСНЭГТ 7.6.	ӨРХ, АМ БҮЛИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	109
ХҮСНЭГТ 7.7.	ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	110

ХҮСНЭГТ 7.8.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН.....	110
ХҮСНЭГТ 7.9.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	111
ХҮСНЭГТ 7.10.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	112
ХҮСНЭГТ 7.11.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	113
ХҮСНЭГТ 8.1.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	117
ХҮСНЭГТ 8.2.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	118
ХҮСНЭГТ 8.3.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХОТ, ХӨДӨӨ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	120
ХҮСНЭГТ 8.4.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	122
ХҮСНЭГТ 8.5.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	122
ХҮСНЭГТ 8.6.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	124
ХҮСНЭГТ 8.7.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ДАВХАРДЛААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	125
ХҮСНЭГТ 8.8.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХ, ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	126
ХҮСНЭГТ 9.1.	ГАР УТАС ХЭРЭГЛЭДЭГ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН .	130
ХҮСНЭГТ 10.1	АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН	136
ХҮСНЭГТ 10.2	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	138
ХҮСНЭГТ 10.3.	АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	139
ХҮСНЭГТ 10.4.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН.....	139
ХҮСНЭГТ 10.5.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН /мян.хүн/.....	139
ХҮСНЭГТ 10.6.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	140
ХҮСНЭГТ 10.7.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	140
ХҮСНЭГТ 10.8.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	141
ХҮСНЭГТ 10.9.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	142
ХҮСНЭГТ 10.10.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	143
ХҮСНЭГТ 10.11.	АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	145
ХҮСНЭГТ 10.12.	АЖИЛГҮЙ ХҮН АМЫН ТОО, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВЬ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН.....	146

ХҮСНЭГТ 10.13.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, /мян.хүн/, 2010, 2020 ОН	147
ХҮСНЭГТ 10.14.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН.....	148
ХҮСНЭГТ 11.1	ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН.....	154
ХҮСНЭГТ 11.2	ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, БАЙНГА СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	156
ХҮСНЭГТ 11.3.	ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ОРШИН СУУГАА БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	156
ХҮСНЭГТ 11.4	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛС, ОРШИН СУУГАА ХУГАЦАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	158
ХҮСНЭГТ 11.5.	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ЯВСАН БОЛОН ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	158
ХҮСНЭГТ 11.6.	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ОРШИН СУУГАА УЛС, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	159
ХҮСНЭГТ 11.7.	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	160
ХҮСНЭГТ 12.1.	СУУЦ БОЛОН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН	167
ХҮСНЭГТ 12.2.	ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2010, 2020 ОН	168
ХҮСНЭГТ 12.3.	ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, БАЙРШИЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	168
ХҮСНЭГТ 12.4.	ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	169
ХҮСНЭГТ 12.5.	ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	169
ХҮСНЭГТ 12.6.	ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	170
ХҮСНЭГТ 12.7.	ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН АМ БҮЛИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	171
ХҮСНЭГТ 12.8.	ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙ НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	172
ХҮСНЭГТ 12.9	БАЙШИНГИЙН ТОО, ХАНЫН ҮНДСЭН МАТЕРИАЛ, ХАНЫН ӨНГӨЛГӨӨНИЙ МАТЕРИАЛ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН.....	175
ХҮСНЭГТ 12.10.	БАЙШИНГИЙН ДЭЭВРИЙН ХУЧИЛТЫН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН.....	176
ХҮСНЭГТ 12.11.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	177
ХҮСНЭГТ 12.12.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХ, АМ БҮЛИЙН ТОО, ӨРӨӨНИЙ ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	177
ХҮСНЭГТ 12.13.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	178
ХҮСНЭГТ 12.14.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	178
ХҮСНЭГТ 12.15.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	179

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.1.	ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ.....	37
ЗУРАГ 2.1.	МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, 2020 ОН.....	41
ЗУРАГ 2.2.	ХҮН АМЫН 1918-2020 ОНЫ ТООЛЛОГО ХООРОНДЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, ХУВИАР	42
ЗУРАГ 2.3.	ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 1989, 2000, 2010, 2020 ОН.....	44
ЗУРАГ 2.4.	ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН.....	45
ЗУРАГ 3.1.	ХҮН АМЫН ТОО, ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛААР, 2020 ОН	51
ЗУРАГ 3.2.	ХҮН АМ, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2020 ОН.....	54
ЗУРАГ 3.3.	КАЗАХ УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН	54
ЗУРАГ 3.4.	ДӨРВӨД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН	54
ЗУРАГ 3.5.	БАЯД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН	55
ЗУРАГ 3.6.	БУРИАД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН.....	55
ЗУРАГ 3.7.	ХҮН АМ, ҮНДЭС, УГСАА, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	55
ЗУРАГ 3.8.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	60
ЗУРАГ 3.9.	ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	61
ЗУРАГ 4.1.	ХҮН АМЫН ТОО, СУМААР, 2020 ОН.....	67
ЗУРАГ 4.2.	ХҮН АМЫН НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН.....	71
ЗУРАГ 4.3.	УЛААНБААТАР ХОТОД ШИЛЖИН ИРЭГЧИД, БҮСЭЭР (ШИЛЖИН ИРСЭН БОЛОН ЯВСАН ХҮНИЙ ЗӨРҮҮГЭЭР МЯН.ХҮН) 2010, 2020 ОН	73
ЗУРАГ 5.1.	ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2020 ОН.....	78
ЗУРАГ 5.2.	СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2020 ОН.....	78
ЗУРАГ 5.3.	СҮҮЛИЙН НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2020 ОН	79
ЗУРАГ 5.4.	АЙМАГ, НИЙСЛЭЛ ХООРОНДЫН ШИЛЖИГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН	79
ЗУРАГ 5.5.	БҮС ХООРОНДЫН ШИЛЖИГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН	79
ЗУРАГ 5.6.	ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЦЭВЭР КОЭФФИЦИЕНТ, БҮСЭЭР, 2010, 2020 ОН.....	86
ЗУРАГ 5.7.	СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН	87
ЗУРАГ 6.1.	ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН СУВАРГА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	96
ЗУРАГ 6.2.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ*, 2020 ОН	97

ЗУРАГ 6.3.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010, 2020 ОН	98
ЗУРАГ 6.4.	СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010, 2020 ОН	101
ЗУРАГ 7.1.	ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМ, 2020 ОН	105
ЗУРАГ 7.2.	ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН	107
ЗУРАГ 7.3.	АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, ЖИЛЭЭР, 2000, 2010, 2020 ОН	111
ЗУРАГ 7.3.	ГЭРЛЭЛТЭЭ ЦУЦЛУУЛСАН ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН	113
ЗУРАГ 8.1.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	118
ЗУРАГ 8.2.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	119
ЗУРАГ 8.3.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН	121
ЗУРАГ 8.4.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН.....	121
ЗУРАГ 8.5.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮМҮҮС, ДАВХАРДЛААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН.....	123
ЗУРАГ 8.6.	АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ОГТ ХҮНДРЭЛГҮЙ ХҮМҮҮСИЙН СУУРИН ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	123
ЗУРАГ 9.1.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010, 2020 ОН.....	129
ЗУРАГ 9.2.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН.....	130
ЗУРАГ 9.3.	ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ХУВИАР, 2020 ОН.....	131
ЗУРАГ 9.4.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010, 2020 ОН	131
ЗУРАГ 9.5.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН.....	132
ЗУРАГ 9.6.	ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН.....	132
ЗУРАГ 10.1.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН	135
ЗУРАГ 10.2.	АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН	136
ЗУРАГ 10.3.	АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН	137

ЗУРАГ 10.4.	АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	137
ЗУРАГ 10.5.	ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН...	138
ЗУРАГ 10.6.	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУУЧИН БОЛОН ШИНЭ СТАТУСЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	144
ЗУРАГ 10.7.	АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН.....	146
ЗУРАГ 10.8.	АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН.....	147
ЗУРАГ 10.9.	15-24 НАСНЫ ХҮН АМД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ, СУРГУУЛЬД СУРАЛЦДАГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	149
ЗУРАГ 10.10.	15-24 НАСНЫ ХҮН АМД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ, СУРГУУЛЬД СУРАЛЦДАГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2020 ОН	149
ЗУРАГ 11.1.	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН	154
ЗУРАГ 11.2.	ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН, / мян.хүн/.....	155
ЗУРАГ 11.3.	ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН	155
ЗУРАГ 11.4.	ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛСААР, 2020 ОН.....	157
ЗУРАГ 11.5.	ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	160
ЗУРАГ 11.6.	ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	161
ЗУРАГ 12.1.	ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН	166
ЗУРАГ 12.2.	ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2019 ОН.....	167
ЗУРАГ 12.3.	ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН	167
ЗУРАГ 12.4.	ГЭРИЙН ДЭЭВЭР, ТУУРГА, ШАЛНЫ ҮНДСЭН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН	171
ЗУРАГ 12.5.	ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	173
ЗУРАГ 12.6.	БАЙШИН, АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН	174
ЗУРАГ 12.7.	БАЙШИНГИЙН ШАЛНЫ ҮНДСЭН БОЛОН ХУЧИЛТЫН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН.....	176
ЗУРАГ 12.8.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	180
ЗУРАГ 12.9.	БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	180

ӨМНӨХ ҮГ



Монгол Улс 2020 онд 11 дэх удаагийн Хүн ам, орон сууцны тооллогыг явуулж, нэгдсэн үр дүнг Та бүхэнд хүргэж байна.

Улс орныхоо хүн амын тоог гаргаж мэдээлэх нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсын Засгийн газрын томоохон үүрэг юм.

Монгол Улсын Засгийн газар дэлхийн улс орнуудын нэг адил хүлээсэн үүргээ биелүүлж, 2020 оны ээлжит тооллогыг “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хууль болон НҮБ-ын Статистикийн Комиссын “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж III”-ийн дагуу амжилттай зохион байгууллаа.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын хүрээнд 1969 оноос хойш хийгдээгүй байсан Байшин, орон сууцны тооллогыг хийсэн.

УИХ-ын 2017 оны 77 дугаар тогтоолоор Хүн ам, орон сууцны тооллогын Улсын Комиссыг Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулан байгуулсан. Өнгөрсөн 2 жил хагасын хугацаанд Тооллогын Улсын Комисс, Үндэсний Статистикийн Хороо, шат шатны тооллогын комисс, түр товчоод хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, үндэсний хэмжээний цогц үйл ажиллагааг явуулж, үр дүнгийн тайланг бэлэн болгов.

“Хүмүүнд төр эрхэм, Төрд хүмүүн эрдэнэ” уриа дор бүртгэл болон уламжлалт тооллогын аргуудыг хосолсон хэлбэрээр зохион байгуулсан энэ удаагийн тооллогын үйл ажиллагааны зардлыг Монгол Улсын Засгийн газар улсын төсвөөсөө анх удаа бүрэн санхүүжүүлсэн. Тооллогын үйл ажиллагааны бүх үе шатанд орчин цагийн мэдээллийн дэвшилтэт технологи, газар зүйн мэдээллийн систем, ялангуяа Байшин, орон сууцны тооллогын мэдээлэл цуглуулалтад таблет төхөөрөмжийг ашиглаж, төрийн байгууллагуудын мэдээллийн санг уялдуулж ажиллалаа.

Хүн ам, орон сууцны тооллого нь товлон тогтоосон хугацаанд тухайн улс оронд оршин суугаа нийт хүн амыг тэдний амьдарч буй сууцны талаарх суурь мэдээллийн хамт цуглуулах, боловсруулах, хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн дүн шинжилгээ хийх, үнэлэх, хэвлэн нийтлэх, нийтэд тархаах цогц үйл ажиллагаа юм.

Улсын Их Хурлын 2017 оны 76 дугаар тогтоолоор Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын товыг 2020 оны 1 дүгээр сарын 8-наас 9-нд шилжих шөнийн 00 /тэг тэг/ цагаар тогтоосон.

Тооллогын Улсын Комиссын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын хүн ам 3 296 866 болсныг 2020 оны 6 дугаар сарын 9-ний өдөр нийтэд зарлалаа.

Хорьдугаар зууны анхны буюу 1918 оны тооллогоор Монгол Улс 647.5 мянган хүн амтай байсан бол өнөөдөр 5 дахин өсжээ.

Энэхүү ном нь 12 бүлэг, тооллогын нэгдсэн үр дүнгийн гол гол үзүүлэлтийг хамарсан хавсралтаас бүрдэнэ.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын онцлог, удирдлагын тухай 1 дүгээр бүлэгт тусгасан.

Хүн амын тоо, өсөлт, нас, хүйсийн бүтэц, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин, суурьшил, нягтрал, хотжилт зэрэг хүн ам зүйн гол үзүүлэлтийг 2-4 дүгээр бүлэгт, хүн амын дотоод шилжих хөдөлгөөн, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, өрх, гэр бүлийн байдал, гар утас, интернэт хэрэглэгчид, эдийн засгийн идэвх, гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн талаарх мэдээллийг тус бүрд нь бүлэг болгосноос гадна тооллогод шинэ аргачлалаар тусгасан үйлдлийн чадварын хүндрэл болон Байшин, орон сууцны тооллогын мэдээллийг бүлэг болгож оруулав.

Энэ удаагийн тооллогын дүнг өмнөх тооллогуудын дүнгийн үзүүлэлттэй зэрэгцүүлэн жиших боломжтойгоос гадна сум, багийн түвшинд зарим онцлог мэдээллүүдийг шинээр нэмж тусгалаа.

Тооллогын дүнг үндэслэн тооллого хоорондын Монгол Улсын хүн амын тоог аймаг, нийслэлээр шинэчлэн тодотгож гаргахын зэрэгцээгээр хүн амын хэтийн тооцоог (2020-2050 он) улс, аймаг, нийслэл, нас, хүйсээр, олон хувилбараар тооцож нийтийн хүртээл болгоно.

Тооллогын дүнг хэвлэмэл бүтээгдэхүүнээс гадна сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан өргөн тархаах болно.

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН УЛСЫН
КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА**

 **АЮУШИЙН
АРИУНЗАЯА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИЛГЭЭЛТ



Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороонд

Монгол Улсын иргэд ээ,

Монгол Улс 11 дэх удаагийн Хүн ам, орон сууцны тооллогыг амжилттай зохион байгуулж дууслаа.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого болон Байшин, орон сууцны 2019 оны тооллогод ажилласан 19 мянга гаруй ажилтан, албан хаагчиддаа талархал илэрхийлье.

Тооллогын дүн мэдээнээс харахад Монгол Улсын нийт хүн амын тоо 2010-2020 оны хооронд жилд дунджаар 2.2 хувиар өсөж, Монголчууд 3 296 866-уулаа болжээ. Хүн амын өсөлт бол тусгаар улсын маань тэргүүлэх бодлого бөгөөд дараа, дараагийн 10 жилд ч хүн амаа өсгөх бодлого тасралтгүй хэрэгжих нь дамжиггүй юм.

Орчин үеийн хүн амын тооллогын түүх харьцангуй богино ч, эртний түүхийн сурвалж бичгүүдэд дурдсанаар Монголчууд эд баялгаа тоолж бүртгэж, албан татвар хураах, улс гүрнээ хамгаалах цэрэг дайчдыг бүрдүүлэх зэргээр хүн амаа тоолдог байжээ.

Хүн ам, орон сууцны энэ удаагийн тооллогоор Монгол Улсын нийт хүн амын тоо, хүн амтай холбоотой нас хүйсийн бүтэц, өсөлт, шилжих хөдөлгөөн, боловсрол, ажил эрхлэлт зэрэг бүхий л үзүүлэлтээс гадна хүн амын амьдарч буй орон сууцны сан хөмрөг, хүчин чадал, хийц, ашиглалт, дэд бүтэц, төрөл, нөхцөлийн өнөөгийн байдлыг нарийн гаргажээ.

Өөрөөр хэлбэл Та бид хэрэгжиж байгаа хөгжлийн бодлого, хөтөлбөрийг дүгнэх, цаашид тэдгээрийг улам бүр сайжруулахад нэн шаардлагатай, шинэчилсэн мэдээлэлтэй боллоо. Тиймээс үндэсний хэмжээний бодлого, төлөвлөлт, аливаа шийдвэрийн уг үндсийг Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогын дүн мэдээтэй холбон үндэслэж байхыг уриалга болгож байна.

Монгол Улсын хүн нэг бүрд хүрсэн хөгжлийн бодлого хэрэгжих болтугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА

Төрийн ордон, Улаанбаатар хот
2020 оны 6 дугаар сарын 12-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ИЛГЭЭЛТ



Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүндэт ард иргэд ээ,

Монгол Улсын Статистикийн тухай болон Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн дагуу Хүн ам, орон сууцны 11 дэх удаагийн тооллогыг 2020 онд зохион байгуулж явууллаа.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын товыг УИХ-ын 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 76 дугаар тогтоолоор 2020 оны 1 дүгээр сарын 8-наас 9-нд шилжих шөнийн Улаанбаатарын 00 /тэг тэг/ цагаар, тоолох ажиллагааг 1 дүгээр сарын 9-ний өглөөний 8 цагт орон даяар эхлүүлсэн билээ.

Тооллогын мэдээллийг Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд заасны дагуу 7 хоногийн хугацаанд буюу 1 дүгээр сарын 9-нөөс 15-ны өдрийн 22 цаг хүртэл хугацаанд цуглуулсан юм.

Энэ тооллогыг зохион байгуулж явуулснаар бид Монгол Улсын хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинг бодитой үнэлж, дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох нэн шинэ мэдээлэлтэй болж байна. Төр, засгийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчид, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачдад нэн хэрэгцээтэй олон улсын түвшинд зэрэгцүүлж харьцуулагдах зарчмыг хангасан, шаардлагад нийцсэн мэдээллийн нарийвчилсан эх үүсвэртэй боллоо.

Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг хөгжлийн төлөө үр ашигтай хэрэгсэл болгон ашиглахыг би Та бүхэнд уриалж байна.

Энэхүү тооллогод иргэн бүр идэвхтэй хамрагдаж, тооллогын ажилтныг байр, сууцандаа саадгүй нэвтрүүлж, өрхийн гишүүд болон орон сууцны нөхцөлийн талаар үнэн бодит мэдээлэл өгч, хамтран ажилласанд талархаж байна.

Үндэсний Статистикийн Хороо энэ удаагийн тооллогыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, холбогдох яамд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, тооллогын бүх шатны комисс, түр товчоодын гишүүд, тоологч, шалгагч нарыг өндөр зохион байгуулалттай удирдан ажиллаж, энэ чухал ажлыг хуулийн дагуу амжилттай гүйцэтгэлээ.

Хүн ам, орон сууцны тооллогод амжилттай ажилласан бүх хүмүүст талархал илэрхийлж, ажлын амжилтыг хүсэн ерөөе.



Төрийн ордон, Улаанбаатар хот
2020 оны 6 дугаар сарын 9-ний өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД, ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН ДАРГЫН ӨМНӨХ ҮГ



Монгол сайхан эх орондоо ажиллаж, амьдарч байгаа болон дэлхийн өнцөг булан бүрд тархан суугаа элэг нэгт Монголчууд Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын зөвлөмжийн дагуу дэлхийн 200 гаруй улс, үүний дотор Ази тивийн 52 улс 2020 он орчимд хүн амынхаа тооллогыг зохион байгуулж байгаа бөгөөд 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар дэлхийн 7.8 тэрбум хүн амын 46.0 хувь нь албан ёсоор тоологджээ.

Монгол Улсын хувьд “Хүмүүнд төр эрхэм, Төрд хүмүүн эрдэнэ” уриа дор 11 дэх удаагийн Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг амжилттай зохион байгуулж, тооллогын нэгдсэн үр дүнг танилцуулж байна.

Монгол Улсын хүн ам 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар 3 296 866 болжээ.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын нэгдсэн үр дүн болон нарийвчилсан судалгаа, шинжилгээний тайланг цаашид хэвлэмэл болон цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх болно.

Монгол Улсын Их Хурлын “Улсын комисс байгуулах тухай” 2017 оны 77 дугаар тогтоол, Хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын “Аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай” 2018 оны 2 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нар тооллогын ажилд онцгой ач холбогдол өгч, хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын мэдээлэл нь төрийн аливаа бодлого, төлөвлөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа Засгийн газрын хувьд хүн амын эдийн засгийн идэвхжил, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг тодорхой цаг хугацааны үечлэлээр тодорхойлох, улмаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулах, шийдвэр гаргах, тэдгээрийн хэрэгжилтийг дүгнэх зэрэгт нэн шаардлагатай мэдээллийн эх үүсвэр болдог.

Тооллогын ажлыг амжилттай явуулахад иргэд, олон нийтийн дэмжлэг, идэвхтэй оролцоо чухал хувь нэмэр оруулсныг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна.

Монгол Улсын Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын зорилго, ач холбогдлыг олон нийтэд таниулж, тооллогыг үр дүнтэй явуулах сурталчилгааны ажлыг зохион байгуулахад хамтран ажилласан бүх хэвлэл, мэдээллийн байгууллага, үүрэн телефоны оператор, аж ахуйн нэгжүүдэд талархал илэрхийлье.

Мөн тооллогын ажлыг улс орон даяар нэгдсэн удирдлага, аргачлал, заавраар ханган, өндөр зохион байгуулалт дор явуулж, үр дүнг богино хугацаанд боловсруулахад гол үүрэг гүйцэтгэсэн Үндэсний Статистикийн Хороо, түүний салбар нэгжийн ажилтан, нийт албан хаагчдад Хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын нэрийн өмнөөс гүн талархал дэвшүүлье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН
УЛСЫН КОМИССЫН ДАРГА

УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

ТОВЧ ДҮГНЭЛТ

ӨРХИЙН ТОО



¹Хоорондоо хамааралтай хэд хэдэн ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг нийлмэл өрх гэнэ.


²Ураг төрлийн хамааралтай болон хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг холимог өрх гэнэ.

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН


10, түүнээс дээш настай хүн амын хувьд




СУУРЬШИЛ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН





АЙМАГ, НИЙСЛЭЛ ХООРОНДЫН ШИЛЖИГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ӨРӨНХИЙ БАЙДАЛ, СУМААР




ХҮН АМ 3 296 866



ҮНДЭС, УГСАА




БАЙШИН, ОРОН СУУЦ, ӨРХИЙН ТОО



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

дүнд эзлэх хувиар



ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ



ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын харьяат хүн ам 3 296 866 боллоо. Монгол Улсын хүн ам 2020 онд 1918 оноос 5 дахин, 2010 оноос хойш жилд дунджаар 2.2 хувиар өсжээ. Бүх аймаг, нийслэлд тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт өмнөх тооллогын дүнгээс өссөн байна.

Монгол Улсын хүн амын насны бүтцэд 2010 онтой харьцуулахад зарим өөрчлөлт гарсан ба нийт хүн амд эзлэх 0-9 насныхны хувийн жин өссөн нь 2011 оноос төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой юм. Харин 15-29 насны бүлэг дэх хүн амын дүнд эзлэх хувь бага байгаа нь 1990-ээд оны эхэн үеэс 2006 он хүртэлх хугацаанд төрөлтийн түвшин бага байснаар тайлбарлагдана.

Хүйсийн харьцаа 1979 оны хүн амын тооллогоор 100.4 байснаа тогтмол буурсаар 2010 онд 98.1, 2020 онд 96.6 болсон нь нийт хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байгааг илэрхийлнэ.

Сүүлийн 30 жилд хүн амын голч нас 18.8-аас 27.9 болж бараг 10 жилээр хойшилсон нь төрөлтийн бууралтаас гадна дундаж наслалт нэмэгдэж байгаатай холбоотой.

Хүн ам зүйн ачаалал 2020 онд 55.3 болж 1989 оноос 29.6 пунктээр буурч, 2010 оноос 10.3 пунктээр өсжээ. Хөдөлмөрийн насны хүн амын тоо их байгаа буюу хүн ам зүйн цонх үеийг ашиглан урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарснаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд эергээр нөлөөлөх юм.

УЛСЫН ХАРЬАЛАЛ, ҮНДЭС, УГСАА, ШАШИН

Монгол Улсын харьяат суурин хүн амын 83.8 хувийг Халхууд эзэлж, өмнөх тооллогоос 1.4 пунктээр өссөн байна. Казахуудын нийт хүн амд эзлэх хувийн жин 3.8 хувь байгаа нь Халхуудын дараа орж байна. Харин Дөрвөд, Баяд, Буриад угсаатнууд 2010 оноос буурсан байна.

Байршлын хувьд Халхууд бүх аймаг, нийслэлд оршин сууж байна. Тухайн аймгийн дотор нийт хүн амд эзлэх хувиар Баян-Өлгий (0.9 хувь), Увс (13.6 хувь), Ховд (28.1 хувь) нь хамгийн бага байна. Харин Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай аймгуудад нийт хүн амын 99-өөс дээш хувь нь Халхууд амьдарч байна.

Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэдийн тоо 2010 оноос 37.4 хувь буюу 6 098 хүнээр өсөж 22 418-д хүрлээ. Харин харьяалалгүй иргэдийн тоо 2010 оноос 71 хүнээр буурч 37 болов. Гадаадын харьяат иргэдийн дотор Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) болон Оросын Холбооны Улс (ОХУ)-ын иргэд нийт гадаад иргэдийн 53.3 хувийг эзэлж байна. 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад Монгол Улсад байнга оршин суугаа БНХАУ-ын иргэдийн эзлэх хувь 11.3 пунктээр, ОХУ-ын иргэдийн эзлэх хувь 3.4 пунктээр тус тус буурсан бол Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын иргэдийн эзлэх хувь 6.6 пунктээр өссөн байна.

Монгол Улсад байнга оршин суугаа гадаад иргэдийг өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 0-14 насны хүн амын эзлэх хувь 9.9 пунктээр, 55, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь 5.0 пунктээр тус тус өссөн байна. Монгол Улсад амьдарч байгаа гадаадын харьяат иргэдийн 70 орчим хувь нь 25, түүнээс дээш насны хүн ам буюу хөдөлмөрийн насны хүн ам байна. Мөн 57.4 хувь нь дээд боловсролтой бөгөөд ихэвчлэн үйлчилгээний бусад үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсролын салбарт ажиллаж байна.

Тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны хүн амын 59.4 хувь нь шашин шүтдэг, 40.6 хувь нь шашин шүтдэггүй хүмүүс байна. Шашин шүтдэг хүмүүсийн 87.1 хувь нь Буддын шашинтан байна. Хүн амын дийлэнх нь Буддын шашинтан боловч насны бүлгээр авч үзэхэд 15-19 насны өсвөр үеийнхний

дийлэнх нь Христ, Исламын шашинтан байна. Мөн үндэс, угсаанаас хамааран шашин шүтэх, эс шүтэх нь харилцан адилгүй бөгөөд Казахуудын 84.7 хувь нь шашин шүтдэг бөгөөд үүнээс 81.9 хувь нь Ислам шашинтан байна.

ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ХОТЖИЛТ

Монгол Улсын хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 45.9 хувь нь Улаанбаатар хотод, 18.7 хувь нь Хангайн бүсэд, 15.8 хувь нь Төвийн бүсэд, 12.6 хувь нь Баруун бүсэд, 7.0 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна.

1990-ээд оны эхэн үеэс эхэлсэн төв, суурин газар луу шилжилт сүүлийн 30 жилд үргэлжилсэн хэвээр байна.

Төв, суурин газарт 2020 онд нийт хүн амын 67.8 хувь буюу 2 168.2 мянга нь амьдарч байна. Баруун бүсэд харьцангуй олон хүн амтай, суурьшлын хувьд нягт хэдий ч хотжих явц эрчимтэй биш байна. Улаанбаатар хотын дараа Төвийн бүсийн хотжилт хамгийн өндөр хэвээр байна.

Аймгуудын хотжилтын түвшин хоорондоо нэлээд ялгаатай байдаг. Аймгийн төвүүдийн боловсрол, эрүүл мэнд, ажлын байр, худалдаа, үйлчилгээ, зэрэг нийгмийн салбарын хөгжил хөдөөгөөс илүү байгаа нь шилжин ирэгчдийг татаж, аймгийн хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жинг өсгөжээ.

Аймаг, нийслэлийн хүн амын нягтралын өөрчлөлтөд дотоод шилжих хөдөлгөөн ихээхэн нөлөөлсөн байна. Улаанбаатар хотын хүн амын нягтрал 2020 онд 2010 оноос 66 хүнээр, Орхон аймгийнх 21 хүнээр, Дархан-Уул аймгийнх 4 хүнээр тус тус өссөн нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой байна.

Төв, суурин газруудад дэд бүтцээр хангагдсан байдал, боловсрол, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж, ялангуяа ажил, орлоготой болох найдвартай эх үүсвэр болж байгаа нь иргэдийг ихээр татаж хотжих үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна.

Хотын хүн амын дийлэнх буюу 67.6 хувь нь зөвхөн Улаанбаатар хотод амьдарч байна. Шилжих хөдөлгөөний үр дүнд Монгол Улсын нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь 2020 онд 3.4 пунктээр нэмэгдэж 2010 онтой харьцуулахад хамгийн ихээр өссөн байна. Үүний дараа Эрдэнэт, Дархан хот орж байна. Эдгээр нь хотын хүн амын 8.4 хувийг эзэлж байна. Дорнод, Дорноговь, Хөвсгөл, Баян-Өлгий, Сэлэнгэ аймаг бусад аймгийг бодвол хотын хүн амд эзлэх хувиараа бусдаас арай өндөр байна. Үлдсэн бүх аймагт хотын хүн амд эзлэх хувь маш бага, 0.5-1.5 хувийн хооронд хэлбэлзэж байна.

ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Монгол Улсын суурин хүн амын 45.9 хувь нь Улаанбаатар хотод, 20.3 хувь нь аймгийн төвд, 1.6 хувь нь тосгонд, 10.5 хувь нь сумын төвд, 21.7 хувь нь хөдөөд амьдарч байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 23.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 9.7 пунктээр, сүүлийн 5 жилийнх 8.2 пунктээр, сүүлийн 1 жилийнх 1.5 пунктээр тус тус буурчээ. Харин бүс хоорондын төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд оролцогчид 8.8 пунктээр, сүүлийн 5 жилийнх 7.3 пунктээр, сүүлийн 1 жилийнх 1.2 пунктээр 2010 оны тооллогоос мөн буурсан үзүүлэлттэй гарч байна.

Аймаг, нийслэл хоорондоо хатуу хучилттай засмал замаар холбогдсон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамжаар 2017-2020 онуудад Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан нь төв, суурин газар луу явах шилжих хөдөлгөөний эрчимжилтийг бууруулсан, түүнчлэн 2010 оны тооллогоос хойш мал аж ахуйн

салбарт тохиолдсон ган, зуд зэрэг хүндрэл гараагүй нь шилжих хөдөлгөөний урсгалыг багасгасан байж болох юм.

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний ерөнхий дүр зургаас харахад Улаанбаатар хот руу чиглэсэн хөдөлгөөн бусад бүсээс нэлээд давамгайлсан хэвээр байна. 2020 оны тооллогын дүнгээр нийслэлийн шилжих хөдөлгөөнд оролцогчдын 76.3 хувь нь шилжин ирэгчид байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 1.3 пунктээр өсжээ. Харин бүс нутгийн шилжих хөдөлгөөний төрх байдлыг үзвэл Төвийн бүсэд шилжин ирэгчид давамгайлсан хэвээр байгаа нь харагдаж байна.

Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөний ерөнхий төрх, төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийхтэй төстэй байгаа юм. Нийслэл хотоос бусад бүсэд шилжих хөдөлгөөний урсгал гадагшаа чиглэсэн байна. Баруун бүс нутгаас бусад бүс нутаг руу шилжсэн хөдөлгөөн хамгийн их байна. Үүний дараа Хангайн бүс орж байна. Бусад бүс нутагт гадагш шилжсэн хөдөлгөөн тийм ч их биш байгаа юм.

Дотоод шилжих хөдөлгөөнийг 2 тооллогын дүнгээс харахад 2010 оноос буурсан. Харин бүх бүсийн хувьд 5 жилийн өмнө байнга оршин сууж байсан бүс нутагтаа тоолох үед байнга оршин сууж байсан хүн амын эзлэх хувь өссөн байна. Төвийн бүс нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал харьцангуй өндөр байгаагаас харахад “Бусад бүс – Төвийн бүс – Улаанбаатар хот” гэсэн үе шаттай урсгал явагдаж байна.

БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ

Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн амын 98.7 хувь нь бичиг үсэг мэдэж байгаа нь өмнөх тооллогоос 0.4 пунктээр өссөн. Монгол Улсын бичиг үсгийн тайлагдалтын түвшин дэлхийн улс орнуудын дундаж түвшинтэй харьцуулахад өндөр хэвээр байгаа юм.

10, түүнээс дээш насны боловсролтой хүн амын дүнд эзлэх хувь 95.1 болж өмнөх тооллогын үеэс 2.6 пунктээр өссөн байна. Хүйсийн ялгаатай байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 2.7 пунктээр, эмэгтэйчүүдийнх 2.3 пунктээр өсжээ. Боловсролгүй хүн амын эзлэх хувь 4.9 болж өмнөх тооллогын дүнгээс 2.6 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Хот, хөдөөгийн хүн амын боловсролын байдал ялгаатай байгаагийн дотор түвшин дээшлэх тутамд ялгаа улам нэмэгдэж байна. Тухайлбал, бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын хувь хотод хөдөөгөөс 9.4-20.1 пунктээр илүү байгаа бол бага болон суурь, боловсролтой хүмүүсийн хувь хөдөөд хотоос 11.2-17.8 пунктээр өндөр байна.

Нөгөөтээгүүр улсын дүнгээр дээд боловсролтой хүн амын эзлэх хувь 26.5 байгаа бол техник мэргэжлийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүмүүсийн хувь 8.6 хувьтай байна. Үүнээс үзэхэд тусгай болон техник мэргэжлийн дунд боловсролтой хүмүүс дээд боловсролтой хүмүүстэй харьцуулахад харьцангуй бага байна.

Сургуулийн өмнөх боловсролд 2–5 насны хүүхдүүдийн 84.1 хувь нь хамрагдаж байгаа бөгөөд 2010 оноос 24.0 пунктээр өсжээ. Байршлаар харвал хөдөөд 2-5 насны хүүхдүүдийн 83.6 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нь өмнөх тооллогоос 38.0 пунктээр өссөн байна.

Сургуульд хамрагдалт өмнөх тооллогуудтай харьцуулахад байнга өсжээ. 2020 оны тооллогоор 6-29 насны хүн амын 72.6 хувь нь сургуульд хамрагдаж байгаа ба 2010 онтой харьцуулахад 14.5 пунктээр нэмэгдсэн байна. Ялангуяа 6-17 насны буюу ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдүүдийн 98.0 хувь нь сургуульд хамрагдаж байна.

Сургуульд хамрагдалтыг хүйсээр харвал 2010 онтой харьцуулахад сургуульд хамрагдалтын байдал 6-14 насны хүн амын хувьд ижил түвшинд байгаа ч 15, түүнээс дээш насанд буюу суурь боловсролын

түвшнийг дүүргэсний дараагаар эрэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад буурсан харагдаж байна.

Сургуульд хамрагдалтын байдал 25-29 насны хүн амд 17.9 хувь болж 2010 оноос 12.3 пунктээр өссөн нь хамгийн өндөр байна.

ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор 897.4 мянган өрх тоологдсон байна. Энэ нь өмнөх тооллогын дүнгээс 183.6 мянга буюу 25.7 хувиар өссөний дотор хотын өрх 126.8 мянга буюу 26.4 хувиар, хөдөөгийн өрх 56.8 мянга буюу 24.2 хувиар тус тус өсжээ.

Өрхийн бүтцийн хувьд авч үзвэл 59.8 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 22.7 хувь нь нийлмэл¹ ам бүлтэй буюу хоорондоо хамааралтай хэд хэдэн ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа өрх, 15.4 хувь нь ганц бие өрх, 2.2 хувь нь холимог² ам бүлтэй буюу ураг төрлийн хамааралтай болон хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа өрх байна. Өмнөх тооллогын дүнгээс ам бүлээрээ байгаа өрх 91.3 мянга буюу 20.5 хувиар, нийлмэл ам бүлтэй өрх 25.4 мянга буюу 14.3 хувиар, ганц бие өрх 61.9 мянга буюу 81.6 хувиар, холимог ам бүлтэй өрх 5.1 мянга буюу 34.2 хувиар тус тус өссөн. Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод хөдөөгөөс 3.9 дахин нэмэгдсэн байна.

Тооллогоор өрхийн ам бүлийн дундаж тоо 3.6 гарсан нь өмнөх тооллоготой ижил түвшинд байна. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн нэмэгджээ. Тухайлбал, 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 1-2 ам бүлтэй өрх хотод 60.4 мянга буюу 48.7 хувиар, хөдөөд 31.0 мянга буюу 46.5 хувиар тус тус өссөн байна.

Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь 28.5 болж 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 7.0 пунктээр, хотод 8.6 пунктээр, хөдөөд 3.7 пунктээр тус тус нэмэгджээ.

15, түүнээс дээш настай хүн амыг гэрлэлтийн байдлаар харвал 31.5 хувь нь огт гэрлээгүй хүмүүс, 60.6 хувь нь батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй, 2.4 хувь нь гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан, 5.5 хувь нь бэлэвсэн байна. Өмнөх тооллогын дүнгээс огт гэрлээгүй хүмүүс 82.8 мянга буюу 13.9 хувиар, батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүс 157.5 мянга буюу 13.7 хувиар, бэлэвсэн хүмүүсийн хувьд 13.4 мянга буюу 12.8 хувиар тус тус өссөн байна. Харин цуцалсан болон тусгаарласан хүмүүсийн хувьд 7.5 мянга буюу 12.7 хувиар буурчээ.

Анхны гэрлэлтийн дундаж нас 27.7 болж 2010 оноос 2020 оны хооронд 2 насаар хойшилсон байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа сүүлийн 20 жилд ойролцоогоор нэгээс хоёр насны зөрүүтэй байсаар байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ

Улсын хэмжээнд 106.4 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 3.3 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 58.9 мянга буюу 55.4 хувь нь эрэгтэй, 47.4 мянга буюу 44.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Тооллогоор нийт 50.6 мянган төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа ба өмнөх тооллогоос 37.7 хувиар өссөн байна. Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 55.7 мянга байгаа нь өмнөх тооллогоос 21.8 хувиар буурсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 45.0 хувь нь төрөлхийн, 55.0 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 50.8 хувь нь төрөлхийн, 49.2 хувь

1 Хоорондоо хамааралтай хэд хэдэн ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг нийлмэл өрх гэнэ.

2 Ураг төрлийн хамааралтай болон хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг холимог өрх гэнэ.

нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Иймд төрөлхийн бэрхшээл их байгаа шалтгааныг удамшлын эмгэг, эх барихын болон төрөх үеийн хүндрэл, хорт нөлөө, агаарын бохирдол зэрэг олон талаас нь нарийвчлан судлах шаардлага байна.

Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулбал хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам 24.0 мянга болж 23.3 хувиар, харааны бэрхшээлтэй хүн ам 12.8 мянга болж 23.3 хувиар, сонсголын бэрхшээлтэй хүн ам 8.7 мянга болж 31.2 хувиар тус тус буурсан бол сэтгэцийн бэрхшээлтэй хүн ам 21.5 мянга болж 3.0 хувиар өссөн байна.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын 12.9 хувь нь 18-34 насны залуучууд байгаа бол 46.9 хувь нь 35-64 насны, 40.2 хувь нь 65, түүнээс дээш насны хүн ам байна. Эдгээрийн 28.7 хувь нь алхах, 18.9 хувь нь харааны хүндрэлтэй байгаа бол хамгийн бага нь харилцах үйлдлийн хүндрэлтэй хүмүүс байна.

Үйлдлийн чадварын хүндрэлийн түвшнийг аймаг, нийслэлээр зэрэгцүүлэн харвал Хөвсгөл, Өвөрхангай, Төв аймгууд хамгийн их хувийг эзэлж байгаа бол хамгийн бага хувийг Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь аймгууд эзэлж байна.

Нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн 15.5 хувь нь боловсролгүй, 84.5 хувь нь ямар нэгэн түвшний боловсролтой байна. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийг боловсролын түвшнээр харвал 25.0 хувь нь бүрэн дунд, 14.7 хувь нь суурь, 10.7 хувь нь бага боловсролтой байгаа нь хамгийн өндөр байна.

Тооллогоор нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн 31.2 хувь нь ажилтай гэж бүртгэгдсэн, хөдөлмөр эрхэлдэг ба эдгээр хүмүүсийг ажил эрхлэлтийн байдлаар нь үзэхэд 47.3 хувь нь өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч, 23.9 хувь нь байнгын ажиллагч, 13.0 хувь нь цалин хөлстэй түр ажиллагч нар байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлэх, тэдний онцлог, хэрэгцээ шаардлагыг цаашид нийгэм, эдийн засгийн хүчин зүйлстэй хамааруулж судлах, улмаар ахуйн нөхцөл, амьжиргааг нь дээшлүүлэхэд ашиглагдах мэдээллийн бодитой эх үүсвэр бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

ГАР, УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИД

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн энэ цаг үед гар утас, интернэт нь хүн амын өдөр тутмын өргөн хэрэглээ болоод байна.

6, түүнээс дээш насны хүн амын 87.8 хувь нь гар утас хэрэглэгч, 64.7 хувь нь интернэт хэрэглэгч болжээ. Уг үзүүлэлтийг 2010 оны тооллоготой харьцуулахад гар утас хэрэглэгч 13.8 пунктээр, интернэт хэрэглэгч 34.1 пунктээр тус тус өссөн байна.

Интернэт хэрэглэдэг хүн амын 58.7 хувь нь байнга хэрэглэдэг, 41.3 хувь нь шаардлагатай үедээ интернэт хэрэглэдэг байна.

Хотод амьдарч буй хүн амын 72.4 хувь нь, хөдөөд амьдарч буй хүн амын 49.3 хувь нь интернэт хэрэглэдэг болжээ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны нийт хүн амын 59.7 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 3.3 пунктээр өсжээ. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн ам (40.3%) 3.3 пунктээр буурчээ. Ерөнхийд нь дүгнэвэл ажиллах хүчний оролцооны түвшин өнгөрсөн тооллогын үеийнхээс өссөн, ялангуяа эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 54.6 болж өмнөх тооллогын

үеийнхээс 4.5 пунктээр өссөн байна.

Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байна. Байршлын хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Тухайлбал, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 69.1 хувь байгаа нь хотынхоос 5.8 пунктээр илүү байна.

15, түүнээс дээш настай нийт хүн амын 53.8 хувь нь ажил эрхэлж байхад энэ үзүүлэлт хөдөөд 60.6 хувь байгаа нь хөдөөгийн хүн амын дийлэнх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэгтэй холбоотой. Ялангуяа хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт 66.5 болж хотынхоос 11.8 пунктээр өндөр байгаа нь хөдөөгийн эрэгтэйчүүдийн дийлэнх нь мал аж ахуй эрхэлж байгаагаар тайлбарлагдана.

Нийт хөдөлмөрийн насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь 53.8 болж өнгөрсөн тооллогын үеийнхээс 6.0 пунктээр нэмэгдэж, ажиллах хүчнээс гадуурх хүн амын хувийн жин 40.3 болж 3.3 пунктээр буурч, ажилгүй иргэд 5.9 хувийг эзэлж байна. 60, түүнээс дээш насны хүн амын 16.7 хувь ажиллах хүчинд хамрагдаж байгаа ба өмнөх тооллогын үеийнхээс 8.3 пунктээр нэмэгдсэн нь эерэг үзүүлэлт байна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдалд 2020 онд өмнөх тооллогынхоос мэдэгдэхүйц өөрчлөлт орсон байна. 2010 онд цалин хөлстэй ажиллагч нийт ажил эрхэлдэг хүн амын 56.2 хувийг эзэлж байсан бол 2020 онд 66.9 хувь болж 10.7 пунктээр өсжээ. Харин ажил олгогчийн эзлэх хувь 0.6 болж өмнөх тооллоготой харьцуулахад 1.9 пунктээр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувь 26.6 болж 1.1 пунктээр тус тус буурчээ. Цалин хөлстэй ажиллагчийн хувийн жин өсөх нь хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангах, нийгмийн хамгаалалд хамрагдаж, хөдөлмөрлөх эрхээ бүрэн дүүрэн эдлэх бололцоог нэмэгдүүлдгээрээ сайн талтай ч хувиараа хөдөлмөр эрхлэгч болон ажил олгогчийн хувийн жин буурсан нь үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж чадахгүй байгааг илэрхийлж болох юм.

Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 тооллогын дүнгээр 9.9 хувь болж, өмнөх тооллогын үеийнхээс 5.4 пунктээр буурчээ. Ажилгүйдлийн түвшин хотод 13.2 байгаа бол хөдөөд 3.7 байна. Энэ нь нэг талаас төв, суурин бараадсан шилжих хөдөлгөөн их байгаа, нөгөө талаас тэд хотод шилжин ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой.

Улсын хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам 873.8 мянга байгаа нь өмнөх тооллогоос 5.2 хувиар, үүний дотор ажиллах сонирхолгүй хүний тоо 3.7 мянга болж 11.3 хувиар, сургуульд сурдаг хүний тоо 327.2 мянга болж 8.9 хувиар тус тус өсжээ. Харин хөдөлмөр эрхлэх чадваргүй, гэрийн ажилтай, тохирох ажил олдохгүй байгаа хүмүүсийн хувь 14.7-18.3 хувиар буурсан байна.

Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийн нэг болох 15-24 насны хүн амд хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй залуучуудын эзлэх хувийг тооцож гаргалаа. Энэ үзүүлэлт тооллогын дүнгээр 12.2 хувь байна. Ялангуяа 15-24 насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлээгүй, сургуульд суралцаагүй хувь улсын дүнгээс 0.3 пунктээр илүү байна.

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 6, түүнээс дээш сарын хугацаагаар гадаадад оршин суугаа 122.3 мянган иргэн тоологдож 2010 оноос 14.2 хувиар өсжээ.

Тооллогын үед суурьших зорилгоор гадаадад оршин суугаа хүмүүсийн 25.1 хувь нь анх суралцахаар явсан байна. Харин тооллогын үед хувиараа хөдөлмөрлөх зорилгоор оршин суугаа хүмүүсийн 19.8 хувь нь анх суралцахаар явж байсан байна.

Гадаадад тоологдсон иргэдийн 58.8 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 23.9 хувь нь Европ тивд суугаагаар тоологдсон байна.

Үүнийг Гадаадад 6, түүнээс дээш хугацаагаар оршин суугаа хүн амыг Монгол Улсын аль бүсээс шилжин суурьшсаныг авч үзвэл Баруун бүсээс бусад бүсэд ижил хандлагатай буюу 53.1-69.9 хувь нь Ази, Номхон далайн бүсэд, 21.3-25.7 хувь нь Европ тивд байна. Харин Баруун бүсээс явсан хүн амын 10 хүн тутмын 9 нь Ази, Номхон далайн бүсэд оршин сууж байна. Мөн Америк тивд Улаанбаатар хотоос хамгийн их хүн оршин сууж байгаа буюу 21.0 хувь байна.

Нийт гадаадад оршин суугаа 122.3 мянган иргэдийн 34.2 хувь нь сурах, 32.0 хувь хөдөлмөр эрхлэх (үүнээс 20.6 хувь нь хувиараа, 10.4 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр, 1.0 хувь нь албан томиллолтоор ажиллах), 12.6 хувь нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух, 11.7 хувийг суурьших, үлдсэн 9.5 хувь нь бусад зорилгоор эх орноосоо явжээ.

ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ

Монгол Улсад хүн амьдран суух зориулалттай нийт 677.6 мянган сууц 2019 онд тоологдсоноос 44.9 хувь нь гэр, 55.1 хувь нь байшин сууц байсан бол гэр сууцны 74.2 хувь нь үндсэн гэр, 25.8 хувь нь илүү гэр байна. Харин байшин сууцны 78.3 хувь нь үндсэн байшин (үүний 74.2 хувь нь хүн байнга амьдардаг байшин), 21.7 хувь нь улирлын чанартай ашигладаг зуслангийн байшин байна.

Хүн байнга амьдардаг 442.7 мянган сууцыг төрлөөр авч үзвэл 51.0 хувь нь гэр сууц, 46.0 хувь нь сууцны тусдаа байшин, 1.7 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 0.9 хувь нь бие даасан тохилог сууц, 0.4 хувь нь нийтийн байр тоологдсон байна. Нийтийн зориулалттай 7 444 орон сууцны байшинд 335 587 сууц тоологдсон байна.

Манай улсын нийт 897.4 мянган өрхийн 38.2 хувь нь гэрт, 60.9 хувь нь байшинд, 0.9 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь 7.3 пунктээр өсөж, гэрт амьдардаг өрхийн хувь 7.0 пунктээр буурчээ.

Хот, хөдөөд амьдарч байгаа өрхийн сууцны төрөл нэлээд ялгаатай байна. Хотод нийт өрхийн 74.5 хувь нь байшинд, 24.7 хувь нь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь 8.0 пунктээр буурч, байшинд амьдардаг өрхийнх 8.6 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь том хотуудад сүүлийн жилүүдэд орон сууцжуулах бодлого, хөтөлбөрүүд нэмэгдсэнтэй холбоотой юм.

Тооллогын дүнгээс үзэхэд улсын хэмжээнд 4.7 мянган өрх цахилгаангүй байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 4.9 дахин буурсан чухал дэвшил байлаа. Цахилгаангүй өрхийн 93.5 хувь нь гэрт амьдарч байгаагийн дотор 76.8 хувь нь хөдөө оршин суудаг ажээ.

Ерөнхийдөө орон сууцны багтаамж сайжирчээ. Үүнийг байшинд амьдардаг өрхийн 24.4 хувь нь 21-40 квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 15.6 пунктээр буурсан, 40-өөс дээш квадрат метр талбайтай байшинд суудаг өрхийн хувь 67.1 хувь болж, өмнөх тооллогынхоос 2.1 дахин өссөнөөс харж болно.

Нийт өрхөд эзлэх төвлөрсөн халаалттай байшинд амьдардаг өрхийн хувь 57.5 болж хотод 5.9 пунктээр, хөдөөд 12.2 болж 5.0 пунктээр тус тус өссөн нь орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоо эрс өссөнтэй холбоотой юм.

Байшинд амьдардаг өрхийн 49.7 хувь нь төвлөрсөн системд холбогдсон бие засах газартай, 47.4 хувь нь энгийн нүхэн жорлонд бие засаж байна. Байшинд амьдардаг нийт өрхийн 46.4 хувь нь онгоц, шүршүүртэй байгааг өмнөх тооллоготой харьцуулахад 5.8 пунктээр нэмэгджээ. Байшинд амьдардаг өрхийн 85.3 хувь нь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 8.2 пунктээр өссөн, 2010 онд байшинд суудаг өрхийн 5.0 хувь нь хатуу хог хаягдлаа зайлуулах тодорхой цэггүй байсан бол 2020 онд 2.5 хувь болтлоо буурчээ.

ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ОНЦЛОГ, УДИРДЛАГА

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ОНЦЛОГ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулахдаа Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг мөрдөж тооллогын үе шат бүрд мэдээллийн технологийн ололт, дэвшлийг өргөн ашигласан төдийгүй уг хуулийн 4.1.1 болон 4.1.2 заалтуудад заасан аргуудыг хослуулан явуулсан. Нийт өрхийн 10 хувийн мэдээллийг дэлгэрэнгүй асуулгын маягтаар сонгогдсон өрх бүрд орж (уламжлалт арга), үлдсэн 90 хувийн мэдээллийг богино асуулга буюу Хүн ам, өрхийн мэдээллийн сан болон төрийн байгууллагуудын мэдээллийн санд тулгуурлан бүртгэлд суурилан цуглуулсан.

Монгол Улсад статистикийн байгууллагын үндэс суурь тавигдсан 1924 оноос хойш 1935, 1944, 1956, 1963 онуудад хүн амын тооллого хийсэн бол улс хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллогыг 1969 онд явуулсан байдаг. Олон улсын нийтлэг аргачлалын дагуу хүн ам болон орон сууцны тооллогыг нэгтгэн 1969 оноос хойш 10 жилийн давтамжтайгаар хийх болж 1979, 1989, 2000, 2010, 2020 онуудад явуулсан бол Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд тусад нь зохион байгууллаа.

Байшин, орон сууцны тооллогоор хүн амьдран суух зориулалттай бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг бүрэн тодорхойлж, орон сууцны хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаарх хаягт суурилсан дэлгэрэнгүй мэдээллийн сантай болсон. Өөрөөр хэлбэл төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчид, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачдад нэн хэрэгцээтэй олон улсын түвшинд зэрэгцүүлж харьцуулагдах зарчмыг хангасан, шаардлагад нийцсэн мэдээллийн нарийвчилсан эх үүсвэрийг шинэчлэн гаргаснаар ихээхэн онцлогтой тооллого байлаа.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТООЛЛОГЫН ТОВЫН ТУХАЙ ТОГТООЛ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2017 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 76

Төрийн ордон, Улаанбаатар хот

Тооллогын тов тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогын товыг 2020 оны 01 дүгээр сарын 08-наас 09-нд шилжих шөнийн "00" /тэг тэг/ цагаар тогтоосугай.



М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИСС БАЙГУУЛАХ ТУХАЙ ТОГТООЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 77

Төрийн ордон, Улаанбаатар хот

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах Улсын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга:

Монгол Улсын Ерөнхий сайд

Комиссын орлогч дарга:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Үндэсний Статистикийн хорооны дарга

Улсын комиссын гишүүд:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
Барилга, хот байгуулалтын сайд
Батлан хамгаалахын сайд
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
Гадаад харилцааны сайд
Зам, тээврийн хөгжлийн сайд
Сангийн сайд
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
Хууль зүй, дотоод хэргийн сайд
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
Эрчим хүчний сайд
Эрүүл мэндийн сайд
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

Нарийн бичгийн дарга:

Орон тооны албан хаагч /Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн 13.4-т заасан шаардлагыг хангасан/

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

УХА0313

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН ДҮНГ НИЙТЭД ЗАРЛАХ ТУХАЙ
ТОГТООЛ



МОНГОЛ УЛСЫН
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ
ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит
тооллогын дүнг нийтэд зарлах тухай

Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13 дугаар зүйлийн
13.6.7 дахь хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 76 тоот
тогтоолоор баталсан товын хугацаанд Монгол Улсын хүн ам 3 296 866, өрхийн тоо
897 427 болсныг зарласугай.

2. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнг нийтийн хүртээл
болгож, энэ тооллогын мэдээлэлтэй уялдуулан хөгжлийн бодлогын холбогдох суурь
болон шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцохыг Монгол Улсын Засгийн газрын
гишүүдэд даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйгээр хангаж
ажиллахыг Улсын комиссын орлогч дарга /Л.Оюун-Эрдэнэ, А.Ариунзаяа/ нарт
даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



У.ХҮРЭЛСҮХ

УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

КОМИССЫН ДАРГА



УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ
Монгол Улсын Ерөнхий Сайд

КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА НАР



А.АРИУНЗАЯА
Үндэсний Статистикийн Хорооны дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга

КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА НАР



Н.ЦЭРЭНБАТ
Байгаль орчин, аялал
жуулчлалын сайд



Х.БАДЕЛХАН
Барилга, хот
байгуулалтын сайд



Н.ЭНХБОЛД
Батлан хамгаалахын
сайд



Ё.БААТАРБИЛЭГ
Боловсрол, соёл, шинжлэх
ухаан, спортын сайд



Д.ЦОГТБААТАР
Гадаад харилцааны
сайд



Б.ЭНХ-АМГАЛАН
Зам, тээврийн
хөгжлийн сайд



Ч.ХҮРЭЛБААТАР
Сангийн сайд



Д.СУМЪЯАБАЗАР
Уул уурхай, хүнд
үйлдвэрийн сайд



С.ЧИНЗОРИГ
Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд



Ц.НЯМДОРЖ
Хууль зүй, дотоод
хэргийн сайд



Ч.УЛААН
Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн сайд



Ц.ДАВААСҮРЭН
Эрчим хүчний сайд



Д.САРАНГЭРЭЛ
Эрүүл мэндийн сайд



С.АМАРСАЙХАН
Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын
захирагч, Нийслэлийн тооллогын комиссын дарга

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



А.АМАРБАЛ
ҮСХ-ны Хүн ам, нийгмийн
статистикийн газрын дарга

КОМИССЫН ДАРГА НАР



С.АМАРСАЙХАН
Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн тооллогын комиссын дарга



Ц.МӨНХНАСАН
Архангай аймгийн Засаг дарга



А.ГЫЛЫМХАН
Баян-Өлгий аймгийн Засаг дарга



Г.БАТЖАРГАЛ
Баянхонгор аймгийн Засаг дарга



З.БАТЗОРИГ
Булган аймгийн Засаг дарга



В. РЭНЦЭНДОРЖ
Говь-Алтай аймгийн Засаг дарга



Г.БАТСУУРЬ
Говьсүмбэр аймгийн Засаг дарга



С.НАСАНБАТ
Дархан-Уул аймгийн Засаг дарга



Т.ЭНХТҮВШИН
Дорноговь аймгийн Засаг дарга



М.БАДАМСҮРЭН
Дорнод аймгийн Засаг дарга



О.БАТ-ЭРДЭНЭ
Дундговь аймгийн Засаг дарга



Д.БАТСАЙХАН
Завхан аймгийн Засаг дарга



Д.БАТЛУТ
Орхон аймгийн Засаг дарга



Г.ГАНБОЛД
Өвөрхангай аймгийн Засаг дарга



Н.НАРАНБААТАР
Өмнөговь аймгийн Засаг дарга



Ж.ЭРДЭНЭБААТАР
Сүхбаатар аймгийн Засаг дарга



Ш.ОРГИЛ
Сэлэнгэ аймгийн Засаг дарга



О.БАТЖАРГАЛ
Төв аймгийн Засаг дарга



Д.БАТСАЙХАН
Увс аймгийн Засаг дарга



Б.ДҮГЭРЖАВ
Ховд аймгийн Засаг дарга



Л.ГАНБОЛД
Хөвсгөл аймгийн Засаг дарга




Н.ГАНБЯМБА
Хэнтий аймгийн Засаг дарга

ЗУРАГ 1.1. ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ



ХҮН АМЫН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын харьяат хүн ам 3 296 866 боллоо. Монгол Улсын хүн ам 2020 онд 1918 оноос 5 дахин, 2010 оноос хойш жилд дунджаар 2.2 хувиар өсжээ. Монгол Улсын суурин хүн ам 3 197 020, гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа хүн амын тоо 122 301 болсон. Харин Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат хүн 22 418, харьяалалгүй 37 хүн байна(Зураг 2.1).

ЗУРАГ 2.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр Монгол Улсын харьяат хүн амын тоо 3 296.9 мянга байгаа нь 2010-2020 оны хооронд буюу 10 жилийн хугацаанд 542.2 мянган хүнээр өсжээ. Монгол Улсын хүн амын 49.1 хувь нь эрэгтэйчүүд, 50.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 96.6 болж, өмнөх тооллогын түвшнээс 1.5 пунктээр буурав (Хүснэгт 2.1). Хүйсийн харьцаа 1979 оны хүн амын тооллогоор 100.4 байснаа тогтмол буурсаар 2010 онд 98.1, 2020 онд 96.6 болсон нь нийт хүн амд эзлэх эмэгтэйчүүдийн хувь илүү байгааг илэрхийлж байна.


ХҮСНЭГТ 2.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР

Тооллого явагдсан он	Хүн амын тоо (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1918	647.5	330.2	317.3	104.1
1935	738.2	370.8	367.4	100.9
1944	759.1	371.3	387.8	95.7
1956	845.5	420.3	425.2	98.8
1963	1 017.1	508.0	509.1	99.8
1969	1 197.6	597.4	600.2	99.5
1979	1 595.0	798.9	796.1	100.4
1989	2 044.0	1 020.7	1 023.3	99.7
2000	2 373.5	1 178.0	1 195.5	98.5
2010	2 754.7	1 363.9	1 390.8	98.1
2020	3 296.9	1 619.6	1 677.3	96.6

ХҮН АМЫН ӨСӨЛТ

Хүн амын тооны өөрчлөлтийг цэвэр өсөлт (төрөлт, нас баралтын зөрүү) болон механик өсөлт(цэвэр шилжих хөдөлгөөн)-өөр тодорхойлдог. Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамаардаг. Хүн ам 1989-2000 оны хооронд 329.5 мянган хүнээр буюу жилд дунджаар 1.4 хувиар, 2000-2010 оны хооронд 381.2 мянган хүнээр буюу жилд дунджаар 1.5 хувиар, 2010-2020 оны хооронд 542.2 мянган хүнээр буюу жилд дунджаар 2.2 хувиар тус тус өсжээ. 1990-ээд оны эхэн үеэс хойш төрөлтийн түвшин буурч байгаад 2006 оноос төрөлт нэмэгдэн 2014 онд 82 839 хүүхэд шинээр мэндэлсэн нь төрөлтийн хамгийн өндөр түвшинд хүрсэн он байлаа. Тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт 1.4-2.2-д хүрсэн бөгөөд энэ өсөлтөд 2000-2010 оны нөхөн үржихүйн насны хүн амын эзлэх хувь их байсан нь нөлөөлсөн. Тухайн үеийн нөхөн үржихүйн насны хүн амын тоо өндөр байгаа нь 1970-1990 оны хоорондох төрөлтийн өндөр түвшинтэй шууд холбоотой юм.

ЗУРАГ 2.2. ХҮН АМЫН 1918-2020 ОНЫ ТООЛЛОГО ХООРОНДЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, ХУВИАР



ХҮСНЭГТ 2.2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2010-2020 ОН

Он	Ерөнхий коэффициент		
	Төрөлт	Нас баралт	Цэвэр өсөлт
2010	23.1	6.7	16.4
2011	25.1	6.9	18.2
2012	26.0	6.3	19.7
2013	27.5	5.9	21.6
2014	28.0	5.6	22.4
2015	27.1	5.8	21.3
2016	25.9	5.8	20.1
2017	23.9	5.5	18.4
2018	24.5	5.6	18.9
2020	24.4	5.6	18.7

Сүүлийн 10 жилд бүх аймаг, нийслэлийн хүн ам жилд дунджаар 0.9-өөс 3.9 хувиар өссөн нь төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой. 1989 оноос хойших аймаг, нийслэлийн хүн амын өсөлт эрс ялгаатай болсон байна. Харин 2000-2010 онд нийслэл, 5 аймгийн хүн амын тоо өсөж, бусад аймгуудад буурсан байжээ (Хүснэгт 2.3). Түүнчлэн 2000-2010 онд Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаас их байсан нь нийслэл, суурин газарт чиглэсэн шилжих хөдөлгөөн өндөр байсантай холбоотой.

2020 оны тооллогын дүнгээр Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Баян-Өлгий, Говьсүмбэр аймаг болон Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаас 0.2-1.7 пунктээр өндөр байна.

ХҮСНЭГТ 2.3. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ХУВИАР, 1989-2000, 2000-2010, 2010-2020 ОН


Аймаг, нийслэл	2000/1989	2010/2000	2020/2010	Жилийн дундаж өсөлт %		
	(%)	(%)	(%)	1989-2000	2000-2010	2010-2020
БҮГД	116.1	116.1	119.7	1.4	1.5	2.2
Архангай	114.9	87.1	112.3	1.3	-1.2	1.4
Баян-Өлгий	100.2	96.7	123.3	0.0	-0.3	2.6
Баянхонгор	113.7	89.7	116.5	1.2	-0.9	1.8
Булган	119.0	86.9	115.7	1.6	-1.2	1.7
Говь-Алтай	101.4	84.2	107.8	0.1	-1.4	0.9
Дорноговь	88.6	115.9	121.2	-1.1	1.4	2.4
Дорнод	93.0	92.3	118.0	-0.7	-0.7	2.0
Дундговь	104.5	75.4	121.3	0.4	-2.2	2.4
Завхан	101.7	72.8	111.2	0.2	-2.5	1.2
Өвөрхангай	115.4	90.9	115.2	1.3	-0.8	1.7
Өмнөговь	110.4	130.9	112.8	0.9	2.8	1.4
Сүхбаатар	110.5	91.4	123.1	0.9	-0.8	2.6
Сэлэнгэ	114.9	97.6	112.8	1.3	-0.2	1.4
Төв	99.2	85.8	110.7	-0.1	-1.3	1.2
Увс	107.2	81.4	113.5	0.6	-1.7	1.5
Ховд	113.4	88.5	116.7	1.2	-1.0	1.9
Хөвсгөл	116.9	96.5	117.5	1.4	-0.3	1.9
Хэнтий	96.1	92.8	118.5	-0.4	-0.7	2.1
Дархан-Уул	97.1	113.6	113.1	-0.3	1.2	1.5
Орхон	127.4	126.8	118.7	2.2	2.4	2.1
Говьсүмбэр	-	108.3	135.4	-	0.8	3.9
Улаанбаатар	138.6	163.1	124.2	3.0	5.7	2.7

ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын насны бүтэц нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоор ихээхэн ач холбогдолтой юм. Хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах шаардлагатай байдаг.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшнээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран үе үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг. Нөгөө талаар хүн амын төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний чиг хандлага ч насны бүтцээс хамааралтай байдаг. Тухайлбал, хүн амын насны бүтэц идэрших хандлагатай болоход (нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь нэмэгдэх үйл явц) цаашид хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэй хүний онцлогийг харгалзан ямар төрлийн ажлын байр илүү хэрэгцээтэй болохыг тохируулах шаардлага гардаг.

ЗУРАГ 2.3. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 1989, 2000, 2010, 2020 ОН



Нийт хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин өмнөх тооллогоос 4.2 пунктээр өссөн нь төрөлт нэмэгдсэнийг харуулж байна (Зураг 2.3). Мөн 65, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийн жин 2000 оноос 0.6 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 2.4. ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010			2020			Хүйсийн харьцаа*	
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2020
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	98.1	96.6
0-4	10.6	10.9	10.4	11.7	12.2	11.2	103.2	105.5
5-9	8.0	8.2	7.7	11.3	11.8	10.8	103.8	104.7
10-14	8.7	8.9	8.5	8.5	8.8	8.2	102.8	104.2
15-19	9.7	9.9	9.5	6.8	7.0	6.5	102.4	103.5
20-24	11.3	11.5	11.2	7.3	7.5	7.1	101.7	101.9
25-29	9.8	9.9	9.7	8.4	8.6	8.2	100.4	100.9
30-34	8.7	8.8	8.6	9.3	9.4	9.1	99.6	99.2
35-39	7.8	7.8	7.8	7.6	7.6	7.6	97.7	97.3
40-44	6.8	6.7	6.9	6.8	6.7	6.9	95.9	94.5
45-49	5.9	5.8	6.0	6.0	5.8	6.2	94.4	91.3
50-54	4.5	4.3	4.7	5.0	4.7	5.3	90.1	86.0
55-59	2.7	2.5	2.8	4.3	4.0	4.7	86.2	81.9
60-64	1.8	1.6	2.0	2.9	2.6	3.3	80.7	75.7
65-69	1.4	1.3	1.5	1.7	1.4	1.9	82.2	69.4
70+	2.3	1.9	2.7	2.4	1.9	3.0	66.8	60.7

Тайлбар: * 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо


Нийт хүн амд 0-9 насны бүлгийн хүн амын эзлэх хувийн жин 2010 онд 18.6 байсан бол 2020 онд 23.0 болж, 4.4 пунктээр өссөн. Харин 15-29 насны бүлгийн хүн амын хувийн жин 2010 онд 30.8 байсан бол 2020 онд 22.5 болж 8.3 пунктээр буурсан нь 1990-ээд оны эхэн үеэс 2006 он хүртэлх төрөлтийн түвшин бага байсныг харуулна.

Төрөх үеийн хүйсийн харьцаа дэлхийн бусад улс орнуудын адил сүүлийн 10 жилийн хугацаанд дунджаар 105 байна. Сүүлийн 2 тооллогын дүнгээс харвал хүн амын хүйсийн харьцаа насны бүлэг ахих тусам буурч байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралтын түвшинтэй холбоотой юм.

Хүн амын нас, хүйсийн бүтцийг илүү тодорхой харуулах дүрслэл бол нас, хүйсийн суварга юм.

Хүн амын нас, хүйсийн 2020 оны суваргаас харахад дунд хэсгээрээ аажмаар өргөсөж байгаа нь хүн ам идэршиж байгааг харуулж байна. Хүн амын ердийн хөдөлгөөний өөрчлөлтөөс шалтгаалан 30-аас доош насанд суваргын хэлбэр өөрчлөгджээ. 2020 оны суваргын 15-24 насны бүлгийн хүн амын хэсгээр нарийссан байгаа нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин буурсныг, 0-9 насанд суваргын суурь өргөн болсон нь сүүлийн жилүүдэд төрөлтийн түвшин нэмэгдсэнийг илэрхийлж байна.

ЗУРАГ 2.4. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



Мөн сүүлийн 10 жилийн төрөлт өндөр байснаас шалтгаалан нийт хүн амд хүүхдүүд (0-17 насны хүн ам)-ийн эзлэх хувь 27.3-аас 31.5 болж нэмэгдсэн. Энэ нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хэрэгцээг нэмэгдүүлсэн, цаашдаа ерөнхий боловсролын сургууль, цаашлаад мэргэжлийн боловсрол, дээд боловсрол олгох байгууллага, ажлын байрны хэрэгцээг нэмэгдүүлэх нь тодорхой юм.

Аймаг, нийслэлийн 2020 оны хүн амын хүйсийн харьцаа Орхон аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 0.2-3.8 пунктээр бага, Дархан-Уул аймагт ижил түвшинд, бусад аймгуудад улсын дунджаас 0.1-8.7 пунктээр дээгүүр байна.

ХҮСНЭГТ 2.5. ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН

Аймаг, нийслэл	2010			2020			Хүйсийн харьцаа	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2020
БҮГД	2 754 685	1 363 923	1 390 762	3 296 866	1 619 573	1 677 293	98.1	96.6
Архангай	84 584	42 219	42 365	94 994	47 641	47 353	99.7	100.6
Баян-Өлгий	88 056	44 127	43 929	108 530	54 196	54 334	100.5	99.7
Баянхонгор	76 085	38 237	37 848	88 672	43 603	45 069	101.0	96.7
Булган	53 655	27 623	26 032	62 089	31 494	30 595	106.1	102.9
Говь-Алтай	53 590	26 830	26 760	57 748	28 775	28 973	100.3	99.3
Дорноговь	58 612	29 537	29 075	71 014	35 527	35 487	101.6	100.1
Дорнод	69 552	35 134	34 418	82 054	40 971	41 083	102.1	99.7
Дундговь	38 821	19 727	19 094	47 104	23 669	23 435	103.3	101.0
Завхан	65 481	32 916	32 565	72 823	36 353	36 470	101.1	99.7
Өвөрхангай	101 314	50 879	50 435	116 732	58 157	58 575	100.9	99.3
Өмнөговь	61 314	35 137	26 177	69 187	34 653	34 534	134.2	100.3
Сүхбаатар	51 334	26 165	25 169	63 182	31 732	31 450	104.0	100.9
Сэлэнгэ	97 584	49 625	47 959	110 110	55 857	54 253	103.5	103.0
Төв	85 166	44 394	40 772	94 250	48 332	45 918	108.9	105.3
Увс	73 328	37 049	36 279	83 223	41 788	41 435	102.1	100.9
Ховд	76 870	38 366	38 504	89 712	44 833	44 879	99.6	99.9
Хөвсгөл	114 926	57 193	57 733	135 095	66 977	68 118	99.1	98.3
Хэнтий	65 811	33 633	32 178	77 957	39 378	38 579	104.5	102.1
Дархан-Уул	94 625	46 491	48 134	107 018	52 578	54 440	96.6	96.6
Орхон	90 700	44 488	46 212	107 634	52 838	54 796	96.3	96.4
Говьсүмбэр	13 240	6 816	6 424	17 928	9 027	8 901	106.1	101.4
Улаанбаатар	1 240 037	597 337	642 700	1 539 810	741 194	798 616	92.9	92.8

Хот, хөдөөд хүн амын хүйсийн харьцаа ялгаатай байгаа бөгөөд хотод эмэгтэйчүүд илүү, хөдөөд эрэгтэйчүүд илүү суурьшиж байна.

ХҮСНЭГТ 2.6. ХҮН АМЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР, 2010, 2020 ОН

Хот, хөдөө	2010			2020		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
Улсын дундаж	1 313 968	1 333 577	98.1	1 619 573	1 677 293	96.6
Хот	915 799	975 953	94.0	1 091 283	1 167 698	93.5
Хөдөө	448 124	414 809	108.0	528 290	509 595	103.7

Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа зааг насыг “Голч нас” гэдэг. Өөрөөр хэлбэл, 2020 онд голч нас 27.9 болсон нь хүн амын тэн хагас нь 27.9-өөс доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна гэсэн үг юм. Сүүлийн 30 жилд хүн амын голч нас бараг 10 жилээр хойшилсон нь төрөлтийн түвшин буурснаас гадна хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаатай холбоотой (Хүснэгт 2.7).

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн тодорхой ач холбогдолтой үзүүлэлт болох хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцаагаар илэрхийлдэг. Хүн амын төрөлтийн түвшин өндөр байснаас шалтгаалан 1989 онд хүн ам зүйн ачаалал их байжээ. Тэгвэл 2020 онд хүн ам зүйн ачаалал 55.3 болж 1989 оноос 29.6 пунктээр буурч, 2010 оноос 10.3 пунктээр өсжээ.


ХҮСНЭГТ 2.7. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ЗАРИМ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 1989, 2000, 2010, 2020 ОН

Үзүүлэлтүүд	1989	2000	2010	2020
Голч нас (жилээр)	18.8	21.6	25.8	27.9
Хүн ам зүйн ачаалал	84.9	64.6	45.0	55.3
Үүнээс:				
Хүүхэд	77.4	58.9	39.6	48.9
Хөгшид	7.5	5.7	5.4	6.4
Хөгшрөлтийн индекс	9.7	9.7	13.6	13.1

УЛСЫН ХАРЬЯАЛАЛ, ҮНДЭС, УГСАА, ШАШИН



МОНГОЛД СУУГАА МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ

3 174 565



МОНГОЛД СУУГАА ГАДААДЫН ХАРЬЯАТ


22 418



ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 99.3 хувь нь Монгол Улсын харьяат, 0.7 хувь нь гадаадын харьяат иргэн байна. Аль нэг улсын харьяалалгүй 37 хүн байна.

ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ТОО, ИРГЭНИЙ ХАРЬААЛЛААР, 2020 ОН



Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоо³ 3 197.0 мянга боллоо.

Хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэйн тоо) 2010-2020 оны хооронд Улаанбаатар хот болон Орхон, Ховд, Архангай аймагт 0.2-1.0 пунктийн өсөлттэй байгаа бол Дархан-Уул аймагт ямар нэгэн өөрчлөлтгүй бусад аймгуудад 0.5-30.6 пунктийн бууралттай байна (Хүснэгт 3.1).

ХҮСНЭГТ 3.1. МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН

Аймаг, нийслэл	2010			2020			Хүйсийн харьцаа	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2020
БҮГД	2 647 545	1 313 968	1 333 577	3 197 020	1 576 930	1 620 090	98.5	97.3
Архангай	84 078	41 943	42 135	94 324	47 272	47 052	99.5	100.5
Баян-Өлгий	85 232	42 655	42 577	103 908	51 855	52 053	100.2	99.6
Баянхонгор	75 690	38 023	37 667	88 008	43 215	44 793	100.9	96.5
Булган	53 065	27 325	25 740	61 344	31 146	30 198	106.2	103.1
Говь-Алтай	53 223	26 602	26 621	57 479	28 649	28 830	99.9	99.4
Дорноговь	57 930	29 230	28 700	69 859	35 046	34 813	101.8	100.7
Дорнод	68 873	34 796	34 077	82 020	41 322	40 698	102.1	101.5
Дундговь	38 543	19 578	18 965	46 698	23 478	23 220	103.2	101.1
Завхан	64 924	32 544	32 380	72 307	36 032	36 275	100.5	99.3
Өвөрхангай	100 444	50 333	50 111	115 737	57 599	58 138	100.4	99.1
Өмнөговь	60 855	34 884	25 971	69 858	35 568	34 290	134.3	103.7
Сүхбаатар	51 091	26 059	25 032	62 884	31 603	31 281	104.1	101.0
Сэлэнгэ	95 804	48 756	47 048	107 755	54 706	53 049	103.6	103.1
Төв	83 838	43 751	40 087	92 409	47 447	44 962	109.1	105.5
Увс	72 906	36 829	36 077	82 941	41 625	41 316	102.1	100.7
Ховд	76 252	38 006	38 246	88 078	44 017	44 061	99.4	99.9
Хөвсгөл	114 331	56 899	57 432	134 318	66 604	67 714	99.1	98.4
Хэнтий	65 335	33 399	31 936	77 320	39 085	38 235	104.6	102.2
Дархан-Уул	90 642	44 556	46 086	102 171	50 234	51 937	96.7	96.7
Орхон	87 118	42 813	44 305	104 032	51 176	52 856	96.6	96.8
Говьсүмбэр	13 081	6 740	6 341	17 445	8 796	8 649	106.3	101.7
Улаанбаатар	1 154 290	558 247	596 043	1 466 125	710 455	755 670	93.7	94.0

3 Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар) оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд, гадаадын харьяат болон харьяалалгүй иргэдийг хэлнэ.

ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг нэлээн өргөжүүлэн судаллаа. Тооллогын үр дүнгийн танилцуулгад бүлэгт 100-аас цөөн хүн амтай үндэс, угсааны бүлгийг “Бусад” гэж нэгтгэсэн болно. Монгол Улсын харьяат суурин хүн амын 83.8 хувийг Халхууд эзэлж, өмнөх тооллогоос 1.4 пунктээр өссөн байна. Казахуудын нийт хүн амд эзлэх хувийн жин 3.8 хувь байгаа нь Халхдын дараа орж байна. Харин Дөрвөд, Баяд, Буриад угсаатнуудын нийт хүн амд эзлэх хувь 2010 оноос буурсан байна.

ХҮСНЭГТ 3.2. ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС, УГСАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Үндэс, угсаа	2010*		2020*	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ-БҮГД	2 631 117	100.0	3 174 565	100.0
Халх	2 168 141	82.4	2 659 985	83.8
Казах	101 526	3.9	120 999	3.8
Дөрвөд	72 403	2.8	83 719	2.6
Баяд	56 573	2.2	63 775	2.0
Буриад	45087	1.7	43 661	1.4
Захчин	32 845	1.2	37 407	1.2
Дарьганга	27 412	1.0	36 419	1.1
Урианхай	26 654	1.0	29 021	0.9
Дархад	21 558	0.8	24 549	0.8
Өөлд	15 520	0.6	14 666	0.5
Хотгойд	15 460	0.6	8 583	0.3
Торгууд	14 176	0.5	15 596	0.5
Хотон	11 304	0.4	12 057	0.4
Мянгад	6 592	0.3	8 125	0.2
Тува	5 169	0.2	2 354	0.1
Барга	2 989	0.1	2 832	0.1
Үзэмчин	2 577	0.1	2 308	0.1
Элжигэн	1 340	0.1	1 034	0.0
Сартуул	1 286	0.0	2 023	0.1
Хамниган	537	0.0	384	0.0
Цаатан(Духа)	282	0.0	208	0.0
Узбек (Чантуу)	260	0.0	202	0.0
Харчин	152	0.0	154	0.0
Цахар	132	0.0	11	0.0
Хошууд	-	-	382	0.0
Бусад	601	0.0	132	0.0
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	541	0.0	3 979	0.1

Тайлбар: * Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй

Хотгойд, Тува, Цаатан (Духа), Хошуудын дунд 0-14 настай хүүхдийн эзлэх хувийн жин 60 хувиас өндөр байгаа нь тэдний дунд төрөлт өндөр байгаатай холбоотой юм. Харин Буриад, Дарьганга, Үзэмчин, Сартуул, Хамниган, Харчинуудын дунд 45, түүнээс дээш настай хүний эзлэх хувийн жин 25 хувиас илүү байгаа нь насжилтыг илэрхийлж байна.

ХҮСНЭГТ 3.3. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Үндэс, угсаа	Бүгд	Насны бүлэг					
		0-14	15-24	25-34	35-44	45-54	55+
МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТ-БҮГД	100.0	32.2	13.8	17.1	14.2	11.0	11.7
Халх	100.0	32.4	13.6	17.1	14.3	11.0	11.6
Казах	100.0	35.9	17.1	16.7	12.2	9.1	9.0
Дөрвөд	100.0	29.8	14.5	17.8	14.1	11.9	11.9
Баяд	100.0	29.6	14.4	17.7	13.9	11.7	12.7
Буриад	100.0	27.4	11.8	17.4	14.4	12.0	17.0
Захчин	100.0	29.8	15.7	17.5	14.0	10.6	12.4
Дарьганга	100.0	22.9	12.1	19.5	16.6	13.2	15.7
Урианхай	100.0	29.1	14.6	17.7	13.8	11.7	13.1
Дархад	100.0	30.4	15.7	18.3	13.2	11.1	11.3
Өөлд	100.0	30.3	14.0	16.1	14.0	11.9	13.7
Хотгойд	100.0	71.5	13.4	4.5	3.8	3.3	3.5
Торгууд	100.0	28.6	12.9	17.9	14.7	11.3	14.6
Хотон	100.0	39.9	17.4	14.9	10.3	9.1	8.4
Мянгад	100.0	28.7	18.4	16.0	15.5	10.7	10.7
Тува	100.0	65.6	13.4	7.1	4.7	4.3	4.9
Барга	100.0	29.3	8.5	23.9	13.8	10.3	14.2
Үзэмчин	100.0	27.4	11.8	20.2	11.8	12.2	16.6
Элжигэн	100.0	31.5	16.9	12.9	14.8	13.1	10.8
Сартуул	100.0	19.8	14.1	18.0	18.2	13.8	16.1
Хамниган	100.0	18.7	17.7	18.8	14.6	13.0	17.2
Цаатан (Духа)	100.0	75.0	14.4	1.5	1.9	4.3	2.9
Узбек (Чантуу)	100.0	25.7	17.3	21.3	15.4	8.4	11.9
Харчин	100.0	46.8	13.6	3.9	7.8	7.8	20.1
Хошууд	100.0	71.5	14.6	3.7	3.9	3.4	2.9
Бусад	100.0	23.1	9.1	14.0	17.4	14.7	21.7
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	100.0	20.2	16.1	21.7	15.2	12.4	14.4

Байршлын хувьд Халхууд бүх аймаг, нийслэлд оршин сууж байна. Тухайн аймгийн нийт хүн амд эзлэх хувиар Баян-Өлгий (0.9 хувь), Увс (13.6 хувь), Ховд (28.1 хувь) аймагт бага байна. Харин Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай аймгуудад нийт хүн амын 99-өөс дээш хувь нь Халхууд байна. Олон угсаатны өлгий нутаг Ховд аймгийн нийт хүн амын дотор Халх 28.1 хувь, Захчин 25.3 хувь, Казах 11.2 хувь, Урианхай 8.3 хувь, Торгууд 7.4 хувь, Дөрвөд 6.5 хувь, Өөлд 6.1 хувь, Мянгад 5.3 хувь байгаа нь бусад аймгаас онцлог юм. Бүс нутгаар үзэхэд Баруун бүсийн нийт хүн амын дотор Халх 41.0 хувь, Казах 25.8 хувь, Дөрвөд 10.4 хувь, Баяд 7.1 хувь, Захчин 5.6 хувийг эзэлж байна. Казахуудын 77.7 хувь нь Баян-Өлгий аймагт, Дөрвөдүүдийн 41.8 хувь, Баядуудын 44.3 хувь, Хотон 47.9 хувь, Элжигэн 86.7 хувь нь Увс аймагт оршин сууж байна.

Харин Хангайн бүсийн нийт хүн амын дотор Халх 91.8 хувь, Дархад 3.5 хувь, Хотгойд 1.3 хувийг эзэлж байгаа бөгөөд Хотгойдуудын 85.4 хувь, Дархаддуудын 81.2 хувь нь Хөвсгөл аймагт оршин сууж байна. Төвийн бүсийн нийт хүн амын дотор Халх 91.6 хувь, Баяд 1.9 хувь, Дөрвөд 1.8 хувийг эзэлж байна. Зүүн бүсийн нийт хүн амын дотор Халх 73.8 хувь, Дарьганга 12.1 хувь, Буриад 10.2 хувийг эзэлж байна. Дарьгангачуудын 67.2 хувь, Үзэмчингүүдийн 7.0 хувь Сүхбаатар аймагт оршин сууж байна. Мөн Дорнод аймгийн нийт хүн амын 2.3 хувь Барга, 2.1 хувь Үзэмчингүүд байгаа нь эдгээр угсаатны хамгийн олноороо оршин суудаг аймаг бөгөөд тухайн угсаатны бүлгийн 67.3 ба 73.7 хувийг тус тус төлөөлж байна. /Хавсралт В-ийн Хүснэгт 3.6-аас харна уу./

Нийт хүн амд өндөр хувийн жин эзлэх угсаатны бүлэгт Халх, Казах, Дөрвөд, Баяд, Буриаддууд орж байна.

ЗУРАГ 3.2. ХҮН АМ, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2020 ОН




ЗУРАГ 3.3. КАЗАХ УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН




Казахууд Баян-Өлгий, Ховд, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотод ихэвчлэн оршин сууж байна.

ЗУРАГ 3.4. ДӨРВӨД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН




Дөрвөд угсаатнууд 41.8 хувь нь Увс аймагт, 34.3 хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байгаа бөгөөд бүх аймагт тархан суурьшсан байна.

ЗУРАГ 3.5. БАЯД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Баядуудын 44.3 хувь нь Увс аймагт, 33.9 хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байгаагаас гадна Орхон, Булган, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгуудаар суурьшсан байна.


ЗУРАГ 3.6. БУРИАД УГСААТНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Буриаддуудын 38.7 хувь нь Дорнод, 37.5 хувь нь Улаанбаатар, 12.6 хувь нь Хэнтий аймагт оршин сууж байна. Мөн Буриаддууд Монгол орны хойд хэсгийн аймгууд болох Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Хэнтий, Дорнод аймгуудаар ихээхэн суурьшсан байна.

Дархад, Тува, Хотгойд, Узбек (Чантуу), Хамниган, Элжигэн, Хошууд, Цаатан (Духа) угсаатны бүлэгт хамаарах иргэд гол төлөв хөдөө суурьшиж байгааг дараах зургаас харж болно.

ЗУРАГ 3.7. ХҮН АМ, ҮНДЭС, УГСАА, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



ХҮСНЭГТ 3.4. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Үндэс, угсаа	10, түүнээс дээш насны хүн ам	Боловсролын түвшин						Боловсролгүй
		Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник мэргэжлийн дунд	Бүрэн дунд	Суурь	Бага	
МОНГОЛ УЛСЫН ХАРЬАТ-БҮГД	100.0	26.5	4.7	3.9	29.2	17.1	13.7	4.9
Халх	100.0	27.1	4.7	3.8	29.8	16.6	13.2	4.8
Казах	100.0	21.2	3.2	4.2	22.3	21.7	20.4	7.0
Дөрвөд	100.0	24.7	4.7	4.6	28.6	18.3	13.9	5.2
Баяд	100.0	26.9	4.6	3.9	27.0	17.7	14.7	5.2
Буриад	100.0	28.1	5.8	4.0	29.5	18.2	10.6	3.8
Захчин	100.0	24.5	4.8	3.6	29.5	18.6	13.9	5.1
Дарьганга	100.0	24.7	6.1	6.4	24.6	20.7	12.9	4.6
Урианхай	100.0	19.9	4.1	4.3	29.6	21.1	15.7	5.3
Дархад	100.0	14.3	2.5	2.4	24.5	22.8	25.3	8.2
Өөлд	100.0	32.0	5.5	3.5	27.8	14.7	12.3	4.2
Хотгойд	100.0	7.9	2.0	2.2	12.0	20.0	38.8	17.1
Торгууд	100.0	28.9	6.3	3.9	29.9	14.9	12.0	4.1
Хотон	100.0	12.9	2.7	7.5	21.2	23.8	23.2	8.7
Мянгад	100.0	23.4	4.8	4.5	29.9	20.1	12.3	5.0
Тува	100.0	11.5	2.9	7.2	15.8	22.2	30.1	10.3
Барга	100.0	20.8	5.7	6.4	26.6	21.8	13.1	5.6
Үзэмчин	100.0	18.7	4.3	7.0	25.1	24.2	15.6	5.1
Элжигэн	100.0	19.6	3.8	6.5	25.7	18.8	15.5	10.1
Сартуул	100.0	24.2	5.8	5.4	30.2	17.1	12.7	4.6
Хамниган	100.0	12.9	2.6	3.7	28.0	27.7	20.3	4.8
Цаатан (Духа)	100.0	4.9	2.0	0.0	17.6	19.6	30.4	25.5
Узбек (Чантуу)	100.0	14.3	1.7	2.3	27.4	21.7	22.3	10.3
Харчин	100.0	27.8	3.5	2.6	19.1	15.7	20.9	10.4
Хошууд	100.0	3.9	3.0	2.0	13.3	23.6	39.4	14.8
Бусад	100.0	31.8	5.3	2.3	28.8	15.2	12.1	4.5
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	100.0	17.8	3.3	4.2	27.0	20.6	20.1	7.0

Баяд, Халх, Харчин, Буриад, Торгууд, Өөлд болон бусад угсаатнуудын боловсролын түвшин улсын дунджаас 0.4-5.5 пунктээр их байгаа бол бусад угсаатнуудын хувьд улсын дунджаас 1.8-22.6 пунктээр бага байгааг дээд боловсрол эзэмшсэн хүн амын эзлэх хувийн жингээс харж болно.

ХҮСНЭГТ 3.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Үндэс, угсаа	Хөдөлмөр эрхэлдэг хүн ам	Байнгын ажиллагч	Түр ажиллагч	Тохиолдлын ажиллагч	Дагалдан, мэргэшиж буй дадлагажигч	Гүйцэтгэх гэрээлэгч
МОНГОЛ УЛСЫН ХАРЬАТ-БҮГД	100.0	60.3	5.3	1.0	0.0	0.5
Халх	100.0	61.5	5.5	1.0	0.0	0.5
Казах	100.0	49.3	2.7	0.9	0.0	0.2
Дөрвөд	100.0	57.9	5.4	0.8	0.0	0.5
Баяд	100.0	53.8	4.9	0.6	0.0	0.4
Буриад	100.0	60.5	6.0	1.0	0.0	0.5
Захчин	100.0	57.6	4.5	0.8	0.0	0.3
Дарьганга	100.0	52.5	3.9	0.4	0.0	0.4
Урианхай	100.0	53.6	4.0	1.1	0.0	0.4
Дархад	100.0	33.2	2.7	0.6	0.0	0.3
Өөлд	100.0	62.6	5.5	0.7	0.0	0.5
Хотгойд	100.0	34.5	4.4	0.5	0.0	0.1
Торгууд	100.0	66.4	5.4	0.8	0.0	0.4
Хотон	100.0	39.7	4.0	0.8	0.0	0.5
Мянгад	100.0	57.5	5.4	0.7	0.0	0.5
Тува	100.0	42.9	6.5	0.7	0.0	0.5
Барга	100.0	54.1	4.5	1.1	0.1	0.5
Үзэмчин	100.0	58.9	3.6	0.7	0.0	1.1
Элжигэн	100.0	33.6	4.0	0.0	0.0	0.0
Сартуул	100.0	60.3	6.3	1.2	0.0	0.5
Хамниган	100.0	39.6	2.8	0.0	0.0	0.0
Цаатан (Духа)	100.0	28.6	0.0	7.1	0.0	0.0
Узбек (Чантуу)	100.0	33.3	4.2	1.4	0.0	0.0
Харчин	100.0	71.4	14.3	0.0	0.0	0.0
Хошууд	100.0	22.0	6.0	2.0	0.0	0.0
Бусад	100.0	55.8	1.9	0.0	0.0	1.9
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	100.0	46.6	4.1	0.5	0.0	0.4

ХҮСНЭГТ 3.5.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН /ҮРГЭЛЖЛЭЛ/

Үндэс, угсаа	ААНБ-ын ажил олгогч	Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	Өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч	Хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүн
МОНГОЛ УЛСЫН ХАРЬАТ-БҮГД	0.4	0.2	0.3	26.1	5.9
Халх	0.5	0.2	0.3	25.2	5.3
Казах	0.2	0.1	0.2	33.6	12.8
Дөрвөд	0.3	0.2	0.2	27.9	6.8
Баяд	0.4	0.2	0.2	31.7	7.8
Буриад	0.4	0.2	0.3	27.5	3.6
Захчин	0.2	0.1	0.6	30.1	5.8
Дарьганга	0.3	0.2	0.2	27.9	14.2
Урианхай	0.2	0.2	0.3	32.0	8.2
Дархад	0.1	0.1	0.1	40.2	22.7
Өөлд	0.5	0.1	0.2	22.2	7.7
Хотгойд	0.2	0.2	0.0	38.2	21.9
Торгууд	0.4	0.2	0.2	20.6	5.6
Хотон	0.1	0.1	0.2	43.2	11.4
Мянгад	0.2	0.2	0.3	30.2	5.0
Тува	0.0	0.0	0.0	38.3	11.1
Барга	0.4	0.1	0.4	30.9	7.9
Үзэмчин	0.3	0.4	0.1	29.4	5.5
Элжигэн	0.2	0.0	0.0	43.6	18.6
Сартуул	0.2	0.4	0.0	27.8	3.3
Хамниган	0.0	0.7	0.7	54.8	1.4
Цаатан (Духа)	0.0	0.0	0.0	50.0	14.3
Узбек (Чантуу)	1.4	1.4	0.0	54.2	4.1
Харчин	0.0	0.0	0.0	14.3	0.0
Хошууд	0.0	0.0	2.0	56.0	12.0
Бусад	0.0	0.0	0.0	34.6	5.8
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	0.5	0.1	0.1	42.0	5.7

Үндэс, угсааг, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар ангилж үзвэл Хошууд, Цаатан (Духа), Дархад, Элжигэн, Узбек (Чантуу), Хотгойдуудын дунд цалин хөлстэй хөдөлмөр эрхлэлт (байнгын ажиллагч, түр ажиллагч, тохиолдлын ажиллагч, дагалдан мэргэшиж буй дадлагажигч, гүйцэтгэх гэрээлэгч) нийт хүн амын 40-өөс бага хувь байгаа бол харин өрхийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэгч болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч харьцангуй өндөр байна. Дурдсан угсаатнууд голдуу хөдөө амьдарч байгаатай холбоотойгоор тэдний дийлэнх нь хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлж байна./Хавсралт В-ийн Хүснэгт 3.7-оос харна уу./

ГАДААДЫН ХАРЬАТ ИРГЭД

Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэдийн тоо 22 418 болж 2010 оноос 37.4 хувь буюу 6 098 хүнээр өсжээ. Харин харьяалалгүй иргэдийн тоо 37 болж 2010 оноос 71 хүнээр буурчээ. Гадаадын харьяат иргэдийн дотор Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) болон Оросын Холбооны Улс (ОХУ)-ын иргэд нийт гадаад иргэдийн 53.3 хувийг эзэлж байна. 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад Монголд байнга оршин суугаа БНХАУ-ын иргэдийн эзлэх хувь 11.3 пунктээр, ОХУ-ын иргэдийн эзлэх хувь 3.4 пунктээр тус тус буурсан бол Америкийн Нэгдсэн Улсын иргэдийн эзлэх хувь 6.6 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 3.6. МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬАТ ИРГЭД, УЛСААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Улсын нэр	2010	2020
БҮГД	100.0	100.0
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	53.0	41.7
Оросын Холбооны Улс	15.0	11.6
Бүгд Найрамдах Солонгос Улс	10.0	9.9
Америкийн Нэгдсэн Улс	4.0	10.6
Бусад	18.0	26.2

Гадаадын харьяат иргэдийн 77.9 хувь нь нийслэлд, 5.6 хувь нь Өмнөговь, 3.5 хувь нь Дорнод, 2.8 хувь нь Баян-Өлгий, 2.3 хувь нь Орхон аймгуудад амьдарч байна. Гадаадын харьяат иргэдийн эзлэх хувийн жин 2010 оноос Улаанбаатар хотод 21.2 пунктээр, Баян-Өлгий аймагт 2.4 пунктээр тус тус өсжээ. Харин Өмнөговь аймагт байнга амьдарч байсан гадаад иргэдийн эзлэх хувь 18.4 пунктээр буурсан бөгөөд хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэйн тоо) 2010 онд 134.3 байсан бол 2020 онд 103.7 болж харьцангуй тэнцвэртэй байна. Мөн бусад аймагтай харьцуулахад Өмнөговь, Дорнод, Баян-Өлгий аймгуудад гадаадын иргэд ихээр суурьшиж байгаа нь БНХАУ, Казахстан улстай хиллэдэгтэй холбоотой байж болох талтай (Хүснэгт 3.7).

ХҮСНЭГТ 3.7. МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬАТ ИРГЭДИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Аймаг, нийслэл	2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	16 320	100.0	22 418	100.0
Архангай	21	0.1	70	0.3
Баян-Өлгий	71	0.4	627	2.8
Баянхонгор	43	0.3	15	0.1
Булган	42	0.3	47	0.2
Говь-Алтай	8	0.0	67	0.3
Дорноговь	319	1.9	221	1.0
Дорнод	284	1.7	792	3.5
Дундговь	28	0.2	23	0.1
Завхан	45	0.3	31	0.1
Өвөрхангай	21	0.1	18	0.1
Өмнөговь	3 913	24.0	1 265	5.6
Сүхбаатар	156	1.0	92	0.4
Сэлэнгэ	323	2.0	197	0.9
Төв	183	1.1	126	0.6
Увс	32	0.2	183	0.8
Ховд	191	1.2	121	0.5
Хөвсгөл	41	0.2	155	0.7
Хэнтий	240	1.5	81	0.4
Дархан-Уул	255	1.6	293	1.3
Орхон	807	4.9	509	2.3
Говьсүмбэр	43	0.3	29	0.1
Улаанбаатар	9 254	56.7	17 456	77.9

ХҮСНЭГТ 3.8. МОНГОЛ УЛСЫН СУУРИН ХҮН АМ, ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010				2020				Хүйсийн харьцаа	
	Суурин хүн амын насны бүтэц	Гадаадын харьяат иргэд			Суурин хүн амын насны бүтэц	Гадаадын харьяат иргэд			2010	2020
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	284.3	165.9
0-14	28.0	7.9	5.6	14.4	32.1	17.8	14.5	23.2	110.1	103.8
15-24	20.8	12.3	10.5	17.3	13.8	12.4	9.0	18.2	173.1	81.6
25-34	17.8	21.8	22.4	20.3	17.1	16.5	16.3	16.8	313.5	161.4
35-44	14.4	28.3	31.8	18.5	14.2	19.6	21.9	15.7	487.9	231.7
45-54	10.6	20.0	21.2	16.6	11.1	19.0	22.6	13.1	362.8	285.4
55+	8.4	9.7	8.5	12.9	11.7	14.7	15.7	13.0	188.7	200.5

Гадаадын харьяат иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл 57.4 хувь нь дээд боловсролтой бөгөөд 2010 оноос 21.3 пунктээр өсжээ. Харин бүрэн дунд, түүнээс доош боловсролтой хүн амын эзлэх хувь 23.9 пунктээр буурчээ.

ЗУРАГ 3.8. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



Гадаадын харьяат иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал 74.9 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа⁴ болон бөөний, жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 2.8 хувь нь боловсролын салбарт, 12.2 хувь

4 Гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа, компьютер, өрхийн болон хувийн хэрэглээний барааны засвар, үйлчилгээ, хувийн хэрэглээний төрөл бүрийн бусад үйлчилгээ

нь уул уурхай, олборлолтын салбарт ажиллаж байна. Мөн өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээний салбарт ажиллагч 10.9 пунктээр өсжээ (Зураг 3.9).

ЗУРАГ 3.9. ГАДААДЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



ШАШИН

Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн “Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” гэсэн 3 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт “Аливаа шашныг шүтэх, эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна” гэж заасан. Хүн ам, орон сууцны тооллогод “Та шашин шүтдэг үү, шүтдэг бол ямар шашин шүтдэг вэ?” гэсэн асуултыг анх удаагаа 2010 оны тооллогоор асууж байсан бөгөөд ээлжит тооллогод хүн амын 10 хувийн түүвэрт сонгогдсон 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан болно. Шашин шүтдэг хүмүүсийг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 5.2 пунктээр илүү шашин шүтдэг байна.

ХҮСНЭГТ 3.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Шашин шүтлэгийн байдал	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Шүтдэггүй	38.6	42.9	34.4	40.6	43.3	38.1
Шүтдэг	61.4	57.1	65.6	59.4	56.7	61.9

Шашин шүтдэг хүмүүсийн 87.1 хувь нь Буддын шашинтан болох нь тооллогын дүнгээс харагдаж байна. Мөн 2010 онтой харьцуулахад нийт хүн амд эзлэх хувь Христ болон Бөөгийн шашинтан буурсан нь бусад шашны урсгал дэлгэрсэнтэй холбоотой байж болох юм.

ХҮСНЭГТ 3.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Шашны төрөл	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Будда	86.2	86.5	86.1	87.1	87.0	87.1
Христ	3.5	2.8	4.1	2.2	1.7	2.6
Ислам	4.9	5.4	4.6	5.4	6.0	5.0
Бөө	4.7	4.7	4.7	4.2	4.2	4.3
Бусад	0.7	0.6	0.5	1.1	1.1	1.0

Шашин шүтдэг нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл нас ахих тусам Буддын шашин шүтэгч байхад Бөөгийн шашинтан нас ахих тусам буурч байна.

ХҮСНЭГТ 3.11. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Шашин шүтдэг	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
БҮГД	100.0	87.1	2.2	5.4	4.2	1.1
15-19	100.0	81.4	3.2	9.2	4.9	1.3
20-29	100.0	83.4	2.1	7.8	5.5	1.2
30-39	100.0	86.3	2.2	5.1	5.1	1.3
40-49	100.0	88.4	2.0	4.6	4.0	1.0
50-59	100.0	89.3	2.3	4.1	3.5	0.8
60-69	100.0	91.1	2.1	3.5	2.6	0.7
70+	100.0	91.8	2.1	3.7	1.7	0.7

Казах, Узбек (Чантуу), Хошууд угсаатнуудад шашин шүтдэггүй иргэд 16 хүртэлх хувийг эзэлж байгаа нь бусад угсаатны бүлэгтэй харьцуулахад бага байна. Казахуудын 81.9 хувь, Узбек (Чантуу)-уудын 88.9 хувь нь Исламын шашин шүтдэг бол Хошуудын 89.3 хувь нь Будда шүтдэг байна. Монгол Улсын Ислам шашинтны 95 хувийг Казахууд эзэлж байна. Мөн Буриадуудын 10.0 хувь, Дархаддуудын 13.8 хувь, Тувачуудын 27.0 хувь, Хамниганчуудын 11.8 хувь, Цаатангуудын 60.5 хувь нь Бөө мөргөл шүтдэг нь бусад угсаатны бүлгээс ялгаатай байна.

ХҮСНЭГТ 3.12. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН


Насны бүлэг	Шашин шүтдэг	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-19	7.9	7.4	11.5	13.4	9.3	9.9
20-29	17.7	17.0	16.9	25.5	22.9	19.5
30-39	22.5	22.4	21.9	21.4	27.3	27.5
40-49	20.7	21.0	18.6	17.6	19.2	19.9
50-59	16.6	17.0	17.1	12.5	13.5	13.4
60-69	9.4	9.8	9.1	6.1	5.7	6.4
70+	5.2	5.4	4.9	3.5	2.1	3.4

ХҮСНЭГТ 3.13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГ, ҮНДЭС, УГСАА, ШАШНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Үндэс, угсаа	15, түүнээс дээш насны хүн ам-Бүгд	Шүтдэггүй	Шүтдэг	Шашин шүтдэг					
				Бүгд	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
БҮГД	100.0	40.6	59.4	100.0	87.1	2.2	5.4	4.2	1.1
МОНГОЛЫН ХАРЬЯАТ-БҮГД	100.0	40.5	59.5	100.0	87.1	2.2	5.4	4.2	1.1
Халх	100.0	41.3	58.7	100.0	92.7	2.3	0.1	4.0	0.9
Казах	100.0	15.3	84.7	100.0	1.3	0.3	96.7	0.1	1.6
Дөрвөд	100.0	42.3	57.7	100.0	92.8	2.0	0.2	2.9	2.1
Баяд	100.0	40.7	59.3	100.0	93.3	1.5	0.2	2.9	2.1
Буриад	100.0	49.2	50.8	100.0	74.5	3.5	0.1	19.8	2.1
Захчин	100.0	46.0	54.0	100.0	93.2	3.1	0.1	2.3	1.3
Дарьганга	100.0	34.5	65.5	100.0	96.6	0.8	-	2.1	0.5
Урианхай	100.0	41.3	58.7	100.0	89.9	2.9	0.5	3.9	2.8
Дархад	100.0	61.2	38.8	100.0	62.2	1.5	-	35.6	0.7
Өөлд	100.0	40.0	60.0	100.0	91.2	2.6	-	5.4	0.8
Хотгойд	100.0	26.7	73.3	100.0	96.3	0.6	-	3.0	0.1
Торгууд	100.0	36.8	63.2	100.0	92.8	2.4	0.6	3.2	1.0
Хотон	100.0	36.7	63.3	100.0	40.9	4.7	42.5	1.7	10.2
Мянгад	100.0	47.8	52.2	100.0	93.1	1.1	-	2.9	2.9
Тува	100.0	48.8	51.2	100.0	44.6	1.2	-	52.6	1.6
Барга	100.0	58.6	41.4	100.0	94.7	1.3	-	2.7	1.3
Үзэмчин	100.0	51.2	48.8	100.0	98.1	-	-	1.0	0.9
Элжигэн	100.0	40.7	59.3	100.0	87.7	-	-	12.0	0.3
Сартуул	100.0	31.0	69.0	100.0	78.7	2.5	8.8	7.5	2.5
Хамниган	100.0	29.4	70.6	100.0	83.3	-	-	16.7	-
Цаатан (Духа)	100.0	31.6	68.4	100.0	11.5	-	-	88.5	-
Узбек (Чантуу)	100.0	11.1	88.9	100.0	-	-	100.0	-	-
Харчин	100.0	50.0	50.0	100.0	100.0	-	-	-	-
Хошууд	100.0	10.7	89.3	100.0	100.0	-	-	-	-
Бусад	100.0	32.4	67.6	100.0	78.3	-	13.0	8.7	-
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	100.0	87.5	12.5	100.0	50.0	-	50.0	-	-
Гадаад	100.0	46.2	53.8	100.0	44.4	30.2	11.1	1.6	12.7

ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ХОТЖИЛТ

ХОТ, СУУРИНД
АМЬДАРДАГ
ХҮН АМ **68%**



32% ХӨДӨӨ
АМЬДАРДАГ
ХҮН АМ




ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ газарзүйн хэд хэдэн бүсэд оршдог, байгалийн баялаг улс орны нутаг дэвсгэрт жигд бус тархсан, уур амьсгал газарзүйн бүсүүдэд ялгаатай, эрс тэс байдаг зэргээс хамааран аймаг, нийслэлийн хүн амын суурьшил нягтрал, хөгжлийн түвшин өөр өөр байгаа нь зүй ёсны асуудал билээ. Хүн амын суурьшлиг хот, хөдөө, бүс нутгаар тодорхойлох нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэн судалж, бүс нутгийн болон орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах үндэс болно.

Хүн амын суурьшлын ерөнхий дүр төрх өмнөх тооллогоос бага зэрэг өөрчлөгдсөн байна. Энэ нь төв суурин газар луу чиглэсэн шилжих хөдөлгөөн ялангуяа Баруун бүсээс Төвийн бүс, нийслэлд олон мянган хүн шилжсэн нь бүс нутгийн хүн ам сийрэгжихэд нөлөөлжээ (Зураг 4.1).

ЗУРАГ 4.1. ХҮН АМЫН ТОО, СУМААР, 2020 ОН



Хүн амын суурьшлиг бүсээр⁵ ангилж үзэхэд нийт хүн амын 45.9 хувь нь Улаанбаатар хотод, 18.7 хувь нь Хангайн бүсэд, 15.8 хувь нь Төвийн бүсэд, 12.6 хувь нь Баруун бүсэд, 7.0 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна (Хүснэгт 4.1). Төв, суурин газар луу 1990-ээд оны эхэн үеэс эхэлсэн шилжилт сүүлийн 30 жилд үргэлжилсэн хэвээр байна. Тухайлбал, 2000 оны тооллогоор манай улсын 10 хүний 3 нь нийслэлд амьдарч байсан бол 2010 болон 2020 онд 4 болж нэмэгджээ.

5 Улсын Их хурлаас баталсан “Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” 2003 он.

Бүсүүдэд хамаарах аймаг, нийслэлийн нэр:

- Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг;
- Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймаг;
- Төвийн бүсэд: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймаг;
- Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг;
- Улаанбаатарын бүсэд: Нийслэл хот, түүний дүвргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотуудыг хамруулдаг.

ХҮСНЭГТ 4.1. ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Бүс	мян.хүн			2010 2000 %	2020 2010 %	Дүнд эзлэх хувь		
	2000	2010	2020			2000	2010	2020
БҮГД	2 373.5	2 647.5	3 197.0	11.5	20.8	100.0	100.0	100.0
Баруун	421.6	352.5	404.7	-16.4	14.8	17.8	13.3	12.6
Хангай	545.7	514.7	597.8	-5.7	16.1	23.0	19.4	18.7
Төв	443.7	440.7	506.2	-0.7	14.9	18.7	16.6	15.8
Зүүн	202.5	185.3	222.2	-8.5	19.9	8.5	7.0	7.0
Улаанбаатар	760.1	1 154.3	1 466.1	51.9	27.0	32.0	43.6	45.9

ХҮСНЭГТ 4.2. ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Аймаг, нийслэл	Хүн ам /мян.хүн/			2010 2000 %	2020 2010 %	Дүнд эзлэх хувь		
	2000	2010	2020			2000	2010	2020
БҮГД	2 373.5	2 647.5	3 197.0	11.5	20.8	100.0	100.0	100.0
Архангай	97.1	84.1	94.3	-13.4	12.1	4.1	3.2	2.9
Баян-Өлгий	91.1	85.2	103.9	-6.4	21.9	3.8	3.2	3.2
Баянхонгор	84.8	75.7	88.0	-10.7	16.2	3.6	2.9	2.7
Булган	61.8	53.1	61.3	-14.0	15.4	2.6	2.0	1.9
Говь-Алтай	63.7	53.2	57.6	-16.4	8.3	2.7	2.0	1.8
Дорноговь	50.6	57.9	70.0	14.5	20.9	2.1	2.2	2.2
Дорнод	75.4	68.9	82.0	-8.6	19.0	3.2	2.6	2.6
Дундговь	51.5	38.6	46.7	-25.1	21.0	2.2	1.5	1.5
Завхан	90.0	64.9	72.3	-27.9	11.4	3.8	2.5	2.3
Өвөрхангай	111.4	100.4	115.7	-9.9	15.2	4.7	3.8	3.6
Өмнөговь	46.9	60.9	69.9	30.0	14.8	2.0	2.3	2.2
Сүхбаатар	56.2	51.1	62.9	-9.0	23.1	2.4	1.9	2.0
Сэлэнгэ	100.0	95.8	107.7	-4.2	12.4	4.2	3.6	3.4
Төв	99.3	83.8	92.4	-15.6	10.3	4.2	3.2	2.9
Увс	90.0	72.9	82.9	-19.0	13.7	3.8	2.8	2.6
Ховд	86.8	76.3	88.1	-12.1	15.5	3.7	2.9	2.8
Хөвсгөл	119.1	114.3	134.3	-4.0	17.5	5.0	4.3	4.2
Хэнтий	70.9	65.3	77.3	-8.0	18.4	3.0	2.5	2.4
Дархан-Уул	83.3	90.6	102.2	8.8	12.8	3.5	3.4	3.2
Орхон	71.5	87.1	104.0	21.8	19.4	3.0	3.3	3.2
Говьсүмбэр	12.2	13.1	17.4	7.1	32.8	0.5	0.5	0.5
Улаанбаатар	760.1	1 154.3	1 466.1	51.9	27.0	32.0	43.6	45.9

Суурин хүн амын нийт дүнд эзлэх Улаанбаатар хотын хүн амын хувь 2020 онд 45.9, бусад аймгууд 0.5-4.2 хувийг эзэлж байна (Хүснэгт 4.2). Аймгуудын хүн амын улсын дүнд эзлэх хувь бага байгаа хэдий ч сүүлийн 2 тооллого хооронд өсжээ. Үүнд хамгийн өндөр өсөлттэй нь Говьсүмбэр аймаг 32.8 хувиар, Улаанбаатар хот 27.0 хувиар тус тус өссөн байна (Хүснэгт 4.2).

Монгол Улсад сүүлийн 30 жилд хотжих үйл явц улам бүр нэмэгдсээр байна. Төв, суурин газруудад дэд бүтэц хангагдсан байдал, боловсрол, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж, ялангуяа ажил, орлоготой болох найдвартай эх үүсвэр болж байгаа нь иргэдийг ихээр татаж хотжих үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна. Дээрх шалтгаанаар төв, суурин газар амьдарч байгаа хүн ам өссөөр 2020 онд нийт хүн амын 67.8 хувь буюу 2 168.2 мянга болжээ. Гэхдээ бүсүүдийн хотжилтын түвшин ялгаатай байгааг Хүснэгт 4.3-аас харж болно.

ХҮСНЭГТ 4.3. ХҮН АМЫН ТОО, БҮС, ХОТ, ХӨДӨӨ, БҮСИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Бүс	Хот, тосгоны тоо	Хот		Хөдөө	
		Хүн ам (мян.хүн)	Бүсийн хүн амд эзлэх хувь	Хүн ам (мян.хүн)	Бүсийн хүн амд эзлэх хувь
2010					
БҮГД	39	1 798.1	67.9	849.4	32.1
Баруун	8	122.3	34.7	230.1	65.3
Хангай	10	225.1	43.8	289.6	56.2
Төв	11	211.4	48.0	229.2	52.0
Зүүн	9	84.9	45.8	100.4	54.2
Улаанбаатар	1	1 154.3	100.0	-	-
2020					
БҮГД	41	2 168.2	67.8	1 028.8	32.2
Баруун	8	135.3	33.4	269.4	66.6
Хангай	9	245.2	41.0	352.6	59.0
Төв	15	229.3	45.3	276.9	54.7
Зүүн	8	92.3	41.5	129.9	58.5
Улаанбаатар	1	1 466.1	100.0	-	-

Баруун бүс нутаг харьцангуй олон хүн амтай, суурьшлын хувьд нягт хэдий ч хотжих явц эрчимтэй биш байна. Төвийн бүс Улаанбаатар хотын дараа хотжилт хамгийн өндөр бүс хэвээр байна. Тухайлбал, Орхон, Дархан-Уул аймагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрчимжсэн, төмөр зам гэх мэт дэд бүтэц сайтай, Өмнөговь аймагт сүүлийн 10 жилд уул уурхайн салбарын хөгжил эрчимжсэнтэй шууд холбоотойгоор тус аймгуудын төв, суурингийн хүн амын тоо өсөх хандлагатай байна. Харин Дорноговь аймгийн төв, суурингийн хүн амын өсөлт аж үйлдвэрийн цогцолбор байгуулагдаж байгаатай холбоотой байж болох юм.

Аймгуудын хотжилтын түвшин хоорондоо нэлээд ялгаатай байдаг. Аймгийн төвүүдийн боловсрол, эрүүл мэнд, ажлын байр, худалдаа, үйлчилгээ, зэрэг нийгмийн салбарын хөгжил хөдөөгөөс илүү байгаа нь шилжин ирэгчдийг татаж, аймгийн хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жинг өсгөжээ. Төмөр замын дагуу байрладаг Говьсүмбэр, Дорноговь, Дархан-Уул, Орхон аймгуудад төв, суурин газрын хүн амын эзлэх хувь 50-аас дээш байна (Хүснэгт 4.4).

Хүн ам харьцангуй ихтэй Архангай, Булган, Завхан, Сүхбаатар, Төв аймгуудын хөдөөгийн хүн амын эзлэх хувийн жин 70-аас илүү хувийг эзэлж байна. Энэ нь эдгээр аймгийн нутаг дэвсгэр байгаль, цаг уурын таатай нөхцөлд оршдогтой холбоотой байж болох юм.

ХҮСНЭГТ 4.4. ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Аймаг, нийслэл	2010				2020			
	Хот		Хөдөө		Хот		Хөдөө	
	мян. хүн	Дүнд эзлэх хувь	мян. хүн	Дүнд эзлэх хувь	мян. хүн	Дүнд эзлэх хувь	мян. хүн	Дүнд эзлэх хувь
БҮГД	1 798.1	67.9	849.4	32.1	2 168.2	67.8	1 028.8	32.2
Архангай	20.6	24.5	63.5	75.5	20.6	21.9	73.8	78.1
Баян-Өлгий	30.7	36.0	54.6	64.0	38.9	37.5	65.0	62.5
Баянхонгор	29.8	39.4	45.9	60.6	31.7	36.1	56.3	63.9
Булган	14.1	26.6	38.9	73.4	15.5	25.3	45.8	74.7
Говь-Алтай	18.0	33.7	35.3	66.3	18.7	32.5	38.9	67.5
Дорноговь	33.9	58.6	24.0	41.4	44.7	64.0	25.3	36.0
Дорнод	38.6	56.1	30.3	43.9	46.2	56.4	35.8	43.6
Дундговь	13.7	35.5	24.9	64.5	12.4	26.6	34.3	73.4
Завхан	17.5	26.9	47.4	73.1	16.2	22.4	56.1	77.6
Өвөрхангай	38.0	37.9	62.4	62.1	32.9	28.4	82.8	71.6
Өмнөговь	18.8	30.9	42.1	69.1	26.4	37.7	43.5	62.3
Сүхбаатар	16.2	31.6	34.9	68.4	18.5	29.5	44.3	70.5
Сэлэнгэ	47.0	49.1	48.8	50.9	37.2	34.5	70.5	65.5
Төв	13.3	15.9	70.5	84.1	16.7	18.0	75.7	82.0
Увс	27.2	37.3	45.7	62.7	30.7	37.0	52.2	63.0
Ховд	29.0	38.1	47.2	61.9	30.9	34.9	57.2	65.1
Хөвсгөл	38.4	33.6	75.9	66.4	44.3	32.9	90.0	67.1
Хэнтий	30.1	46.0	35.2	54.0	27.5	35.6	49.8	64.4
Дархан-Уул	75.0	82.7	15.7	17.3	81.5	79.8	20.7	20.2
Орхон	84.2	96.6	2.9	3.4	100.2	96.3	3.8	3.7
Говьсүмбэр	9.7	74.5	3.3	25.5	10.4	59.8	7.0	40.2
Улаанбаатар	1 154.3	100.0	-	-	1 466.1	100.0	-	-

ХҮН АМЫН НЯГТРАЛ

Улс төр, соёл, түүх, засаг захиргаа, цаг агаар, газар зүй зэрэг олон хүчин зүйлс хүн амын суурьшил, нягтралд нөлөөлдөг. Сүүлийн 10 жилд бүс, аймаг, нийслэлийн хүн амын нягтралд хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйлд хүн амын шилжих хөдөлгөөн орж байна.

Монгол Улс дэлхийн хамгийн сийрэг суурьшилтай орнуудын нэг хэвээр байгаа хэдий ч нэг квадрат километр нутаг дэвсгэрт ногдох хүний тоо 2020 онд 2.0 болж өмнөх тооллогын дүнгээс 0.3 пунктээр өсжээ.

ХҮСНЭГТ 4.5. ХҮН АМЫН НЯГТРАЛ, БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН


Бүс	Нутаг дэвсгэр		2010			2020		
	мян. км ²	Дүнд эзлэх хувь	Хүн ам		1 км ² -т ногдох хүн	Хүн ам		1 км ² -т ногдох хүн
			мян. хүн	Дүнд эзлэх хувь		мян. хүн	Дүнд эзлэх хувь	
БҮГД	1 564.1	100.0	2 647.5	100.0	1.7	3 197.0	100.0	2.0
Баруун	415.3	26.6	352.5	13.3	0.8	404.7	12.6	1.0
Хангай	384.3	24.6	514.7	19.4	1.3	597.8	18.7	1.6
Төв	473.6	30.3	440.7	16.6	0.9	506.2	15.8	1.1
Зүүн	286.2	18.3	185.3	7.0	0.6	222.2	7.0	0.8
Улаанбаатар	4.7	0.3	1 154.3	43.6	245.6	1 466.1	45.9	311.9

Хүн амын нягтрал газар зүйн бүс нутгаар нэлээд ялгаатай байна. Улаанбаатар хот хүн амын нягтралаар хамгийн өндөр хэвээр байгаагийн зэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Нэг квадрат километр нутаг дэвсгэрт 2000 онд 162 хүн ногдож байсан бол 2010 онд 246, 2020 онд 312 болж тус тус өсжээ. Өмнөх тооллоготой Хангайн бүсийн нягтралыг харьцуулахад 0.3 пунктээр, Төвийн, Баруун болон Зүүн бүсийнх тус бүр 0.2 пунктээр өссөн байна.

Улаанбаатар хот хэдийгээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг ч 2020 онд хүн амын 45.9 хувь нь оршин сууж, цаашид ч нэмэгдэх хандлага хадгалагдсаар байна. Улаанбаатар хоттой харьцуулахад бусад бүс нутгийн хүн амын нягтрал харьцангуй сийрэг ч хоорондоо нэлээд ялгаатай.

Байгаль цаг уурын харьцангуй эерэг нөхцөлтэй Хангай болон Төвийн бүсэд Баруун болон Зүүн бүсээс харьцангуй нягтрал ихтэй байна. Жишээлбэл, Хангайн бүсэд нэг квадрат километрт 1.6 хүн ногдож байгаа нь Зүүн бүсээс 2 дахин их байна. Энэ нь мөн л хүн амын дотоод шилжих хөдөлгөөний урсгал төв рүү чиглэсэн байгааг илэрхийлж байна.

ЗУРАГ 4.2. ХҮН АМЫН НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Хүн амын нягтрал хамгийн өндөр Монгол Улсын нийслэл хот Улаанбаатар хотоос гадна томоохон хот суурин газар болох Орхон (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 130 хүн), Дархан-Уул аймгийн (нэг километр квадрат нутаг дэвсгэрт 31 хүн) нягтрал бусад аймгаас өндөр байна. Харин Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Дорнод, Баянхонгор, Сүхбаатар, Завхан аймгуудад 0.4-0.9 хүн байгаа нь хамгийн бага буюу сийрэг нягтралтай байна.

Хүн амын нягтрал хүн амын өсөлттэй холбоотойгоор 2010 оны тооллоготой харьцуулахад Өмнөговь аймгийнх ижил түвшинд, харин бусад бүх аймгуудынх өссөн байна. Сэлэнгэ, Говьсүмбэр аймгийн нутгаар төмөр зам дайран өнгөрдөг бөгөөд энд хотжилт нэмэгдсээр байгаа юм.

ХҮСНЭГТ 4.6. ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН


Аймаг, нийслэл	2010			2020		
	мян. хүн	Дүнд эзлэх хувь	хүн/км ²	мян. хүн	Дүнд эзлэх хувь	хүн/км ²
БҮГД	2 647.5	100.0	1.7	3 197.0	100.0	2.0
Архангай	84.1	3.2	1.5	94.3	2.9	1.7
Баян-Өлгий	85.2	3.2	1.9	103.9	3.2	2.3
Баянхонгор	75.7	2.9	0.7	88.0	2.7	0.8
Булган	53.1	2.0	1.1	61.3	1.9	1.3
Говь-Алтай	53.2	2.0	0.4	57.6	1.8	0.4
Дорноговь	57.9	2.2	0.5	70.0	2.2	0.6
Дорнод	68.9	2.6	0.6	82.0	2.6	0.7
Дундговь	38.6	1.5	0.5	46.7	1.5	0.6
Завхан	64.9	2.5	0.8	72.3	2.3	0.9
Өвөрхангай	100.4	3.8	1.6	115.7	3.6	1.8
Өмнөговь	60.9	2.3	0.4	69.9	2.2	0.4
Сүхбаатар	51.1	1.9	0.6	62.9	2.0	0.8
Сэлэнгэ	95.8	3.6	2.3	107.7	3.4	2.6
Төв	83.8	3.2	1.1	92.4	2.9	1.2
Увс	72.9	2.8	1.0	82.9	2.6	1.2
Ховд	76.3	2.9	1.0	88.1	2.8	1.2
Хөвсгөл	114.3	4.3	1.1	134.3	4.2	1.3
Хэнтий	65.3	2.5	0.8	77.3	2.4	1.0
Дархан-Уул	90.6	3.4	27.5	102.2	3.2	31.0
Орхон	87.1	3.3	108.9	104.0	3.2	130.0
Говьсүмбэр	13.1	0.5	2.4	17.4	0.5	3.2
Улаанбаатар	1 154.3	43.6	245.6	1 466.1	45.9	311.9

ХОТЖИЛТ

Өндөр хөгжилтэй улс оронд үйлдвэржих үйл явцтай холбогдон хот суурин газарт үйлдвэрийн газар бий болж түүнийг дагасан шилжих хөдөлгөөн өрнөдөг. Хөгжиж байгаа улс оронд үйлдвэржих явц тэгтлээ өрнөөгүй тохиолдолд ч шилжих хөдөлгөөний өрнөл төв, суурин газрыг чиглэж, шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл, хотын хүн ам өсөх нь хөгжил сайжирч байна гэсэн үг биш юм. Үүнтэй адил Монгол Улсын хувьд шилжих хөдөлгөөн жилээс жилд эрчимжиж байгаа ч үйлдвэржилтээс үүдэлтэй хотжилтыг бий болж байгаа эсэх нь эргэлзээтэй юм.

Сүүлийн 20 жилд Монгол Улсын хотын хүн амын өсөлт түүний өмнөх 30 (1969-2000 оны тооллого) жилийн өсөлттэй ойролцоо болж байна. 2020 оны байдлаар Монгол Улсын 3 хүний 2 нь төв, суурин газар амьдарч байна. Хотын хүн амын өсөлтийн дийлэнхийг дотоодын шилжих хөдөлгөөний өсөлт бүрдүүлдэг. Нийслэл болон аймгийн төвүүдэд боловсрол, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээний чанар хөдөө орон нутгаас илүү байдгийн зэрэгцээгээр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх өөрөөр хэлбэл ажлын байр олох боломж илүү байдаг нь тодорхой юм.

ЗУРАГ 4.3. УЛААНБААТАР ХОТОД ШИЛЖИН ИРЭГЧИД, БҮСЭЭР (ШИЛЖИН ИРСЭН БОЛОН ЯВСАН ХҮНИЙ ЗӨРҮҮГЭЭР МЯН.ХҮН) 2010, 2020 ОН



Улаанбаатар хотын хүн амын өсөлт аймгуудын хотын хүн амаас харьцангуй өндөр байгаа төдийгүй 2 тооллогын хооронд 311.8 мянган хүнээр нэмэгдэж 2020 оны тооллогын дүнгээр нийт хотын хүн амын 67.6 хувийг эзэлдэг болов.

ХҮСНЭГТ 4.7. ХОТЫН ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Аймаг, нийслэл	Хотын хүн амын тоо		Өсөлтийн хувь	Дүнд эзлэх хувь	
	2010	2020		2010	2020
БҮГД	1 798 147	2 168 253	120.6	100.0	100.0
Баруун бүс	122 334	135 327	110.6	6.8	6.2
Баян-Өлгий	30 663	38 950	127.0	1.7	1.8
Говь-Алтай	17 962	18 706	104.1	1.0	0.9
Завхан	17 485	16 232	92.8	1.0	0.7
Увс	27 178	30 662	112.8	1.5	1.4
Ховд	29 046	30 777	106.0	1.6	1.4
Хангайн бүс	225 221	245 163	108.9	12.5	11.3
Архангай	20 619	20 648	100.1	1.1	1.0
Баянхонгор	29 829	31 731	106.4	1.7	1.5
Булган	14 116	15 522	110.0	0.8	0.7
Орхон	84 187	100 183	119.0	4.7	4.6
Өвөрхангай	38 027	32 891	86.5	2.1	1.5
Хөвсгөл	38 443	44 188	114.9	2.1	2.0
Төвийн бүс	211 451	229 331	108.5	11.8	10.6
Говьсүмбэр	9 742	10 427	107.0	0.5	0.5
Дархан-Уул	74 985	81 517	108.7	4.2	3.7
Дорноговь	33 932	44 714	131.8	1.9	2.1
Дундговь	13 664	12 412	90.8	0.8	0.6
Өмнөговь	18 781	26 367	140.4	1.0	1.2
Сэлэнгэ	47 008	37 217	79.2	2.6	1.7
Төв	13 339	16 677	125.0	0.7	0.8
Зүүн бүс	84 851	92 307	108.8	4.7	4.3
Дорнод	38 615	46 221	119.7	2.1	2.1
Сүхбаатар	16 150	18 561	114.9	0.9	0.9
Хэнтий	30 086	27 525	91.5	1.7	1.3
Улаанбаатар	1 154 290	1 466 125	127.0	64.2	67.6

Улаанбаатар хотыг оруулахгүйгээр тооцвол Хангайн бүс хотжилтын түвшнээр хамгийн өндөр (11.3 хувь) байна (Хүснэгт 4.7).

Хотжилтын түвшин шилжих хөдөлгөөн сөрөг урсгал өндөр Баруун болон Зүүн бүс нутагт шилжин ирэгчдийг хамгийн их хүлээж авдаг Төвийн бүс нутгаас илүү өссөн нь анхаарал татаж байна. Энэ нь нэг талдаа Төвийн бүс нутагт шилжиж ирсэн хүмүүс хөдөө аж ахуйн салбарт ажиллаж, өөрөөр хэлбэл, “Бусад бүс нутгийн хөдөөгөөс - Төвийн бүсийн хөдөө рүү” шилжиж байгааг харуулж байна. Нөгөө талдаа, Баруун, Хангайн, Зүүн бүс нутагт гадагшаа шилжих хөдөлгөөнөөс гадна бүс нутаг, аймаг дотроо “хөдөөгөөс – хот руу” шилжих хөдөлгөөн байгааг харуулж байна. Энэ шилжих хөдөлгөөнийг аймгийн түвшинд хийх судалгаагаар илүү тодорхойлж гаргаж болох юм.

Хотжилтын түвшнийг аймаг, нийслэлээр үзэхэд Улаанбаатар хотын дараа Орхон аймаг (96.3 хувь) орж байна. Орхон аймгийн хүн амын 3.7 хувь нь хөдөөд амьдарч байна. Эндээс Орхон аймгийг бүхэлд нь хот гэж үзэх боломжтой мэт харагдаж байна. Орхон аймгийн дараа Дархан-Уул (79.8 хувь), Дорноговь (64.0 хувь) аймаг орж байна. Харин бусад аймгуудын хувьд Говьсүмбэр (59.8 хувь), Дорнод (56.4 хувь) аймагт хотжилтын түвшин өндөр, 10 хүн тутмын 6 нь хотод амьдардаг байна. Эдгээрийн дараа 32-37 хувийн хотжилттой Говь-Алтай, Хөвсгөл, Сэлэнгэ, Ховд, Хэнтий, Баянхонгор, Увс, Баян-Өлгий, Өмнөговь аймгууд орж байна.

Сүхбаатар, Өвөрхангай, Дундговь, Булган, Завхан, Архангай, Төв аймагт хотжилтын түвшин харьцангуй бага 18.0-29.5 хувийн хооронд байна. Харин шилжин ирэгчид хамгийн их Төв аймагт хотжилтын түвшин хамгийн бага, нийт хүн амын дийлэнх буюу 82.0 хувь нь хөдөөд амьдарч байна. Энэ нь зах зээлд ойртсон малчдын нүүдэл, мал аж ахуйн салбар Төвийн бүсэд бөөгнөрч байгаатай холбоотой. Түүнээс гадна, Төвийн бүс “Баруун бүсээс – Улаанбаатар хот руу” чиглэсэн нүүдлийн “дамжих цэг” болж буйтай ч холбоотой юм (Хүснэгт 4.4).

Баян-Өлгий, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Төв аймгаас бусад бүх аймагт хотжилтын түвшин буурсан байна. Хотжилтын түвшин Өмнөговь (6.8 пункт), Дорноговь (5.4 пункт) аймагт, бусад аймагтай харьцуулахад өссөн байна. Энэ нь Өмнөговь аймагт сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын хөгжил эрчимжиж байгаатай холбоотойгоор төв, суурины хүн амын тоо өсөж байгаа бол Дорноговь аймгийн хувьд аж үйлдвэрийн цогцолбор байгуулагдаж байгаатай холбоотой байж болох юм.


Хотжилтын түвшнээс гадна хүн амын хотжилт болон төвлөрлийг харуулах өөр үзүүлэлт бол Монгол Улсын хотын хүн амд тухайн аймаг, нийслэлийн хотын хүн амын эзлэх хувь юм. Монгол Улсын хотын хүн амын дийлэнх буюу 67.6 хувь нь зөвхөн Улаанбаатар хотод амьдарч байна. Шилжих хөдөлгөөний үр дүнд Монгол Улсын хотын хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь 2020 онд 2010 онтой харьцуулахад хамгийн ихээр буюу 3.4 пунктээр нэмэгдсэн байна. Үүний дараа Эрдэнэт, Дархан хот орж байна. Эдгээр нь хотын хүн амын 8.4 хувийг эзэлж байна. Дорноговь, Дорнод, Хөвсгөл, Баян-Өлгий, Сэлэнгэ аймагт хотын хүн амд эзлэх хувь бусад аймгаас өндөр орж байна. Үлдсэн аймагт хотын хүн амын эзлэх хувь 0.5-1.5 хувийн хооронд байна.

Улаанбаатар хотоос гадна Дорноговь, Өмнөговь, (тус тус 0.2 пунктээр), Төв, Баян-Өлгий (тус тус 0.1 пунктээр) аймгийн хүн амын улсын дүнд эзлэх хувь өссөн байна. Харин Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар аймагт өөрчлөлтгүй, үлдсэн аймгуудын хотын хүн амын улсын дүнд эзлэх хувь буурсан байна. Үүнээс үзэхэд аймгаасаа гадагшаа шилжин явагч ихтэй газар хотжилт нэмэгдэж, харин шилжин ирэгч ихтэй аймагт хотжилт буурсан нь эдийн засгийн өсөлттэй холбоотой байж болох юм. 1990-ээд оноос өмнөх шилжих хөдөлгөөн нь тодорхой чиглэл зорилготой шилжиж байсан бол 90-ээд оноос хойш энэ байдал эрс өөрчлөгдөж шилжих хөдөлгөөн урсгалаараа явагдаж байгааг харуулж байна.

5

БҮЛЭГ

ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН



ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Шилжих хөдөлгөөн нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтөд голлон нөлөөлдөг хүчин зүйл юм. Сүүлийн 30 гаруй жилд хүн амын дотоод, гадаад шилжих хөдөлгөөн эрчимжиж, аймаг, нийслэл, бүс нутгийн хүн амын тоо, бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан төдийгүй нийгэм, эдийн засгийн хөгжилд хүчтэй нөлөөлж байна. Монгол Улс нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс гол төлөв хөдөөгөөс мэргэжил, боловсрол эзэмших шалтгаанаар төв суурин газар луу шилжих нь нэмэгдэв. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэж заасан нь иргэд шилжих хөдөлгөөнд сайн дураараа чөлөөтэй оролцох эрх зүйн боломжийг бүрдүүлдэг.

Шилжих хөдөлгөөнийг тодорхой цаг хугацаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үздэг. Байнга оршин сууж байсан газраасаа буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс (аймаг, нийслэл) өөр газар луу шилжсэн, шилжиж ирсэн газартаа 6, түүнээс дээш сарын хугацаагаар суурьшин сууж байгаа хүн амыг шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үздэг.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор шилжих хөдөлгөөн буюу шилжигчдийг тодорхойлохдоо тооллогын товын үед:

- төрсөн нутгаасаа өөр газар амьдарч байгаа;
- таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газар;
- нэг жилийн өмнө байнга оршин сууж байсан газар гэсэн гурван үндсэн хугацаагаар авсан.

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний мэдээллийг 10 хувийн түүврийн мэдээлэлд үндэслэн гаргасан бол сүүлийн 1 болон 5 жилийн шилжих хөдөлгөөний мэдээллийг бүртгэлд суурилсан аргаар буюу Хүн ам, өрхийн мэдээллийн санд үндэслэн тооцсон болно.

Шилжих хөдөлгөөнд оролцогчдыг дээрх 3 хугацаагаар хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан хамгийн сүүлд шилжсэн нутаг дэвсгэрийн байдлаар тодорхойлов. Шилжих хөдөлгөөнд оролцогчдын шинж төрхийг тодорхойлохдоо эхний арга нь төрсөн газрын асуултад үндэслэсэн (Зураг 5.1).

“Төрснөөсөө хойш сууж байгаа” гэдэгт төрсөн аймаг, нийслэлдээ төрснөөсөө хойш амьдарч байгаа буюу амьдралынхаа туршид байнга суудаг нэгжээс өөр аймаг, нийслэлд шилжин суурьшиж байгаагүй тохиолдлыг энд оруулсан.

Харин тооллогын товын үед төрсөн аймаг, нийслэлээсээ өөр газар байнга оршин сууж байгаа болон өөр аймаг, нийслэлд амьдарч байгаад буцаад төрсөн аймаг, нийслэлдээ ирсэн хүмүүсийг “Төрснөөсөө хойш шилжигчид” гэж үзэв. Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийг тухайн хүний хамгийн сүүлд шилжиж ирсэн аймаг, нийслэлийг үндэслэв. Өөрөөр хэлбэл, тухайн хүн төрснөөсөө хойш 2020 оны 1 дүгээр сар буюу тоолох үе хүртэлх хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан зөвхөн сүүлчийн аймаг, нийслэлийг хамруулж байгаа болно.

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний үндсэн агуулга нь аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа хүн амын хэдэн хувь нь уугуул нутагтаа амьдарч байгааг илэрхийлэхэд оршино.

Шилжих хөдөлгөөний урсгал, шилжин суурьшсан хугацааг тоолох үед байнга оршин сууж байгаа аймаг, нийслэлд шилжиж ирсэн хүн нэг бүрээс байнга оршин сууж байгаа хугацаа, өмнө нь байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг асууж тодруулсан.


ЗУРАГ 5.1. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2020 ОН



НҮБ болон олон улсад шилжих хөдөлгөөний чиг хандлагыг цаг хугацаагаар хэмжин судалдаг жишгийг үндэслэн Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоос эхлэн таван жилийн шилжих хөдөлгөөнийг судалж эхэлсэн.

Шилжих хөдөлгөөнийг судлах хоёр дахь арга нь тогтсон цаг хугацааг хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, яг таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газрыг асуудаг. Сүүлчийн таван жилийн шилжих хөдөлгөөнийг тоолуулагч 2015 оноос өмнө болон хойших хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан, товын үед болон товоос таван жилийн өмнө байнга сууж байсан газраар тооцоолсон. Уг тооцооллыг 5, түүнээс дээш насны хүн амын мэдээлэлд хийсэн.

ЗУРАГ 5.2. СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2020 ОН



Шилжих хөдөлгөөнийг хэмжих гурав дахь арга нь байнга оршин сууж байгаа хугацааг үндэслэсэн байв. Тооллогын үед байнга оршин сууж байсан аймаг, нийслэлд шилжиж ирсэн хүн нэг бүрээс байнга оршин сууж байгаа хугацаа, урьд нь байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг асуусан.


Шилжих хөдөлгөөнийг хэмжих хамгийн чухал нэг хэмжүүр нь нутаг дэвсгэр буюу засаг захиргааны нэгж юм. Тооллогын шилжих хөдөлгөөний үзүүлэлтэд аймаг, нийслэл хоорондын хөдөлгөөнийг хамруулж, аймаг, нийслэл дотор шилжих хөдөлгөөнийг оруулаагүй болно.

ЗУРАГ 5.3. СҮҮЛИЙН НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2020 ОН




Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 23.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 9.7 пунктээр, сүүлийн 5 жилийнх 8.2 пунктээр, сүүлийн 1 жилийнх 1.5 пунктээр тус тус буурчээ.

ЗУРАГ 5.4. АЙМАГ, НИЙСЛЭЛ ХООРОНДЫН ШИЛЖИГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН



Харин бүс хоорондын төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд оролцогчид 8.8 пунктээр, сүүлийн 5 жилийнх 7.3 пунктээр, сүүлийн 1 жилийнх 1.2 пунктээр 2010 оны тооллогын дүнгээс буурсан үзүүлэлттэй гарч байна.

ЗУРАГ 5.5. БҮС ХООРОНДЫН ШИЛЖИГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН



Шилжих хөдөлгөөний судалгааг энгийн болгох үүднээс энэхүү тайланд зөвхөн бүс хоорондын шилжих хөдөлгөөнийг авч үзсэн. Ингэхдээ аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнийг бүсээр нэгтгэж, бүсүүдийн хоорондын шилжих хөдөлгөөнийг тодорхойлсон. Тиймээс бүс нутгийн хэмжээнд шилжих хөдөлгөөнийг тодорхойлоход аймаг хоорондын шилжих хөдөлгөөнөөс бага байх болно.

ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний ерөнхий дүр зургаас харахад Улаанбаатар хот руу чиглэсэн хөдөлгөөн бусад бүсээс нэлээд давамгайлсан хэвээр байна. 2020 оны тооллогын дүнгээр нийслэлийн шилжих хөдөлгөөнд оролцогчдын 76.3 хувь нь шилжин ирэгчид байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 1.3 пунктээр өсжээ. Харин бүс нутгийн шилжих хөдөлгөөний төрх байдлыг үзвэл Төвийн бүсэд шилжин ирэгчид давамгайлсан хэвээр байгаа нь харагдаж байна.

Төвийн бүс нутгийн төв, суурин газруудыг хөгжихөд Улаанбаатар хот, бусад бүс нутагтай холбосон төмөр зам, хатуу хучилттай засмал зам, Өмнөговь аймагт хөгжиж буй Оюу толгой, Таван толгой төслөөс уул уурхайн бүтээн байгуулалт илүү боломжийг бий болгож байгаатай холбоотой. Ийм учир Улаанбаатар хотоос гадна Төвийн бүс нутагт 14.4 хувь нь шилжин ирсэн байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад өндөр байна.

Төв болон Хангайн бүс нутгаас хүмүүс ихэвчлэн Улаанбаатар хот руу шилжихээс гадна эдгээр бүсэд Баруун болон Зүүн бүсээс хүмүүс түлхүү ирж суурьшиж байна. Төв болон Хангай бүс нь Баруун болон Зүүн бүс нутгаас шилжигчдийн хувьд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалын “дамжих цэг” болж байна.

2020 онд шилжин явагчдын 33.0 хувь нь Баруун бүсээс бусад бүс рүү шилжин явсан байхад шилжин ирэгчдийн дөнгөж 0.9 хувь нь Баруун бүс нутагт шилжиж очсон байна. Өөрөөр хэлбэл, Баруун бүс шилжин явагч хамгийн олонтой бүс болох нь харагдаж байна. Харин сийрэг суурьшилтай Зүүн бүсийн хүн амын өсөлтөд шилжих хөдөлгөөн харьцангуй бага нөлөө үзүүлдэг ажээ. Шилжин явагчдын 10.5 хувь нь Зүүн бүсээс байна.

ХҮСНЭГТ 5.1. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧИД, ТӨРСӨН БҮСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Төрсөн бүс	Дүнд эзлэх хувь	Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний байдал		
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгчид	Шилжин явагчид
2010				
БҮГД	100.0	100.0	100.0	100.0
Баруун	22.5	18.5	1.0	31.8
Хангай	25.7	25.1	6.4	27.5
Төв	18.2	16.9	15.9	21.2
Зүүн	9.7	9.2	1.7	10.9
Улаанбаатар	23.1	30.3	75.0	5.9
Гадаад*	0.8	-	-	2.7
2020				
БҮГД	100.0	100.0	100.0	100.0
Баруун	19.2	15.5	0.9	33.0
Хангай	23.1	21.8	6.7	28.2
Төв	17.8	16.9	14.4	21.2
Зүүн	9.3	9.0	1.7	10.5
Улаанбаатар	30.3	36.8	76.3	5.8
Гадаад*	0.3	-	-	1.3

Тайлбар: *Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнгээр төрсөн бүсдээ байнга амьдарч байгаа хүн амын эзлэх хувь хамгийн өндөр байгаа бүс нь Баруун бүс (98.6 хувь) бөгөөд өмнөх тооллогоос 0.7

пунктээр, дараа нь Зүүн бүсийнх (95.2 хувь) 2.4 пунктээр, Хангайн (92.5 хувь) бүсийнх 2.3 пунктээр, Төвийн (81.6 хувь) бүсийнх 10.1 пунктээр, Улаанбаатар (64.6 хувь) хотынх 15.7 пунктээр тус нэмэгджээ (Хүснэгт 5.2).

ХҮСНЭГТ 5.2. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧИД, ТӨРСӨН БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Төрсөн бүс	Бүгд	Тоолох үед байнга амьдарч байсан газар					ШИЛЖИН ЯВСАН
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	-
Баруун	19.2	98.6	3.9	7.1	1.1	11.0	33.0
Хангай	23.2	0.4	92.5	5.7	0.8	10.8	28.2
Төв	17.8	0.3	1.5	81.6	1.2	8.9	21.2
Зүүн	9.3	0.1	0.3	1.5	95.2	4.2	10.5
Улаанбаатар	30.3	0.6	1.7	4.0	1.7	64.6	5.8
Гадаад*	0.2	0.0	0.1	0.1	0.0	0.5	1.3
ШИЛЖИН ИРСЭН	-	0.9	6.7	14.4	1.7	76.3	100.0

Тайлбар: * Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨХТЭЙ ХАРЬЦУУЛСАН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 5 жилийн шилжих хөдөлгөөнийг 2015 оны 1-р сард байнга сууж байсан аймаг, нийслэлээр тооцож гаргасан. Таван жилийн шилжих хөдөлгөөн төрснөөс хойших шилжих хөдөлгөөнтэй харьцуулахад харьцангуй сүүлийн үеийн дүр зургийг харуулдаг.

Таван жилийн өмнөхтэй харьцуулсан шилжих хөдөлгөөний ерөнхий төрх, төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийхтэй төстэй байгаа бөгөөд үндсэн гурван чиглэлтэй байна (Хүснэгт 5.3). Үүнд:

1. Улаанбаатар хот
2. Төвийн бүс нутаг
3. Хангайн бүс нутаг

Нийслэл хотоос бусад бүсэд шилжих хөдөлгөөний урсгал гадагшаа чиглэсэн байна. Цэвэр шилжих хөдөлгөөний сөрөг урсгал Хангайн болон Баруун бүсэд хамгийн өндөр (-8 279, -6 843) байна. Улаанбаатар хотын хүн ам 5 жилийн дотор шилжих хөдөлгөөний улмаас 29.4 мянган хүнээр нэмэгдэж 1 256.4 мянга болсон нь 5, түүнээс дээш насны суурин хүн амын 44.7 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.3. ТАВАН ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮСЭЭР, 2010, 2020 ОН

Бүс	Хүн амын тоо	5 жилийн өмнөх шилжих хөдөлгөөний байдал			Цэвэр шилжих хөдөлгөөн (+/-)
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгчид	Шилжин явагчид	
2010					
БҮГД	2 321 148	2 038 750	282 398	282 398	-
Баруун	348 358	292 011	11 121	56 347	-45 226
Хангай	493 075	425 698	23 723	67 377	-43 654
Төв	391 445	332 898	53 822	58 547	-4 725
Зүүн	182 152	153 452	8 275	28 700	-20 425
Улаанбаатар	884 407	834 691	185 457	49 716	135 741
Гадаад*	21 711	-	-	21 711	-21 711
2020					
БҮГД	2 813 761	2 675 743	138 018	138 018	-
Баруун	361 775	346 400	8 892	15 375	-6 483
Хангай	537 850	510 538	19 033	27 312	-8 279
Төв	447 260	419 342	28 124	27 918	206
Зүүн	195 383	186 564	9 082	8 819	263
Улаанбаатар	1 256 377	1 212 899	72 887	43 478	29 409
Гадаад*	15 116	-	-	15 116	-15 116

Тайлбар: * Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Улаанбаатар хот руу чиглэсэн хамгийн том урсгал төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд оролцогчдын хувьд Баруун бүс нутгаас байсан бол сүүлийн 5 жилд Хангайн болон Төвийн бүс нутгаас ирэгчид хамгийн их байна. Улаанбаатар хот руу Хангайн бүс нутгаас 21.3 мянган хүн шилжиж иржээ. Үүнийг 2010 оны тооллоготой харьцуулахад хоёр дахин буурсан байна. Хамгийн бага урсгал нь Зүүн бүс нутгаас Баруун бүс нутаг руу 107 хүн очсон байна.

ХҮСНЭГТ 5.4. ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮСЭЭР, 2010, 2020 ОН

5 жилийн өмнө байнга амьдарч байсан бүс	5, түүнээс дээш насны хүн амын тоо	Тоолох үед байнга амьдарч байсан бүс					ШИЛЖИН ЯВСАН
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
2010							
БҮГД	2 321 148	303 132	449 421	386 720	161 727	1 020 148	-
Баруун	348 358	292 011	5 355	11 204	379	39 409	56 347
Хангай	493 075	1 430	425 698	9 642	441	55 864	67 377
Төв	391 445	1 117	4 382	332 898	1 439	51 609	58 547
Зүүн	182 152	120	431	3 409	153 452	24 740	28 700
Улаанбаатар	884 407	7 721	12 572	24 038	5 385	834 691	49 716
Гадаад*	21 711	733	983	5 529	631	13 835	21 711
ШИЛЖИН ИРСЭН	-	11 121	23 723	53 822	8 275	185 457	282 398
2020							
БҮГД	2 813 761	355 292	529 571	447 466	195 646	1 285 786	-
Баруун	361 775	346 400	1 199	2 464	312	11 400	15 375
Хангай	537 850	923	510 538	4 530	582	21 277	27 312
Төв	447 260	979	2 974	419 342	1 494	22 471	27 918
Зүүн	195 383	107	445	1 611	186 564	6 656	8 819
Улаанбаатар	1 256 377	6 084	13 816	17 594	5 984	1 212 899	43 478
Гадаад*	15 116	799	599	1 925	710	11 083	15 116
ШИЛЖИН ИРСЭН	-	8 892	19 033	28 124	9 082	72 887	138 018

Тайлбар: * Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Монгол Улсын 2020 оны дотоод шилжих хөдөлгөөнийг 2010 онтой харьцуулахад ерөнхийдөө буурсныг өмнө нь тэмдэглэсэн. Харин бүх бүсийн хувьд 5 жилийн өмнө байнга оршин сууж байсан бүс нутагтаа тоолох үед байнга оршин сууж байсан хүн амын эзлэх хувь өссөн байна. Төвийн бүс нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал харьцангуй өндөр байгаагаас харахад “Бусад бүс – Төвийн бүс – Улаанбаатар хот” гэсэн үе шаттай урсгал явагдаж байна.

Тухайлбал, 5 жилийн өмнө байнга амьдарч байсан бүсдээ тоологдсон 5, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь Улаанбаатар хотод 2010 онд 81.8 хувь байснаа 2020 онд 94.3 хувь болж өссөн байна. Улаанбаатараас бусад бүсэд тоологдсон хүн амын 93.7-97.5 хувь нь тухайн бүс нутагтаа 2015 оны 1 дүгээр сард байнга амьдарч байжээ (Хүснэгт 5.5).

ХҮСНЭГТ 5.5. ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

5 жилийн өмнө байнга амьдарч байсан бүс	Бүгд	Тоолох үед байнга амьдарч байсан бүс				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
2010						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	15.0	96.3	1.2	2.9	0.2	3.9
Хангай	21.2	0.5	94.7	2.5	0.3	5.5
Төв	16.9	0.4	1.0	86.1	0.9	5.1
Зүүн	7.8	0.0	0.1	0.9	94.9	2.4
Улаанбаатар	38.1	2.5	2.8	6.2	3.3	81.8
Гадаад*	0.9	0.2	0.2	1.4	0.4	1.4
2020						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	12.9	97.5	0.2	0.6	0.1	0.9
Хангай	19.1	0.3	96.4	1.0	0.3	1.7
Төв	15.9	0.3	0.6	93.7	0.8	1.7
Зүүн	6.9	0.0	0.1	0.4	95.3	0.5
Улаанбаатар	44.7	1.7	2.6	3.9	3.1	94.3
Гадаад*	0.5	0.2	0.1	0.4	0.4	0.9

Тайлбар: * Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Баруун бүсээс гадагшаа шилжих урсгал өндөр хэвээрээ байна. Гэхдээ Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний хувьд Хангайн бүс Баруун бүсийн оронд түрж орж ирсэн байна. Учир нь Хангайн бүс нутгаас гарсан урсгалын хувьд Төвийн бүс, Улаанбаатар хот гэсэн хоёр гол хүлээж авах бүс байхад Баруун бүсээс гарсан урсгалын хувьд Хангай, Төв, Улаанбаатар хот гэсэн гурван хүлээж авах бүс нутаг байна.

НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөний урсгалыг бүсээр харахад шилжих хөдөлгөөний урсгал өмнөх тооллогууд болох 2000, 2010 онуудын тооллогын үр дүнтэй адилхан үндсэн хоёр чиглэлтэй байна (Хүснэгт 5.6). Үүнд:

1. Улаанбаатар хот
2. Төвийн бүс нутаг

Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал сүүлийн нэг жилд мөн адил хэвээр хадгалагдсан байна. 2010 оны тооллогоор Улаанбаатар хот руу чиглэсэн хамгийн том урсгал Хангайн бүс байсан бол 2020 оны тооллогоор Хангайн бүс дээр Төвийн бүс нэмэгджээ. Тооллогын товоос өмнөх нэг жилд улсын хэмжээнд 80.5 мянган хүн шилжих хөдөлгөөнд оролцсоноос 68.7 хувь нь Улаанбаатар хотод, 13.4 хувь нь Төвийн бүсэд ирж суурьшжээ.

ХҮСНЭГТ 5.6. НЭГ ЖИЛИЙН ӨМНӨ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮСЭЭР, 2010, 2020 ОН

Жилийн өмнө байнга амьдарч байсан бүс	Хүн амын тоо	Сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөний байдал			Цэвэр шилжих хөдөлгөөн (+/-)
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгчид	Шилжин явагчид	
2010					
БҮГД	2 647 545	2 546 378	101 167	101 167	-
Баруун	365 998	347 989	4 548	18 009	-13 461
Хангай	530 152	506 142	8 584	24 010	-15 426
Төв	435 318	417 104	23 589	18 214	5 375
Зүүн	191 418	182 146	3153	9 272	-6 119
Улаанбаатар	1 113 649	1 092 997	61 293	20 652	40 641
Гадаад*	11 010	-	-	11 010	-11 010
2020					
БҮГД	3 123 431	3 042 920	80 511	80 511	-
Баруун	400 987	391 396	3 316	9 591	-6 275
Хангай	594 318	576 652	7 800	17 666	-9 866
Төв	502 161	483 716	10 830	18 445	-7 615
Зүүн	219 214	213 776	3 269	5 438	-2 169
Улаанбаатар	1 391 312	1 377 380	55 296	13 932	41 364
Гадаад*	15 439	-	-	15 439	-15 439

Тайлбар: * Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Улаанбаатар хот руу Төвийн бүсээс сүүлийн нэг жилд 16.1 мянган хүн, Хангайн бүсээс 15.3 мянган хүн шилжиж ирсэн байна. Хамгийн бага урсгал нь Зүүн бүсээс Баруун бүс рүү байна. Мөн 2019 оноос хойш Баруун бүсээс 9.6 мянган хүн, Улаанбаатар хотоос 13.9 мянган хүн, Хангайн бүсээс 17.7 мянган хүн, Төвийн бүсээс 18.4 мянган хүн шилжин явсан байна.

ХҮСНЭГТ 5.7. ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮСЭЭР, 2010, 2020 ОН

Жилийн өмнө байнга амьдарч байсан бүс	Хүн амын тоо	Тоолох үед байнга амьдарч байсан бүс					ШИЛЖИН ЯВСАН
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаан- баатар	
2010							
БҮГД	2 647 545	352 537	514 726	440 693	185 299	1 154 290	-
Баруун	365 998	347 989	1 632	3 083	130	13 164	18 009
Хангай	530 152	570	506 142	4 137	178	19 125	24 010
Төв	435 318	409	1 551	417 104	488	15 766	18 214
Зүүн	191 418	61	158	1 227	182 146	7 826	9 272
Улаанбаатар	1 113 649	3 077	4 838	10 746	1 991	1 092 997	20 652
ШИЛЖИН ИРСЭН	-	4 548	8 584	23 589	3 153	61 293	101 167
2020							
БҮГД	3 123 431**	394 712	584 452	494 546	217 045	1 432 676	-
Баруун	400 987	391 396	597	932	116	7 946	9 591
Хангай	594 318	297	576 652	1 837	216	15 316	17 666
Төв	502 161	336	1 526	483 716	463	16 120	18 445
Зүүн	219 214	50	272	658	213 776	4 458	5 438
Улаанбаатар	1 391 312	1 827	4 817	5 509	1 779	1 377 380	13 932
Гадаад*	15 439	806	588	1 894	695	11 456	15 439
ШИЛЖИН ИРСЭН	-	3 316	7 800	10 830	3 269	55 296	80 511

Тайлбар: * Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

**Монгол Улсад оршин суугаа 1, түүнээс дээш насны хүн амын тоо

Сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөнөөс харахад Улаанбаатар хотын хүн ам 55.3 мянган хүнээр нэмэгджээ. Түүнчлэн, Монгол Улсад оршин суугаа 1, түүнээс дээш насны хүн амын 44.6 хувь нь нэг жилийн өмнө Улаанбаатар хотод амьдарч байсан бол 2020 оны тооллогоор 45.9 хувь болж, нэг жилийн дотор Улаанбаатар хотын эзлэх хувь 1.3 пунктээр өсөж, харин Баруун, Хангай, Төвийн бүсийн эзлэх хувь 0.2-0.3 пунктээр тус тус буурч, Зүүн бүсэд ижил түвшинд байна.

ХҮСНЭГТ 5.8. ХҮН АМ, ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Жилийн өмнө байнга амьдарч байсан бүс	Бүгд	Тоолох үед байнга амьдарч байсан бүс				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
2010						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	13.8	98.7	0.3	0.7	0.1	1.1
Хангай	20.0	0.2	98.3	0.9	0.1	1.7
Төв	16.4	0.1	0.3	94.6	0.3	1.4
Зүүн	7.2	0.0	0.0	0.3	98.3	0.7
Улаанбаатар	42.1	0.9	0.9	2.4	1.1	94.7
Гадаад	0.4	0.1	0.1	1.0	0.2	0.5
2020						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	12.8	99.1	0.1	0.2	0.1	0.6
Хангай	19.0	0.1	98.7	0.4	0.1	1.1
Төв	16.1	0.1	0.3	97.8	0.2	1.1
Зүүн	7.0	0.0	0.0	0.1	98.5	0.3
Улаанбаатар	44.6	0.5	0.8	1.1	0.8	96.1
Гадаад	0.5	0.2	0.1	0.4	0.3	0.8


Тайлбар: *Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Энэ удаагийн тооллогын дүнг 2010 онтой харьцуулахад жилийн өмнө байнга амьдарч байсан бүсдээ тооллогын үед байнгаар тоологдсон хүн амын эзлэх хувь төрснөөс хойш болон 5, түүнээс дээш жилийн шилжих хөдөлгөөнтэй адил Улаанбаатар хот болон бүх бүсэд өссөн байна. Жишээлбэл, Улаанбаатар хотод 1.4 пунктээр, бусад бүсэд тоологдсон хүн амын эзлэх хувь 0.2-3.2 пунктээр тус тус нэмэгджээ (Хүснэгт 5.8).

Түүнчлэн, Төв болон Хангайн бүсээс Улаанбаатар хотод, Баруун, Зүүн бүсээс Төв, Хангайн бүсэд хүмүүс ирж байгаа тул Төв болон Хангайн бүс нь зөвхөн “илгээх” биш харин “хүлээж авах” газар, Улаанбаатар хот руу чиглэсэн “үе шаттай шилжих хөдөлгөөн”-ий “дамжих цэг” болж, харин Улаанбаатар хот “эцсийн цэг” болж байна. Өөрөөр хэлбэл, Төвийн бүс нутаг, Улаанбаатар хотод улс орны өнцөг булан бүрээс ирсэн дийлэнх хүмүүсийн хувьд хүлээж авах “эцсийн цэг” нь болсон хэвээр байна.

Сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөний урсгалын талаарх тоо баримтыг бүс нутагт тоологдсон хүн амын тоотой харьцуулан шилжих хөдөлгөөний цэвэр коэффициентыг тооцож үзэхэд бүх бүсийн хувьд 2010 онтой харьцуулахад буурсан байна. Улаанбаатар хотын цэвэр шилжилтийн коэффициент эерэг байгаа бөгөөд шилжин ирэгчид шилжин явагчдаасаа өндөр үзүүлэлттэй гарч 6.8 промиллээр буурсан байна. Харин бусад бүсийнх сөрөг гарсан нь шилжин явагчид ирэгчдээсээ өндөр байгаа бөгөөд Зүүн бүсийнх 22.1, Баруун бүсийнх 21.2, Хангайн бүсийнх 12.5 промиллээр тус тус буурчээ. Төвийн бүсийн шилжих хөдөлгөөний цэвэр коэффициентыг харахад сонирхолтой дүр зураг харагдаж байгаа бөгөөд 12.3-аас сөрөг урсгалтай болж 15.2 болсон байна.

ЗУРАГ 5.6 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЦЭВЭР КОЭФФИЦИЕНТ, БҮСЭЭР, 2010, 2020 ОН



ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Шилжих хөдөлгөөнийг хугацаа, нутаг дэвсгэрээс гадна хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, тухайлбал, нас хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал, эдийн засгийн идэвх, орлого, өрхийн сууцны нөхцөл, дэд бүтцийн хангамж зэрэг олон үзүүлэлтүүдийг хамааруулан судлах нь илүү ач холбогдолтой юм. Хэдийгээр тооллогоор цуглуулсан мэдээлэл, үзүүлэлтүүд хязгаарлагдмал ч энэ сэдвээр олон талаас нь нарийвчлан судлах боломж бий бөгөөд дараагийн түүвэр судалгааг хийх хамгийн өргөн хүрээний эх олонлог болдог.

Сүүлийн нэг жилд шилжих хөдөлгөөнд оролцогчдыг нас, хүйсээр ангилан үзэхэд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бараг 5.4 мянгаар илүү байгаа нь эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд давамгайлж байгааг харуулж байна. Ялангуяа 20-54 насны эрэгтэйчүүд түлхүү шилжих хөдөлгөөнд оролцжээ.


Ахимаг насанд эрэгтэйчүүдийн шилжих хөдөлгөөн давамгайлж байгааг тэд эхлээд зорьсон газраа ганцаараа очиж, дараа нь гэр бүлийнхнийгээ татан авч байгаатай холбон тайлбарлаж болно. Шилжигчдийн дотор 20-34 насны залуучууд илүү ихээр шилжсэн нь (нийт шилжигчдийн 38.5 хувь) их, дээд, мэргэжлийн сургуульд суралцагчдыг тоолох үед байгаа газарт нь тоолсонтой холбоотой юм.

ХҮСНЭГТ 5.9. СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010				2020			
	Эрэгтэй		Эмэгтэй		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	60 953	100.0	53 069	100.0	46 679	100.0	41 276	100.0
0-4	4 776	7.8	4 613	8.7	4 782	10.2	4 547	11.0
5-9	2 384	3.9	2 354	4.4	4 254	9.1	4 149	10.1
10-14	2 370	3.9	2 236	4.2	2 462	5.3	2 430	5.9
15-19	10 645	17.5	12 253	23.1	2 354	5.0	2 465	6.0
20-24	13 239	21.7	12 483	23.5	5 066	10.8	6 496	15.7
25-29	6 988	11.5	5 262	9.9	6 663	14.3	6 231	15.1
30-34	5 307	8.7	3 375	6.4	5 546	11.9	3 885	9.4
35-39	4 441	7.3	2 568	4.8	3 808	8.2	2 406	5.8
40-44	3 841	6.3	2 014	3.8	3 070	6.6	1 849	4.5
45 +	6 962	11.4	5 911	11.1	8 674	18.6	6 818	16.5

Монгол Улсын нийт хүн амд сүүлийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 2.8 байгаагийн дотор эрэгтэйчүүд (1.5 хувь) эмэгтэйчүүдээс (1.3 хувь) ялимгүй илүү байна. Эмэгтэйчүүдийн хувьд 20-29 насны эмэгтэйчүүд (30.8 хувь) давамгайлж байгаа нь сургуульд дэвшин суралцахтай холбоотой байж болох юм. Нөгөө талаар 15-аас доош насны хүүхдүүд, 60, түүнээс дээш насны өндөр настнууд багагүй хэмжээгээр шилжих хөдөлгөөнд оролцсон байгаагаас үзэхэд гэр бүлийн шилжилт байгааг харуулж байна. Хүүхэд, өндөр настнууд эцэг, эх болон асран хамгаалагчийнхаа хамт шилждэг байна (Зураг 5.7).

СУРАГ 5.7 СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД ШИЛЖИГЧИД, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН



Нийт хүн амтай харьцуулахад 20-34 насны залуучууд боловсролоо ахиулах, мэргэжил эзэмших шалтгаанаар шилжих хөдөлгөөнд илүү их оролцож байна. Харин 20-24 насны хувьд боловсрол мөн чухал хүчин зүйл болохоос гадна шилжин очиж байгаа газарт ажил олдох боломжтой байдаг нь бас нэг шалтгаан болно.

ХҮН АМЫН БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС

Төрсөн нутагтаа 2020 оны тооллогын үед байнга оршин суугаа хүн амын эзлэх хувь Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 96.1 байна (Хүснэгт 5.1). Энэ үзүүлэлтийг 2010 оны тооллоготой харьцуулахад 3.8 пунктээр өссөн байна. Төрсөн бүс нутагтаа тооллогын үед амьдарч байгаа хүн амын эзлэх хувь хамгийн бага түвшинтэй бүс нь Баруун бүс (64.0 хувь) байна. Харин Төвийн бүс 9.6, Зүүн бүсийнх 9.4, Хангайн бүсийнх 6.3 пунктээр өмнөх тооллогоос нэмэгджээ.

Улаанбаатар хотод төрөөд, өөр бүсэд тоологдсон хүн амын 2.2 хувь нь Төвийн бүсэд, 1.1 хувь нь Хангайн бүсэд, 0.4 хувь нь Зүүн бүсэд, 0.2 хувь нь Баруун бүсэд байна. Энэ нь Улаанбаатар хотод төрсөн хүн өөр бүсэд шилжин суурьших сонирхол тун бага байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 5.10. ТӨРСӨН БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Төрсөн бүс	Бүгд	Тоолох үед байнга амьдарч байсан газар				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
2010						
БҮГД	100.0	13.3	19.4	16.6	7.0	43.6
Баруун	100.0	57.9	4.2	8.1	0.4	29.4
Хангай	100.0	0.3	68.2	5.2	0.3	26.0
Төв	100.0	0.3	2.1	65.4	0.7	31.5
Зүүн	100.0	0.1	0.8	3.6	67.0	28.5
Улаанбаатар	100.0	0.5	2.0	4.4	0.7	92.3
Гадаад*	100.0	2.5	5.3	24.6	4.2	63.5
2020						
БҮГД	100.0	12.4	18.7	16.4	7.4	45.1
Баруун	100.0	64.0	3.7	6.1	0.4	25.8
Хангай	100.0	0.2	74.5	4.0	0.3	21.0
Төв	100.0	0.2	1.6	75.0	0.5	22.7
Зүүн	100.0	0.1	0.7	2.5	76.4	20.3
Улаанбаатар	100.0	0.2	1.1	2.2	0.4	96.1
Гадаад*	100.0	1.2	4.3	8.3	0.7	85.5

Тайлбар: * Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Улаанбаатар хотын хүн амын 99.0 хувь нь жилийн өмнө амьдарч байсан бүсдээ тоологдсон ба 2010 оны тооллоготой харьцуулахад 1.0 пунктээр өссөн байна (Хүснэгт 5.11). Өөрөөр хэлбэл, 2020 оны тооллогын үед Улаанбаатар хотод байнга оршин сууж байгаа хүн амын 0.9 хувь нь сүүлийн нэг жилд шилжин хөдөлгөөнд оролцсон байна. Улаанбаатар хотын дараа жилийн өмнө амьдарч байсан бүс нутагтаа тооллогын үед байнга амьдарч байсан хүн амын эзлэх хувь хамгийн өндөртэй бүс нутаг нь Баруун (97.7 хувь) болон Зүүн бүс (97.6 хувь) байна.

ХҮСНЭГТ 5.11. НЭГ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Жилийн өмнө байнга амьдарч байсан бүс	Бүгд	Тоолох үед байнга амьдарч байсан бүс				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
2010						
БҮГД	100.0	13.3	19.4	16.6	7.0	43.6
Баруун	100.0	95.1	0.4	0.8	-	3.6
Хангай	100.0	0.1	95.5	0.8	-	3.6
Төв	100.0	0.1	0.4	95.8	0.1	3.6
Зүүн	100.0	0.0	0.1	0.6	95.2	4.1
Улаанбаатар	100.0	0.3	0.4	1.0	0.2	98.1
Гадаад*	100.0	3.9	3.7	39.9	3.3	49.2
2020						
БҮГД	100.0	12.6	18.7	15.8	7.0	45.9
Баруун	100.0	97.7	0.1	0.2	0.0	2.0
Хангай	100.0	0.0	97.0	0.3	0.0	2.7
Төв	100.0	0.1	0.3	96.3	0.1	3.2
Зүүн	100.0	0.0	0.1	0.3	97.6	2.0
Улаанбаатар	100.0	0.1	0.3	0.4	0.1	99.0
Гадаад*	100.0	5.2	3.8	12.3	4.5	74.2

Тайлбар: *Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс


Доорх хүснэгтээс харахад Монгол Улсад оршин суугаа хүн амын 45.9 хувь нь амьдардаг Улаанбаатар хотын 5, түүнээс дээш насны хүн амын 96.5 хувь нь 5 жилийн өмнө Улаанбаатар хотод амьдарч байжээ. Энэ нь 2010 оны тооллоготой харьцуулахад 2.1 пунктээр өссөн байна. Харин бүсээр задалбал Баруун бүсийнх 12.0 пунктээр, Зүүн бүсийнх 11.3 пунктээр, Төвийн бүсийнх 8.8 пунктээр, Хангайн бүсийнх 8.6 пунктээр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 5.12. ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, ТООЛОХ ҮЕД БАЙНГА АМЬДАРЧ БАЙСАН БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

5 жилийн өмнө байнга амьдарч байсан бүс	Бүгд	Тоолох үед байнга амьдарч байсан бүс				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
2010						
БҮГД	100.0	13.1	19.4	16.7	7.0	44.0
Баруун	100.0	83.8	1.5	3.2	0.1	11.3
Хангай	100.0	0.3	86.3	2.0	0.1	11.3
Төв	100.0	0.3	1.1	85.0	0.4	13.2
Зүүн	100.0	0.1	0.2	1.9	84.2	13.6
Улаанбаатар	100.0	0.9	1.4	2.7	0.6	94.4
Гадаад*	100.0	3.4	4.5	25.5	2.9	63.7
2020						
БҮГД	100.0	12.6	18.8	15.9	7.0	45.7
Баруун	100.0	95.8	0.3	0.7	0.1	3.1
Хангай	100.0	0.2	94.9	0.8	0.1	4.0
Төв	100.0	0.2	0.7	93.8	0.3	5.0
Зүүн	100.0	0.1	0.2	0.8	95.5	3.4
Улаанбаатар	100.0	0.5	1.1	1.4	0.5	96.5
Гадаад*	100.0	5.3	4.0	12.7	4.7	73.3

Тайлбар: *Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ



10, түүнээс дээш
насны хүн ам

- A Боловсролгүй
- B Бага
- C Суурь
- D Бүрэн дунд
- E Техникийн болон мэргэжлийн
- F Тусгай мэргэжлийн дунд
- H Дээд

БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Тооллогоор хүн амын боловсролыг тодорхойлох нь хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд, ажиллах хүч, шилжих хөдөлгөөн, байршил, орон сууц зэрэг үндэсний болон бүс нутаг, аймаг, нийслэлийн хэмжээний бодлого, төлөвлөлтийг боловсруулахад чухал хэрэглүүр болдог.

Хүн амын үзүүлэлтүүдээс боловсрол, бичиг үсэг тайлагдалт нь хүний хөгжлийн явцыг илтгэдэг.

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 10 дугаар зүйлд “Боловсролын агуулга нь суралцагчийн нас, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ” гэсэн үндсэн агуулгад үндэслэн сүүлийн тооллогуудын асуулга, аргачлал, заавар, үр дүн боловсруулсан байдаг.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын асуулгын хуудсанд боловсролын түвшний холбогдох асуултыг 6, түүнээс дээш насны бүх хүнээс асуудаг байсан бол 2020 оны тооллогоор 5, түүнээс дээш насны хүнээс асуусан. Мөн 2010 оны тооллогоор бакалаврын болон дипломын дээдийг хамтад нь авч үздэг байсан бол 2020 оны тооллогоор уг үзүүлэлтийг тус тусад нь авч үзэв.

Монгол Улсын “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 7 дугаар зүйлд “Бага боловсролыг 6, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлнэ”, мөн “Дээд боловсролын тухай” хуулиар “Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120-оос, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна” гэж заажээ.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолмол аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн гишүүдээс бичиг үсэг тайлагдалтын талаарх мэдээллийг авсан. Тиймээс 2020 оны тооллогын бичиг үсэг тайлагдалтын талаарх тоо мэдээллийг 2010 оны тооллогын дүнтэй хувийн жингээр харьцуулна.

НҮБ-ын зөвлөмж, олон улсын нийтлэг жишгийг харгалзан хүн амын боловсролын түвшнийг 10, түүнээс дээш насанд тодорхойлов.

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Монгол Улсын боловсролын систем улам бүр шинэчлэгдэж хөгжингүй орнуудын түвшинд хүрч эхэлсэн. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор боловсролын үзүүлэлтүүд 2010 оны тооллогоос өсөж, харин 10, түүнээс дээш насны хүн амд боловсролгүй хүний эзлэх хувь буурсан.

Боловсролтой 10, түүнээс дээш насны хүн амын дунд эзлэх хувь 95.1 болж өмнөх тооллогын үеэс 2.6 пунктээр өссөн байна. Хүйсийн ялгаатай байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 2.7 пунктээр, эмэгтэйчүүдийнх 2.3 пунктээр өсжээ. Боловсролгүй хүн амын эзлэх хувь 4.9 болж өмнөх тооллогын дүнгээс 2.6 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Боловсролтой хүн амыг боловсролын түвшнээр харвал бага, суурь, бүрэн дунд, тусгай мэргэжлийн дунд 0.8-аас 2.8 пунктээр тус тус буурсан бол техникийн болон мэргэжлийн, дээд боловсролтой хүн амын эзлэх хувь өмнөх тооллоготой харьцуулахад өсжээ.

Харин 10, түүнээс дээш насны нийт хүн амын 26.5 хувь нь дээд боловсролтой, байгааг хүйсээр харвал эрэгтэйчүүдийн 21.7 хувь, эмэгтэйчүүдийн 31.1 хувь нь дээд боловсролтой хүн ам байна. Монгол Улсад дээд боловсролтой хүн ам сүүлийн 10 жилд даруй 8.2 пунктээр өссөн нь сайшаалтай хэрэг юм.

ХҮСНЭГТ 6.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Боловсролын түвшин	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	7.5	8.0	6.9	4.9	5.3	4.6
Боловсролтой	92.5	92.0	93.1	95.1	94.7	95.4
Бага	15.8	16.6	15.0	13.7	14.6	12.8
Суурь	17.9	20.3	15.6	17.1	19.2	15.1
Бүрэн дунд	32.0	32.2	31.9	29.2	30.8	27.7
Техникийн болон мэргэжлийн	2.8	3.1	2.6	3.9	4.3	3.4
Тусгай мэргэжлийн дунд	5.7	4.6	6.9	4.7	4.1	5.3
Дээд	18.3	15.4	21.2	26.5	21.7	31.1

Боловсрол эзэмшигчдийг хүйсээр ангилж үзэхэд нэлээд ялгаатай талууд ажиглагдаж байна. Ялангуяа өмнөх тооллогоор дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 5.8 пунктээр илүү байсан бол 2020 онд тус зөрүү нь 9.4 пункт болж нэмэгджээ.

Боловсролгүй 10, түүнээс дээш настай хүн амын дүнд эзлэх хувь 4.9 болж 2.6 пунктээр буурсны дотор эрэгтэйчүүдийнх 2.7 пунктээр буурчээ.

Нийгмийн хөгжлийн явцад хүн амын боловсрол эзэмших хэрэгцээ, шаардлага, боломж өөр өөр байна. Өмнөх тооллогуудын дүнгээс үзэхэд нас ахих тусам хүн амын боловсролын түвшин залуучуудтай харьцуулахад бага байдаг нь нас дэвшилтээс шалтгаалсан байж болох юм.

Хүн амын боловсролын байдал хот, хөдөөгөөр ангилж үзэхэд ялгаатай байдал харагдаж байна.

ХҮСНЭГТ 6.2. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Боловсролын түвшин	Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	4.9	5.2	4.6	13.1	13.7	12.5
Боловсролтой	95.1	94.8	95.4	86.9	86.3	87.5
Бага	10.8	11.1	10.6	26.6	27.6	25.5
Суурь	14.3	16.5	12.2	26.0	27.9	23.9
Бүрэн дунд	37.6	38.8	36.5	19.6	18.6	20.6
Техникийн болон мэргэжлийн	2.5	2.8	2.2	3.5	3.5	3.5
Тусгай мэргэжлийн дунд	6.5	5.3	7.5	4.2	3.0	5.4
Дээд, түүнээс дээш	23.4	20.2	26.4	7.0	5.6	8.6
2020						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	4.3	4.7	4.0	6.2	6.6	5.9
Боловсролтой	95.7	95.3	96.0	93.8	93.4	94.1
Бага	10.0	10.6	9.6	21.2	22.4	20.0
Суурь	11.2	12.7	9.9	29.0	31.7	26.2
Бүрэн дунд	32.3	35.2	29.7	22.9	22.2	23.6
Техникийн болон мэргэжлийн	3.6	4.0	3.1	4.5	4.8	4.1
Тусгай мэргэжлийн дунд	5.5	4.8	6.0	3.2	2.7	3.6
Дээд	33.1	28.0	37.7	13.0	9.6	16.6

Хот, хөдөөгийн хүн амын боловсролын байдал ялгаатай байгаагийн дотор түвшин дээшлэх тутамд ялгаа улам нэмэгдэж байна. Тухайлбал, бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын хувь хотод хөдөөгөөс 9.4-20.1 пунктээр илүү байгаа бол бага болон суурь, боловсролтой хүмүүсийн хувь хөдөөд хотоос 11.2-17.8 пунктээр өндөр байна.

Харин боловсролгүй хүн амын хувьд хот, хөдөөгийн зөрүү 2000 оноос 2010 оны хооронд 8.2 пункт байсан бол 2010 оноос 2020 оны хооронд 1.9 пункт болж 6.3 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Хотын хүн амын боловсролын түвшин 2010 онтой харьцуулахад дээд, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын хувь өссөн байгаа бол хөдөөгийн хүн амын хувьд бага, суурь боловсролтой хүн амын хувь буурсан байна.

ХҮСНЭГТ 6.3. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Боловсролгүй	БОЛОВСРОЛЫН ТҮВШИН					
			Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
2010								
БҮГД	100.0	7.5	15.8	17.9	32.0	2.8	5.7	18.3
10-14	100.0	33.0	59.8	7.2	-	-	-	-
15-19	100.0	3.4	12.8	41.0	39.4	1.8	1.0	0.6
20-24	100.0	4.0	5.7	9.7	51.3	2.8	2.7	23.8
25-29	100.0	6.1	10.2	13.0	31.1	1.5	2.2	36.1
30-34	100.0	3.7	10.1	19.6	34.9	1.5	3.0	27.3
35-39	100.0	2.1	4.0	20.3	40.3	4.4	7.4	21.5
40-44	100.0	2.5	4.5	18.2	39.4	5.9	11.7	17.9
45-49	100.0	3.1	6.5	18.3	33.9	5.6	12.7	19.8
50-54	100.0	3.1	11.2	19.7	27.1	5.0	13.9	20.0
55-59	100.0	3.7	16.8	17.2	23.8	4.1	15.1	19.4
60+	100.0	11.7	30.6	11.5	15.7	2.2	11.0	17.2
2020								
БҮГД	100.0	4.9	13.7	17.1	29.2	3.9	4.7	26.5
10-14	100.0	28.5	70.8	0.7	-	-	-	-
15-19	100.0	2.0	5.4	61.3	27.9	1.8	0.9	0.7
20-24	100.0	1.7	3.3	12.2	49.9	4.9	2.6	25.4
25-29	100.0	1.6	3.2	8.5	29.4	5.4	3.1	48.8
30-34	100.0	1.9	5.2	9.4	29.5	3.2	2.7	48.1
35-39	100.0	2.6	8.1	14.8	30.9	2.6	2.6	38.4
40-44	100.0	1.7	6.3	20.3	35.6	3.0	3.6	29.5
45-49	100.0	1.4	3.6	18.4	38.4	5.9	7.4	24.9
50-54	100.0	1.6	4.3	17.7	36.7	7.1	10.5	22.1
55-59	100.0	1.8	6.5	17.8	32.0	6.8	11.8	23.3
60+	100.0	2.9	18.0	16.2	22.5	4.7	12.7	23.0


Боловсролын түвшнийг насаар ангилж үзэхэд зарим сонирхолтой дүр зураг харагдаж байна. 2020 оны тооллогоор 10, түүнээс дээш насны хүн амын дийлэнх нь буюу 64.3 хувь нь бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой байгаа нь өмнөх тооллогынхоос 5.5 пунктээр өссөн байна (Хүснэгт 6.3).

25-44 насны хүн амын дээд боловсролтой хүн амын эзлэх хувь хамгийн өндөр болж өмнөх

тооллоготой харьцуулахад 11.6-20.8 пунктээр өссөн байна. Ерөнхийдөө бүх насны бүлэгт ажиглагдаж байгаа дүр зураг нь бүрэн дундаас доош боловсролтой хүн амын эзлэх хувийг 2010 онтой харьцуулахад 15-44 насны бүлэгт буурч байгаа бол эсрэгээрээ бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой хүн амын эзлэх хувь насны бүлэг бүрд тодорхой хэмжээгээр өссөнийг харж болохоор байна. Энэ нь сүүлийн жилүүдэд манай улсын сургуулийн өмнөх боловсрол болон сургуульд хамрагдалтын байдал нийт хүн амын хувьд өссөн байгаатай холбон тайлбарлаж болох юм. 2010 оны тооллогоор 60, түүнээс дээш насны хүн амд боловсролгүй хүн амын эзлэх хувь өндөр байсан бол энэ удаагийн тооллогоор бага боловсролтой хүн амын эзлэх хувь буурч, суурь, түүнээс дээш боловсролын түвшний хувь нь өссөн байна.

Ерөнхийдөө 20-40 хүртэл насны хүмүүс буюу ид хөдөлмөрийн насны хүн амын хувьд боловсролын түвшин өндөр байгаа нь сайн талтай ч тухайн насны хүн амын дотор мэргэжлийн боловсролтой хүний эзлэх хувь маш бага байгаа нь үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжилтэй ажиллагчдын хүрэлцээ хангалтгүй байгааг харуулж байна.

ЗУРАГ 6.1. ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН СУВАРГА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН




Өмнөх тооллогын дүнгээр эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэйгээр дээд боловсрол эзэмшдэг байсан бол энэ удаад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдтэй ижил түвшинтэй болж байгаа хандлага ажиглагдаж байна (Зураг 6.1). Мөн 2010 онтой харьцуулахад дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь 30, түүнээс дээш насны бүлэгт өссөн байгаа бол эрэгтэйчүүдийн хувьд эсрэгээрээ бага зэргийн бууралт ажиглагдаж байна.

БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

НҮБ-ын бичиг үсгийн мэдлэгийн тодорхойлолтын талаарх зөвлөмжийг өмнөх тооллогуудтай адил 2020 оны тооллогод баримталсан. Аль нэг хэлээр энгийн өгүүлбэрийг уншиж ойлгодог, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзсэн. Тооллогод боловсролгүй хүнээс бичиг үсгийн мэдлэгийг асуусан.

ЗУРАГ 6.2. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ*, 2020 ОН



Тайлбар: *Монголд суугаа гадаадын харьяат иргэн болон харьяалалгүй иргэн ороогүй.

Бичиг үсгийн мэдлэгийн талаарх асуултыг 5, түүнээс дээш насны бүх хүнээс асуусан ч Монгол Улсын хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшнийг олон улстай харьцуулагдахуйц байдлыг ханган 15, түүнээс дээш насаар тодорхойлов (Хүснэгт 6.4).


ХҮСНЭГТ 6.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Бичиг үсгийн мэдлэг	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бичиг үсэг мэддэг	98.3	99.1	96.3	98.7	99.3	97.6
Бичиг үсэг мэддэггүй	1.7	0.9	3.7	1.3	0.7	2.4

Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсэг мэдлэгийн түвшин 98.7 хувь болж өмнөх тооллогоос 0.4 пунктээр өссөн. Монгол Улсын бичиг үсэг тайлагдалтын түвшнийг дэлхийн улс орнуудын дундаж түвшинтэй⁶ харьцуулахад өндөр байгаа юм. Харин хот, хөдөөгийн оршин суугчдын хувьд ялгаа ажиглагдаж байна. Хотын бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь 0.7 хувь байхад хөдөөгийнх 2.4 хувь буюу 1.7 пунктээр зөрүүтэй байна. Үүнээс үзэхэд хотын хүн амын ихэнх нь бичиг үсэг мэддэг болсон ба энэ үзүүлэлтэд оюун ухааны бэрхшээлийн улмаас бичиг үсэг сурах боломжгүй хүн байгааг харгалзан үзэх учиртай.

6 <http://data.uis.unesco.org/index.aspx?queryid=166>

ЗУРАГ 6.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010, 2020 ОН



Бичиг үсэг мэддэггүй залуучуудын түвшин 2020 онд 15-19 насныхны хувьд 0.6 хувь болж 2010 онтой харьцуулахад 1.0 пунктээр буурсан байна. Харин байршлаар харвал хотын залуучуудын 0.6 хувь, хөдөөгийн залуучуудын 1.7 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байна. Үүнээс үзэхэд хөдөөгийн хүн амын боловсролд анхаарах шаардлагатай болсныг харуулж байна./Хавсралт В-ийн Хүснэгт 6.3-аас харна уу./ Бичиг үсэг мэддэггүй хүн ам 2010 онтой харьцуулахад бүх насны бүлэгт буурсан харагдаж байна.

СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод сургуульд суралцаж байгаа болон цэцэрлэгт хүмүүжиж байгаа эсэхийг 2-39 насны хүмүүсээс асуусан.

НҮБ-ын зөвлөмжийн дагуу сургуульд суралцах насыг 5-29 насаар тодорхойлох ёстой боловч манай улсын боловсролын шинэ тогтолцооны дагуу хүүхдийг 6 наснаас эхлэн сургуульд элсүүлэх болсонтой холбогдуулан сургуульд хамрагдалтыг 6-29 насаар авлаа.

Сургуульд хамрагдалт өмнөх тооллогуудтай харьцуулахад байнга өсжээ. 2020 оны тооллогоор 6-29 насны хүн амын 72.6 хувь нь сургуульд хамрагдаж байгаа ба 2010 онтой харьцуулахад 14.5 пунктээр нэмэгдсэн байна. Ялангуяа 6-17 насны буюу ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдүүдийн 98.0 хувь нь сургуульд хамрагдаж байна (Хүснэгт 6.5).

ХҮСНЭГТ 6.5. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Нас	Сургуульд сурдаг			Сургуульд сурдаггүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010						
6-29	58.1	55.7	60.6	41.9	44.3	39.4
6	93.6	93.0	94.3	6.4	7.0	5.7
7	97.9	97.7	98.1	2.1	2.3	1.9
8	98.4	98.3	98.6	1.6	1.7	1.4
9	98.5	98.3	98.6	1.5	1.7	1.4
6-9	97.1	96.8	97.4	2.9	3.2	2.6
10	98.2	97.9	98.5	1.8	2.1	1.5
11	97.6	97.1	98.1	2.4	2.9	1.9
12	96.7	95.8	97.7	3.3	4.2	2.3
13	95.8	94.6	97.0	4.2	5.4	3.0
14	94.7	92.8	96.7	5.3	7.2	3.3
10-14	96.6	95.6	97.6	3.4	4.4	2.4
15	93.0	90.5	95.6	7.0	9.5	4.4
16	89.5	85.5	93.6	10.5	14.5	6.4
17	84.0	79.0	89.2	16.0	21.0	10.8
6-17	94.8	93.3	96.3	5.2	6.7	3.7
18	72.5	65.2	80.0	27.5	34.8	20.0
19	61.0	52.2	69.9	39.0	47.8	30.1
20-24	29.8	25.8	33.8	70.2	74.2	66.2
25-29	5.6	4.7	6.5	94.4	95.3	93.5
2020						
6-29	72.6	71.5	73.8	27.4	28.5	26.2
6	93.3	93.0	93.6	6.7	7.0	6.4
7	97.3	96.9	97.7	2.7	3.1	2.3
8	98.9	98.9	98.9	1.1	1.1	1.1
9	98.8	98.7	98.9	1.2	1.3	1.1
6-9	96.9	96.7	97.1	3.1	3.3	2.9
10	99.4	99.4	99.4	0.6	0.6	0.6
11	99.4	99.3	99.5	0.6	0.7	0.5
12	99.4	99.3	99.5	0.6	0.7	0.5
13	99.3	99.2	99.5	0.7	0.8	0.5
14	99.2	99.0	99.4	0.8	1.0	0.6
10-14	99.4	99.3	99.4	0.6	0.7	0.6
15	98.3	97.6	99.0	1.7	2.4	1.0
16	97.4	96.3	98.6	2.6	3.7	1.4
17	96.3	94.8	97.8	3.7	5.2	2.2
6-17	98.0	97.6	98.3	2.0	2.4	1.7
18	87.1	82.9	91.3	12.9	17.1	8.7
19	80.5	73.9	87.3	19.5	26.1	12.7
20-24	53.4	50.2	56.7	46.6	49.8	43.3
25-29	17.9	17.0	18.9	82.1	83.0	81.1

Сургуульд хамрагдалтыг хүйсээр харвал 2010 онтой харьцуулахад сургуульд хамрагдалтын байдал 6-14 насны хүн амын хувьд ижил түвшинд байгаа ч 15, түүнээс дээш насанд буюу суурь боловсролын түвшнийг дүүргэсний дараагаар эрэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад буурсан харагдаж байна.

Сургуульд хамрагдалтын байдал 25-29 насны хүн амд 17.9 хувь болж 2010 оноос 12.3 пунктээр өссөн нь хамгийн өндөр байна.


Сургуульд хамрагдалтыг хот, хөдөөгөөр харвал 14 нас хүртэл хөдөөд өндөр байсан бол 15, түүнээс дээш насанд хотын хүн амын сургууль хамрагдалт өндөр болж байна. Энэ хандлага нь нас ахих тусам нэмэгдсээр 25-29 насанд хотын хүн амын сургуульд хамрагдалт хөдөөгийнхөөс 7.4 пунктээр өндөр байна.

ХҮСНЭГТ 6.6. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Нас	Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010						
6-29	60.1	58.4	61.8	53.8	50.2	57.8
6	96.1	95.8	96.5	89.6	88.5	90.7
7	98.4	98.3	98.5	97.0	96.7	97.4
8	98.7	98.6	98.7	98.0	97.8	98.3
9	98.7	98.6	98.9	98.0	97.8	98.2
6-9	98.0	97.8	98.2	95.7	95.3	96.2
10-14	71.7	97.1	98.0	95.1	93.4	96.9
15-17	93.0	91.1	94.8	80.7	73.5	88.7
15	95.8	94.7	96.9	88.2	83.5	93.1
16	93.5	91.7	95.4	81.2	73.4	89.8
17	89.6	86.9	92.2	68.8	59.5	79.9
6-17	96.4	95.6	97.2	92.0	89.3	94.8
18	81.4	76.8	85.7	35.4	27.7	47.8
19	71.7	64.9	77.9	17.4	13.1	24.5
20-24	37.3	33.5	40.9	6.2	5.1	7.6
25-29	7.2	6.1	8.3	2.0	1.8	2.2
2020						
6-29	73.7	73.8	73.6	70.6	67.4	74.1
6	93.0	92.8	93.2	94.0	93.4	94.5
7	97.6	97.3	97.9	96.7	96.0	97.3
8	98.7	98.7	98.7	99.2	99.5	99.2
9	98.5	98.4	98.6	99.4	99.3	99.4
6-9	96.8	96.6	96.9	97.2	96.9	97.5
10-14	99.3	99.3	99.3	99.4	99.2	99.6
15-17	98.3	97.9	98.6	95.8	93.5	98.3
15	98.8	98.5	99.0	97.5	96.0	99.0
16	98.4	97.9	98.9	95.9	93.6	98.3
17	97.7	97.3	98.1	94.1	90.9	97.5
6-17	98.0	97.9	98.2	97.8	97.1	98.5
18	89.6	87.2	92.0	83.2	76.3	90.2
19	84.1	79.6	88.7	75.0	65.6	85.1
20-24	56.7	55.5	57.9	48.3	42.4	54.9
25-29	20.2	19.7	20.7	12.8	11.4	14.4

Бүх насны бүлэгт сургуульд суралцаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь хот, хөдөөгийн хувьд ялгаагүй эрэгтэйчүүдийнхээс илүү байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол зөвхөн сургуульд орохдоо төдийгүй сургуульд орсныхоо дараа бүх насанд өндөр байна.

ЗУРАГ 6.4. СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010, 2020 ОН



Сургуульд хамрагдаж буй нийт хүн амын хүйсийн харьцааг өмнөх тооллоготой харьцуулбал бүх насны бүлэгт нэмэгдэж байна. Энэ нь эрэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт нэмэгдэж байгааг харуулж байна. 2020 оны тооллогоор 6-14 насны бүлэгт хүйсийн харьцаа 104.1 байгаа нь нийт хүн амын бүтэцтэй ижил байгаа боловч нас дээшлэх тусам хүйсийн харьцаа буурч байна.

Сургуулийн өмнөх боловсролд 2-5 насны хүүхдийн 84.1 хувь нь хамрагдаж байгаа бөгөөд 2010 оноос 24.0 пунктээр өсжээ. Байршлаар харвал хөдөөд 2-5 насны хүүхдүүдийн 83.6 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нь өмнөх тооллогоос 38.0 пунктээр өссөн эерэг үзүүлэлттэй байна.


ХҮСНЭГТ 6.7. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, НАС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Нас	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	60.1	68.2	45.6	84.1	84.3	83.6
2	44.5	51.6	31.5	65.2	65.5	64.4
3	59.2	68.4	42.1	85.0	85.1	84.8
4	67.5	76.9	51.2	90.9	90.9	91.0
5	75.5	83.0	62.7	94.0	93.9	94.1

7

БҮЛЭГ

ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ



ӨРХИЙН ТОО, БҮТЭЦ

Өрхийг “Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо садан төрлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно. Өрх гэдэг ойлголт нь гэр бүл гэдэг ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно” гэж тодорхойлдог. Өрхийн талаарх энэ тодорхойлолт нь өмнөх тооллогууд болоод олон улсад ашигладаг нэгдмэл ойлголт юм.

Хүн амыг үндсэнд нь өрхөд, өрх үүсгээгүй нэгжид тоологдсон гэж 2 ангилдаг. Өрх үүсгээгүй нэгж гэж “Нийтээрээ буюу хэсэг бүлгээрээ амьдарч байгаа хоорондоо гэр бүл ураг төрөл, хамаатан садны холбоогүй хүмүүсийг” хэлнэ. Өрх үүсгээгүй нэгжийн хүмүүс ихэвчлэн цэрэг, хоригдол, оюутан сурагчид болон ажиллагчдын нийтийн байр, эмнэлэг, сувилал, зочид буудлын нэг өрөөнд хамт амьдарч байгаа болон орон сууцны нэг өрөө буюу бүхэлд нь хөлслөн сууж байгаа мөн байшингийн дээвэр хонгил, орц, дулааны шугам сүлжээний сувагт хамт амьдардаг, ураг төрөл, хамаатан садны холбоогүй хүмүүс юм.

ЗУРАГ 7.1. ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМ, 2020 ОН



Хүн ам, орон сууны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 897.4 мянган өрхөд суурин хүн амын 97.7 хувь буюу 3 123 487 хүн, өрх үүсгээгүй нэгжид 2.3 хувь буюу 73 533 хүн тус тус тоологдов (Зураг 7.1).

ХҮСНЭГТ 7.1. ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

	2010		2020		2020 / 2010 %
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	мян.хүн	Дүнд эзлэх хувь	
БҮГД	2 647.5	100.0	3 197.0	100.0	120.8
Өрхөд	2 553.8	96.5	3 123.5	97.3	122.3
Өрх үүсгээгүй нэгжид	93.7	3.5	73.5	2.3	78.4

Өрхөд тоологдсон хүний тоо өмнөх тооллогын үеийнхээс 569.7 мянга буюу 22.3 хувиар (жилд дунджаар 2.3 хувиар) өсөж, өрх үүсгээгүй нэгжид тоологдсон хүний тоо өмнөх тооллогын үеийнхээс 20.2 мянга буюу 21.6 хувиар (жилд дунджаар 2.4 хувиар) буурсан байна.

ХҮСНЭГТ 7.2. ӨРХ, ӨРХ ҮҮСГЭЭГҮЙ НЭГЖИД ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Өрхийн хамаарал					
	Бүгд	хувь	Өрхөд тоологдсон хүн ам	хувь	Өрхөд хамаарахгүй хүн ам	хувь
БҮГД	3 197 020	100.0	3 123 487	97.7	73 533	2.3
Архангай	94 324	100.0	93 278	98.9	1 046	1.1
Баян-Өлгий	103 908	100.0	102 696	98.8	1 212	1.2
Баянхонгор	88 008	100.0	87 019	98.9	989	1.1
Булган	61 344	100.0	60 541	98.7	803	1.3
Говь-Алтай	57 479	100.0	56 612	98.5	867	1.5
Дорноговь	69 859	100.0	67 752	97.0	2 107	3.0
Дорнод	82 020	100.0	79 705	97.2	2 315	2.8
Дундговь	46 698	100.0	45 994	98.5	704	1.5
Завхан	72 307	100.0	71 293	98.6	1 014	1.4
Өвөрхангай	115 737	100.0	114 003	98.5	1 734	1.5
Өмнөговь	69 858	100.0	65 973	94.4	3 885	5.6
Сүхбаатар	62 884	100.0	62 105	98.8	779	1.2
Сэлэнгэ	107 755	100.0	105 535	97.9	2 220	2.1
Төв	92 409	100.0	89 117	96.4	3 292	3.6
Увс	82 941	100.0	82 286	99.2	655	0.8
Ховд	88 078	100.0	87 113	98.9	965	1.1
Хөвсгөл	134 318	100.0	132 137	98.4	2 181	1.6
Хэнтий	77 320	100.0	75 796	98.0	1 524	2.0
Дархан-Уул	102 171	100.0	99 888	97.8	2 283	2.2
Орхон	104 032	100.0	101 699	97.8	2 333	2.2
Говьсүмбэр	17 445	100.0	16 860	96.6	585	3.4
Улаанбаатар	1 466 125	100.0	1 426 085	97.3	40 040	2.7

Өрхөд үүсгээгүй нэгжид тоологдсон хүн амын улсын дундаж 2.3 байна. Энэ нь Улаанбаатар, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Өмнөговь аймгуудад улсын дунджаас 0.4-3.3 пунктээр өндөр байна.

ХҮСНЭГТ 7.3. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

	2010		2020		2020 / 2010 %
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	
БҮГД	713.8	100.0	897.4	100.0	125.7
Хот	479.5	67.2	606.3	67.6	126.5
Хөдөө	234.3	32.8	291.1	32.4	124.2

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор 897.4 мянган өрх тоологдсон байна. Энэ нь өмнөх тооллогын дүнгээс 183.6 мянга буюу 25.7 хувиар (жилд дунджаар 2.9 хувиар) өссөн байна. Үүний дотор хотын өрх 126.8 мянга буюу 26.4 хувиар (жилд дунджаар 2.9 хувиар), хөдөөгийн өрх 56.8 мянга буюу 24.3 хувиар (жилд дунджаар 2.7 хувиар) тус тус өсжээ. Мөн нийт өрхийн тоо 1989 оноос 2.1 дахин, хотын өрхийн хувьд 2.6 дахин, хөдөөгийн өрхийн хувьд 1.5 дахин тус тус өсжээ.

2020 оны тооллогоор тоологдсон 897.4 мянган өрхийн 67.6 хувь нь хотод, 32.4 хувь нь хөдөөд амьдарч байна. Хотод амьдарч байгаа өрхийн хувь өмнөх тооллоготой харьцуулахад 0.4 пунктээр нэмэгдсэн байна.

ӨРХИЙН ХЭЛБЭР

Өрхийн хэлбэрийг НҮБ-ын аргачлалын дагуу тодорхойлдог ба ингэхдээ тухайн өрхөд тоологдсон өрхийн гишүүдийн өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг харгалздаг. Энэ нь улс орны нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн дунд болон урт хугацааны бодлого боловсруулах үндсэн мэдээлэл болдог. Өрхийг өмнөх тооллогуудын мөн адил 4 хэлбэрт ангилсан.

ЗУРАГ 7.2. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Өрхийн бүтцийн хувьд авч үзвэл 59.8 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 22.7 хувь нь нийлмэл⁷ ам бүлтэй өрх, 15.4 хувь нь ганц бие өрх, 2.2 хувь нь холимог⁸ ам бүлтэй өрх байна. Өмнөх тооллогын дүнгээс ам бүлээрээ байгаа өрх 91.3 мянга буюу 20.5 хувиар, нийлмэл ам бүлтэй өрх 25.4 мянга буюу 14.3 хувиар, ганц бие өрх 61.9 мянга буюу 81.6 хувиар, холимог ам бүлтэй өрх 5.1 мянга буюу 34.2 хувиар тус тус өссөн байна. (Зураг 7.2).

Өөрөөр хэлбэл, 10 өрх тутмын 6 нь ам бүлээрээ буюу эхнэр, нөхөр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх байна. Мөн нийлмэл ам бүлтэй, өөрөөр хэлбэл эцэг, эх, ах, дүүс, садан төрлөөрөө сууж байгаа бүтэцтэй өрх нэлээдгүй хувийг эзэлж байгаа нь үр хүүхэд, хамаатан садантайгаа хамт амьдрах нь манай уламжлалт заншилтай уялдаатай гэж үзэж болно.

ХҮСНЭГТ 7.4. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Өрхийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
2010						
БҮГД	713.8	100.0	479.5	100.0	234.3	100.0
Ганц бие	75.9	10.6	47.2	9.9	28.7	12.2
Ам бүлээрээ	445.0	62.4	275.6	57.5	169.4	72.3
Нийлмэл	177.9	24.9	145.2	30.3	32.7	13.9
Холимог	14.9	2.1	11.4	2.4	3.5	1.5
2020						
БҮГД	897.4	100.0	606.3	100.0	291.1	100.0
Ганц бие	137.8	15.4	86.1	14.2	51.7	17.7
Ам бүлээрээ	536.3	59.8	340.0	56.1	196.3	67.4
Нийлмэл	203.3	22.6	161.4	26.6	41.9	14.4
Холимог	20.0	2.2	18.8	3.1	1.2	0.5

7 Хоорондоо хамааралтай хэд хэдэн ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг нийлмэл өрх гэнэ.

8 Ураг төрлийн хамааралтай болон хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг холимог өрх гэнэ.

Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод (161.4 мянга) хөдөөгөөс (41.9 мянга) 3.9 дахин их байгаа нь өмнөх тооллогын дүнгээс 0.5 пунктээр өссөн байна. Энэ нь төв, суурин газарт орон сууцны хүрэлцээ хангамж болон хөдөөгөөс шилжин ирэгчид хамаатан садантайгаа хамт амьдрах нь ихсэж байгаатай холбоотой гэж үзэж байна. Үүний зэрэгцээ хотод ганц бие өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 81.6 хувиар өссөнийг мөн шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болох юм (Хүснэгт 7.4).

ХҮСНЭГТ 7.5. ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	хувь	мян.өрх	хувь	мян.өрх	хувь
2010						
БҮГД	713.8	100.0	479.5	100.0	234.3	100.0
1-2	190.6	26.7	124.0	25.9	66.6	28.4
3-4	337.6	47.3	229.7	47.9	107.9	46.1
5-6	154.0	21.6	102.3	21.3	51.7	22.1
7+	31.6	4.4	23.6	4.9	8.0	3.4
2020						
БҮГД	897.4	100.0	606.3	100.0	291.1	100.0
1-2	282.0	31.4	184.5	30.4	97.5	33.5
3-4	340.6	38.0	235.5	38.9	105.1	36.1
5-6	215.8	24.0	141.5	23.3	74.3	25.5
7+	59.0	6.6	44.8	7.4	14.2	4.9

Өрхийн ам бүлийн тоо хот, хөдөөгөөр ялгаатай байгаа боловч улсын хэмжээний өрхийн ам бүлийн дундаж хэмжээ болох 3-4 ам бүлтэй өрхийн эзлэх хувь хотод 69.1 хувь, хөдөөд 30.9 хувьтай байна.

Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 1-2 ам бүлтэй өрх хотод 60.4 мянга буюу 48.7 хувиар, хөдөөд 31.0 мянга буюу 46.5 хувиар тус тус өссөн байна. Үүнийг шилжих хөдөлгөөнтэй холбож тайлбарлавал хотод их, дээд сургуульд суралцагчид болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирсэн хүмүүс тусдаа өрх болж тоологдсонтой холбоотой байж болох юм. 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн тоо хотод хөдөөгөөс 3.1 дахин их байна.

ХҮСНЭГТ 7.6. ӨРХ, АМ БҮЛИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Ам бүлийн тоогоор				Өрхийн ам бүлийн дундаж тоо	
		1-2	3-4	5-6	7+	2010	2020
БҮГД	100.0	31.4	38.0	24.0	6.6	3.6	3.6
Архангай	100.0	33.3	36.9	26.0	3.8	3.3	3.5
Баян-Өлгий	100.0	16.9	34.3	35.7	13.1	4.4	4.3
Баянхонгор	100.0	34.0	38.1	24.1	3.8	3.4	3.4
Булган	100.0	38.3	34.9	23.1	3.7	3.3	3.3
Говь-Алтай	100.0	30.1	40.5	26.0	3.4	3.5	3.6
Дорноговь	100.0	34.5	38.7	21.8	5.0	3.3	3.5
Дорнод	100.0	35.8	36.0	22.6	5.6	3.5	3.5
Дундговь	100.0	38.7	36.3	21.5	3.5	3.4	3.3
Завхан	100.0	32.6	38.7	25.1	3.6	3.4	3.5
Өвөрхангай	100.0	33.0	37.9	25.1	4.0	3.5	3.5
Өмнөговь	100.0	39.7	38.1	19.7	2.5	3.3	3.3
Сүхбаатар	100.0	29.6	42.2	25.0	3.2	3.5	3.5
Сэлэнгэ	100.0	29.6	37.5	25.5	7.4	3.5	3.7
Төв	100.0	38.2	34.0	22.9	4.9	3.3	3.4
Увс	100.0	26.3	37.4	29.9	6.4	3.8	3.8
Ховд	100.0	25.3	35.0	31.7	8.0	3.9	3.9
Хөвсгөл	100.0	31.5	40.3	24.1	4.1	3.4	3.5
Хэнтий	100.0	40.9	34.5	20.9	3.7	3.3	3.2
Дархан-Уул	100.0	30.2	39.4	23.7	6.7	3.5	3.5
Орхон	100.0	26.0	43.8	24.5	5.7	3.5	3.7
Говьсүмбэр	100.0	33.5	37.5	24.1	4.9	3.3	3.5
Улаанбаатар	100.0	30.7	38.2	22.9	8.2	3.7	3.6

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор өрхийн ам бүлийн дундаж тоо 3.6 гарсан нь өмнөх тооллоготой ижил түвшинд байна. Өрхийн ам бүлийн дундаж тоо Төв, Говь-Алтай, Говьсүмбэр, Завхан, Дорноговь, Сэлэнгэ, Архангай, Орхон аймгуудад 0.1-0.2 хувиар өссөн. Харин Баян-Өлгий, Дундговь, Хэнтий аймаг болон Улаанбаатар хотод 0.1 хувиар буурсан байна. Баянхонгор, Булган, Хөвсгөл Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Дархан-Уул аймгуудын хувьд 2010 оны тооллогын өрхийн ам бүлийн дундажтай ижил байна (Хүснэгт 7.6).

Өрхийн ам бүлийн дундаж тоо Баян-Өлгий аймагт хамгийн өндөр бөгөөд улсын дунджаас бараг нэг хүнээр илүү байна. Баян-Өлгий аймгийн дараа Ховд аймгийн өрхийн ам бүлийн дундаж тоо улсын дунджаас илүү байна. Нийт өрхөд эзлэх 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн хувь Баян-Өлгий аймагт улсын дунджаас 2 дахин өндөр байгаа нь угсаатны онцлог юм. Улаанбаатар хотод 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн эзлэх хувь нэлээд өндөр байгаа нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой гэж үзэж байна.

Өрхийн тэргүүлэгчийг хүйс, хот, хөдөөгөөр ангилахад ялгаатай талууд ажиглагдана.

ХҮСНЭГТ 7.7. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
2010						
БҮГД	713.8	100.0	479.5	100.0	234.3	100.0
Эрэгтэй тэргүүлэгчтэй	560.2	78.5	364.3	76.0	196.0	83.6
Эмэгтэй тэргүүлэгчтэй	153.6	21.5	115.2	24.0	38.3	16.4
2020						
БҮГД	897.4	100.0	606.3	100.0	291.1	100.0
Эрэгтэй тэргүүлэгчтэй	641.5	71.5	408.9	67.4	232.5	79.9
Эмэгтэй тэргүүлэгчтэй	255.9	28.5	197.4	32.6	58.6	20.1

Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 7.0 пунктээр, хотод 8.6 пунктээр, хөдөөд 3.7 пунктээр тус тус нэмэгджээ.

ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн амын төрөлт, өсөлтөд шууд нөлөөлдөг хүчин зүйл бол гэр бүлийн байдал юм. Гэрлэх нь үндэсний соёл, уламжлалтай нягт холбоотой явагддаг нийгмийн үзэгдэл тул түүний үндсэн төрх тооллого хоорондын жилүүдэд төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

ХҮСНЭГТ 7.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Гэрлэлтийн байдал	2000		2010		2020	
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	мян.хүн	Дүнд эзлэх хувь	мян.хүн	Дүнд эзлэх хувь
БҮГД	1 524.4	100.0	1 906.0	100.0	2 152.1	100.0
Огт гэр бүл болоогүй	505.1	33.1	596.1	31.3	678.9	31.5
Гэр бүлтэй*	880.4	57.8	1 146.2	60.1	1 303.7	60.6
Цуцалсан**	41.5	2.7	59.0	3.1	51.5	2.4
Бэлэвсэн	97.4	6.4	104.6	5.5	118.0	5.5

Тайлбар: *батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

**гэрлэлтээ цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Гэрлэлтээ цуцалсан болон тусгаарласан хүний эзлэх хувь өмнөх тооллогын дүнгээс 0.7 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ 7.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Гэрлэлтийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	мян.хүн	Дүнд эзлэх хувь	мян.хүн	Дүнд эзлэх хувь
2010						
БҮГД	1 906.0	100.0	937.3	100.0	968.7	100.0
Огт гэр бүл болоогүй	596.1	31.3	322.5	34.4	273.6	28.2
Гэр бүлтэй*	1 146.2	60.1	568.9	60.7	577.3	59.6
Цуцалсан**	59.0	3.1	25.2	2.7	33.8	3.5
Бэлэвсэн	104.6	5.5	20.7	2.2	84.0	8.7
2020						
БҮГД	2 152.1	100.0	1 039.6	100.0	1 112.5	100.0
Огт гэр бүл болоогүй	678.9	31.5	366.4	35.2	312.5	28.1
Гэр бүлтэй*	1 303.7	60.6	633.9	61.0	669.8	60.2
Цуцалсан**	51.5	2.4	20.3	2.0	31.2	2.8
Бэлэвсэн	118.0	5.5	18.9	1.8	99.0	8.9


Тайлбар: *батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

**гэрлэлтээ цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан.

15, түүнээс дээш настай хүн амыг гэрлэлтийн байдлаар харвал 31.5 хувь нь огт гэрлээгүй, 60.6 хувь нь батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй, 2.4 хувь нь гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан, 5.5 хувь нь бэлэвсэн байна. Өмнөх тооллогын дүнгээс огт гэрлээгүй хүмүүс 82.8 мянга буюу 13.9 хувиар, батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүс 157.5 мянга буюу 13.7 хувиар, бэлэвсэн хүмүүсийн хувьд 13.4 мянга буюу 12.8 хувиар тус тус өссөн байна. Харин цуцалсан болон тусгаарласан хүмүүсийн хувьд 7.5 мянга буюу 12.7 хувиар буурчээ.

Анхны гэрлэлтийн дундаж нас гэсэн үзүүлэлт нь эрэгтэй, эмэгтэйчүүд анх хэдэн насандаа гэр бүл болж байгааг илэрхийлдэг.

ЗУРАГ 7.3. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, ЖИЛЭЭР, 2000, 2010, 2020 ОН



Нийгэм, эдийн засаг хөгжиж, ялангуяа хүн амын боловсролын түвшин дээшлэх тутам анхны гэрлэлтийн дундаж нас хойшилсон байна. Хөгжсөн орнуудын хүн амын хөгжлийн түүхээс үзэхэд анхны гэрлэлтийн дундаж нас хойшилсон нь ажиглагддаг. Манай улсын хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас сүүлийн 20 жилд, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд адилхан 3 насаар хойшилсон. Анхны гэрлэлтийн дундаж нас 2000 оноос 2010 оны хооронд нэг насаар хойшилсон бол 2010 оноос 2020 оны хооронд 2 насаар хойшилсон байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа сүүлийн 20 жилд ойролцоогоор 1-2 насны зөрүүтэй байсаар байна. Энэ бол үндэсний уламжлалт зан заншилтай холбоотой явагддаг нийгмийн үзэгдэл тул тийм ч богино хугацаанд өөрчлөгдөхгүй нь харагдаж байна.

Өмнөх тооллоготой харьцуулахад 15-34 насны бүлэгт огт гэр бүл болоогүй залуучуудын эзлэх хувь 10 орчим пунктээр өссөн нь анхны гэрлэлтийн дундаж насыг хойшлуулж байна. Насны бүлэг дээшлэх тусам огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь 2010 онтой харьцуулахад өсөж байгаа байдал ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 7.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Эрэгтэй					Эмэгтэй				
	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй*	Цуцалсан**	Бэлэвсэн	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй*	Цуцалсан**	Бэлэвсэн
2010										
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-24	29.7	72.8	7.5	2.7	0.1	28.1	75.3	11.1	4.1	0.2
25-34	25.2	18.8	29.8	21.6	2.0	24.2	15.5	31.4	23.8	2.5
35-44	20.2	5.6	28.1	36.8	7.7	19.9	5.2	27.4	35.8	9.6
45-54	14.5	2.0	20.7	28.4	19.7	15.0	2.6	19.1	27.6	22.5
55-64	5.9	0.5	8.4	7.7	21.0	6.8	0.8	7.2	6.8	23.9
65+	4.6	0.3	5.4	2.8	49.7	6.1	0.6	3.8	2.2	41.2
2020										
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-24	21.4	57.2	2.0	0.4	0.0	19.5	61.5	3.7	0.7	0.0
25-34	26.1	29.6	25.3	10.1	1.3	24.4	25.3	27.9	12.5	1.3
35-44	21.4	8.2	29.4	27.4	5.2	20.5	7.1	28.6	27.3	5.5
45-54	16.0	3.5	22.6	35.8	14.6	16.5	3.6	21.7	34.2	16.3
55-64	10.0	1.2	14.2	21.3	29.2	11.7	1.8	13.1	21.0	31.3
65+	5.1	0.3	6.5	5.0	49.7	7.4	0.7	5.0	4.3	45.6

Тайлбар: *батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

**гэрлэлтээ цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Гэрлэлтээ цуцлуулсан болон тусгаарласан хүн амд 45-64 насныхны эзлэх хувь өмнөх тооллоготой харьцуулахад аль ч хүйсийн хувьд нэмэгдсэн, ялангуяа 55-64 насны бүлэгт хүйс тус бүрд 14 орчим пунктээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 7.11. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН


Насны бүлэг	Эрэгтэй					Эмэгтэй				
	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй*	Цуцалсан**	Бэлэвсэн	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй*	Цуцалсан**	Бэлэвсэн
2010										
БҮГД	100.0	34.4	60.7	2.7	2.2	100.0	28.2	59.6	3.5	8.7
15-24	100.0	84.4	15.3	0.2	0.0	100.0	75.7	23.7	0.5	0.1
25-34	100.0	25.7	71.8	2.3	0.2	100.0	18.1	77.6	3.4	0.9
35-44	100.0	9.6	84.7	4.9	0.8	100.0	7.4	82.1	6.3	4.2
45-54	100.0	4.7	87.1	5.3	3.0	100.0	4.9	75.7	6.4	13.0
55-64	100.0	2.8	85.9	3.5	7.8	100.0	3.3	62.8	3.5	30.4
65+	100.0	2.5	71.9	1.6	24.0	100.0	2.9	37.2	1.2	58.6
2020										
БҮГД	100.0	35.2	61.0	2.0	1.8	100.0	28.1	60.2	2.8	8.9
15-24	100.0	94.3	5.7	0.0	0.0	100.0	88.5	11.4	0.1	0.0
25-34	100.0	40.0	59.1	0.8	0.1	100.0	29.1	69.0	1.4	0.5
35-44	100.0	13.5	83.6	2.5	0.4	100.0	9.7	84.2	3.7	2.4
45-54	100.0	7.8	86.1	4.4	1.7	100.0	6.2	79.2	5.8	8.8
55-64	100.0	4.3	86.3	4.1	5.3	100.0	4.3	67.0	5.0	23.7
65+	100.0	2.1	78.1	1.9	17.9	100.0	2.7	40.7	1.6	55.0

Тайлбар: *батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

**гэрлэлтээ цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан.


Бэлэвсэн эмэгтэйчүүдийн хувь аль ч насанд эрэгтэйчүүдийнхээс мэдэгдэхүйц их байна (Хүснэгт 7.11). Ялангуяа 65, түүнээс дээш насанд бэлэвсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 37.1 пунктээр илүү байгаа бөгөөд тухайн насны бүлэгт эрэгтэйчүүдийн нас баралт өндөр байгаатай холбон тайлбарлаж болох юм.

ЗУРАГ 7.3. ГЭРЛЭЛТЭЭ ЦУЦЛУУЛСАН ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН



Гэрлэлтээ цуцлуулсан хүний тоо 2010 онд 35-44 насанд өндөр байсан бол 2020 оны тооллогын дүнгээс 45-54 насанд гэр бүл цуцлалт илүү нэмэгдсэн байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ



Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хууль, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”, Ази Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги 2012-2022 зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний бүрэн оролцоог хангасан, ая тухтай, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх асуудлаарх үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх дэлгэрэнгүй, үнэн бодит тоо мэдээлэл зайлшгүй шаардлагатай байдаг. Иймээс НҮБ-ын тооллогын зарчим зөвлөмжид хөгжлийн бэрхшээлийн асуудлыг үндсэн үзүүлэлтээр оруулахыг зөвлөмж болгосон байдаг.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх тоо мэдээллийг гаргах нь улс орны хөгжлийн бодлого хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын бодлого хөтөлбөрийг боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн өргөн хүрээний хэрэгцээг тодорхойлох, тэдгээрийн оролцоог бүхий л салбарт өсөн нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэхэд нэн ач холбогдолтой.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын онцлогоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо мэдээллийг Хүн ам, ерхийн мэдээллийн сан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Эрүүл мэндийн яамны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сангуудыг уялдуулж гаргасан.

Хөгжлийн бэрхшээл


Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2020 онд 106.4 мянга болж өмнөх тооллогоос 1.6 хувиар буурч, суурин хүн амын 3.3 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	108 071	100.0	106 363	100.0
0-4	1 957	1.8	1 548	1.4
5-9	3 068	2.8	3 298	3.1
10-14	4 436	4.1	3 274	3.1
15-19	6 390	5.9	3 205	3.0
20-24	7 933	7.3	4 685	4.4
25-29	8 833	8.2	6 517	6.1
30-34	8 988	8.3	8 299	7.8
35-39	10 250	9.5	10 114	9.5
40-44	11 596	10.7	11 122	10.5
45-49	13 551	12.5	13 248	12.5
50-54	11 788	10.9	15 192	14.3
55-59	6 756	6.3	13 665	12.8
60-64	3 223	3.0	6 603	6.2
65-69	2 690	2.5	2 422	2.3
70+	6 612	6.2	3 171	3.0

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 6.1 хувийг 10-19 нас буюу өсвөр үеийнхэн, 10.5 хувийг 20-29 насныхан эзэлж байгаа бөгөөд өмнөх тооллогоос 3.9 пункт, 5.0 пунктээр тус тус буурчээ. Харин 35-59 насныхан нийт хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 59.6 хувийг (63.3 мянга) эзэлж байна. Үүнээс 50-54 насныхан 14.3 хувь болж 2010 оноос 3.4 пунктээр, 55-59 насныхан 12.8 хувь болж 6.5 пунктээр тус тус өссөн нь хамгийн өндөр өсөлт байна.

ЗУРАГ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



2020 оны тооллогын дүнгээр хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 58.9 мянга (55.4 хувь) нь эрэгтэй, 47.4 мянга (44.6 хувь) нь эмэгтэйчүүд байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 41.3 хувийг 15-44 насныхан, 46.2 хувийг 45-64 насныхан, үлдсэн хувийг нь 0-14 насны хүүхдүүд болон 65, түүнээс дээш насныхан эзэлж байна. 2010 онтой харьцуулахад нийт хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдэд 15-44 насныхны эзлэх хувь 9.1 пунктээр буурсан бол 45-64 насныхны эзлэх хувь 12.2 пунктээр өссөн байна. Харин нийт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 41.3 хувийг 15-44 насныхан, 45.3 хувийг 45-64 насныхан эзэлж байгаа нь өмнөх тооллогоос 15-44 насныхны эзлэх хувь 8.2 пунктээр, 65 түүнээс дээш насныхны эзлэх хувь 4.7 пунктээр тус тус буурсан бол 45-64 насныхан 14.3 пунктээр өссөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний 45-64 насныхан аль ч хүйсэд өндөр хувь эзэлж байгааг дээрхээс харж болно(Зураг 8.1). Харин 65, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.8 дахин олон байгаа нь эмэгтэйчүүд өндөр насалдагтай холбоотой юм.

ХҮСНЭГТ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН


Аймаг, нийслэл	2010		2020		2020 / 2010 %
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	
БҮГД	108 071	100.0	106 363	100.0	98.4
Архангай	3 720	3.4	3 430	3.2	92.2
Баян-Өлгий	3 856	3.6	4 245	4.0	110.1
Баянхонгор	3 696	3.4	3 590	3.4	97.1
Булган	2 318	2.1	2 098	2.0	90.5
Говь-Алтай	2 528	2.3	2 904	2.7	114.9
Дорноговь	2 560	2.4	2 654	2.5	103.7
Дорнод	4 082	3.8	4 019	3.8	98.5
Дундговь	1 881	1.7	1 858	1.7	98.8
Завхан	2 939	2.7	3 650	3.4	124.2
Өвөрхангай	4 604	4.3	3 972	3.7	86.3
Өмнөговь	2 183	2.0	2 026	1.9	92.8
Сүхбаатар	3 057	2.8	2 672	2.5	87.4
Сэлэнгэ	4 711	4.4	4 416	4.2	93.7
Төв	3 825	3.5	3 216	3.0	84.1
Увс	3 358	3.1	4 470	4.2	133.1
Ховд	2 896	2.7	2 564	2.4	88.5
Хөвсгөл	6 553	6.1	5 826	5.5	88.9
Хэнтий	4 136	3.8	3 004	2.8	72.6
Дархан-Уул	3 738	3.5	4 131	3.9	110.5
Орхон	3 516	3.3	4 226	4.0	120.2
Говьсүмбэр	510	0.5	707	0.7	138.6
Улаанбаатар	37 404	34.6	36 685	34.5	98.1

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоогоор Хөвсгөл, Увс, Сэлэнгэ, Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул аймгууд хамгийн олон, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь аймгууд хамгийн цөөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2010 онтой харьцуулахад Говьсүмбэр, Увс, Завхан аймгуудад хамгийн өндөр өсөлттэй байгаа бол Хэнтий, Төв, Өвөрхангай аймгуудад хамгийн өндөр бууралттай байна.

Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 34.5 хувь (36.7 мянга) нь оршин сууж байгаа хэдий ч өсөлтийн түвшин нь 2010 оныхтой бараг ижил түвшинд буюу 0.1 пунктээр өссөн байна. Тус өсөлт Увс (1.1 пункт), Орхон (0.7 пункт), Завхан (0.7 пункт) аймгуудад хамгийн өндөр байна.

СУРАГ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



Тухайн аймгийн нийт хүн амд эзэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийг өмнөх тооллоготой харьцуулахад Орхон, Говьсүмбэр, Говь-Алтай, Завхан, Увс аймгуудад 0.1-0.8 пунктээр өссөн бол бусад аймаг болон Улаанбаатар хотод буурсан байна. Эдгээрээс Хэнтий(2.4 пункт), Сүхбаатар(1.8 пункт), Хөвсгөл(1.4 пункт) аймгуудад хамгийн ихээр буурчээ.

ХҮСНЭГТ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХОТ, ХӨДӨӨ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН


Аймаг нийслэл	2010				2020			
	Хот		Хөдөө		Хот		Хөдөө	
	хүний тоо	хувь	хүний тоо	хувь	хүний тоо	хувь	хүний тоо	хувь
БҮГД	67 069	62.1	41 002	37.9	65 060	61.2	41 303	38.8
Архангай	914	24.6	2 806	75.4	693	20.2	2 737	79.8
Баян-Өлгий	1 222	31.7	2 634	68.3	1 358	32.0	2 887	68.0
Баянхонгор	1 584	42.9	2 112	57.1	1 255	35.0	2 335	65.0
Булган	591	25.5	1 727	74.5	625	29.8	1 473	70.2
Говь-Алтай	864	34.2	1 664	65.8	1 004	34.6	1 900	65.4
Дорноговь	1 309	51.1	1 251	48.9	1 511	56.9	1 143	43.1
Дорнод	2 309	56.6	1 773	43.4	2 192	54.5	1 827	45.5
Дундговь	640	34.0	1 241	66.0	543	29.2	1 315	70.8
Завхан	696	23.7	2 243	76.3	680	18.6	2 970	81.4
Өвөрхангай	1 851	40.2	2 753	59.8	1 149	28.9	2 823	71.1
Өмнөговь	782	35.8	1 401	64.2	904	44.6	1 122	55.4
Сүхбаатар	1 033	33.8	2 024	66.2	828	31.0	1 844	69.0
Сэлэнгэ	2 244	47.6	2 467	52.4	1 804	40.9	2 612	59.1
Төв	606	151.8	3 219	84.2	631	19.6	2 585	80.4
Увс	1 302	38.8	2 056	61.2	1 749	39.1	2 721	60.9
Ховд	1 095	37.8	1 801	62.2	1 014	39.5	1 550	60.5
Хөвсгөл	2 148	32.8	4 405	67.2	1 756	30.1	4 070	69.9
Хэнтий	1 991	48.1	2 145	51.9	1 169	38.9	1 835	61.1
Дархан-Уул	2 708	72.4	1 030	27.6	3 074	74.4	1 057	25.6
Орхон	3 393	96.5	123	3.5	4 024	95.2	202	4.8
Говьсүмбэр	383	75.1	127	24.9	412	58.3	295	41.7
Улаанбаатар	37 404	100.0	-	-	36 685	100.0	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 61.2 хувь (65.1 мянга) нь хотод, 38.8 хувь (41.3 мянга) нь хөдөөд амьдарч байгаа ч аймаг бүрд ялгаатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог хот, хөдөөгөөр зэрэгцүүлэн тайлбарлахдаа Улаанбаатар хот болон Орхон, Дархан-Уул аймгуудыг оруулаагүй болно.

Дорноговь, Дорнод, Говьсүмбэр аймгуудын хот суурин газарт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хөдөө оршин сууж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдээсээ их байгаа бол Хөвсгөл, Завхан, Архангай аймгуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөөд илүү олноороо оршин сууж байна. Хотод байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өмнөх тооллоготой харьцуулахад Хэнтий 41.3 хувь, Өвөрхангай 37.9 хувь, Архангай 24.1 хувиар тус тус буурч, хөдөө оршин сууж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд Говьсүмбэр 132.3 хувь, Орхон 64.2 хувь, Завхан 32.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


ЗУРАГ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН



Тооллогоор нийт 106.4 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд тоологдсоны 50.6 мянга(47.6 хувь) нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байгаа ба өмнөх тооллогоос 37.7 хувиар өссөн байна. Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 55.7 мянга (52.4 хувь) байгаа нь өмнөх тооллогоос 21.8 хувиар буурсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 45.0 хувь (26.5 мянга) нь төрөлхийн, 55.0 хувь (32.4 мянга) нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 50.8 хувь (24.1 мянга) нь төрөлхийн, 49.2 хувь (23.3 мянга) нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна (Зураг 8.3). Дээрхээс харахад 2020 онд хөгжлийн бэрхшээлтэй 10 эмэгтэй тутмын 5 нь олдмол байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 1 хүнээр, эрэгтэйчүүдийн хувьд 5 болж 2 хүнээр буурсан байна.

ЗУРАГ 8.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН



Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл 20.2 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй, 22.5 хувь нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 33.9 хувь нь бусад (Хавсарсан болон бусад хөгжлийн бэрхшээлийг энд оруулав) төрлийн бэрхшээлтэй хүн ам байгаа нь хамгийн өндөр байна. Харин харааны бэрхшээлтэй хүн ам 3.1 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага байна.

Уг үзүүлэлтийг өмнөх тооллогын дүнтэй харьцуулбал хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам 23.3 хувиар, харааны бэрхшээлтэй хүн ам 23.3 хувиар, сонсголын бэрхшээлтэй хүн ам 31.2 хувиар тус тус буурсан бол сэтгэцийн бэрхшээлтэй хүн ам 3.0 хувиар өссөн байна.

ҮЙЛДЛИЙН ЧАДВАР

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор НҮБ-ын Вашингтон бүлгээс боловсруулсан үйлдлийн чадварыг тодорхойлох богино багц асуултуудыг асуусан. Богино багц асуулга нь харах, сонсох, алхах, өөртөө анхаарал тавих, харилцах, ой тогтоолт /санах/ гэсэн 6 багц үйл ажиллагааны хувьд хүндрэлийг тодорхойлдог.

Үйлдлийн хүндрэлийг Вашингтон бүлгийн богино багц асуулгын зөвлөмжийн дагуу 18, түүнээс дээш настай хүн амын хувьд тооцдог. Ингэхдээ дээрх 6 үйлдлийн чадвараас дор хаяж нэгд нь “маш их хүндрэлтэй” эсвэл “огт чадахгүй” гэж хариулсан тохиолдлыг үйлдлийн чадварын хүндрэлтэй гэж үздэг.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын 12.9 хувь нь 18-34 насны залуучууд байгаа бол 46.9 хувь нь 35-64 насны, 40.2 хувь нь 65, түүнээс дээш насны хүн ам байна. Эдгээрийн 28.7 хувь нь алхах, 18.9 хувь нь харааны байгаа бол хамгийн бага (10.1 хувь) нь харилцах үйлдлийн хүндрэлтэй хүмүүс байна.

ХҮСНЭГТ 8.4. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Хүндрэлийн хэлбэр					
		Харааны	Сонсголын	Алхах	Ой тогтоолт/ санах	Өөртөө анхаарал тавих	Харилцах
БҮГД	100.0	18.9	15.9	28.7	12.9	13.5	10.1
18-19	100.0	19.0	13.1	14.9	17.5	14.2	21.3
20-24	100.0	17.4	13.1	15.9	21.8	13.0	18.8
25-29	100.0	20.2	11.9	16.9	19.8	12.2	19.0
30-34	100.0	18.2	16.2	20.3	17.0	11.7	16.6
35-39	100.0	20.1	17.4	21.4	16.4	10.8	13.9
40-44	100.0	19.3	18.9	22.9	16.1	9.5	13.3
45-49	100.0	22.7	16.3	26.5	13.1	10.1	11.3
50-54	100.0	22.4	16.7	28.8	12.8	9.4	9.9
55-59	100.0	20.6	15.0	32.7	11.2	12.3	8.2
60-64	100.0	17.4	15.1	36.7	10.5	13.3	7.0
65-69	100.0	18.5	13.9	38.3	10.7	13.2	5.4
70+	100.0	16.9	16.6	30.1	11.0	17.5	7.9


ХҮСНЭГТ 8.5. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Хүндрэлийн хэлбэр					
		Харааны	Сонсголын	Алхах	Ой тогтоолт/ санах	Өөртөө анхаарал тавих	Харилцах
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
18-19	1.3	1.3	1.0	0.7	1.7	1.3	2.6
20-24	3.1	2.9	2.6	1.7	5.2	3.0	5.8
25-29	3.6	3.8	2.7	2.1	5.5	3.4	6.8
30-34	4.9	4.7	4.9	3.4	6.4	4.2	8.0
35-39	5.6	6.0	6.1	4.2	7.1	4.5	7.8
40-44	6.2	6.3	7.3	4.9	7.7	4.4	8.1
45-49	7.9	9.4	8.1	7.3	8.0	5.9	8.8
50-54	8.5	10.1	8.9	8.6	8.5	5.9	8.4
55-59	9.6	10.5	9.1	11.0	8.4	8.8	7.9
60-64	9.1	8.4	8.6	11.7	7.4	9.0	6.3
65-69	7.9	7.8	6.9	10.6	6.6	7.8	4.2
70+	32.3	28.8	33.8	33.8	27.5	41.8	25.3

18-34 насныхны хувьд хараа, харилцах, ой тогтоолт/ санах үйлдлийн хүндрэл, 35 ба түүнээс насныхны хувьд хараа болон алхах үйлдлийн хүндрэл хамгийн их байна.


Тухайн үйлдлийн чадварын хүндрэлийг насны ангиллаар авч үзвэл 45, түүнээс дээш насны хүн амын хүндрэл бусад насны хүн амынхнаас өндөр байна.

ЗУРАГ 8.5. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮМҮҮС, ДАВХАРДЛААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Идэр залуу буюу 18-34 насныхан болон 65, түүнээс дээш насныхны хувьд хүндрэлийн давхардал их байгаа бол дунд эргэм насныхны хувьд харьцангуй бага байна.

ЗУРАГ 8.6. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ОГТ ХҮНДРЭЛГҮЙ ХҮМҮҮСИЙН СУУРИН ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Дээрх зургаас харахад 55, түүнээс дээш насны хүн амын үйлдлийн чадварын хүндрэл нас ахихын хэрээр их болж байна.

Хүндрэлгүй хүн амын нийт суурин хүн амд эзлэх хувийн жин бүх насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс өндөр байна. Энэ нь эмэгтэйчүүд илүү хянамгай, эрүүл мэнддээ анхаардгаас шалтгаалдаг байж болох юм.

ХҮСНЭГТ 8.6. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Хүндрэлийн хэлбэр						
	Бүгд	Харааны	Сонсголын	Алхах	Ой тогтоолт/ санах	Өөртөө анхаарал тавих	Харилцах
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Архангай	3.4	2.8	3.1	3.3	4.1	3.8	3.7
Баян-Өлгий	3.2	3.5	3.0	3.5	3.2	3.4	2.4
Баянхонгор	3.3	3.7	3.3	3.3	3.7	2.8	2.8
Булган	2.4	2.1	2.6	2.5	2.5	2.4	2.7
Говь-Алтай	2.3	2.3	2.8	2.2	2.3	2.3	2.1
Дорноговь	3.0	2.5	2.6	3.5	2.8	2.7	2.7
Дорнод	2.3	2.9	2.5	2.0	2.5	1.8	2.0
Дундговь	1.7	1.6	1.2	2.0	2.1	1.4	1.7
Завхан	2.2	2.3	2.2	2.1	2.4	2.3	1.9
Өвөрхангай	4.6	4.8	4.9	4.5	4.4	4.4	4.1
Өмнөговь	1.8	1.8	1.9	2.0	1.5	2.0	1.7
Сүхбаатар	2.8	3.3	2.5	2.8	2.3	2.9	3.0
Сэлэнгэ	2.6	2.1	2.3	2.6	3.1	3.0	3.4
Төв	3.8	4.2	3.6	3.9	3.9	3.5	3.3
Увс	2.9	2.7	2.8	2.8	2.9	2.2	3.3
Ховд	3.2	2.8	3.0	3.1	3.4	3.6	3.1
Хөвсгөл	4.7	4.9	4.7	4.5	4.6	5.0	5.2
Хэнтий	3.1	4.0	3.1	3.0	3.0	2.5	2.7
Дархан-Уул	3.8	4.0	4.1	3.7	3.7	3.5	3.7
Орхон	2.7	2.4	2.9	2.6	2.6	3.3	2.7
Говьсүмбэр	0.7	0.8	0.8	0.7	0.6	0.7	0.8
Улаанбаатар	39.5	38.5	40.1	39.4	38.4	40.5	41.0

Үйлдлийн чадварын хүндрэлийн түвшнийг аймаг, нийслэлээр зэрэгцүүлэн тайлбарлахдаа Улаанбаатар хотын дүн оруулахгүйгээр харвал Хөвсгөл, Өвөрхангай, Төв аймгууд хамгийн их хувийг эзэлж байгаа бол хамгийн бага хувийг Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь аймгууд эзэлж байна.

Улаанбаатар хотын нийт хүндрэлтэй хүний хувьд эзлэх хувь их байгаа хэдий ч тухайн нэг бэрхшээлийн хувьд суурин хүн амд эзлэх дүнтэй харьцуулахад бага байгаа юм.

БОЛОВСРОЛ

ХҮСНЭГТ 8.7. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ДАВХАРДЛААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Боловсролын түвшин	Бүгд	Үйлдлийн чадварын хүндрэлийн давхардлаар					
		1	2	3	4	5	6
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	15.5	10.5	18.3	28.5	31.0	24.8	27.0
Бага	10.7	9.0	11.8	12.9	13.8	20.9	22.3
Суурь	14.7	15.9	14.2	10.5	12.4	11.2	10.9
Бүрэн дунд	25.0	27.5	23.9	20.2	18.6	13.8	14.5
Техникийн болон мэргэжлийн	9.4	10.7	8.3	6.8	7.0	4.5	6.2
Тусгай мэргэжлийн дунд	10.5	10.9	10.4	10.0	7.6	10.6	9.0
Дипломын дээд	3.0	2.7	3.6	2.9	3.4	4.5	3.5
Бакалаврын дээд	10.2	11.7	8.5	7.6	5.3	8.7	6.6
Магистр	0.8	1.0	0.7	0.3	0.7	1.0	-
Доктор	0.2	0.1	0.3	0.3	0.2	-	-

Нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн 19.6 хувь нь боловсролгүй, 80.4 хувь нь ямар нэгэн түвшний боловсролтой байна. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийг боловсролын түвшингээр харвал 22.7 хувь нь бүрэн дунд, 13.6 хувь нь суурь, 12.6 хувь нь бага байгаа нь хамгийн өндөр байна. Энэ нь хүндрэлийн хэлбэрүүдэд ижил хандлагатай байна.

Нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн 15.5 хувь нь боловсролгүй, 84.5 хувь нь ямар нэгэн түвшний боловсролтой байна. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийг боловсролын түвшнээр харвал 25.0 хувь нь бүрэн дунд, 14.7 хувь нь суурь, 10.7 хувь нь бага боловсролтой байгаа нь хамгийн өндөр хувь байна. Хүндрэлийн давхардлаар авч үзвэл бол 5 болон 6 хүндрэлтэй хүмүүсийн хувьд бага боловсрол өндөр хувийг эзэлж байна.

АЖИЛ ЭРХЛЭЛТ

ХҮСНЭГТ 8.8. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХ, ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

	Бүгд	Үйлдлийн чадварын хүндрэлийн давхардлаар					
		1	2	3	4	5	6
Хөдөлмөр эрхэлдэг эсэх							
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажилтай	31.2	39.4	24.9	14.2	9.5	6.8	7.0
Ажилгүй	68.8	60.6	75.1	85.8	90.5	93.2	93.0
Хөдөлмөр эрхлэлтийн байдал							
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй байнгын ажиллагч	23.9	26.4	16.1	14.9	16.1	9.5	27.8
Цалин хөлстэй түр ажиллагч	13.0	13.5	13.0	10.4	3.6	4.8	-
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	1.3	1.4	1.1	-	-	-	-
Цалин хөлстэй дагалдан, дадлагажигчид	0.1	0.1	-	-	-	-	-
Гүйцэтгэх гэрээлэгч	0.3	0.3	0.2	-	-	-	-
ААНБ-ын ажил олгогч	0.2	0.2	0.2	0.7	-	-	-
Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	0.4	0.4	0.2	-	-	-	-
Цалин хөлстэй ажилтангүй ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	0.5	0.6	0.6	-	-	-	-
Цалин хөлстэй ажилтангүй, зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч	47.3	44.8	55.9	51.9	57.1	71.4	50.0
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	13.0	12.3	12.7	22.1	23.2	14.3	22.2


Тооллогоор нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн 31.2 хувь нь ажилтай гэж бүртгэгдсэн, хөдөлмөр эрхэлдэг ба эдгээр хүмүүсийг ажил эрхлэлтийн байдлаар нь үзэхэд 47.3 хувь нь өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч, 23.9 хувь нь байнгын ажиллагч, 13.0 хувь нь цалин хөлстэй түр ажиллагч нар байна.

Аль ч хүндрэлийн давхардлаар өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч дийлэнх хувийг эзэлж байна. Харин ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч болон ААНБ-ын ажил олгогч, дагалдан, мэргэшиж буй дадлагажигчид маш бага байна. Үүнээс харахад үйлдлийн чадварын хүндрэлийн давхардал нэмэгдэх тусам хүмүүсийн ажиллах боломж нь харьцангуй бага, эсрэгээрээ өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэх болон хувь нэмрээ оруулах үйлчилгээнд оролцох байдал илүү байдаг байна.

9

БҮЛЭГ

ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИД



Дэлхий дахинд интернэт хэрэглээ



0%

100%

ГАР УТАС, ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ


Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн энэ цаг үед гар утас, интернэт нь хүн амын өдөр тутмын өргөн хэрэглээ болоод байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолмол аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 6, түүнээс дээш насны хүн амаас гар утас, интернэт хэрэглээний талаарх мэдээллийг авсан. Тиймээс 2020 оны тооллогын гар утас, интернэт хэрэглээний талаарх тоо мэдээллийг 2010 оны тооллогын дүнтэй хувийн жингээр харьцуулан танилцуулж байна.

Гар утас хэрэглэгчид

Монгол Улсын 6, түүнээс дээш насны хүн амын 87.8 хувь нь гар утас хэрэглэдэг болж өмнөх тооллогоос 13.8 пунктээр өсжээ. Аймаг, нийслэлийн 6, түүнээс дээш настай хүн амд гар утас хэрэглэгчдийн эзлэх хувь Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймгуудад улсын дунджаас өндөр байна. Харин Баян-Өлгий аймагт гар утасны хэрэглээ хамгийн доогуур буюу 76.3 хувьтай байна. Өмнөх тооллогын үед ч Баян-Өлгий аймгийн хүн амын гар утасны хэрэглээ доогуур байсан (Зураг 9.1).

ЗУРАГ 9.1. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010, 2020 ОН




6, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн 88.9 хувь нь, эрэгтэйчүүдийн 86.5 хувь нь гар утас хэрэглэж байна. Гар утас хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс 2.4 пунктээр илүү бол насны бүлгийн хувьд 70, түүнээс дээш насны бүлэгт эрэгтэйчүүдийн дүнд эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс 1.9 пунктээр их байна (Хүснэгт 9.1).

ХҮСНЭГТ 9.1. ГАР УТАС ХЭРЭГЛЭДЭГ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	74.0	72.2	75.9	87.8	86.5	88.9
6-9	22.6	20.7	24.6	37.2	35.4	39.1
10-14	51.5	47.2	55.9	74.7	73.3	76.2
15-19	81.6	77.2	86.1	96.6	95.9	97.2
20-24	88.0	85.9	90.3	98.1	97.7	98.5
25-29	85.9	85.3	86.5	98.2	97.9	98.5
30-34	85.1	84.4	85.8	98.3	98.0	98.5
35-39	84.4	83.3	85.5	97.7	97.2	98.2
40-44	81.8	80.1	83.4	97.5	96.9	98.0
45-49	79.8	77.6	81.9	97.0	96.2	97.7
50-54	77.7	75.6	79.5	96.3	95.0	97.4
55-59	75.5	73.8	77.0	95.8	94.4	96.9
60-64	73.5	73.3	73.7	95.2	93.9	96.3
65-69	65.4	66.4	64.6	94.0	92.7	95.0
70+	46.0	50.7	42.8	81.8	83.0	81.1


Гар утас хэрэглэгчдийг байршлаар нь ангилж үзэхэд төв, суурин газрын хүн амын 90.2 хувь нь, хөдөөгийн хүн амын 82.9 хувь нь гар утас хэрэглэгч байна. Хүн амын гар утасны хэрэглээ 2010 оны тооллогоор төв, суурин газарт хөдөөгөөс 28.6 пунктээр илүү байсан бол 2020 онд уг зөрүү багасаж 7.3 пункт болжээ. Энэ нь техник технологийн хөгжлийн хурдацтай өсөлттэй холбоотой. Өөрөөр хэлбэл, орчин үеийн харилцаа холбооны техник, технологи харьцангуй богино хугацаанд өргөн нэвтэрч суурьшил хоорондын ялгаа нь багасаж байна (Зураг 9.2).

ЗУРАГ 9.2. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН



Ажил эрхэлж буй суурин хүн амын 97.9 хувь нь гар утас хэрэглэдэг. Тэдгээрийг хөдөлмөр эрхлэлтийн статусаар харвал аж ахуй нэгж байгууллагын ажил олгогчдын 97.8 хувь, цалин хөлстэй байнгын ажиллагчдын 99.6 хувь, дагалдан мэргэшиж буй дадлагажигч 100 хувь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн өндөр байна. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын гар утасны хэрэглээг хүйсээр харвал эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү хэрэглэж байгааг Зураг 9.3-аас харж болно.

ЗУРАГ 9.3. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ХУВИАР, 2020 ОН




ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИД

Суурин эсвэл хөдөлгөөнт сүлжээгээр интернэтэд холбогдохыг интернэт ашигласан гэж тодорхойлон интернэт хэрэглэгчдийг байнга болон шаардлагатай үед хэрэглэдэг гэж 2 хувааж үзсэн.

6, түүнээс дээш настай хүн амын 64.7 хувь нь интернэт хэрэглэгдэг болж өмнөх тооллогоос 34.1 пунктээр өсжээ. Интернэт хэрэглэдэг хүн амын 58.7 хувь нь байнга ашигладаг байна.


Интернэт хэрэглэдэг хүмүүсийн 41.3 хувь нь шаардлагатай үедээ буюу интернэт кафе, найз нөхөд, бусад хүмүүсийн интернэтэд холбогдсон шугамаар интернэт ашиглаж байгаа нь 2010 оны дүнгээс 6 пунктээр буурчээ.

ЗУРАГ 9.4. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010, 2020 ОН



6, түүнээс дээш настай интернэт хэрэглэгчдийг аймаг, нийслэлээр харвал Архангай, Өвөрхангай, Увс аймгуудад хамгийн бага хувьтай, Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймаг зэрэг хот суурин газрын интернэт хэрэглээ бусад аймгуудтай харьцуулахад 2 дахин их байна. (Зураг 9.4).


ЗУРАГ 9.5. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН



Интернэт хэрэглэгчдийг байршлаар нь авч үзэхэд хотод амьдарч буй хүн амын 72.4 хувь нь, хөдөөд амьдарч буй хүн амын 49.3 хувь нь интернэт хэрэглэдэг болжээ. 2010 онтой харьцуулбал хөдөөгийн хүн амын интернэтийн хэрэглээ 42.5 пунктээр, хотын хүн амын 30.7 пунктээр тус тус өссөн байна.

6, түүнээс дээш настай интернэт хэрэглэгчдийг хүйсээр харахад эмэгтэйчүүдийн 66.6 хувь, эрэгтэйчүүдийн 62.7 хувь нь хэрэглэдэг байна. Энэ үзүүлэлтийг насны бүлгээр харахад 6-9 нас, 70, түүнээс дээш насны бүлгээр эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их, харин бусад насны бүлгийн хувьд эмэгтэйчүүд их байна (Зураг 9.6).

ЗУРАГ 9.6. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

9.9%
Ажилгүйдлийн
түвшин

40.3%
Ажиллах хүчнээс
гадуурх хүн ам

59.7%
Ажиллах
хүч

Хүн ам, орон сууцны тооллогоор хүн амын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг гаргах нь хэд хэдэн шалтгаантай байдаг. Хүн амын эдийн засгийн талаарх мэдээлэл нь тухайн улс орны эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн хэв маяг, зах зээлийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээ зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Мөн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн гол үзүүлэлтүүдийг тооллогоор цуглуулан хувь хүний болон өрх, орон сууцны нөхцөлийн үзүүлэлтүүдтэй холбосноор нийгэм, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Хүн ам, орон сууцны тооллогын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг засаг захиргааны хамгийн бага нэгжийн түвшинд гаргах боломжтойгоороо бусад төрлийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаануудаас давуу талтай.

Хүн амын асуулгын эдийн засгийн үзүүлэлтүүдийн ойлголт тодорхойлолтыг боловсруулахдаа НҮБ-ын “Хүн ам, орон сууцны 2020 он орчмын тооллогод баримтлах зарчим, зөвлөмж- III”-ийг үндэслэсэн.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолсон аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 15, түүнээс дээш насны хүн амаас хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултуудыг асуусан.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын уламжлалт асуулгын эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүдийг Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлаар шинэчлэн баталсан аргачлалын дагуу тооцсон.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын уламжлалт асуулгын эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүдийг Хөдөлмөрийн статистикчдийн олон улсын 19-р бага хурлаар шинэчлэн баталсан аргачлалын дагуу тооцсон. Уламжлалт тооллогын асуулгаар “Тооллогын товын үедажил эрхэлж байгаа эсэх, товоос өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин хөлстэй ажил эрхэлсэн болон тухайн хугацаанд ажил эрхлээгүй боловч ер нь ажилтай хүнийг “Ажил эрхэлдэг” гэж үзсэн. Харин бүртгэлд суурилсан мэдээлэл боловсруулалтад Хүн ам, өрхийн мэдээллийн санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон Гадаадын иргэн харьяатын газрын гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн сантай уялдуулан ажил эрхэлдэг хүнийг гаргасан.

ЗУРАГ 10.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

15, түүнээс дээш буюу хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүй иргэдийг хамруулаа. Энэ нь цаашдаа улс орны нийгэм, эдийн засаг ялангуяа ажиллах хүчний бодлого боловсруулахад суурь мэдээлэл болдог.

Уламжлалт тооллогоор тухайн үед ажиллаж байгаа гэдэг ойлголтод байнгын болон улирлын чанартай ажилтай, тооллогын үед ажил эрхлэхгүй байгаа ч ер нь ажил эрхэлдэг хүн амыг болон бүртгэлд суурилсан тооллогоор нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн санд бүртгэлтэй ажил эрхэлдэг бүх хүн амыг ажил эрхэлдэг гэж үзсэн.

Харин эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлээгүй хүмүүсээс гадна тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй хүнийг оруулсан болно.

ЗУРАГ 10.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН



15, түүнээс дээш насны нийт хүн амын 59.7 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 3.3 пунктээр өсжээ (Зураг 10.2).

Ажиллах хүчний оролцооны түвшнийг байршил, хүйсээр ангилахад нэлээд ялгаатай байна. Энэ үзүүлэлт хөдөөд хотоос 4.8 пунктээр илүү байгаа нь манай улсын онцлог юм. Тооллогоор хөдөөгийн малчин өрхийн 15, түүнээс дээш настай хүмүүсийг үндсэнд нь ажил эрхэлдэг гэж үздэгээс хамаарч, хөдөөгийн ажиллах хүчний оролцооны түвшин өндөр гарахад нөлөөлсөн байх талтай. Хөдөөгийн хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 2010 оны тооллогын үеийнхээс 3.1 пунктээр буурчээ.


Хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 69.1 хувь байгаа нь хотынхоос 5.8 пунктээр өндөр байна (Хүснэгт 10.1).

ХҮСНЭГТ 10.1 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллах хүч	59.7	65.3	54.6	58.2	63.3	53.6	63.0	69.1	56.6
Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь	40.3	34.7	45.4	41.8	36.7	46.4	37.0	30.9	43.4


Ажиллах хүчний оролцооны түвшнийг аймаг, нийслэлээр харвал аймгуудад ажиллах хүчний оролцооны түвшин улсын түвшинтэй харьцуулахад өндөр байна. Ялангуяа, Баянхонгор аймагт хамгийн өндөр буюу 67.7 хувьтай, Өмнөговь аймагт 65.7, Дундговь аймагт 65.6 хувь, Архангай аймагт 65.4 хувь, Говь-Алтай аймагт 65.3 хувь, Сүхбаатар аймагт 65.2 хувьтай байгаа бол хамгийн бага нь Баян-Өлгий аймагт 48.7 хувьтай байна (Зураг 10.3).

ЗУРАГ 10.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх тооллогын үеийнхээс өссөн нь 25, түүнээс дээших насны бүх бүлэгт ажиллах хүчний оролцооны түвшин, ялангуяа эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өссөнтэй холбоотой юм (Зураг 10.4).

ЗУРАГ 10.4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Ажиллах хүчийг насны бүлгээр ангилахад мэдэгдэхүйц ялгаатай байгаа нь харагдана. Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний түвшин бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Үүний дотор 20-34 насанд 9.0-13.3 пунктээр их байгаа нь тухайн насны их, дээд сургуульд суралцагчдад эмэгтэйчүүд илүү байдагтай холбоотой. Хүн амын ажиллах хүчний оролцоо 25-44 насанд хамгийн өндөр байгаагийн дотор эрэгтэйчүүдийн хувьд 81.8-84.2 хувьтай бол эмэгтэйчүүдийнх 72.1-78.5 хувьтай байна. Ялангуяа 40-49 насанд хүйсийн хувьд ажиллах хүчний оролцооны түвшний зөрүү хамгийн бага байгаа нь энэ насанд эдийн засгийн идэвх хамгийн өндөр байгааг гэрчилнэ. Харин 55, түүнээс дээш насанд эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх огцом буурч байгаа нь тэд 55 наснаас эхлэн өндөр насны тэтгэвэрт гардагтай холбоотой (Хүснэгт 10.2).

ХҮСНЭГТ 10.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Ажиллах хүч						Ажиллах хүчнээс гадуурх хүн ам					
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*	мян. хүн	хувь*
БҮГД	1296.8	59.7	686.2	65.3	610.6	54.6	873.8	40.3	365.4	34.7	508.4	45.4
15-19	16.6	7.7	12.2	11.0	4.5	4.2	200.2	92.3	98.0	89.0	102.2	95.8
20-24	100.0	44.4	57.8	51.0	42.2	37.7	125.4	55.6	55.5	49.0	69.9	62.3
25-29	189.5	73.1	101.9	78.3	87.6	67.9	69.7	26.9	28.2	21.7	41.5	32.1
30-34	230.6	80.4	121.9	84.9	108.8	75.9	56.2	19.6	21.6	15.1	34.6	24.1
35-39	194.1	80.9	101.3	84.6	92.8	77.2	45.7	19.1	18.4	15.4	27.3	22.8
40-44	175.9	81.7	88.8	83.7	87.1	79.8	39.3	18.3	17.4	16.3	22.0	20.2
45-49	154.8	80.8	75.9	81.5	78.9	80.1	36.8	19.2	17.3	18.5	19.6	19.9
50-54	121.1	74.5	59.1	77.5	62.0	71.9	41.4	25.5	17.1	22.5	24.2	28.1
55-59	75.4	53.4	43.6	67.8	31.8	41.3	65.8	46.6	20.7	32.2	45.2	58.7
60+	38.8	25.2	23.8	25.0	15.0	10.9	193.3	83.3	71.3	75.0	122.0	89.1

Тайлбар: *Тухайн насны бүлгийн хүн амд эзлэх хувь


АЖИЛЛАХ ХҮЧ

Тооллогын өмнөх 7 хоногт ядаж нэг цагаас илүү хугацаагаар цалин орлоготой ажил эрхэлсэн, ажил хайж байгаа хүнийг ажиллах хүчинд хамааруулсныг дээр тэмдэглэсэн. Бид ажил эрхлэлтийг богино хугацаагаар тодорхойлж байгаа болохоор НҮБ-ын зөвлөмжийг үндэслэн ажиллах хүч гэдэг ойлголтыг хэрэглэж байна.

Тооллогоор тухайн тоолуулагч аж ахуйн нэгж, байгууллагаасаа хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй бол хөдөлмөр эрхэлсэн гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, тухайн тоолуулагч тооллогын өмнөх долоо хоногт ажил эрхлээгүй байвал түүний ажил эрхлэлтийг үнэн зөв тодорхойлохын тулд ер нь ажилтай эсэхийг тодруулан асууж хөдөлмөр эрхлэлтийн шинэчилсэн аргачлалын дагуу тодорхойлсон.

Ажилгүй хүн гэдгийг тодорхойлоход хүн амын тооллогын асуулгын хөдөлмөр эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаан, мөн сүүлийн 30 хоногт цалин хөлстэй ажил хайх (бизнес эрхлэх) ямар нэгэн оролдлого хийсэн эсэхийг тодруулсан. Ажил хайж байгаа гэдэгт тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй бөгөөд хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс бүртгэлтэй болон бүртгэлгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүнийг хамааруулж, ажилгүйчүүдийг тодорхойлов.

ЗУРАГ 10.5. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



15, түүнээс дээш насны хүн амд эзлэх ажилгүй иргэдийн хувь 5.9 болж өнгөрсөн 10 жилийн хугацаанд 2.7 пунктээр буурчээ. Хэдийгээр ажилгүй иргэдийн хувь буурсан ч ажилгүйдлийн түвшин хэрхэн өөрчлөгдсөнийг дараагийн дэд бүлэгт оруулав.

АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ

Ажил эрхэлдэг бүх хүмүүсийн эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуй, нэгж байгууллагынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэл, ажил эрхлэлтийн байдал гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон.

ХҮСНЭГТ 10.3. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН

Хүйс	2010		2020		2020 / 2010 %
	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*	
БҮГД	911.7	47.8	1 167.9	53.8	128.1
Эрэгтэй	495.1	52.8	617.4	58.7	124.7
Эмэгтэй	416.6	43.0	550.5	49.2	132.1

Тайлбар: *15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Ажил эрхэлдэг хүн амын тоо 2010 оноос хойш 28.1 хувиар өсжээ. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийн хувь илүү өсөлттэй байна. Харин байршлаар нь ангилахад нэлээд ялгаатай байна (Хүснэгт 10.4).

ХҮСНЭГТ 10.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*	мян.хүн	хувь*
БҮГД	1 167.9	53.8	740.0	50.5	427.9	60.6
Эрэгтэй	617.4	58.7	378.6	54.7	238.8	66.5
Эмэгтэй	550.5	49.2	361.4	46.8	189.1	54.6

Тайлбар: *15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувь

Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын 53.8 хувь нь ажил эрхэлж байхад энэ үзүүлэлт хөдөөд 60.6 хувь байгаа нь хотынхоос 10.1 пунктээр өндөр байна. Хөдөөгийн хүн ам жилээс жилд буурч байгаа болон тэд үндсэндээ мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг нь хөдөлмөр эрхэлдэг хүний хувийн жин хөдөөд хотоос өндөр байх нөхцөлийг бүрдүүлдэг. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт хотынхоос 7.8 пунктээр их бол эрэгтэйчүүдийнх 11.8 пунктээр илүү байна. Хэдийгээр уг зөрүү 2010 оны тооллогын үеийнхээс буурсан ч хөдөлмөр эрхлэх зорилгоор хот суурин газар луу нүүж, амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн олон мянган хүн ажлын байраар тэр бүр хангагдаж чадахгүй байдалд байсаар байгааг хотын ажил эрхлэлтийн түвшнээс харж болно (Хүснэгт 10.4).

ХҮСНЭГТ 10.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН /мян.хүн/

Насны бүлэг	2010			2020			2020 / 2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	911.7	495.1	416.6	1 167.9	617.4	550.5	128.1
15-19	25.6	18.7	6.9	15.9	11.7	4.2	62.0
20-24	122.9	72.7	50.2	93.7	54.4	39.3	76.3
25-34	300.6	163.8	136.7	379.4	201.9	177.6	126.2
35-44	255.9	129.1	126.8	330.8	168.4	162.4	129.3
45-54	169.1	85.4	83.7	245.2	119.4	125.8	145.0
55-59	25.0	16.9	8.1	65.0	38.5	26.5	259.9
60+	12.6	8.5	4.1	38.0	23.2	14.8	301.3

Дээрх хүснэгтээс сонирхолтой дүр төрх ажиглагдаж байна. 15-24 насны ажил эрхэлдэг хүний тоо 2010 оныхоос буурч, харин 45-59 насны хүний тоо эрс өссөн нь залуучуудын сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үеэс нэмэгдсэнтэй уялдаатай байх талтай. Түүнчлэн, 45-59 насны хүмүүсийн хувьд тэд төдийлөн хөдөлмөр эрхлэлтээ солихгүй, тогтвор суурьшилтай ажиллах сонирхолтой байж болох юм.

ХҮСНЭГТ 10.6. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Мян.хүн			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 167.9	617.4	550.5	100.0	100.0	100.0
Менежер	117.6	59.8	57.8	10.1	9.7	10.5
Мэргэжилтэн	231.7	83.2	148.5	19.8	13.5	27.0
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	49.5	25.0	24.5	4.2	4.0	4.5
Контор, үйлчилгээний ажилтан	42.8	13.6	29.2	3.7	2.2	5.3
Худалдаа, үйлчилгээний ажилтан	139.7	50.1	89.6	12.0	8.1	16.3
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	279.6	165.8	113.8	23.9	26.8	20.7
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	89.5	62.9	26.6	7.7	10.2	4.8
Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	94.5	85.7	8.8	8.1	13.9	1.6
Энгийн ажил, мэргэжил	100.5	52.3	48.2	8.6	8.5	8.7
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	22.6	19.1	3.5	1.9	3.1	0.6

ХҮСНЭГТ 10.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Мян.хүн			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1167.9	617.4	550.5	100.0	52.9	47.1
Менежер	117.6	59.8	57.8	100.0	50.8	49.2
Мэргэжилтэн	231.7	83.2	148.5	100.0	35.9	64.1
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	49.5	25.0	24.5	100.0	50.4	49.6
Контор, үйлчилгээний ажилтан	42.8	13.6	29.2	100.0	31.8	68.2
Худалдаа, үйлчилгээний ажилтан	139.7	50.1	89.6	100.0	35.9	64.1
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	279.6	165.8	113.8	100.0	59.3	40.7
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	89.5	62.9	26.6	100.0	70.3	29.7
Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	94.5	85.7	8.8	100.0	90.7	9.3
Энгийн ажил, мэргэжил	100.5	52.3	48.2	100.0	52.1	47.9
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	22.6	19.1	3.5	100.0	84.6	15.4

Хүн амын эрхэлдэг ажил мэргэжлийн онцлогоос хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаа ангилал тус бүрд өөр өөр байна. Эрхэлдэг ажил мэргэжил хүйсийн хувьд хамгийн бага зөрүүтэй нь менежер, техникч болон туслах/дэд мэргэжилтэн, энгийн ажил мэргэжил ажээ. Харин машин механизм, төхөөргийн операторч, угсрагч, зэвсэгт хүчний ажил, мэргэжил, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажлын 70-аас дээш хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна. Гэтэл мэргэжилтэн, контор, үйлчилгээ, худалдаа, үйлчилгээний ажилтай 10 хүн тутмын 6 нь эмэгтэйчүүд байна.

Ажил эрхэлдэг нийт хүн амын 98.6 хувь нь ямар нэг шатны боловсролтой бол эрэгтэйчүүдийн 98.3 хувь, эмэгтэйчүүдийн 99.0 хувь нь боловсролтой хүмүүс байна. Ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн

30.9 хувь нь дээд боловсролтой байхад эмэгтэйчүүдийн 48.5 хувь нь дээд боловсролтой байгаагаас үзэхэд ажил эрхэлдэг дээд боловсролтой хүмүүсийн дотор эмэгтэйчүүд давамгайлж байна. Өнгөрсөн тооллогоор буюу 2010 онд ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн боловсрол эрэгтэйчүүдийнхээс өндөр хэдий ч менежерийн түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байсан бол 2020 онд эмэгтэйчүүдийн менежерийн ажил эрхэлж буй хувь өмнөх тооллогоос 6.1 пунктээр нэмэгджээ. Харин техникч болон туслах дэд мэргэжилтэн хийдэг эрэгтэйчүүдийн хувьд өмнөх тооллогоос 12.3 пунктээр өссөн нь энэ төрлийн ажилд хүйсийн зөрүү багасаж байгааг илэрхийлж байна (Хүснэгт 10.7).

Тооллогоор хөдөлмөр эрхэлдэг хүний ажилладаг байгууллага эсвэл эрхэлдэг ажлынх нь үндсэн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллыг хуулийн этгээд, өөрөө хэлбэл, өмчийн бүх төрөлд хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллага болон хүн амд үйлчилдэг ашгийн бус төр, олон нийт, шашны зэрэг байгууллагууд, хувиараа аж ахуй эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээг үйл ажиллагааны чиглэлээр нь ялгаж, дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, ажиллах хүчний судалгаа зэрэг олон зорилгоор ашигладаг.

ХҮСНЭГТ 10.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Мян.хүн			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 167.9	617.4	550.5	100.0	100.0	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	286.3	169.1	117.2	24.5	27.4	21.3
Уул уурхай, олборлолт	51.3	41.0	10.3	4.4	6.6	1.9
Боловсруулах үйлдвэрлэл	90.5	45.8	44.7	7.7	7.4	8.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	16.6	12.1	4.5	1.4	2.0	0.8
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7.9	4.4	3.4	0.7	0.7	0.6
Барилга	68.1	51.8	16.3	5.8	8.4	3.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ	142.2	68	74.2	12.2	11.0	13.5
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	58.1	45.4	12.7	5.0	7.4	2.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	27.1	7.9	19.3	2.3	1.3	3.5
Мэдээлэл холбоо	17.7	9.4	8.3	1.5	1.5	1.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	31.0	11.0	20.0	2.7	1.8	3.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4.5	2.2	2.4	0.4	0.4	0.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	22.8	11.3	11.5	2.0	1.8	2.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	24.7	15.4	9.3	2.1	2.5	1.7
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	94.2	57.2	37.0	8.1	9.3	6.7
Боловсрол	115.1	27.1	88.0	9.9	4.4	16.0
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	50.7	9.4	41.2	4.3	1.5	7.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	10.5	5.2	5.3	0.9	0.8	0.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.9	21.7	23.2	3.8	3.5	4.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээ	2.1	1.2	1.0	0.2	0.2	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1.8	0.8	0.9	0.1	0.1	0.2

Хүн амын 24.5 хувь нь ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилтын салбарт ажиллаж байгаа нь бусад салбараас хамгийн өндөр юм. Ажил эрхэлдэг хүн амыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай байна. Тухайлбал, уул уурхай, олборлолт, тээвэр агуулахын үйл ажиллагаа, барилга, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллагчдын 73-аас дээш хувь нь эрэгтэйчүүд байхад хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, боловсрол, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагчдын 71-ээс дээш хувь нь эмэгтэйчүүд байна (Хүснэгт 10.8).

ХҮСНЭГТ 10.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Мян.хүн			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 167.9	617.4	550.5	100.0	52.9	47.1
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	286.3	169.1	117.2	100.0	59.1	40.9
Уул уурхай, олборлолт	51.3	41.0	10.3	100.0	80.0	20.0
Боловсруулах үйлдвэрлэл	90.5	45.8	44.7	100.0	50.6	49.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	16.6	12.1	4.5	100.0	73.0	27.0
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7.9	4.4	3.4	100.0	56.3	43.7
Барилга	68.1	51.8	16.3	100.0	76.0	24.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ	142.2	68	74.2	100.0	47.8	52.2
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	58.1	45.4	12.7	100.0	78.2	21.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	27.1	7.9	19.3	100.0	29.0	71.0
Мэдээлэл холбоо	17.7	9.4	8.3	100.0	53.1	46.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	31.0	11.0	20.0	100.0	35.5	64.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4.5	2.2	2.4	100.0	47.6	52.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	22.8	11.3	11.5	100.0	49.7	50.3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	24.7	15.4	9.3	100.0	62.4	37.6
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	94.2	57.2	37.0	100.0	60.7	39.3
Боловсрол	115.1	27.1	88.0	100.0	23.6	76.4
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	50.7	9.4	41.2	100.0	18.6	81.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	10.5	5.2	5.3	100.0	49.3	50.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.9	21.7	23.2	100.0	48.4	51.6
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээ	2.1	1.2	1.0	100.0	54.8	45.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1.8	0.8	0.9	100.0	46.1	53.9

Хот, хөдөөгийн хүн амын эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлийг авч үзэхэд хотын хүн амын хувьд бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсрол, боловсруулах үйлдвэрлэл, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт ажиллагчдын хувийн жин өндөр байна. Гэхдээ салбар салбарын

ажиллагчдын хувь хөдөөгийнх шиг нэг салбарт хэт төвлөрсөн бус харьцангуй жигд тархжээ. Өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллагчдын 60.3 хувийг хөдөөгийн ажиллагчид бүрдүүлж, үүний дараа боловсрол, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар орж байгаагаас харахад хөдөөд боловсруулах аж үйлдвэрийн салбар муу хөгжсөнийг гэрчилнэ (Хүснэгт 10.10).

ХҮСНЭГТ 10.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Хот		Хөдөө	
	мян.хүн	Дүнд эзлэх хувь	мян.хүн	Дүнд эзлэх хувь
БҮГД	740.0	100.0	427.9	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	28.3	3.8	258.0	60.3
Уул уурхай, олборлолт	37.7	5.1	13.6	3.2
Боловсруулах үйлдвэрлэл	73.6	9.9	16.9	4.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	13.7	1.8	2.9	0.7
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	6.8	0.9	1.0	0.2
Барилга	59.0	8.0	9.1	2.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ	123.0	16.6	19.1	4.5
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	50.0	6.8	8.1	1.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	22.7	3.1	4.5	1.0
Мэдээлэл холбоо	15.9	2.2	1.8	0.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	25.9	3.5	5.1	1.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4.2	0.6	0.3	0.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	19.1	2.6	3.7	0.9
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	21.4	2.9	3.3	0.8
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	69.8	9.4	24.3	5.7
Боловсрол	80.3	10.9	34.8	8.1
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	38.9	5.3	11.7	2.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	7.7	1.0	2.7	0.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	38.6	5.2	6.3	1.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээ	1.7	0.2	0.4	0.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1.6	0.2	0.2	0.0

Ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хэрэглэгддэг дараагийн чухал үзүүлэлт бол хөдөлмөр эрхлэлтийн байдал (статус) юм. Тоолуулж байгаа хүний эрхэлдэг ажил болон ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагадаа гүйцэтгэж байгаа үүрэг, байгуулсан гэрээ хэлцэл, тухайн хүний байгууллага, хувь хүнтэй харилцах эрх мэдэл, ажил үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж өгдөг учраас энэ үзүүлэлт ихээхэн чухал ач холбогдолтой.

Олон улсын хөдөлмөрийн статистикчдийн 19-р бага хурлаар хөдөлмөр эрхлэлтийн статусыг шинэчлэн баталсан байдаг ба хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогод уг шинэчилсэн хөдөлмөр эрхлэлтийн статусыг ашигласан болно. 2010 болон 2020 оны тооллогын хөдөлмөр эрхлэлтийн хоёр өөр статусыг ашигласан учир дараах байдлаар харьцуулсан болно. Үүнд:

ЗУРАГ 10.6. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУУЧИН БОЛОН ШИНЭ СТАТУСЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ



ХҮСНЭГТ 10.11. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010			
БҮГД	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй ажиллагч	56.2	53.6	59.3
Ажил олгогч	2.5	3.1	1.8
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	27.7	37.7	15.9
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	0.2	0.2	0.2
Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	12.9	4.9	22.5
Бусад	0.5	0.5	0.3
2020			
БҮГД	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй байнгын ажиллагч	59.6	55.3	64.4
Цалин хөлстэй түр ажиллагч	6.4	7.0	5.9
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	0.9	1.2	0.6
Цалин хөлстэй дагалдан, мэргэшиж буй дадлагажигч	0.0	0.0	0.0
Гүйцэтгэх гэрээлэгч	0.5	0.7	0.2
ААНБ-ын ажил олгогч	0.4	0.5	0.3
Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	0.2	0.2	0.2
ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	0.3	0.3	0.3
Өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч	25.8	32.3	18.5
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	5.9	2.5	9.6

Хүн амын ажил эрхлэлтийн байдал сүүлийн 10 жилийн хугацаанд багагүй өөрчлөгджээ. 2020 онд цалин хөлстэй ажиллагч нийт ажил эрхэлдэг хүн амын 66.9 хувийг эзэлж 2010 оныхоос 10.7 пунктээр өсжээ. Харин ажил олгогчийн эзлэх хувь 0.6 болж өмнөх тооллоготой харьцуулахад 1.9 пунктээр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувь 26.6 болж 1.1 пунктээр тус тус буурчээ. Цалин хөлстэй ажиллагчийн хувийн жин өсөх нь хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангах, нийгмийн хамгаалалд хамрагдаж, хөдөлмөрлөх эрхээ бүрэн дүүрэн эдлэх бололцоог нэмэгдүүлдгээрээ сайн талтай ч хувиараа хөдөлмөр эрхлэгч болон ажил олгогчийн хувийн жин буурсан нь үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж чадахгүй байгааг илэрхийлж болох юм (Хүснэгт 10.11).

АЖИЛГҮЙЧҮҮД

Улсын хэмжээнд ажилгүйчүүдийн тоо 2020 онд 128.9 мянган хүн байгаа нь 2010 оноос 21.5 хувиар буурсан байна. Энэ хугацаанд Монгол Улсын ажиллах хүч 256.3 мянган хүнээр хүрээгээ тэлсэн байна. Харин ажилгүйдлийн түвшин 2020 онд 2010 оныхоос 5.4 пунктээр буурсны дотор хотод 3.3 пунктээр, хөдөөд 9.3 пунктээр тус тус буурсан байна. Ажил эрхэлдэггүй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс их байгаатай холбоотойгоор ажилгүйдлийн түвшин ч мөн адил эрэгтэйчүүдийнх өндөр байна. Энэ нь эрэгтэйчүүдийн боловсролын түвшин эмэгтэйчүүдийнхээс бага байгаатай холбоотой.


ХҮСНЭГТ 10.12. АЖИЛГҮЙ ХҮН АМЫН ТОО, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВЬ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН

Хүйс	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.хүн	Ажилгүйдлийн түвшин	мян.хүн	Ажилгүйдлийн түвшин	мян.хүн	Ажилгүйдлийн түвшин
2010						
БҮГД	164.1	15.3	114.6	16.5	49.5	13.0
Эрэгтэй	95.0	16.1	65.9	17.7	29.1	13.4
Эмэгтэй	69.1	14.2	48.7	15.0	20.4	12.6
2020						
БҮГД	128.9	9.9	112.4	13.2	16.4	3.7
Эрэгтэй	68.7	10.0	59.5	13.6	9.2	3.7
Эмэгтэй	60.1	9.8	52.9	12.8	7.2	3.7

Ерөнхийдөө ажилгүйдлийн түвшин хотод өндөр, хөдөөд бага байна. Энэ нь нэг талаас хот суурин бараадсан шилжих хөдөлгөөн их байгаа, нөгөө талаас тэд хотод шилжин ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой.


Ажилгүйдлийн түвшнийг аймаг, нийслэлээр харьцуулан харвал Дорнод аймагт хамгийн өндөр 20.8 хувьтай, Баян-Өлгий аймагт 15.2 хувь, Улаанбаатар хотод 14.5 хувьтай байгаа нь улсын дүнгээс 4.6-10.9 пунктээр илүү байна. Харин Төв аймагт ажилгүйдлийн түвшин 2.6 хувьтай гарсан нь хамгийн бага байна.

ЗУРАГ 10.7. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Улсын хэмжээнд ажилгүй байгаа хүмүүсийн дотор 30-44 насны 63.0 мянган залуучууд байгаа нь нийт ажилгүй хүний 49.1 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, 30-44 насныхны дотор ажилгүйдэл хамгийн өндөр байна. Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 15-24 насанд эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа нь тухайн насанд суралцаж байгаа эмэгтэйчүүдийн тоо өндөр, тэд энэ насанд суралцахыг илүүд үзэж байгаатай, мөн 55, түүнээс дээш насанд өндөр байгаа нь тэд 55 наснаас эхлэн өндөр насны тэтгэвэрт гардагтай холбоотой юм. Харин 30, түүнээс дээш насныханд эрэгтэйчүүд илүү их ажилгүйдэлд өртөж байна.

ЗУРАГ 10.8. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Өнгөрсөн 10 жилийн хугацаанд ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 5.4 пунктээр буурсан байна. Насны бүлгээр ангилан харвал 15-24 насанд 19.1 пунктээр буурсан байна. Энэ нь тухайн насны залуучуудын сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үеийнхээс 13.4-24.7 пунктээр нэмэгдсэнтэй холбоотой юм. Харин 45, түүнээс дээш насанд ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн нь ажил олгогчдын зүгээс шинээр ажлын байранд насны хязгаар заадаг, түүнчлэн энэ насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хөтөлбөр дутмаг байгаатай холбоотой байж болох юм.

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ

Ажил эрхэлдэггүй 15, түүнээс дээш насны хүн амаас ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг асуусан. Тухайлбал, сургуульд сурдаг хүн амд 15, түүнээс дээш настай бүх шатны сургуульд өдрөөр суралцагчдыг, хөдөлмөрлөх чадваргүй хүн амд хөдөлмөрлөх насных боловч хөдөлмөрлөх чадвараа байнга буюу удаан хугацаагаар бүтэн болон хэсэгчлэн алдсан сэргээгдэх боломжгүй хүнийг, гэрийн ажилтайд хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, гэр бүлийн хүний ажлын онцлог зэргээс хамааран ажиллаж чадахгүй байгаа хүнийг тус тус хамааруулав. Тохирох ажил олдохгүй байгаа гэдэг ойлголтод “Ажил хийхийг хүсэж байгаа, ажил хийхэд бэлэн, урьд нь ажил идэвхтэй хайж байгаад тохирох ажил олдохгүй итгэл алдарсны улмаас тооллогын өмнөх 7 хоногт ажил идэвхтэй хайгаагүй эсвэл тохирох ажлыг хаанаас хайхаа мэдэхгүй байгаа хүмүүсийг” оруулав.

ХҮСНЭГТ 10.13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, АЖИЛ ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, /мян.хүн/, 2010, 2020 ОН

Ажил эрхлээгүй шалтгаан	2010			2020			2020 / 2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	830.3	347.1	483.2	873.8	365.4	508.4	105.2
Сургуульд сурдаг	300.5	136.7	163.8	327.2	151.8	175.5	108.9
Тэтгэвэрт	191.9	65.7	126.2	236.4	75.6	160.9	123.2
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	55.9	31.3	24.6	45.7	25.4	20.2	81.7
Гэрийн ажилтай	108.4	12.1	96.3	92.5	10.9	81.6	85.3
Тохирох ажил олдохгүй байгаа	121.6	71.9	49.7	103.7	62.3	41.4	85.3
Ажиллах сонирхолгүй	3.3	2.3	1.0	3.7	2.6	1.1	111.3
Бусад	48.7	27.1	21.6	64.6	36.8	27.9	132.7

Ажиллах хүчнээс гадуурх 10 хүн тутмын 6 нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам нийтдээ 873.8 мянга байгаа нь өмнөх тооллогоос 5.2 хувиар, үүний дотор ажиллах сонирхолгүй хүний тоо 11.3 хувиар, сургуульд сурдаг 8.9 хувиар тус тус өсжээ. Харин хөдөлмөр эрхлэх чадваргүй, гэрийн ажилтай, тохирох ажил олдохгүй байгаа хүмүүсийн хувь 14.7-18.3 хувиар буурсан байна. Ялангуяа гэрийн ажилтайн улмаас хөдөлмөр эрхлэхгүй байгаа эмэгтэйчүүдийн тоо 2010 оноос 15.3 хувиар буурсан байна. Гэрийн ажилтай эмэгтэйчүүдийн тоо өмнөх тооллогоос буурсан хэдий ч эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхгүй үндсэн шалтгаанд гэрийн ажил хэвээр байсаар байна (Хүснэгт 10.13).

ХҮСНЭГТ 10.14. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд / мян. хүн/	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам /мян.хүн/						
		Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
БҮГД	873.8	315.6	236.4	46.3	96.2	107.8	3.8	67.8
15-19	200.2	191.1	-	0.9	1.9	2.6	0.1	3.6
20-24	125.4	94.0	-	2.1	8.7	12.4	0.3	7.9
25-34	125.9	27.5	-	7.4	36.7	33.8	0.9	19.6
35-44	85.0	2.6	0.7	10.8	27.3	26.0	1.0	16.6
45-54	78.2	0.3	9.1	14.7	15.9	23.4	1.0	13.8
55-59	65.8	0.1	41.6	7.1	4.4	7.8	0.3	4.5
60+	193.3	0.1	185.1	3.2	1.2	1.8	0.1	1.8

Ажил хийх сонирхолгүй 3.8 мянган хүн байгаагийн 1.9 мянга нь буюу 51.8 хувь нь ажил эрхлэх идэвхтэй нас болох 25-44 насны, 1.0 мянга нь буюу 27.4 хувь нь 45-54 насны хүмүүс байгаа нь цаашид анхааран судлах асуудлуудын нэг юм.

Тохирох ажил олдохгүй байгаа хүний 98.0 хувь боловсролтой, үүний дотор 19.0 хувь нь дээд, 4.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 6.0 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн байна. Гэрийн ажилтай хүмүүсийн 98.5 хувь нь боловсролтой байгаагийн дотор 29.0 хувь нь дээд боловсролтой, 4.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 4.3 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой байна. Ажиллах сонирхолгүй бүх хүний 95.4 хувь боловсролтой, үүний дотор 11.5 хувь нь дээд, 3.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.5 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой хүмүүс байна.

15, түүнээс дээш насны нийт хүн амын 40.3 хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам юм. Энэ тоон дээр ажилгүйчүүдийг нэмж үзвэл дээрх насны нийт хүн амын 46.2 хувь буюу 2 хүн тутмын нэг нь ажил эрхлэхгүй байна гэсэн дүгнэлт хийж болно. Үүнээс гадна тохирох ажил олдохгүй байгаа, гэрийн ажилтай, ажиллах сонирхолгүй хүмүүсийн 11.5-29.0 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байгаагийн шалтгаан нөхцөлийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.


ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ, СУРГУУЛЬД СУРАЛЦДАГГҮЙ 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУД

Хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй 15-24 насны залуучууд тухайн насны хүн амын хэдэн хувийг эзэлж буйг илэрхийлнэ. Уг үзүүлэлт нь боловсролын системээс гадуур байгаа, сургалтад хамрагдаагүй, хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудыг тодорхойлох бөгөөд залуучуудын ажилгүйдлийн түвшнээс илүүтэй залуучуудын хөдөлмөрийн зах зээлд хамрагдах боломжийг харуулдаг. Хөдөлмөр

эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй 15-24 насны залуучуудын эзлэх хувь нь Тогтвортой хөгжлийн 8-р зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтүүдийн нэг юм. (ТХЗ-ын 8-р зорилго: Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих)


Монгол Улсын хувьд нийт хүн амын 13.8 хувийг, хөдөлмөрийн насны хүн амын 20.4 хувийг 15-24 насны залуучууд эзэлдэг. Энэ нь залуу насны бүтэцтэй, хүн ам зүйн цонх нээгдсэн манай улс орны хувьд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц нөхцөл бүрэлдсэн, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлөх боломжтой үе юм.

ЗУРАГ 10.9. 15-24 НАСНЫ ХҮН АМД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ, СУРГУУЛЬД СУРАЛЦДАГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



15-24 насны хүн амын 12.2 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй залуучууд байна. Энэ нь хөдөлмөрлөх насны залуучуудын 8 хүн тутмын 1 нь хөдөлмөр эрхлээгүй, сургуульд суралцаагүй байгааг илэрхийлж байна. Ялангуяа 15-24 насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлээгүй, сургуульд сураагүй хувь 12.5 буюу улсын дүнгээс 0.3 пунктээр илүү байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны хүн ам их байгаа хүн ам зүйн таатай нөхцөл байдал, боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байгааг цаашид анхааран судлах шаардлагатай юм.

ЗУРАГ 10.10. 15-24 НАСНЫ ХҮН АМД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ, СУРГУУЛЬД СУРАЛЦДАГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй 15-24 насны залуучуудын 94.7 хувь нь боловсролтой, үүнээс 24.1 хувь нь дээд боловсролтой, 11.4 хувь нь техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд боловсролтой залуучууд байна. Ялангуяа энэ насны хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй эмэгтэйчүүдийн 32.8 хувь, эрэгтэйчүүдийн 15.2 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД



ГАДААДАД 6, ТҮҮНЭЭС ДЭЭШ САРЫН ХУГАЦААГААР ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр хүн амын гадаад улс орнууд руу хийх шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн. “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэсэн Үндсэн хуулийн заалт нь иргэдийг гадаад зорчих, сурах, ажиллах, эх орондоо дуртай цагтаа эргэн ирэх эрх зүйн үндэс болдог.

Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуульд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж, ажиллаж амьдарч, сурч байгаа иргэдийнхээ талаар бодитой тоо мэдээллийг тодорхойлох асуудлыг хуульчилсан байдаг.

Сурч боловсрох, хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх, бизнес эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, гэр бүл болох зэрэг олон шалтгааны улмаас манай улсын иргэд гадаадын улс орнуудад зорчих хөдөлгөөн улам бүр нэмэгдэж байна. Энэ талаарх бүртгэл, албан ёсны тоо мэдээлэл өнөө хэр байхгүй байсныг шийдвэрлэх үүднээс Гадаад харилцааны яам, Үндэсний Статистикийн Хороо хамтран гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдийг бүртгэх маягтыг боловсруулж, маягтын дагуу www.citizen.gov.mn гэсэн цахим систем хөгжүүлэн 2018 оны 3-р улирлаас эхлэн нэвтрүүлсэн. Гэвч иргэдэд мэдээлэл хүргэх, бүртгэлийг идэвхжүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааг тогтмолжуулах зэрэг нөхцөл байдлаас үүдэн энэ удаагийн гадаадад суугаа Монгол Улсын иргэдийн тооллогын дүнг Хил, хамгаалах ерөнхий газар (ХХЕГ), Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-ын мэдээллийн сангууд болон хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн санг уялдуулах, өрхөөс асуусан тооллогын асуулгын мэдээллийг нэгтгэн гаргалаа. Тооллогын мэдээлэл цуглуулалт Монголд байх гэр бүлээс асуух, нөгөө талаас гадаадад оршин суугаа иргэд өөрсдөө интернэтээр (www.citizen.gov.mn) тоолуулахаар зохион байгуулсан юм.

Мэдээлэл боловсруулалтын явцад гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа иргэдийн тоог чиглэлийн байгууллагуудын мэдээллийг нарийн уялдуулан нягталж, гадаадад оршин суугаа Монгол иргэдийн тоог гаргах шаардлага зүй ёсоор тавигдсан. Тухайлбал, 2010-2020 онуудад нийт 30 орчим мянган иргэд, үүний дотроос 29 мянга орчим иргэд Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэний харьяалалтай болсон байв.

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 122 301 иргэн тоологдож 2010 оноос 14.2 хувиар өсжээ. Гадаадад оршин суугаа иргэдийн насны бүтцийг харвал 0-14 насны хүн ам 12.7 хувь, 15-44 насныхан 72.3 хувь, 45-64 насныхан 14.4 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 0.6 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, гадаадад удаан хугацаагаар суугаа хүн амын 10 хүн тутмын 9 нь хөдөлмөрийн насны хүн ам байна (Хүснэгт 11.1).


ХҮСНЭГТ 11.1 ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010				2020				2020 / 2010 %
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	
БҮГД	107 140	49 955	57 185	87.4	122 301	56 655	65 646	86.3	114.2
0-4	4 598	2 309	2 289	100.9	3 509	1 781	1 728	103.1	76.3
5-9	3 171	1 595	1 576	101.0	6 272	3 216	3 056	105.2	197.8
10-14	3 535	1 771	1 764	100.2	5 755	3 003	2 752	109.1	162.8
15-19	9 176	4 420	4 756	93.0	7 262	3 782	3 480	108.7	79.1
20-24	20 400	10 164	10 236	99.3	16 060	8 484	7 576	112.0	78.7
25-29	20 739	10 161	10 578	96.1	19 954	10 155	9 799	103.6	96.2
30-34	16 855	7 500	9 355	80.1	19 820	9 507	10 313	92.2	117.6
35-39	13 343	5 797	7 546	76.8	14 176	6 102	8 074	75.6	106.2
40-44	7 930	3 380	4 550	74.3	11 083	4 221	6 862	61.5	139.8
45-49	4 168	1 628	2 540	64.1	8 798	3 112	5 686	54.7	2.1*
50-54	1 883	742	1 141	65.1	5 140	1 769	3 371	52.5	2.7*
55-59	709	269	440	61.1	2 647	902	1 745	51.7	3.7*
60-64	304	117	187	62.6	1 080	365	715	51.0	3.6*
65-69	162	54	108	50.0	396	149	247	60.3	2.4*
70+	167	48	119	48.1	349	107	242	44.2	2.1*

Тайлбар: * дахин их


Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн нас, хүйсийн бүтцийг суваргаар харвал гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн ихэнх хувийг хөдөлмөр эрхлэх насныхан эзэлж байгаа нь харагдаж байна (Зураг 11.1). Мөн 2010 оны насны бүтэцтэй харьцуулахад 0-14 насны хүүхдүүдийн тоо бараг 2 дахин нэмэгдсэн байгаа нь гэр бүлээрээ гадаадад удаан хугацаагаар суралцах болон хувиараа хөдөлмөрлөх шалтгаанаар оршин суух болсонтой холбоотой харагдаж байна.

ЗУРАГ 11.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН




Зуун эмэгтэйд ногдох эрэгтэй хүн ам буюу хүйсийн харьцаа 86.3 байгаа (46.3 хувь эрэгтэй, 53.7 хувь эмэгтэйчүүд) нь гадаадад оршин суугаа эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээсээ олон байгааг илтгэх бөгөөд 2010 онтой харьцуулахад уг үзүүлэлт 1.1 пунктээр буурсан байна. Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч, 35 наснаас эхлэн огцом буурчээ. 0-29 насныхны хувьд дийлэнх нь эрэгтэйчүүд байхад хөдөлмөрийн насны болон ахмад настнуудын хувьд эмэгтэйчүүд илүү байна.

ЗУРАГ 11.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН, /мян.хүн/



Гэхдээ гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн хүйсийн харьцаа улс орон бүрд харилцан адилгүй байна. Тухайлбал, хамгийн олон иргэн оршин суугаа Бүгд Найрамдах Солонгос Улсад хүйсийн харьцаа 2010 онд 127.6 байсан бол 2020 онд 99.6, Оросын Холбооны Улсад 96.2 байсан бол 98.9, Японд 79.9 байсан бол 90.7 болсон байна (Зураг 11.2).

ЗУРАГ 11.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Гадаадад оршин суугаа иргэдийн тоог Монголд байнга амьдарч байсан аймаг, нийслэлээр харвал 74.5 хувь нь Улаанбаатараас, 4.3 хувь нь Баян-Өлгий, 4.2 хувь нь Дархан-Уул, 3.4 хувь нь Орхон аймгаас гадаад улсад оршин суухаар явжээ (Зураг 11.3).

ХҮСНЭГТ 11.2 ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, БАЙНГА СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Аймаг, нийслэл	2010		2020		2020 / 2010 %
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	
БҮГД	107 140	100.0	122 301	100.0	114.2
Архангай	505	0.5	740	0.6	146.5
Баян-Өлгий	2 824	2.6	5 250	4.3	185.9
Баянхонгор	395	0.4	679	0.6	171.9
Булган	588	0.6	792	0.6	134.7
Говь-Алтай	368	0.3	336	0.3	91.3
Дорноговь	682	0.6	1 376	1.1	2.0*
Дорнод	679	0.6	826	0.7	121.6
Дундговь	277	0.3	429	0.4	154.9
Завхан	557	0.5	547	0.4	98.2
Өвөрхангай	870	0.8	1 013	0.8	116.4
Өмнөговь	459	0.4	594	0.5	129.4
Сүхбаатар	243	0.2	390	0.3	160.5
Сэлэнгэ	1 780	1.7	2 553	2.1	143.4
Төв	1 330	1.2	1 968	1.6	148.0
Увс	422	0.4	465	0.4	110.2
Ховд	617	0.6	1 758	1.4	2.8*
Хөвсгөл	593	0.6	933	0.8	157.3
Хэнтий	476	0.5	718	0.6	150.8
Дархан-Уул	3 978	3.7	5 141	4.2	129.2
Орхон	3 581	3.3	4 113	3.4	114.9
Говьсүмбэр	158	0.2	512	0.4	3.2*
Улаанбаатар	85 758	80.0	91 168	74.5	106.3

Тайлбар: * дахин их

Гадаадад тоологдсон хүн амын дүнг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад Говьсүмбэр аймгаас явсан хүн ам 3.2 дахин, Ховд аймгаас 2.8 дахин, Баян-Өлгий, Дорноговь аймгаас ойролцоогоор 2 дахин их хүн гадаад улсад оршин суухаар явсан байна (Хүснэгт 11.2). Харин Завхан, Говь-Алтай аймгаас гадаад улсад байнга оршин сууж байгаа хүн амын тоо өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад буурсан байна.


ХҮСНЭГТ 11.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ОРШИН СУУГАА БҮС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Бүс	2010					2020				
	Бүгд	Америк	Ази, Номхон далай	Европ	Африк	Бүгд	Америк	Ази, Номхон далай	Европ	Африк
БҮГД	100.0	18.4	49.0	31.3	1.3	100.0	17.0	58.8	23.9	0.3
Улаанбаатар	100.0	20.8	46.3	31.6	1.3	100.0	21.0	53.1	25.7	0.2
Зүүн	100.0	7.9	54.8	35.6	1.7	100.0	5.7	68.6	25.4	0.3
Төв	100.0	10.0	51.4	37.1	1.5	100.0	6.9	68.1	24.7	0.3
Хангай	100.0	11.1	55.9	31.9	1.1	100.0	8.2	69.9	21.3	0.6
Баруун	100.0	4.6	81.3	13.2	0.9	100.0	2.0	92.8	4.9	0.3

Гадаадад тоологдсон иргэдийн 58.8 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 23.9 хувь нь Европ тивд суугаагаар тоологдсон байна. Үүнийг Монгол Улсын бүсийн хувьд харвал Баруун бүсээс бусад бүсүүдэд ижил хандлагатай байна. Харин Баруун бүсээс явсан хүн амын 92.8 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт суугаагаар тоологдсон байна. Гадаадад суугаа иргэдийн дүнг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад Ази, Номхон далайн бүсэд оршин суугаа иргэд 9.8 пунктээр өссөн бол Европ тивд оршин суугаа иргэд 7.4 пунктээр, Америк тивд оршин суугаа иргэд 1.3 пунктээр, Африк тивд оршин суугаа иргэд 1 пунктээр тус тус буурсан байна (Хүснэгт 11.3).

Монгол Улсын иргэдийн оршин сууж байгаа улсыг авч үзвэл БНСУ (39982), АНУ (19170), Япон (8772), Казахстан (7218), Чех (5997), Австрали (5538), Хятад (5146) улсуудад хамгийн ихээр сууж байна (Зураг 11.4).

ЗУРАГ 11.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛСААР, 2020 ОН



Монголчууд гадаадад чөлөөтэй зорчих болсноос хойш 30 гаруй жил өнгөрчээ. Иргэдийн гадаадад оршин суугаа хугацааг авч үзэхэд 28.4 хувь нь 1 жил хүртэлх, дийлэнх буюу 41.7 хувь нь 2-5 жил, 16.9 хувь нь 6, түүнээс дээш жил, үлдсэн 13.0 хувь нь 11, түүнээс дээш жил гадаадад амьдарч байна. Гадаадад оршин суугаа иргэдийн дотор 11, түүнээс дээш жилээр суугаа иргэд Их британи, Ирланд, Польш, Унгар, Герман гэх мэт Европ тивийн улсуудад өндөр байна. Харин ОХУ, БНХАУ, Япон болон БНСУ-д суугаа иргэдийн ихэнх нь 1 хүртэлх жилийн хугацаагаар оршин сууж байна. Энэтхэг, Турк, Австрали улсуудад амьдарч байгаа иргэдийн ойролцоогоор 50 орчим хувь нь 2-5 жил, Казахстан, Франц, Канад улсуудад суугаа иргэдийн 30 орчим хувь нь 6-10 жил оршин суугаа иргэд байна (Хүснэгт 11.4).

ХҮСНЭГТ 11.4 ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛС, ОРШИН СУУГАА ХУГАЦАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Оршин суугаа улс	Тоо	Бүгд	Оршин суугаа хугацаа			
			0-1 жил	2-5 жил	6-10 жил	11-ээс дээш жил
БҮГД	122 301	100.0	28.4	41.7	16.9	13.0
Солонгос /Өмнөд/	39 982	100.0	33.7	44.9	12.8	8.6
Америк	19 170	100.0	17.0	40.9	21.5	20.6
Япон	8 772	100.0	38.9	41.3	10.7	9.1
Казахстан	7 218	100.0	26.3	32.3	31.3	10.1
Чех	5 997	100.0	24.1	40.5	16.3	19.1
Австрали	5 538	100.0	33.4	46.0	13.1	7.5
Хятад	5 146	100.0	42.1	42.3	9.6	6.0
Герман	3 972	100.0	19.8	39.6	19.3	21.3
Швед	3 951	100.0	22.7	41.7	23.3	12.3
Франц	3 102	100.0	14.6	35.8	29.5	20.1
Орос	2 814	100.0	41.3	41.7	9.9	7.1
Турк	2 716	100.0	33.4	47.0	13.9	5.7
Австри	1 676	100.0	20.3	41.8	21.7	16.2
Швейцар	1 469	100.0	22.9	37.1	22.7	17.3
Их британи	1 466	100.0	10.9	34.5	23.2	31.4
Унгар	1 341	100.0	30.9	32.7	14.9	21.5
Канад	1 283	100.0	17.1	37.6	27.9	17.4
Энэтхэг	744	100.0	31.5	52.1	9.7	6.7
Польш	654	100.0	18.2	41.1	17.1	23.6
Ирланд	643	100.0	25.8	36.5	13.1	24.6
Бусад	4 647	100.0	22.9	37.2	20.9	19.0

Энэ удаагийн тооллогоор нийт өрхийн 10 хувиас уламжлалт асуулгаар мэдээлэл цуглуулахдаа гадаадад оршин суугаа иргэдээс анх явсан зорилго болон тооллогын үед сууж байгаа зорилгыг тодруулсан. Уг дүнгээр гадаадад оршин суугаа нийт иргэдийн дийлэнх нь буюу 46.7 хувь нь анх суралцахаар гадаад улс руу явсан байна.

Тооллогын үед гадаадад суурьших зорилготой байгаа иргэдийн 25.1 хувь нь анх суралцах зорилгоор явж байсан байна. Харин тооллогын үед хувиараа хөдөлмөрлөхөөр гадаадад байгаа иргэдийн 19.8 хувь нь анх суралцахаар явж байсан байна. Үүнээс үзэхэд суралцах, ажиллах болон бусад зорилгоор гадаад руу явсан хүмүүсийн дийлэнх нь тухайн улсдаа суурьших хандлагатай байна (Хүснэгт 11.5).

ХҮСНЭГТ 11.5. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ЯВСАН БОЛОН ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Явсан зорилго	Тооллогын үед сууж байгаа зорилго							
	Бүгд	Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Хувиараа хөдөлмөрлөх	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Суралцах	46.7	95.1	25.1	6.1	15.2	19.8	9.2	21.0
Суурьших	7.2	0.5	51.4	0.7	2.8	1.4	2.0	3.2
Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	14.2	1.0	5.6	92.6	2.3	4.2	2.2	10.9
Албан томилолтоор ажиллах	2.3	0.1	1.0	0.1	76.5	0.6	0.4	1.7
Хувиараа хөдөлмөрлөх	15.2	0.8	7.2	0.2	1.8	71.0	3.2	10.2
Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	11.9	2.1	7.0	0.3	1.4	1.9	82.0	1.4
Бусад	2.5	0.4	2.7	0.0	0.0	1.1	1.0	51.6


Энэ удаагийн тооллогын дүнгээр нийт иргэдийн 34.2 хувь нь сурах, 32.0 хувь нь хөдөлмөр эрхлэх (үүнээс 20.6 хувь нь хувиараа, 10.4 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр, 1.0 хувь нь албан томиллоор ажиллах), 12.6 хувь нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух, 11.7 хувь нь суурьших, үлдсэн 9.5 хувь нь бусад зорилгоор эх орноосоо явжээ. [Хүснэгт 11.6].

Явсан зорилгыг оршин суугаа улсаар авч үзвэл Энэтхэг, ОХУ, БНХАУ, Япон, Австрали, Герман, Ирланд руу хамгийн олон хүн суралцахаар (нийт сурахаар явагчдын 35.1 хувь), Казахстан, Польш, Их Британи, Америк руу хамгийн олон хүн суурьшихаар (нийт суурьшихаар явагчдын 54.8 хувь), БНСУ, БНЧУ, Унгар луу хамгийн их хүн хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар (нийт хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явагчдын 71.3 хувь), БНСУ, БНЧУ, Швед, Турк, Швейцар, Польш руу хамгийн их хүн хувиараа хөдөлмөрлөхөөр (нийт хувиараа хөдөлмөрлөхөөр явагчдын 62.2 хувь) явсан байна [Хүснэгт 11.6].

ХҮСНЭГТ 11.6. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ОРШИН СУУГАА УЛС, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Оршин суугаа улс	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томиллоор ажиллах	Хувиараа ажиллах	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Бусад
БҮГД	122 301	100.0	34.2	11.7	10.4	1.0	20.6	12.6	9.5
Солонгос / Өмнөд/	39 982	100.0	27.7	4.6	19.4	0.6	29.7	8.1	9.9
Америк	19 170	100.0	37.0	17.2	3.6	0.8	15.4	15.0	11.0
Япон	8 772	100.0	49.1	8.1	8.6	1.5	13.8	11.7	7.2
Казахстан	7 218	100.0	21.5	40.2	2.8	0.2	9.8	17.9	7.6
Чех	5 997	100.0	19.6	10.7	19.8	1.0	25.1	15.9	7.9
Австрали	5 538	100.0	42.5	11.6	3.3	0.6	13.8	14.4	13.8
Хятад	5 146	100.0	62.0	5.5	4.7	1.2	11.5	8.9	6.2
Герман	3 972	100.0	41.6	15.4	4.0	0.7	14.2	14.8	9.3
Швед	3 951	100.0	24.0	15.2	7.6	0.9	24.7	20.8	6.8
Франц	3 102	100.0	27.2	14.9	4.4	0.8	18.5	22.5	11.7
Орос	2 814	100.0	63.4	7.1	2.7	1.8	9.4	10.2	5.4
Турк	2 716	100.0	32.3	6.9	10.7	0.9	31.8	10.4	7.0
Австри	1 676	100.0	36.4	11.8	4.7	0.6	17.8	16.3	12.4
Швейцар	1 469	100.0	31.3	14.0	5.7	1.9	21.9	14.9	10.3
Их британи	1 466	100.0	33.1	19.2	2.9	0.5	15.1	18.1	11.1
Унгар	1 341	100.0	33.9	10.8	15.1	1.2	19.6	11.8	7.6
Канад	1 283	100.0	35.1	16.5	4.4	1.8	14.4	16.2	11.6
Энэтхэг	744	100.0	82.5	2.8	1.4	0.8	3.6	6.9	2.0
Польш	654	100.0	29.5	20.3	6.1	2.3	20.7	13.0	8.1
Ирланд	643	100.0	40.3	14.8	3.0	0.9	16.9	15.7	8.4
Бусад	4 647	100.0	30.9	14.5	6.3	5.4	16.4	15.3	11.2

ЗУРАГ 11.5. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН




Тооллогын үед гадаадад байнга суугаа зорилгыг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулбал хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хувь 8.7 пунктээр, суралцах зорилгоор суугаа иргэдийн хувь 2.8 пунктээр, албан томилолтоор ажиллаж буй иргэдийн хувь 1.6 пунктээр тус тус буурсан байна (Зураг 11.5).

ХҮСНЭГТ 11.7. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Тооллогын үед сууж байгаа зорилго							
	Бүгд	Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Хувиараа хөдөлмөрлөх	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
0-4	2.9	0.7	2.9	-	-	-	15.8	3.0
5-9	5.1	2.8	5.1	-	-	-	25.3	4.0
10-14	4.7	3.9	4.9	-	-	-	18.2	5.4
15-19	5.9	11.0	3.8	1.3	0.4	0.9	7.7	4.8
20-24	13.1	27.2	4.4	8.4	11.4	5.7	2.8	8.4
25-29	16.3	24.1	8.8	18.5	31.2	15.2	4.3	11.9
30-34	16.2	16.7	11.8	22.0	20.6	21.3	6.1	15.2
35-39	11.6	8.8	10.4	15.8	10.5	18.1	5.2	13.1
40-44	9.1	2.8	12.9	15.6	10.6	15.5	4.8	11.4
45-49	7.2	1.2	12.8	12.3	7.3	12.3	3.6	9.8
50-54	4.2	0.5	10.9	4.0	3.9	6.9	2.3	6.1
55-59	2.2	0.2	6.2	1.5	3.1	2.9	1.7	3.9
60-64	0.9	0.1	2.8	0.5	0.8	0.9	1.0	1.8
65-69	0.3	-	1.1	0.0	0.2	0.2	0.6	0.7
70+	0.3	-	1.2	0.1	0.0	0.1	0.6	0.5


Гадаадад оршин суугаа иргэдийн тооллогын үед сууж байгаа зорилгыг насны бүлгийн хувьд харвал суралцах зорилгоор оршин суугаа хүмүүсийн 79.0 хувь нь 15-34 насныхан байна. Хувиараа хөдөлмөрлөх зорилгоор суугаа хүмүүсийн 52.8 хувийг 35-54 насныхан эзэлж байна.

ЗУРАГ 11.6. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



35-54 насны хүмүүсийн тооллогын үед суугаа зорилгын 33.9 хувь нь хувиараа хөдөлмөрлөх, 52.4 хувь нь суралцах байна. Харин 15 хүртэлх насны хүн амын дийлэнх буюу 58.8 хувь нь гэр бүлийн шалтгаанаар, 55, түүнээс дээш насны хүн амын 36.1 хувь нь суурьших зорилгоор гадаадад оршин сууж байна.

ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ



Хүний амьдралын анхдагч хэрэгцээ, эрүүл энх, тав тухтай, аюулгүй амьдрах үндсэн орчин бол орон сууц юм. Төр, засгийн бодлогын нэг хэсэг нь хүн амаа орон сууцаар хангаж, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэдэг.

Монгол Улс хүн ам, орон сууцны тооллогоор орон сууц, тэдгээрийн дэд бүтцийн хангамжийн байдлыг нэлээд өөр өөр аргачлалаар тоолж ирсэн. Улс, хоршооллын байгууллагын орон сууцны сан хөмрөгийн тооллогыг 1969 онд анх удаа зохион байгуулж байжээ. Харин хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогуудад орон сууцны сан хөмрөгийн тооллого явуулаагүй, хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, өмчлөл болон эзэмшлийн хэлбэр, дэд бүтцийн хангамжийг хүн амын тооллоготой хамтатган явуулж байсан.

Энэ удаа хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, түүний нөхцөлийн талаарх үзүүлэлтүүдийг цуглуулахаас гадна хүн амьдран суух зориулалттай бүх төрлийн орон сууц, түүний насжилт, хана болон дээврийн материал, дэд бүтцийн талаарх мэдээллийг цуглуулах зорилготой Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд улс орон даяар зохион байгуулж явуулсан.

Зуслангийн суурьшлын бүс харгалзахгүйгээр улирлын чанартай амьдардаг байшин, орон сууцыг урьдчилсан бүртгэлээр бүртгэж, харин хүн амьдран суух зориулалттай үндсэн сууцны мэдээллийг тооллогоор цуглуулсан ба дараах орон сууцыг хамруулсан. Үүнд:

1. Бүх төрлийн гэр
2. Сууцны тусдаа байшин
3. Бие даасан тохилог сууц
4. Нийтийн зориулалттай орон сууцны байшин
5. Нийтийн байр

Мөн Байшин, орон сууцны тооллогод хамрагдсан бүх орон сууцнаас хүн байнга амьдардаг эсэхийг тодруулж, хүн байнга амьдардаг орон сууцны насжилт, хана, шал, дээврийн материал, дэд бүтэц зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж тоолсон.

Харин хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор тоологдсон өрхийн амьдарч буй сууцны нөхцөлийн мэдээллийг хүн ам, өрхийн мэдээллийн сан болон уламжлалт тооллогоор өрхийн орон сууцны нөхцөлийн талаарх мэдээллийг цуглуулсан. Ингэхдээ эхлээд өрх ямар төрлийн сууцанд амьдарч байгааг асууж, дараа нь сууцны ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Тоолох үед өрхийн амьдарч буй сууцыг ерөнхийдөө хүн амьдрах зориулалтаар нь гэр, байшин, бусад сууц (зориулалтын бус) гэж ангилсан.

Байшин, орон сууцны болон Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг хослуулан ашиглахад онцлон тэмдэглэх нэг асуудал бол нэг сууцанд нэгээс олон өрх амьдрах боломжтой учир өрхийн тоо сууцны тооноос өндөр гарах боломжтой, мөн орон сууцны байшингийн мэдээллийг Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Сууц өмчлөгчдийн холбооноос цуглуулсан учир доторх сууцны тоо буюу хэдэн айлын орон сууц гэдгийг асууж тодруулахдаа үйлчилгээ эрхэлж байгаа, түрээслэх болон өөр шалтгаанаар эзгүй байгаа хаалгыг ялгаж тодорхойлоогүй. Иймд орон сууцны байшингийн доторх сууцны тоо орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоо хоорондоо зөрөх боломжтой юм.

СУУЦНЫ ТӨРӨЛ

Байшин, орон сууцны тооллогоор нийт 677 620 сууц тоологдсоноос 304 361 гэр (44.9 хувь), 373 259 (55.1 хувь) байшин сууц байсан бол гэр сууцны 74.2 хувь нь үндсэн гэр, 25.8 хувь нь илүү гэр байна. Харин байшин сууцны 78.3 хувь нь үндсэн байшин (үүний 74.2 хувь нь хүн байнга амьдардаг байшин), 21.7 хувь нь улирлын чанартай хүн амьдардаг зуслангийн байшин байна.

Тооллогоор хүн байнга амьдардаг сууцны дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан. Харин хүн байнга амьдардаггүй байшин, илүү гэр, зуслангийн байшин зэрэг сууцны дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулаагүй болно. Тиймээс энэ бүлэгт хүн байнга амьдардаг 442 725 гэр, байшин, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулаад 770 868 сууцны дэлгэрэнгүй үр дүнг танилцуулах болно.


ЗУРАГ 12.1. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 51.0 хувь нь гэр сууц, 46.0 хувь нь сууцны тусдаа байшин, 1.7 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 0.9 хувь нь бие даасан тохилог сууц, 0.4 хувь нь нийтийн байр байна. Нийтийн зориулалттай 7 444 орон сууцны байшинд 335 587 сууц тоологдсон байна.

Улсын хэмжээнд тоологдсон хүн байнга амьдардаг сууцны 32.0 хувь нь Улаанбаатар хотод, 25.0 хувь нь Хангайн бүсэд, 18.1 хувь нь Төвийн бүсэд, 15.5 хувь нь Баруун бүсэд, 9.4 хувь нь Зүүн бүсэд тус тус тоологдсон байна. Нийт тоологдсон хүн байнга амьдардаг сууц Өвөрхангай (5.3 хувь), Хөвсгөл (5.2 хувь), Архангай (4.4 хувь), Сэлэнгэ (4.0 хувь) аймгуудад хамгийн их байна.

ЗУРАГ 12.2. ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2019 ОН



Цаашид Байшин, орон сууцны тооллогоор тоологдсон хүн байнга амьдардаг гэр, байшин сууцны мэдээллийг Хүн ам, орон сууцны тооллогоор тоологдсон нийт өрхийн сууцны нөхцөлтэй холбон тайлбарлах болно. Ингэхдээ байшин болон Монголын ард түмний уламжлалт сууц – гэрийн талаарх мэдээллийг тус тусад нь авч үзэв.

ЗУРАГ 12.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН



Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийт өрхийн 38.2 хувь нь уламжлалт сууц гэрт, 60.9 хувь нь байшинд, 0.9 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 7.0 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 7.3 пунктээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 12.1. СУУЦ БОЛОН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

	Хүн байнга амьдардаг сууц			Өрхийн тоо		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	770.9	562.6	208.3	897.4	606.3	291.1
Гэр	225.9	98.6	127.3	342.4	149.9	192.5
Байшин	545.0	464.0	81.0	547.0	451.6	95.3
Бусад сууц	-	-	-	8.0	4.8	3.3

Тайлбар: *Орон сууцны байшингийн доторх сууцыг нэмж оруулав.

Монгол Улсад нийт 897.4 мянган өрх 770.9 мянган сууцанд амьдарч байна. Амьдарч буй өрхийн тоо, хүн байнга амьдардаг сууцны тооны харьцаа хотод ойролцоо байхад, хөдөөд өрхийн тоо нь илүү

байна. Энэ нь хөдөөд нэг сууцанд олон өрхүүд хамт амьдарч байгааг харуулж байна.

Хот, хөдөөд амьдарч байгаа өрхийн сууцны төрөл нэлээд ялгаатай байна. Хотод нийт өрхийн 74.5 хувь нь байшинд, 24.7 хувь нь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь 8.0 пунктээр буурч, байшинд амьдардаг өрхийнх 8.6 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь том хотуудад сүүлийн жилүүдэд орон сууцжуулах бодлого, хөтөлбөрүүд нэмэгдсэнтэй холбоотой юм. Хөдөөгийн өрхийн 66.1 хувь нь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 4.8 пунктээр буурч, харин байшинд амьдардаг өрхийн хувь 4.2 пунктээр өссөн байна. Ерөнхийдөө хот, хөдөөд гэр, байшинд амьдардаг өрхийн хувийн жингийн зөрүү тооллого хооронд буурч, өрхүүдийн сууцны ялгаа багасах хандлагатай байна. Хот, хөдөөд байшинд амьдардаг өрхийн тоо өсөж байгаа нь тохилог сууцанд суугчдын тоо нэмэгдэхийн зэрэгцээгээр иргэд өөрсдөө байшин барьж суух нь олширч, орон сууцаар хангах бодлого тодорхой хэмжээгээр нөлөөлснийг гэрчилнэ.

Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 29.4 хувийг эзэлж байгаа нь 2010 оныхоос 8.1 пунктээр нэмэгдсэн буюу сүүлийн 10 жилд орон сууцанд амьдардаг айл өрхүүд 112.0 мянгаар нэмэгджээ. Мөн сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 2010 оныхоос 0.5 пунктээр, бие даасан тохилог сууцных 0.2 пунктээр тус тус өссөн нь иргэд өөрсдөө байшин барьж суух бололцоо нэмэгдсэнийг харуулж байна

ХҮСНЭГТ 12.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	2010		2020	
	мян.өрх	дүнд эзлэх хувь	мян.өрх	дүнд эзлэх хувь
БҮГД	713.8	100.0	897.4	100.0
Гэр	322.8	45.2	342.4	38.2
Байшин	382.8	53.6	547.0	60.9
Орон сууцны байшин	152.3	21.3	264.3	29.4
Бие даасан тохилог сууц	3.8	0.5	6.5	0.7
Сууцны тусдаа байшин	209.9	29.4	267.9	29.9
Нийтийн байр	16.7	2.3	8.3	0.9
Бусад сууц	0.1	1.1	8.0	0.9

Гэрт амьдардаг өрхийг байршлаар харахад сумын төвд оршин суудаг өрхийн 58.6 хувь нь, хөдөөд 20.1 хувь нь байшинд амьдарч, 2010 оныхоос 5.2-11.7 пунктээр нэмэгдсэн нь хөдөөгийн өрхүүд, ялангуяа сумын төвийн өрхүүд байшинд амьдрах нь нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 12.3. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, БАЙРШИЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд	Байршил				
		Нийслэл	Аймгийн төв	Тосгон	Сумын төв	Хөдөө
2010						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Гэр	45.2	28.9	39.4	36.7	52.0	84.7
Байшин	53.6	69.7	59.1	62.3	46.9	14.9
Бусад сууц	1.2	1.4	1.5	1.0	1.1	0.4
2020						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Гэр	38.2	22.2	29.9	32.3	39.6	79.1
Байшин	60.9	77.3	68.8	65.9	58.6	20.1
Бусад сууц	0.9	0.5	1.3	1.8	1.8	0.8

ӨРХИЙН СУУЦНЫ ӨМЧЛӨЛ

Өрхийн амьдарч байгаа сууцны өмчийн хэлбэрийг иргэний, хувийн аж ахуйн нэгж байгууллагын, төрийн өмчийн гэж 3 ангилж үзсэн.

ХҮСНЭГТ 12.4. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд		Өмчийн хэлбэр		
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	Иргэний	Хувийн ААНБ-ын	Төрийн өмчийн
2010					
БҮГД	713.8	100.0	96.2	2.2	1.6
Гэр	322.8	100.0	99.2	0.4	0.4
Байшин	382.8	100.0	94.7	2.9	2.5
Бусад сууц	8.2	100.0	48.6	39.8	11.6
2020					
БҮГД	897.4	100.0	98.5	0.8	0.7
Гэр	342.4	100.0	99.1	0.8	0.1
Байшин	547	100.0	98.3	0.7	1.0
Бусад сууц	8.0	100.0	95.8	1.9	2.3

Нийт өрхийн 98.5 хувь нь иргэний, 1.5 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын болон төрийн өмчийн сууцанд сууж байна. Өөрийн өмчлөлийн сууцанд суугаа өрхийн хувийг 2010 онтой харьцуулахад 2.3 пунктээр нэмэгдсэн байна. Гэрт амьдарч байгаа бараг бүх өрх хувийн өмчийн гэрт амьдарч байна. Харин байшинд амьдардаг өрхийн 1.0 хувь нь төрийн өмчийн сууцанд амьдарч байгааг өмнөх тооллоготой харьцуулахад 1.5 пунктээр буурсан нь жил ирэх тусам төрийн өмчийн сууцууд багасаж, иргэд өмчтэй болж байгааг харж болохоор байна.

ХҮСНЭГТ 12.5. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Сууцны эзэмшлийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
2010						
БҮГД	713.8	100.0	479.5	100.0	234.3	100.0
Өөрийн	619.0	86.7	401.1	83.7	217.9	93.1
Бусдын сууцанд түрээстэй	45.0	6.3	40.9	8.5	4.1	1.7
Бусдын сууцанд түрээсгүй	43.5	6.1	33.0	6.9	10.6	4.5
Бусад	6.3	0.9	4.5	0.9	1.7	0.7
2020						
БҮГД	897.4	100.0	606.3	100.0	291.1	100.0
Өөрийн	822.6	91.6	547.0	90.2	275.6	94.7
Бусдын сууцанд түрээстэй	32.8	3.7	28.3	4.7	4.5	1.6
Бусдын сууцанд түрээсгүй	39.5	4.4	28.9	4.8	10.6	3.6
Бусад	2.5	0.3	2.1	0.3	0.4	0.1

Өрх, хүн амын хэдэн хувь нь өөрийн гэсэн орон сууцтай вэ гэдгийг тодорхойлох үзүүлэлт бол өрхийн сууцны эзэмшил юм. Сууцны эзэмшлийг хэлбэрээр нь үзэхэд хэд хэдэн асуудал тодорхой болно. Улсын хэмжээнд нийт өрхийн 8.4 хувь нь буюу 74.8 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байна. Эдгээрийн 59.3 мянга нь хотод амьдардаг өрхүүд байна. Хөдөөд энэ үзүүлэлт харьцангуй бага байгаа нь орон сууцны хэрэгцээг гол төлөв шинэ гэр, байшин барьж хангах боломжтой байдагтай холбоотой юм.

ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өрхийн 99.5 хувь, гэрт амьдардаг өрхийн 98.7 хувь, байшинд амьдардаг өрхийн 99.9 хувь нь цахилгааны эх үүсвэрт холбогдсон байна. Сэргээгдэх эрчим хүчинд холбогдсон өрхийн 88.9 хувь нь гэрт амьдардаг, тэдгээрийн 97.1 хувь нь хөдөөд тоологдсон байна.

ХҮСНЭГТ 12.6. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР	Бүгд		Хот		Хөдөө	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	889.4	100.0	601.5	100.0	287.9	100.0
Төвлөрсөн систем	725.5	81.6	594.5	98.8	131.0	45.5
Дизель станц	0.5	0.1	0.2	0.0	0.3	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	151.2	17.0	4.6	0.8	146.6	50.9
Бага оврын цахилгаан үүсгүүр	7.6	0.8	1.0	0.2	6.6	2.3
Цахилгааны эх үүсвэргүй	4.7	0.5	1.3	0.2	3.4	1.2
ГЭР	342.4	100.0	149.9	100.0	192.5	100.0
Төвлөрсөн систем	196.7	57.4	144.1	96.2	52.6	27.3
Дизель станц	0.2	0.1	0.0	0.0	0.2	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	134.4	39.2	3.9	2.6	130.5	67.8
Бага оврын цахилгаан үүсгүүр	6.8	2.0	0.8	0.5	6.0	3.1
Цахилгааны эх үүсвэргүй	4.4	1.3	1.0	0.7	3.4	1.7
БАЙШИН	547.0	100.0	451.6	100.0	95.4	100.0
Төвлөрсөн систем	528.8	96.7	450.4	99.7	78.4	82.3
Дизель станц	0.3	0.0	0.2	0.0	0.1	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	16.8	3.1	0.7	0.2	16.1	16.9
Бага оврын цахилгаан үүсгүүр	0.8	0.1	0.2	0.0	0.6	0.6
Цахилгааны эх үүсвэргүй	0.3	0.1	0.3	0.1	0.0	0.1


Улсын хэмжээнд 4.7 мянган өрх цахилгаангүй байна. Энэ нь өмнөх тооллогын үеийнхээс 4.9 дахин буурсан үзүүлэлт юм. Нийт цахилгаангүй өрхийн 93.5 хувь нь гэрт амьдардаг өрх бөгөөд тэдгээрийн 76.8 хувь нь хөдөө оршин суудаг ажээ.

ГЭР СУУЦ БОЛОН ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Монгол Улсын хэмжээнд үндэсний уламжлалт 225.8 мянган гэр сууцанд 342.4 мянган өрх тоологдсон нь нийт өрхийн 38.2 хувийг эзэлж, 2010 онтой харьцуулахад 7.0 пунктээр буурчээ.

Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг ашиглагдаж байгаа гэр сууцны дээвэр, туурга, шалны материалыг тодруулан асуусан. Хүн байнга амьдардаг гэр сууцны 91.3 хувь нь өвлийн улиралд давхар, 8.7 хувь нь дан дээвэр туургатай байдаг гэж хариулжээ. Улсын хэмжээнд нийт гэрийн 53.8 хувь нь шалгүй, 38.1 хувь нь модон шалтай, 6.1 хувь нь цементэн шалтай, 2.0 хувь нь бусад төрлийн шалтай байна.

ЗУРАГ 12.4. ГЭРИЙН ДЭЭВЭР, ТУУРГА, ШАЛНЫ ҮНДСЭН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Тооллогоор гэрт амьдардаг нийт өрхийн 68.7 хувь нь 5 ханатай гэрт, 11.3 хувь нь 6 ханатай гэрт амьдарч байна. Гэхдээ аймаг орон нутаг, угсаатны уламжлалт зан заншилтай холбоотойгоор ханын толгойн тоо, зууравчны хэмжээнээс хамаарч гэрийн хэмжээ бүс нутгуудад өөр өөр байдгийг анхаарах нь зүйтэй.

Таван ханатай гэрт амьдарч буй өрхийн 69.3-69.9 хувь нь 3-аас дээш ам бүлтэй өрх байгаагаас үзэхэд таван ханатай гэр манай ард түмний хамгийн түгээмэл сууц болох нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 12.7. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН АМ БҮЛИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		5-аас цөөн		5		6		6-аас дээш	
	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь
2010										
БҮГД	322.8	100.0	82.0	25.4	181.7	56.3	50.8	15.7	8.3	2.6
1-2	88.0	100.0	31.3	35.6	44.8	51.0	10.5	11.9	1.4	1.5
3-4	150.4	100.0	35.2	23.4	87.8	58.4	23.7	15.7	3.7	2.5
5-6	71.6	100.0	13.3	18.5	41.6	58.2	14.1	19.6	2.6	3.7
7+	12.8	100.0	2.3	17.5	7.4	58.0	2.6	20.5	0.5	4.0
2020										
БҮГД	342.4	100.0	60.9	17.8	235.2	68.7	38.5	11.3	7.8	2.2
1-2	118.4	100.0	27.6	23.3	79.1	66.8	9.9	8.3	1.8	1.6
3-4	124.4	100.0	20.0	16.1	87.0	69.9	14.3	11.5	3.1	2.5
5-6	81.7	100.0	11.2	13.6	56.6	69.3	11.6	14.2	2.3	2.9
7+	17.9	100.0	2.2	12.1	12.5	69.8	2.7	15.2	0.5	2.9

Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн талаар бие засах газар, хатуу хог, хаягдал болон бохир ус зайлуулах хэлбэр гэсэн үзүүлэлтийг тухайн өрхөөс асуусан бөгөөд үр дүнг нь нэгтгэвэл дараах байдалтай байна.

ХҮСНЭГТ 12.8. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙ НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Ахуйн нөхцөл	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРӨЛ	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Сайжруулсан нүхэн жорлон	-	-	-	1.5	2.2	0.9
Энгийн нүхэн жорлон	-	-	-	77.4	96.8	62.3
Био жорлон	-	-	-	0.1	0.2	0.1
Тогтсон газар байхгүй	25.8	4.7	45.7	21.0	0.8	36.8
БИЕ ЗАСАХ ГАЗАР	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бусадтай хамтран ашигладаг	58.7	61.3	54.3	30.3	33.1	27.3
Бусадтай хамтран ашигладаггүй	41.3	38.7	45.7	69.7	66.9	72.7
ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Үйлчилгээний байгууллагаар	43.0	80.1	7.9	45.5	90.5	10.4
Зөвшөөрөгдсөн цэгт	21.9	10.0	33.2	15.4	5.3	23.2
Шатаадаг	-	-	-	3.3	0.2	5.7
Булдаг	-	-	-	0.4	0.1	0.6
Тогтсон цэг байхгүй	35.1	9.9	58.9	35.5	4.0	60.1
БОХИР ЗАЙЛУУЛАЛТ	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цооног	56.5	81.7	32.6	53.7	85.2	29.2
Задгай	43.5	18.3	67.4	46.3	14.8	70.8


Бие засах тодорхой цэггүй өрх нийт өрхийн 21.0 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 4.8 пунктээр буурсан байна. Энэ үзүүлэлт хөдөөд 36.8 хувь байна. Хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх хотын нийт өрхийн 4.0 хувийг, бохир усаа задгай асгадаг өрх 14.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад буурсан үзүүлэлт хэдий ч төв, суурин газар оршин суугчдын орчны эрүүл ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлж байгааг анхаарч, цаашид гүнзгийрүүлэн судалж, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөдөө амьдардаг өрхийн хувьд 2010 онтой харьцуулахад хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэг байхгүй өрхийн хувь 1.2 пунктээр, бохир усаа задгай асгадаг өрхийн хувь 3.4 пунктээр тус тус өсжээ. Тиймээс хот, хөдөөд хөрсний бохирдол, амьдрах орчны эрүүл ахуйн нөхцөл зэргийг анхаарч, энэ талын бодлого хөтөлбөрийг түлхүү хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.

Гэрт амьдардаг өрхийн 63.5 хувь нь шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээс ундны усаа авч байна. Харин 36.5 хувь нь шаардлага хангаагүй ундны ус хэрэглэж байгаагаас 19.8 хувь нь усны ил эх үүсвэр, 13.4 хувь нь хамгаалагдаагүй гар худгаас ундны усаа хэрэглэж байна.

ЗУРАГ 12.5. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



БАЙШИНГИЙН ТОО, БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ


Байшин, орон сууцны болон Хүн ам, орон сууцны тооллогод байшинд дараах сууцуудыг хамруулсан ба Хавсралт Б-д байгаа “Тооллогод хэрэглэсэн ойлголт тодорхойлолт” хэсгээс дэлгэрэнгүй ойлголтуудыг үзнэ үү. Үүнд:

1. Орон сууцны байшин
 - 1.1. Орон сууцны байшингийн доторх сууц
2. Сууцны тусдаа байшин
3. Бие даасан тохилог сууц
4. Нийтийн байр

Монгол Улсын хэмжээнд 216.8 мянган байшин, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулаад 545.0 мянган байшин сууц тоологдсон байна.

Эдгээр байшингийн хийц, ашиглалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулсан ба үр дүнг нэгтгэвэл дараах байдалтай байна.

ЗУРАГ 12.6. БАЙШИН, АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН.



Тоологдсон нийт байшингийн 44.7 хувь нь 2009-2019 онд, 29.7 хувь нь 2000-2009 онд, 12.2 хувь нь 1990-1999 онд, 6.1 хувь нь 1980-1989 онд, 2.0 хувь нь 1970-1979 онд, 2.6 хувь нь 1969 оноос өмнө тус тус ашиглалтад орсон байна. Байшинг төрлөөр нь ангилан харвал орон сууцны байшингийн 29.5 хувь нь их бүтээн байгуулалтын жилүүд болох 1960-1989 онуудад ашиглалтад орсон бол 60.3 хувь нь сүүлийн 20 жилд ашиглалтад оржээ. Сууцны тусдаа байшингийн 43.0 хувь нь 1990-2009 онуудад, 44.5 хувь нь 2009-2019 онуудад ашиглалтад оржээ. Харин бие даасан тохилог сууцны 88.7 хувь нь сүүлийн 20 жилд, үүнээс 62.5 хувь нь сүүлийн 10 жилд ашиглалтад оржээ. Мөн бие даасан тохилог сууцны ашиглалтад оруулсан оныг мэдэхгүй (3.4 хувь) гэсэн хариулт бусад сууцнаас өндөр байгаа нь сууцыг худалдаж авсан, түрээсэлж байгаа тохиолдлууд их байсан.

ХҮСНЭГТ 12.9 БАЙШИНГИЙН ТОО, ХАНЫН ҮНДСЭН МАТЕРИАЛ, ХАНЫН ӨНГӨЛГӨӨНИЙ МАТЕРИАЛ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН

	Бүгд		НЗОСБ		Сууцны тусдаа байшин		Бие даасан тохилог сууц		Нийтийн байр	
	мян. сууц	Дүнд эзлэх хувь	мян. сууц	Дүнд эзлэх хувь	мян. сууц	Дүнд эзлэх хувь	мян. сууц	Дүнд эзлэх хувь	мян. сууц	Дүнд эзлэх хувь
ХАНЫН ҮНДСЭН МАТЕРИАЛ	216.8	100.0	7.4	100.0	203.6	100.0	4.3	100.0	1.6	100.0
Цутгамал төмөр бетон	5.2	2.4	1.9	24.9	3.0	1.5	0.2	5.9	0.1	4.1
Угсармал төмөр бетон	1.9	0.9	1.3	17.8	0.5	0.2	0.1	2.0	0.0	0.9
Блок	45.5	21.0	0.8	10.9	43.5	21.4	0.8	19.2	0.4	22.7
Тоосго	27.8	12.8	2.3	30.6	23.8	11.7	1.3	31.7	0.4	25.4
Мод	127.1	58.6	-	-	125.2	61.5	1.3	29.4	0.6	38.2
Сэндвич хавтан	1.1	0.5	-	-	0.8	0.4	0.2	5.8	0.0	2.1
Холимог	4.3	2.0	0.7	9.6	3.3	1.6	0.2	4.4	0.1	3.3
Бусад	4.0	1.8	0.5	6.2	3.5	1.7	0.1	1.6	0.1	3.3
ХАНЫН ӨНГӨЛГӨӨ, ГАДНА ФАСАДНЫ МАТЕРИАЛ	216.8	100.0	7.4	100.0	203.6	100.0	4.3	100.0	1.6	100.0
Цементэн шавардлага	65.7	30.3	3.8	50.9	60.0	29.5	1.2	29.0	0.7	41.9
Мод	22.7	10.5	-	-	22.4	11	0.3	6.0	0.1	8.1
Металл хавтан	4.3	2.0	0.1	0.7	3.9	1.9	0.3	6.7	0.0	1.1
Хуванцар хавтан	2.3	1.1	0.0	0.5	1.9	1.0	0.3	7.6	0.0	0.6
Чулуун хавтан	0.7	0.3	0.3	3.9	0.4	0.2	0.1	1.3	0.0	0.1
Тоосго	71.1	32.8	1.3	17.9	67.8	33.3	1.4	34	0.5	28.9
Шар шавар	17.3	8.0	0.4	4.9	16.7	8.2	0.1	1.4	0.2	10.9
Плита	0.5	0.2	0.2	2.1	0.3	0.1	0.0	0.3	0.0	0.2
Бусад	10.9	5.0	0.9	12.1	9.5	4.7	0.5	10.7	0.1	4.9
Байхгүй	21.4	9.8	0.5	7.0	20.7	10.1	0.1	3.0	0.1	3.3

Байшин сууцны ханын үндсэн материалын дийлэнхийг буюу 92.4 хувийг блок, тоосго, мод эзэлж байгаа бол ханын өнгөлгөө, гадна фасадын материалын 63.1 хувийг цементэн шавардлага, тоосго эзэлж байна. Сууцны төрлөөр дэлгэрүүлж харвал нийтийн зориулалттай орон сууцны байшингийн ханын үндсэн материалын 30.6 хувь нь тоосго, 24.9 хувь нь цутгамал төмөр бетон, 17.8 хувь нь угсармал төмөр бетон, харин ханын өнгөлгөөний 50.9 хувь нь цементэн шавардлага тус тус эзэлж байна. Сууцны тусдаа байшингийн ханын үндсэн материалын 61.5 хувь нь мод, өнгөлгөөний материалын 33.3 хувь нь тоосго, 29.5 хувь нь цементэн шавардлага байна.

ЗУРАГ 12.7. БАЙШИНГИЙН ШАЛНЫ ҮНДСЭН БОЛОН ХУЧИЛТЫН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Байшин сууцны 57.9 хувь нь бетон/цементэн шалтай, 36.5 хувь нь модон шалтай, 5.6 хувь нь бусад төрлийн шалтай байна. Байшин сууцны шалны хучилтад хулдаас 55.6 хувь, шахмал паркет 24.5 хувь, модон паркет 10.7 хувь, 8.6 хувь нь мод, плита болон бусад төрлийн материал ашигласан байна. Харин байшин сууцны 0.6 хувь нь ямар нэгэн шалны хучилтын материалгүй байна.

ХҮСНЭГТ 12.10. БАЙШИНГИЙН ДЭЭВРИЙН ХУЧИЛТЫН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН

Дээврийн материал	Бүгд	Сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, нийтийн байр	Орон сууцны байшин
БҮГД	100.0	100.0	100.0
Төмөр	81.5	83.8	23.1
Шавар	5.3	5.4	2.7
Шифр	4.8	4.8	5.9
Зөөлөн дээвэр	0.3	0.2	2.0
Хар цаас	6.3	4.2	60.2
Бусад	1.8	1.6	6.1

Орон сууцны байшингаас бусад төрлийн байшингийн дээврийн хучилтад төмөр (83.8 хувь) материалыг түлхүү ашигласан бол нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дээврийн хучилтад хар цаас (60.2 хувь)-ыг түлхүү хэрэглэжээ.

БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Монгол Улсын хэмжээнд 216.8 мянган байшин, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулаад 545.0 мянган байшин сууцанд 547.0 мянган өрх тоологдсон байна. Байшинд амьдардаг өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 7.3 пунктээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 12.11. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Сууцны талбай (квадрат метр)					
			20 хүртэл		21-40		40-өөс дээш	
	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
2010								
БҮГД	378.2	100.0	50.4	13.3	151.3	40.0	176.5	46.7
1-2	95.0	100.0	19.1	20.1	39.7	41.8	36.2	38.1
3-4	180.6	100.0	22.7	12.5	72.6	40.2	85.3	47.3
5-6	82.8	100.0	7.2	8.7	31.4	37.9	44.2	53.4
7+	19.8	100.0	1.5	7.5	7.4	37.6	10.9	54.9
2020								
БҮГД	546.6	100.0	46.4	8.5	133.1	24.4	367.1	67.1
1-2	160.6	100.0	16.5	10.2	42.8	26.6	101.3	63.1
3-4	213.2	100.0	17.3	8.1	50.9	23.9	145.0	68.0
5-6	132.2	100.0	9.8	7.4	29.9	22.6	92.6	70.0
7+	40.6	100.0	2.8	7.1	9.6	23.6	28.2	69.4

Байшинд амьдардаг өрхийн 24.4 хувь нь 21-40 квадрат метр талбайтай сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 15.6 пунктээр буурав. Гэтэл 40-өөс дээш квадрат метр талбайтай байшинд суудаг өрхийн хувь 67.1 хувь болж, өмнөх тооллогынхоос 2.1 дахин өссөнийг ерөнхийдөө орон сууцны багтаамж сайжирсан гэж үзэж болно. Үүнийг нотлох нэг үзүүлэлт бол 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 69.4 хувь нь 40-өөс дээш квадрат метр талбайтай байранд амьдарч байгаа явдал юм. Өрөөний болон өрхийн ам бүлийн тоог харьцуулж үзэхэд сууцны багтаамж нэмэгдсэн нь илүү тодорхой болно.

ХҮСНЭГТ 12.12. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХ, АМ БҮЛИЙН ТОО, ӨРӨӨНИЙ ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд	Өрөөний тоо					
		1	2	3	4	5-7	8+
2010							
БҮГД	100.0	33.6	39.5	18.9	5.5	2.1	0.4
1-2	100.0	43.5	37.0	14.5	3.5	1.2	0.3
3-4	100.0	32.8	40.8	18.9	5.2	1.9	0.4
5-6	100.0	26.5	40.0	22.4	7.5	3.0	0.6
7+	100.0	23.5	38.4	24.9	8.5	3.9	0.8
2020							
БҮГД	100.0	28.6	43.5	20.4	5.3	1.9	0.2
1-2	100.0	37.6	41.3	15.8	3.8	1.3	0.1
3-4	100.0	28.6	45.7	19.2	4.6	1.7	0.2
5-6	100.0	24.0	42.8	23.8	6.8	2.4	0.3
7+	100.0	23.4	40.9	25.1	7.2	2.9	0.4

Тооллогоор байшинд амьдардаг нийт өрхийн 72.1 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь 2010 оноос 1.0 пунктээр буурсан байна. Манай улсын өрхийн ам бүлийн дундаж үзүүлэлт болох 3-4 ам бүлтэй өрхийн 74.3 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгааг өмнөх тооллогын үеийнхтэй харьцуулахад 0.7 пунктээр, 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 64.3 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 2.4 пунктээр тус тус өссөн байна.

БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ

Доорх хүснэгтүүдэд байшинд амьдардаг өрхийн дэд бүтцийн хангамж болох халаалтын төрөл, усан хангамж, бие засах газар, онгоц, шүршүүрийн өрөөний талаарх үр дүнг нэгтгэж харууллаа.

Байшинд амьдардаг нийт өрхийн 49.6 хувь нь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 5.7 пунктээр өсжээ. Төвлөрсөн халаалтай байшинд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь хотод 5.9 пунктээр, хөдөөд 5.0 пунктээр тус тус өссөн нь орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоо эрс өссөнтэй холбоотой юм.

ХҮСНЭГТ 12.13. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Халаалтын төрөл	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн систем	43.9	51.6	7.2	49.6	57.5	12.2
Нам даралтын зуух	5.3	5.6	3.6	7.1	7.3	6.2
Цахилгаан халаагуур	0.6	0.7	0.5	2.0	2.3	0.6
Ердийн галлагаа	50.2	42.1	88.7	41.3	32.9	81.0
Газрын гүнийн дулаан	-	-	-	0.0	0.0	0.0
Шатдаг хий	-	-	-	0.0	0.0	0.0

Халуун, хүйтэн устай байшинд амьдардаг өрхийн хувь 45.9 хувь байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 7.3 пунктээр өсжээ. Энэ үзүүлэлт хотод 53.8, хөдөөд 8.6 хувь байна. Байшинд амьдардаг өрхийн 49.4 хувь нь буюу 270.4 мянган өрх зөөврийн ус хэрэглэж байгаагийн дотор хотын 187.3 мянган өрх байна. Байшинд амьдардаг, зөөврийн ус хэрэглэдэг өрхийн хувь өмнөх тооллогоос 7.4 пунктээр буурсны дотор хотод 7.5 пунктээр, хөдөөд 6.6 пунктээр тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 12.14. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Усан хангамж	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн усан хангамж	42.8	50.6	5.9	49.1	57.1	10.8
Халуун, хүйтэн устай	38.4	45.8	3.5	45.2	53.0	8.1
Зөвхөн хүйтэн устай	4.4	4.8	2.4	3.9	4.1	2.8
Бие даасан систем	0.4	0.4	0.3	1.5	1.4	2.0
Халуун, хүйтэн устай	0.2	0.2	0.1	0.7	0.8	0.5
Зөвхөн хүйтэн устай	0.2	0.2	0.2	0.8	0.6	1.4
Зөөврийн	56.8	49.0	93.8	49.4	41.5	87.2

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь онгоц, шүршүүр юм. Энэхүү үзүүлэлт нь хүн амын эрүүл ахуйн нөхцөл, ариун цэврийн байгууламжийн хүртээмж ямар байгааг тодруулах, энэ төрлийн бодлого, хөтөлбөр боловсруулах суурь эх үүсвэр болно.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор онгоц, шүршүүртэй эсэх асуултыг онгоц, шүршүүртэй, нийтээрээ ашигладаг, онгоц, шүршүүргүй гэж 3 ангилж байсан бол 2020 оны тооллогоор онгоц, шүршүүртэй, онгоц, шүршүүргүй гэж 2 ангилж, онгоц, шүршүүртэй бол бусадтай хамтран ашигладаг эсэхийг тодруулж асуусан болно.


ХҮСНЭГТ 12.15. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРӨЛ	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн системд холбогдсон	-	-	-	49.7	58.0	10.5
Цооногт урсгадаг ус татуургын бие засах газар	-	-	-	1.1	1.1	1
Нүхэн жорлонд урсгадаг ус татуургын бие засах газар	-	-	-	0.5	0.3	1.1
Сайжруулсан нүхэн жорлон	-	-	-	0.6	0.5	1.2
Энгийн нүхэн жорлон	-	-	-	47.4	39.9	83.1
Био жорлон	-	-	-	0.1	0.1	0.1
Тогтсон газар байхгүй	-	-	-	0.6	0.1	3.1
БИЕ ЗАСАХ ГАЗАР	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бусадтай хамтран ашигладаг	31.0	30.5	33.3	13.6	12.7	17.5
Бусадтай хамтран ашигладаггүй	66.9	69.0	57.0	86.4	87.3	82.5
Тогтсон газар байхгүй	2.1	0.5	9.7			
ОНГОЦ, ШҮРШҮҮР*	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Онгоц, шүршүүртэй	40.6	47.8	6.6	46.4	54.7	11.8
Байнгын суурилуулсан	40	47.1	6.0	45.4	53.7	10.7
Угсардаг/зөөврийн/	0.6	0.7	0.6	1.0	1.0	1.1
Нийтээрээ ашигладаг	2.2	2.5	0.5	6.5	6.4	7.7
Онгоц, шүршүүргүй	57.2	49.7	92.9	53.6	45.3	88.2

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор өрхийн бие засах газрын төрлийг асуугаагүй тул 2020 оны тооллоготой харьцуулах боломжгүй юм. Байшинд амьдардаг өрхийн 49.7 хувь нь төвлөрсөн системд холбогдсон бие засах газартай, 47.4 хувь нь энгийн нүхэн жорлонд бие засаж байна. Хотод 58.0 хувь нь төвлөрсөн системд холбогдсон бие засах газартай бол хөдөөд 83.1 хувь нь энгийн нүхэн жорлонд бие засдаг байна. Харин нийт байшинд суудаг өрхийн 0.6 хувь нь бие засах тогтсон газаргүй байгаа нь 2010 онтой харьцуулахад 1.5 пунктээр буурсан хэдий ч тогтсон бие засах газаргүй 3.3 мянган өрх байгаа нь хөрсний бохирдол, хүн амд халдварт өвчин тархах магадлалыг нэмэгдүүлэх эрсдэлтэй юм.


Байшинд амьдардаг нийт өрхийн 46.4 хувь нь онгоц, шүршүүртэй байгааг өмнөх тооллоготой харьцуулахад 5.8 пунктээр нэмэгджээ. Энэ үзүүлэлт хотод 6.9 пункт, хөдөөд 5.2 пунктээр тус тус өсжээ. Байнгын суурилуулсан онгоц, шүршүүртэй байшинд амьдардаг өрх нийт байшинд амьдардаг өрхийн 45.4 хувийг эзэлж байгаагийн дотор хөдөөд энэ үзүүлэлт 10.7 хувь байгаа нь хангалтгүй юм. Харин онгоц, шүршүүргүй өрхийн хувь улсын хэмжээнд 53.6 хувь байхад хөдөөд 88.2 хувь байна.

ЗУРАГ 12.8. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Өрхийн хатуу, хог хаягдлыг нэгдсэн бодлогоор ангилан ялгаж, тогтсон газар зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам сүлжээгээр зайлуулж, цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдолд ихээхэн нөлөөтэй. Ялангуяа, хүн ам ихээр төвлөрсөн томоохон төв, суурин газруудад хатуу хог, хаягдлыг дахин боловсруулах, иргэдэд хогоо ялгаж зайлуулах ухамсрыг төлөвшүүлэх зэрэг олон асуудалд энэхүү үзүүлэлтүүд тодорхой хариулт өгнө. Байшинд амьдардаг өрхийн 85.3 хувь нь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 8.2 пунктээр өссөн байна. 2010 онд байшинд суудаг өрхийн 5 хувь нь хатуу хог хаягдлаа зайлуулах тодорхой цэггүй байсан бол 2020 онд 2.5 болтлоо буурчээ.

ЗУРАГ 12.9. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Байшинд амьдардаг өрхийн 48.5 хувь нь төвлөрсөн системээр, 1.0 хувь нь бие даасан системээр шингэн хог хаягдлаа зайлуулж, 46.3 хувь нь цооногт, үлдсэн 4.2 хувь нь задгай асгаж байна. Цооногт асгаж байгаа хувь өндөр байгаа нь сууцны тусдаа байшинд амьдардаг өрх байшинд амьдардаг өрхийн дийлэнхийг бүрдүүлж байгаатай холбоотой.



ХАВСРАЛТ



ХАВСРАЛТ А

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ТҮҮХЭЭС

Аливаа улс үндэстнүүд эрт дээр үеэс цэрэг дайчлах, албан татвар хураах зэрэг зорилгоор хүн амаа бүртгэн тоолж байсан.

Монгол Улс хүн амын бүртгэлийг нэн эртнээс явуулж, XIII зуунаас эхлэн хүн амаа тоолж байсан тухай түүхийн сурвалж бичигт тэмдэглэжээ. Гэхдээ хэдий хэмжээний газар нутгийг хамарч, хэдэн онд бүртгэл, тооллого явуулж, хэчнээн хүн тоологдож байсан талаар тэр үеийн түүхэн тодорхой баримт хараахан олдоогүй байна.

Түүхийн Төв архивын эх сурвалжаас үзэхэд 1789 онд Түшээт хан аймгийн Ахай гүний хошуу (Одоогийн Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум) хүн ам, малын тоо бүртгэлийг явуулжээ. Түүний дараа 1854 онд Түшээт хан аймгийн арван хошуу нэг жилийн дотор хүн ам, малаа тоолсон баримт байна. Энэ мэтчилэн 1789-1919 он хүртэлх 130 жилд Монгол Улсын 4 аймгийн хошууд давхардсан тоогоор 80 удаа хүн ам, малын бүртгэл, тооллого явуулжээ.

Манай улсын хүн амын бүртгэлийн нэг онцлог бол хүн амаа тоолохын зэрэгцээ малынхаа тоог хамт бүртгэж, тоолж байжээ. Ийм төрлийн бүртгэлийг 1940 оныг хүртэл явуулж байлаа.⁹

Дэлхийн улс орон орчин үед явагдаж байгаа хүн амын тооллогыг 200-гаад жилийн тэртээгээс тодорхой давтамжтайгаар, нэгдсэн хөтөлбөрөөр явуулж, үр дүнг нь албан ёсоор нэгтгэн гаргаж иржээ.

Монгол Улсад хүн амын тооллого XX зууныг хүртэл тогтмол явагдаж байгаагүй. Богд Хаант Монгол Улс 1918 онд хүн амын анхны тооллогыг хийсэн юм. Удаах тооллогуудыг 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000, 2010 онуудад, завсрын тооллогыг 2015 онд явуулсны дотор сүүлийн 4 тооллогыг орон сууцны тооллоготой хамтатган зохион байгуулсан. Үүний зэрэгцээгээр 1947, 1950 онуудад хүн амын тооллого шиг нэг удаагийн бүртгэл хийсэн байдаг.

Хүн амын 1956 оны тооллогыг Улсын төлөвлөгөөний комиссын Тоо бүртгэлийн хэлтсээс эрхлэн явуулсан нь аргачлал, хөтөлбөрийн хувьд нэлээд боловсронгуй болсон байжээ.

Монгол Улсад статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны бие даасан байгууллага 1960 онд байгуулагдаж, 1963 оны тооллогоос эхлэн тус байгууллага хүн ам, орон сууцны тооллогыг эрхлэн явуулж ирэв.

Статистикийн байгууллага тооллогыг эрхлэн явуулж эхэлснээр тооллогын асуулга, хөтөлбөр, заавар, аргачлалыг олон улсын нийтлэг жишиг аргачлалтай нийцүүлэн боловсруулж, баталж, мөрдүүлэх, тооллогын дүнг нэгтгэн боловсруулахад орчин үеийн техник, технологи ашиглах болсон байна.

Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн аргачлалын дагуу 1969, 1979, 1989 оны тооллогыг явуулсан ба энэхүү аргачлал нь НҮБ-ын зөвлөмжтэй нийцэж байв.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого нь өмнөх тооллогоос ихээхэн онцлогтой байв. Энэхүү тооллого нь Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үед явуулсан анхны тооллого болсон ба тооллогод ашиглагдах ойлголт, тодорхойлолт, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг шинэчлэн өөрчлөх шаардлага гарсан.

9 Б.Эрдэнэсүрэн, Ц.Бадрах, Монгол улсын хүн ам зүйн түүхэн товчоо, Улаанбаатар хот, 2013 он

НҮБ-аас удаа дараа гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж”-ийг 2000 оны тооллогод анх удаа, уг зөвлөмжийн 2008 онд өргөжүүлэн шинэчилсэн хоёр дахь хувилбарыг 2010 оны тооллогод удирдлага болгосон нь олон улсын стандартад нийцсэн, орчин үеийн аргачлалтай тооллого болгосон юм. Харин 2015 онд зохион байгуулж явуулсан завсрын тооллогыг өмнө зохион байгуулсан туршлага байхгүй бөгөөд дээрх зөвлөмж, хуульд заасны дагуу анх удаагаа зохион байгуулсны сацуу “Хүн амын регистрийн бүртгэлд суурилсан бүртгэлийн аргаар” хийсэн. Өөрөөр хэлбэл, засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, хороонд хөтлөгддөг “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-г төрийн захиргааны бусад байгууллагын мэдээллийн сантай уялдуулан завсрын тооллогын үр дүнг гаргасан юм. Түүнчлэн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдээ интернэтээр тоолон, гадаадын олон орны туршлагад тулгуурлан орон зайн газарзүйн мэдээллийг тооллогын үр дүнтэй холбон ашигласан тооллого болсон.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС, ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТООЛЛОГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

Хүн амын тооллого явуулах хууль, эрх зүйн бусад үндсийг бүрдүүлэх нь тооллого явуулах үндсэн баталгаа юм. Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оноос өмнөх бүх тооллогыг “Хүн амын тооллого явуулах тухай” Засгийн газрын шийдвэрээр зохицуулж ирсэн.

Харин Хүн ам, орон сууцны 2010, 2015 (завсрын тооллого), 2020, Байшин, орон сууцны 2019 оны улсын тооллогыг 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн дагуу явууллаа. Уг хуулиар тооллого явуулах эрх зүйн болоод эдийн засгийн баталгааг хангаж, тооллого явуулах хугацаа, арга зүй, зохион байгуулах байгууллага, институт, төрийн байгууллага, засаг захиргааны нэгжийн удирдлага болон хувь хүний тооллогод оролцох үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллоготой холбогдсон эрх зүйн акт:

Монгол Улсын хууль:

- “Статистикийн тухай” хууль, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;
- “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хууль;
- “Зөрчлийн тухай” хууль

Монгол Улсын Их Хурлын тогтоолууд:

- “Тооллогын тов тогтоох тухай”
2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 76 дугаар тогтоол;
- “Улсын комисс байгуулах тухай”
2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 77 дугаар тогтоол

Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын тогтоолууд:

- “Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын улсын комиссын ажиллах журам”
2018 оны 2 дугаар сарын 22-ны өдөр;
- “Төлөвлөгөө батлах тухай”
2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоол;
- “Аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай”
2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоол;
- “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын хүрээнд Байшин орон, сууцны туршилтын тооллогыг зохион байгуулах тухай”
2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоол;
- “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын мастер төлөвлөгөө”

- 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоол;
- “Хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах Улсын комиссын Нарийн бичгийн даргыг томилох тухай”
2018 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн Б/20 дугаар тушаал;
- “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай”
2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоол;
- “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын төсвийн эрх нээх тухай”
2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоол
- “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнг нийтэд зарлах тухай”
2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоол

Үндэсний Статистикийн Хорооны даргын тушаалууд:

- “Ажлын хэсэг байгуулах тухай”
2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тушаал;
- “Хүн ам, орон сууцны туршилтын тооллого явуулах тухай”
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/150 дугаар тушаал;
- “Аймаг, нийслэлийн тооллогын комисс, түр товчооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах тухай”
2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/36 дугаар тушаал;
- “Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн маягт, нөхөх заавар шинэчлэн батлах тухай”
2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/44 дүгээр тушаал;
- “Байшин, орон сууцны тооллогын асуулга, гарын авлага батлах тухай”
2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/81 дүгээр тушаал

Энэ тушаалаар баталсан маягтууд:

- Байшин сууцны асуулга (БОСТ-1-1)
 - Гэр сууцны асуулга (БОСТ-1-2)
 - Нийтийн зориулалттай орон сууцны асуулга (БОСТ-2)
 - Урьдчилсан бүртгэлийн маягт (БОСТ-3)
 - Явцын мэдээний маягт (БОСТ-4)
 - Байшин орон, сууцны тооллогын гарын авлага
- “Статистикийн зорилгоор ашиглах улс, нутаг дэвсгэрийн ангилал, код батлах тухай”
2019 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/104 дүгээр тушаал;
 - “Баг, хорооны нэр, кодыг засварлаж, шинэчлэн батлах тухай”
2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн А/117 дугаар тушаал;
 - “Статистикийн зорилгоор “Дээд боловсролын мэргэжлийн ангилал, код”-ыг батлах тухай”
2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн А/118 дугаар тушаал;
 - “Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын асуулга, гарын авлага, нөхөх заавар батлах тухай”
2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/151 дүгээр тушаал;

Энэ тушаалаар баталсан маягт, зааврууд:

- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын асуулга (ХАОСТ-1)
- Тооллогын асуулгын нэмэлт хуудас- Хүн амын асуулга (ХАОСТ-1а,1б)
- Тооллогын асуулгын нэмэлт хуудас- Гадаадад 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа иргэдийн мэдээлэл (ХАОСТ-1в)
- Хүн ам, орон сууцны тооллогын явцын мэдээ (ХАОСТ-2)
- Хүн ам, орон сууцны тооллогын урьдчилсан дүн (ХАОСТ-3)

- Хүн ам, орон сууцны тооллогын нөхөгдсөн асуулга хүлээлцэх баримт (ХАОСТ-4)
- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого - Хяналтын тооллогын асуулга (ХАОСТ-11)
- Хяналтын тооллогын асуулгын нэмэлт хуудас (ХАОСТ-11а)
- Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын асуулга, нэгтгэлийн маягтын нөхөх заавар, гарын авлага

ТООЛЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Тооллого нь статистикийн мэдээллийн томоохон эх сурвалжуудын нэг юм.

Хүн ам, орон сууцны улсын тооллогын үйл ажиллагааны онцлог нь засаг захиргааны хамгийн бага нэгжээс төрийн захиргааны төв байгууллагууд, ард иргэдийг нийтэд нь хамруулан өргөн цар хүрээтэй, нарийн нягт зохион байгуулалттай явуулдагт оршино.

Тооллогын бэлтгэл ажлыг сайн зохион байгуулах удирдлагын багийг бүрдүүлж, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагыг 2020 оны ээлжит тооллого нь бүрэн хангасан болно.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гишүүн орнууддаа хүн ам, орон сууцны тооллогыг 2015-2024 онуудад наад зах нь нэг удаа тухайлбал, 2020 оны орчимд зохион байгуулахыг зөвлөмж болгосон. Энэ утгаараа хүн ам, орон сууцны тооллогыг зохион байгуулж явуулах нь НҮБ-ын өмнө Монгол Улсын хүлээж буй нэг үүрэг болж байлаа.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг холбогдох Монгол Улсын хууль болон НҮБ-ын Статистикийн хэлтсээс эрхлэн гаргасан “Хүн ам, орон сууцны 2020 он орчмын тооллогод баримтлах зарчим, зөвлөмж III”-ийн Хүн амын тооллого бүлэгт үндэслэн зохион байгуулж явуулсан. Түүнчлэн шинээр бий болсон хаягийн мэдээлэлд тулгуурлан үндэстний хэмжээнд тулгамдаж байгаа мэдээллийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын хүрээнд Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд зохион байгуулж явуулсан.

Тооллого явуулах арга, аргачлал, удирдлага, зохион байгуулалт, үе шат, төсвийн асуудлыг цогцоор нь тусгасан мастер төлөвлөгөө боловсруулж, Монгол Улсын Хүн ам, орон сууцны тооллогын Улсын комиссын 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталж мөрдөв.

Тооллогын бэлтгэл хангах 73 зүйл заалтыг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг Улсын комиссын анхдугаар хуралдаанаар 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталж, мөрдөж хэрэгжүүлсэн.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын үйл ажиллагааг дараах үндсэн үе шатуудаар зохион байгуулж явуулсан. Үүнд:

- I. Тооллогын бэлтгэлийг хангах үе
- II. Тоолох үе
- III. Тооллогын хяналт, үнэлгээ хийх үе
- IV. Тооллогын мэдээлэл боловсруулах үе
- V. Тооллогын үр дүнд дүн шинжилгээ хийх үе
- VI. Тооллогын мэдээллийн сан үүсгэх, үр дүнг тархаах үе

Тооллогын бэлтгэл үед зохион байгуулалтын ажил, тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийн зураглал хийх, тооллогын ухуулга сурталчилгаа, асуулгын хуудас, гарын авлага боловсруулах, хэвлэх, тархаах, туршилтын тооллого явуулах, сургалтууд зохион байгуулах, материаллаг бааз тоног төхөөрөмж, программ хангамжийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, шинэчлэн сайжруулах зэрэг арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн.

ТООЛЛОГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн дагуу 2020 оны ээлжит тооллогын удирдлага, зохион байгуулалт нь тооллогын Улсын комисс, Үндэсний Статистикийн Хороо, аймаг, нийслэл, сум, дүүрэг болон тооллого зохион байгуулж явуулах төрийн захиргааны төв байгууллагын тооллогын комисс, орон нутгийн түр товчоод, тооллого зохион байгуулж явуулах төрийн захиргааны төв байгууллагын түр товчоод, тоологч, шалгагч нараас бүрдсэн.

ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИСС

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 77 дугаар тогтоолоор тооллогыг удирдан зохион байгуулах Улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр батлав. Үүнд:

Комиссын дарга:

Монгол Улсын Ерөнхий сайд

Комиссын орлогч дарга:

Үндэсний Статистикийн Хорооны дарга

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Улсын комиссын гишүүд:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Барилга, хот байгуулалтын сайд

Батлан хамгаалахын сайд

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд

Гадаад харилцааны сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

Сангийн сайд

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

Хууль зүй, дотоод хэргийн сайд

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

Эрчим хүчний сайд

Эрүүл мэндийн сайд

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

Нарийн бичгийн дарга:

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга.

Монгол Улсын “Хүн ам, орон сууцны тооллогын тухай” хуулийн 13.4-т заасан шаардлагыг хангасан орон тооны албан хаагчийг тооллогын Улсын комиссын 2018 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар Нарийн бичгийн даргыг томилж, ажиллуулсан.

Тооллогын Улсын комисс нь дараах үндсэн чиг үүрэгтэйгээр ажилласан. Үүнд:

- Тооллогын бэлтгэл ажлыг хангуулах, удирдан зохион байгуулж явуулах, үр дүнг нэгтгэн гаргахад хяналт тавьж, нэгдсэн удирдамж чиглэл өгөх;
- Тооллогод тодорхой үүрэгтэйгээр оролцох яам, агентлагуудын ажлын уялдаа холбоо, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах;
- Хүн ам, орон сууцны тооллогод улсын төсвөөс гарах зардлыг тооллогын төсөвт суулган батлуулах;
- “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заагдсан бүрэн эрхийг хэрэгжүүлэх

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Үндэсний Статистикийн Хороо нь дараах үндсэн чиг үүрэгтэйгээр тооллогыг удирдан зохион байгуулж явуулсан. Үүнд:

- Тооллогыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж явуулах;
- Улсын комисс, түүний гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;
- Улсын комиссын шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх;
- Улсын комиссын хуралдааны бэлтгэл хангах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, гаргасан шийдвэрийг хэлбэржүүлэх, нийтлэх, мэдээлэх;
- Тооллогын асуулгын хуудас, тооллогын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх аргачилсан заавар, зөвлөмж батлах, асуулгын хуудас болон холбогдох материалуудыг хэвлүүлэх, хуваарилах;
- Тооллогын дүнг нэгтгэж, Улсын комисст оруулах;
- Тооллогын мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, үр дүнг хэрэглэгчдэд мэдээлэх, тархаах;
- Шаардлагатай сургалт, сурталчилгаа явуулах;
- Хууль тогтоомжид заасан болон Улсын комиссоос үүрэг болгосон бусад чиг үүрэг

ОРОН НУТГИЙН ТООЛЛОГЫН КОМИСС

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн дагуу тооллогын Улсын комиссын “Аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай” 2018 оны 2 дугаар сарын 22-ний өдрийн 02 дугаар тогтоолоор холбогдох шатны тооллогын комиссыг байгуулж ажиллууллаа.

Тооллогын Улсын комисс аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг, аймаг, нийслэлийн тооллогын комисс сум, дүүргийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг тус тус тогтоож, шийдвэр гаргаж, холбогдох шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын шийдвэрээр аймаг, нийслэл, сум, дүүрэг тухайн нэгжид тооллогыг зохион байгуулж явуулах тооллогын комиссыг байгуулсан.

Дээд шатны тооллогын комиссын зөвлөмж болгосны дагуу хүн ам, орон сууцны тооллого зохион байгуулж явуулах үүрэг бүхий түр товчоог байгуулж, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13.7-д заасан үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Тооллогын бүх шатны комисс нь хариуцсан засаг захиргааны нэгжийн хэмжээнд тооллогыг удирдан зохион байгуулж, шаардагдах хөрөнгө, хүн хүч, байр, унаа, шатахуунаар хангах, тооллогын ажилтныг сургаж бэлтгэх, бүрэн хамралттай явуулах, дүнг нэгтгэн тушаах үндсэн үүрэгтэйгээр ажиллав.

ОРОН НУТГИЙН ТҮР ТОВЧОО

Тооллогын түр товчоог аймаг, нийслэлийн түвшинд статистикийн хэлтсийн дарга, сум, дүүргийн түвшинд Засаг даргын орлогчоор ахлуулж, статистик болон бүртгэлийн хэлтэс, тамгын газрын гүйцэтгэх ажилтны бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсан. Тооллогын түр товчоод нь тооллогын комиссын удирдлагын дор нийтдээ 3-6 (шинээр авсан болон статистикийн газар/ хэлтэст ажиллаж байгаа хүмүүсээс бүрдсэн) хүний бүрэлдэхүүнтэйгээр дараах үүрэгтэйгээр ажилласан. Үүнд:

- Анхан шатны нэгжид зураглал хийхэд туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах;
- Орон нутагт сургалт зохион байгуулах бэлтгэлийг хангах, хамтран зохион байгуулах;
- Харьяалагдах өрх, иргэн бүрд тооллогын ач холбогдлыг сурталчлах;
- Тооллого явагдахаас сарын өмнө Хүн ам, өрхийн бүртгэлийг шинэчлэн хөтлөх, тулгалт хийх,

жагсаалтыг бэлтгэх ажлыг орон нутагтаа зохион байгуулсан байх;

- Харьяалагдах өрх, иргэн нэг бүрийг орхигдуулалгүй, давхардуулалгүй тоолох, товчоолсон мэдээллийг өдөр бүр нэгтгэж дээд шатны комисст хүлээлгэн өгөх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэв.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын орон нутаг дахь түр товчоодыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн статистикийн газар/ хэлтсийн бүтцийн хүрээнд байгуулж, тооллогын түр товчоонд 1 ажилтныг тооллогын үеэр буюу 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс 2021 оны 1 дүгээр сарын 1 хүртэл 1 жилийн хугацаатай гэрээгээр ажиллуулж байна.

ТООЛОГЧ, ШАЛГАГЧ

Сум, дүүргийн тооллогын комисс, тооллогын түр товчоод нь тоологч, шалгагчаар дараах нийтлэг шаардлагыг хангасан хүнийг сонгон шалгаруулж авсан. Үүнд:

- Бүтэн цагаар ажиллах бололцоотой;
- Бүрэн дундаас дээш боловсролтой;
- Цэвэр нямбай, гаргацтай бичих бичгийн чадвартай;
- Харилцааны өндөр соёлтой;
- Багаар ажиллах чадвартай;
- Хүн амын болон мал тооллого, бусад төрлийн судалгаа, сонгууль болон олон нийтийг хамарсан ажилд оролцож байсан туршлагатай.

Байшин, орон сууцны тооллогын тоологчид дээрх шаардлагаас гадна тооллогын сургалтад хамрагдаж, тоолох үе дуусахад таблетыг сумын тооллогын комисст тушаах хүртэл хугацаанд тухайн суманд тогтвортой амьдрах, ажиллах заалтыг нэмэлтээр тавьсан.

ТУРШИЛТЫН ТООЛЛОГО, АСУУЛГЫН МАЯГТЫГ НЯГТЛАХ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын зохион байгуулалт болон асуулгын маягтыг нягтлах туршилтын тооллогыг хамтад нь явуулсан болно. Харин Байшин, орон сууцны 2019 оны тооллогын мэдээлэл цуглуулах арга, зарчим, систем, хэрэглэгдэхүүнийг анхан шатны нэгжид турших, хүндрэл бэрхшээлийг судалж, сайжруулах зорилгоор асуулгын маягтыг Архангай аймгийн Эрдэнэбулган сум, Ихтамир суманд, таблетаар Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6, 9, 19-р хороонд 2018 оны 6 дугаар сард хийсэн.

Туршилтын тооллогод манай улсын байгаль цаг уурын янз бүрийн бүс, хүн амын суурьшил, дотоод шилжих хөдөлгөөний байдал зэргээс хамааран ээлжит тооллогод ямар нэг хэлбэрээр хүндрэл бэрхшээл гарч болох нутаг дэвсгэрийг сонгосон юм. Туршилтын тооллогод нийслэл хотын хамгийн их хүн амтай хэсэг болох Сонгинохайрхан дүүргийн 6-р хорооны 1, 2, 3, 10-р хэсэг, Хан-Уул дүүргийн 15-р хорооны 4, 13, 14, 16-р хэсэг, Баянзүрх дүүргийн 5-р хорооны 6, 9, 19-р хэсэг, орон нутгаас Дорнод аймгийн Хэрлэн сумын 1, 7-р баг, Сэргэлэн сумын 5-р багийн нутаг дэвсгэрт зохион байгуулав. Хүн ам, орон сууцны 2020 оны туршилтын тооллогын тов нь ээлжит тооллогын адилаар шилжихгүй шөнийн товтой байв. Энэ нь товын дараа төрсөн хүүхдийг тоолохгүй, харин товын дараа нас барсан хүнийг тоолно гэсэн ойлголт юм. Байшин, орон сууцны туршилтын тооллогын мэдээлэл цуглуулалтыг 2018 оны 10 дугаар сараас 11 дүгээр сард, Хүн ам, орон сууцны туршилтын тооллогын мэдээлэл цуглуулалтыг 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 16-ны өдрүүдэд зохион байгуулав. Хүн ам, орон сууцны туршилтын тооллогоор 25402 хүн тоологдсон бол Байшин, орон сууцны туршилтын тооллогоор 3018 сууц тоологдсон байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын туршилтад мэдээлэл цуглуулалтын уламжлалт аргыг

ашигласан. Өөрөөр хэлбэл, туршилтын тооллогод сонгогдсон нэгжийн бүх өрхийг тоолов. Энэ нь ээлжит тооллогын уламжлалт аргыг турших, мөн тоолсон өрхийн мэдээллийг Хүн ам, өрхийн мэдээллийн сан болон Байшин, орон сууцны тооллогын сантай уялдуулан шалгаж мэдээллийн сангийн бүрдэлт, нөхөлт, мэдээллийн чанарыг үнэлэхийг зорьсон юм.

Харин Байшин, орон сууцны туршилтын тооллогын хүрээнд Collector for ArcGIS программ ашиглан “Хаягийн зураг”-т дүрслэгдсэн сууцыг нийтийн зориулалттай орон сууцны байшин, орон сууцнаас бусад төрлийн сууц, зуслангийн сууц, сууцны бус байшин, барилга гэсэн үндсэн 4 ангиллаар ангилан ялгаж, “Хаягийн зураг”-т дүрслэгдээгүй буюу шинээр баригдсан сууц, гэр сууц зэргийг зурагт нэмж тэмдэглэх байдлаар урьдчилсан бүртгэлийг хийж байшин, орон сууцны туршилтын тооллогоор тоологдох нийт сууцны тоог урьдчилсан байдлаар гаргасан. Collector for ArcGIS программ нь сууцны төрлөөс хамааран цэг, полигон(өнцөг бүхий дүрс)-оор ялган ангилах, тухайн сууцны байршлыг орон зайн төвшинд тодорхойлох, тооллогын явцыг орон зайн төвшинд онлайнаар хянах зэрэг олон давуу талуудтай байв. Collector for ArcGIS программ нь судалгаанд зориулсан программ биш учраас асуулга боловсруулахад хүндрэл үүссэн, энэ шалтгаанаар тооллого, судалгааны мэдээлэл цуглуулах боломжтой Survey123 for ArcGIS программ хангамжийг Collector for ArcGIS программ хангамжтай уялдуулан тооллогын асуулгыг маягтын дагуу боловсруулсан. Энэхүү программ хангамж нь асуулга хоорондын уялдаа хамаарал, шилжилт, шалгуур, ангилал кодчилал буюу мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд шаардлагатай бүх төрлийн боломжуудыг агуулсан байдаг.

Дээр дурдсан туршилтуудыг хийснээр ээлжит тооллогын асуулгыг эцэслэн боловсруулж, нөхөх заавар, комисс, түр товчооны ажилтнууд, шалгагч, тоологчийн гарын авлагыг бэлтгэж, хэвлэх, бусад бэлтгэлийг хангах боломж бүрдсэн. Туршилтын үр дүнд ээлжит тооллогын төсөв, төлөвлөлт, асуулга болон нэгтгэлийн маягтын үзүүлэлт, нөхөх зааварт анхаарах асуудлуудыг тусгасан.

ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, ГАЗРЫН ЗУРАГЛАЛ

Монгол Улс 2019 онд анх удаа Байшин, орон сууцны тооллого (БОСТ) явуулж, энэ ажлын хүрээнд анх удаа орчин үеийн техник, технологийг ашигласан юм. Тооллогод 200 ширхэг таблет төхөөрөмжид ArcGIS for Collector болон Survey123 for ArcGIS программ дээр тухайн нутаг дэвсгэрийн хаягийн зургийг тухай бүр суулгаж, тооллогыг Баруун бүс, Хангайн бүс, Төвийн бүс, Зүүн бүс, Улаанбаатар гэсэн бүсчилсэн маршрутын дагуу тооллогыг явуулаа. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогыг БОСТ-ын хаягийн зураг дээр суурилж явуулсан бусад тооллогуудаас онцлогтой болов.

Тоологчийн газрын зураг

Байшин, орон сууцны тооллогын мэдээлэл цуглуулалтад олон улсын газар зүйн мэдээллийн системийн программ хангамж нийлүүлэгч ESRI компанийн судалгаанд зориулагдсан Collector for ArcGIS болон Survey123 for ArcGIS програмуудыг хослуулан ашигласан.

Collector for ArcGIS программ нь сууцны төрлөөс хамааран цэг, полигон (өнцөг бүхий дүрс)-оор ялган ангилах, тухайн сууцны байршлыг орон зайн төвшинд тодорхойлох, онлайнаар хянах зэрэг олон давуу талуудтай байв. Түүнчлэн тоологч мэдээлэл цуглуулалтаар явж байх үед гар зурагт дүрслэгдээгүй хүн байнга амьдардаг сууцыг нэмж оруулах боломжоор хангаж өгсөн.

Урьдчилсан бүртгэлийн үр дүнд үүссэн газрын зургийг тооллогын асуулгатай холбон тоологч тус бүрээр нутаг дэвсгэрийг хуваарилан тооллого явуулах зөөврийн төхөөрөмж (таблет)-д суулган, тоологч интернэтгүй орчинд тооллогын мэдээллийг цуглуулж, заасан хугацаанд түр товчооны байранд очиж интернэтэд холбогдон цуглуулсан мэдээллээ төв серверт дамжуулж, тооллогын явцын мэдээллийг цаг тухай бүр мэдээлж байв.

Түүнчлэн, тооллогын явцын мэдээллийг хянах цахим хяналтын программыг ArcGIS On-line программаар боловсруулж цахим хяналтын программаар орон зайн төвшинд болон хүснэгт

хэлбэрээр мэдээллийг гаргаж хянасан.

Газарзүйн мэдээллийн системийн программуудыг мэдээлэл цуглуулалтад ашигласнаар тооллогын үр дүнг хэрэглэгчдэд илүү ойлгомжтой хүргэхээс гадна орон зайн төвшинд сэдэвчилсэн газрын зургууд, аппликейшн хийх боломж бүрдсэн юм.

Тооллогыг чанарын өндөр түвшинд сайн явуулахад газрын зураг чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнд:

1. Тооллогыг удирдан явуулж байгаа ажилтнууд ажлаа тухайн засаг захиргааны нэгжийн зургийн дагуу төлөвлөж, тооллогын үйл явцыг зохицуулахад илүү хялбар болгодог.
2. Тоологдох орон сууцыг олж, тоологч нарт оноож өгөн тоологч нарын гүйцэтгэх ажлын хуваарийг тооллогын хэсгийн хил хязгаартай нийцүүлснээр бүх өрхийг тооллогод хамруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.
3. Системтэй, шаталсан газарзүйн тогтолцоо нь сэдэвчилсэн газрын зураг ашиглах боломжийг олгож, тооллогын үр дүнгээс гарах бүтээгдэхүүний төрөл, тоог баяжуулдаг юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бүхий л үе шатад эдгээр программ хангамжуудыг ашиглах боломжийг ESRI компани болон ESRI компанийн Монгол дахь дистрибьютер Монмап компани олгосон юм.

Байшин, орон сууцны тооллогын бас нэгэн онцлог нь мэдээлэл цуглуулалтыг орон даяар нэгэн зэрэг эхлэлгүй баруунаас зүүн тийш бүсчилсэн байдлаар зохион байгуулсан ба мэдээллийг цуглуулахдаа Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас хаягжилтын шинэчилсэн аргачлалын дагуу хийгдсэн хаягийн зургийг суурь болгон сууцны зориулалттай бүх байшин, орон сууцыг тоолсон явдал юм. Тооллогоор сууцны мэдээллийг цуглуулахдаа шинэ дэвшилтэт техник технологи болох таблет төхөөрөмж, мөн Collector for ArcGIS, Survey123 for ArcGIS программуудыг ашиглалаа. Харин нийтийн зориулалттай орон сууцны байшингийн мэдээллийг тухайн сууцыг хариуцан ажилладаг Сууц өмчлөгчдийн холбоо, Орон сууц, нийтийн аж ахуйн газраас цуглуулсан.

ХАВСРАЛТ Б

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

№	Ойлголт	Тодорхойлолт
ТООЛЛОГО		
1	Хүн ам, орон сууцны тооллого	Товлон тогтоосон хугацаанд тухайн улс оронд (буюу түүний нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг) оршин суугаа нийт хүн амыг хамарч, тэдний амьдарч буй сууцны талаарх суурь мэдээллийг цуглуулах, боловсруулах, хүн ам зүйн, эдийн засаг, нийгмийн дүн шинжилгээ хийх, үнэлэх, хэвлэн нийтлэх, нийтэд тархаах цогц үйл ажиллагаа;
2	Тооллогын тов	Тооллого явуулах хугацааны эхний өдөрт шилжих шөнийн 00 цагийг; 2020 оны 1 дүгээр сарын 08-наас 09-нд шилжих шөнийн "00" /тэг тэг/ цаг;
3	Тоолох үе	2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 08 цагаас 1 дүгээр сарын 15-ны өдрийн 22 цаг хүртэлх хугацаа;
4	Тооллогын нэгж	Хувь хүн, түүний амьдарч байгаа байр, орон сууц;
ӨРХ, ХҮН АМ		
5	Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.
6	Үндсэн өрх	Сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг (ордер), орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.
7	Хамт суудаг өрх	Тухайн өрхийн өөрийн сууц биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хамруулна.
8	Өрхийн тэргүүлэгч	Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16, түүнээс дээш настай, хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
9	Өрхийн ам бүлийн гишүүд	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Тоолох үед тухайн өрхөд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно.
10	Ам бүлээрээ байгаа өрх	Ам бүлээрээ байгаа өрх дангаараа амьдрахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эхнэр, нөхөр, хүүхдийн (хүүхдүүдийн) хамт, мөн эцэг эсвэл эх нь хүүхдийн (хүүхдүүдийн) хамт өрх үүсгэн амьдрахыг хэлнэ.
11	Нийлмэл ам бүлтэй өрх	Нийлмэл өрхөд дараах бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд: а. Нэг ам бүл бусад хамаатан садантайгаа хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх б. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгэнтэй нь хамааралтай хүнтэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа зэрэг өрх орно.

№	Ойлголт	Тодорхойлолт
12	Холимог өрх	Холимог өрхөд дараах бүтэцтэй өрх хамаарна. Үүнд: а. Нэг ам бүл бусад хамаатан садан хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх б. Нэг ам бүл, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгнийх нь хамаатан садан, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл эдгээр ам бүлийн алинд ч хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа д. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралгүй ам бүл бусад хүмүүстэй амьдарч байгаа е. Хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хоёр, түүнээс олон хүмүүс бусад хамааралгүй хүмүүстэй өрх үүсгэн амьдарч байгаа ё. Хоорондоо хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа өрх орно.
13	Оршин суугаа хүн ам	Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар) оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд, гадаадын харьяат болон харьяалалгүй иргэдийг хэлнэ.
14	Бэлэн хүн ам	Тооллого явуулж буй үед тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа нийт хүн амыг (байнга болон түр хугацаагаар амьдарч байгаагаас үл хамаарч) хэлнэ.
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ		
15	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг ойлгоно.
16	Төрөлхийн	Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
17	Олдмол	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
18	Харааны	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "харах" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
19	Ярианы	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний "ярих" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
20	Сонсголын	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "сонсох" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
21	Хөдөлгөөний	Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
22	Сэтгэцийн	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан.
23	Хавсарсан	Хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд тооцно.
24	Бусад	Дээрхээс бусад ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан буюу хязгаарлагдсан.
ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛ, ТҮҮНИЙ ХЭЛБЭР		
25	Хүндрэлгүй	Аливаа үйлдэл хийхдээ ямар ч асуудалгүй, мэдрэхүйн эрхтнүүдэд ямар ч хүндрэл тулгардаггүй;
26	Бага зэрэг хүндрэлтэй	Аливаа үйлдэл хийхдээ бусдын дэмжлэг эсвэл туслах хэрэгсэл хэрэглэж өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдог;

№	Ойлголт	Тодорхойлолт
27	Их хүндрэлтэй	Аливаа үйлдлийг хийх процессын 60-90 хувьд нь туслах хэрэгслийн болон бусдын тусламжийг авдаг. (алхаж явахдаа байнга хэн нэгнийг түшиж, тулж явдаг, аливаа зүйлийг ойлгохдоо бусдаар нэмэлт тайлбар хийлгэдэг, ахуйн энгийн үйлдлүүдийг бусдын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлдэг)
28	Огт чаддаггүй	Аливаа үйлдлийг хийхэд эрүүл мэндийн асуудал нь тухайн хүний үйлдлийн чадварт 100% сөргөөр нөлөөлж ямар ч үйлдлийг өөрөө бие даан хийх боломжгүй.
29	Харааны хүндрэл	Харааны бэрхшээлтэй буюу харааны шил эсвэл контакт линз зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд харахад хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой юм. Тухайн хүн харааны шил зүүдэг тохиолдолд Та харааны шил зүүсэнч юм харахад хүндрэлтэй байдаг уу? гэж асуух байдлаар оруулсан.
30	Сонсголын хүндрэл	Сонсголын бэрхшээлтэй, сонсголын аппарат зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд сонсоход хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. Сонсголын хүндрэлд чимээ ихтэй орчин эсвэл нам гүм орчинд янз бүрийн дуу чимээг ялгаж сонсоход нэг эсвэл 2 чихээрээ сонсоход хүндрэл тулгарч байгааг ойлгоно. Тухайн хүн сонсголын аппарат зүүдэг бол Та сонсголын аппарат зүүсэн ч юм сонсоход хүндрэлтэй байдаг уу? гэж асуух байдлаар оруулсан.
31	Алхах болон шатаар өгсөх/ дээшээ авирах хүндрэл	Алхахдаа ямар нэгэн хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. Ямар нэгэн дэмжлэг болох төхөөрөмж (тэргэнцэр, таяг, алхуулагч гэх мэт) эсвэл хэн нэгний туслалцаагүйгээр алхаж чадаж байвал алхаж чаддаг гэж үзнэ. Алхахад хүндрэлтэй гэдэгт алхсанаас эсвэл шатаар дээш, доош алхсанаас шалтгаалж бие сулрах, тэнцвэр алдах, эсвэл бусад тулгуур эрхтэн тогтолцооны бус хүндрэл тохиолдож байгааг оруулна.
32	Аливаа зүйлийг санах, анхаарлаа төвлөрүүлэх хүндрэл	Эргэн санах гэж нь өнгөрсөн үйл явдлыг эргэж санахыг ойлгоно. Зам харгуй олох, аливаа асуудалд анхаарлаа хандуулж чадахгүй байх, хаана байгаагаа эсвэл он сараа мартах зэргийг бэрхшээлтэй гэж үзнэ. Мөн хэн нэгний хэлсэн ярьсныг санахгүй байх, будилах, ихэнх зүйлсээс айх зэргийг хүндрэлтэйд тооцно. Ажлын ачаалал, стресс бухимдал, эмийн нөлөөний улмаас үүссэн санах, анхаарлаа төвлөрүүлэхтэй холбоотой хүндрэлийг хүндрэлтэй гэж үзээгүй.
33	Бие даан усанд орох, хувцсаа өмсөх зэргээр өөрийгөө арчлах хүндрэл	Энэ асуулт нь бие даан өөрийгөө халамжлах, анхаарахад хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой.
34	Бусадтай ярилцах хүндрэл	Энэ хэсэг нь ярих, сонсох, бусдыг ойлгох, бусдад өөрийгөө ойлгуулахад ямар нэг хүндрэлтэй байдаг хүмүүсийг илрүүлэх зорилготой. Мэдээлэл солилцохдоо дохио зангаа хэрэглэдэг (дохионы хэл орно), бичгээр эсвэл дуу авиа ашигладаг бол харилцааны бэрхшээлтэй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, бусдад өөрийгөө ойлгуулахдаа эсвэл бусдын яриаг ойлгохдоо харилцааны өөр арга хэрэглэж байгаа тохиолдлыг ойлгоно.
СУУРЬШИЛ		
35	Байнга оршин суугаа	Тооллогын товын байдлаар тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин суугаа хүн
36	Түр эзгүй байгаа	Тооллогын товоос өмнө үндсэн засаг захиргааны нэгжээс гадагш 6 сар (183 хоног) хүрэхгүй хугацаагаар явсан хүн
37	Түр оршин суугаа	Өөр засаг захиргааны нэгжээс ирж, тооллогын товын өмнө тухайн засаг захиргааны нэгжид 6 сар (183 хоног)-аас доош хугацаагаар сууж байгаа хүн
БОЛОВСРОЛ		
38	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгсөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2020 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.
39	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн

№	Ойлголт	Тодорхойлолт
40	Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг 1975 он хүртэл, 8 дугаар ангийг 1975-2004 онуудад, 9 дүгээр ангийг 2005 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн
41	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг 2005 он хүртэл, 11 дүгээр ангийг 2006-2014 онуудад, 12 дугаар ангийг 2015 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн
42	Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
43	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
44	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизм оройн дээд сургууль Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.
45	Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг Бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
46	Бичиг үсэг мэддэггүй	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг Бичиг үсэг мэддэггүй гэнэ.
ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ		
47	Огт гэрлээгүй	Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн
48	Гэрлэсэн батлуулаагүй	Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн
49	Гэрлэсэн батлуулсан	Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
50	Тусгаарласан	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Тусгаарласан гэж үзнэ. Гэхдээ албан ажлын улмаас 2 тусдаа амьдарч байгаа хүнийг тусгаарласан гэж үзэхгүй.
51	Цуцалсан	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Цуцалсан гэж үзнэ.
52	Бэлэвсэн	Эхнэр/нөхрийн аль нэг нь нас барснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр Бэлэвсэн гэж үзнэ.
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ		
53	Ажил эрхэлдэг хүн	Сүүлийн 7 хоногт наад зах нь 1 цаг цалин хөлстэй хөдөлмөр эрхэлсэн болон ер нь цалинтай ажил/бизнесийн үйл ажиллагаа байгаа хүн ам;
54	Ажилгүй хүн	Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

№	Ойлголт	Тодорхойлолт
55	Боломжит ажиллах хүч	Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд: а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн; б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.
56	Хөдөлмөрийн насны хүн ам	15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.
57	Ажиллах хүч	Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.
58	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно.
59	Цалин хөлстэй байнгын ажиллагч	Ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллаж байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч орно.
60	Цалин хөлстэй түр ажиллагч	Хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3, түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.
61	Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	Ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм
62	Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан	Цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй ажиллагч юм.
63	Гүйцэтгэх гэрээлэгч	Эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагч нь тухайн эдийн засгийн нэгжийн цалин хөлстэй ажиллагч биш боловч ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, орлого болон зах зээлд гарах боломж зэрэг нь уг эдийн засгийн нэгжээс хамаардаг. Мөн эдгээр ажиллагч нь тэдний үйлдвэрлэлийн (бүтээмжтэй) үйл ажиллагаанд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлынх нь үр шимийг шууд хүртдэг эдийн засгийн өөр нэгжээс хараат, ашгийн төлөө ажиллагч юм.
64	Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	Ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

№	Ойлголт	Тодорхойлолт
65	Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	Ашиг олох зорилгоор аж ахуй нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуй нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулж байгаа ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.
66	Ажилтан ажиллуулдаггүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажилчид юм.
67	Ажилтан ажиллуулдаггүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	Ямар нэгэн цалин хөлстэй ажиллагч авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажилчид юм.
68	Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	Өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ БА ТОДОРХОЙЛОЛТ

69	Менежер	Менежер нь Засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотоод нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, үнэлэх, бодлого, журам боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтанг хамруулна. Тухайлбал, төрийн болон хувийн аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын бүх төвшний дарга, захирал, хууль тогтоогч, төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, бүх төвшний засаг дарга, захирагч, ТББ-ын удирдах албан тушаалтан, менежер гэх мэт.
70	Мэргэжилтэн	Мэргэжтэн нь мэдлэгийнхээ санг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, урлагийн онол, үзэл баримтлалыг ашиглах, тэдгээрийг системтэйгээр заах сургах буюу мэргэжлийн өндөр төвшин шаардсан ажил гүйцэтгэгч байна. Тухайлбал, шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн, эмч, сувилагч, багш, судлаач, бизнесийн болон захиргааны мэргэжилтэн, программ зохиогч, шашны мэргэжилтэн, уран бүтээлч, дуучин, жүжигчин гэх мэт.
71	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн нь шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр хийх судалгаа, практикт хэрэгжүүлэхэд холбогдох техник шинжтэй ажил гүйцэтгэнэ. Тэд уул уурхай, аж үйлдвэр, барилга болон бусад салбарын инженерийн үйл ажиллагаатай холбоотой техникийн болон үйлдлийн арга ажиллагааг хянах, удирдах, тоног төхөөрөмж ажиллуулна. Физик, инженерийн ухааны техникч, уурхай, үйлдвэр болон барилга угсралтын байцаагч, технологи процесс, чанар шалгагч, амьд ертөнц судлах ухааны техникч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн, усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч гэх мэт.
72	Контор, үйлчилгээний ажилтан	Тодорхой асуудалд хамаарах мэдээллийг тэмдэглэх, эмхлэх, хадгалах, тооцоолон бодох, сэргээн засварлах ба мөнгөний гүйлгээ хийх, аялал жуулчлал зохион байгуулах, мэдээлэл авах, хүсэлт тавих, уулзалт товлох зэрэг туслах шинжтэй олон төрлийн үүргийг гүйцэтгэнэ. Компьютерийн операторч, үйлчилгээний туслах ажилтан, тооцоолол, материал, тоо бүртгэлийн ажилтан, конторын бусад туслах ажилтан гэх мэт.

№	Ойлголт	Тодорхойлолт
73	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Үйлчилгээ, худалдааны ажилтан нь аялал жуулчлал, гэр ахуйн ажил эрхлэх, нийтийн хоолоор үйлчлэх, хувь хүн асрах юмуу хууль бус үйлдэл, гал түймрээс сэргийлэх, хамгаалах эсвэл бөөний ба жижиглэн худалдаа, бусад төстэй байгууллагад, тэрчлэн зах, мухлагаар бараа таваар дэлгэн үзүүлэх, худалдаж борлуулахад холбогдсон хувийн болон хамгаалалтын шинжтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Хувийн үйлчилгээний ажилтан, худалдааны ажилтан, хувь хүн асрах ажилтан, хамгаалах үйлчилгээний ажилтан гэх мэт.
74	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан нь үр тариа, мод, бут, малын тэжээл ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, ан амьтан үржүүлэх, харж хамгаалах, агнах, төрөл бүрийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, гэр бүлийнхээ хоол хүнсэнд зориулан загас үржүүлэх буюу барих, усны бусад төрөл зүйлийг өсгөж, үржүүлнэ. Зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан, зах зээлийн баримжаатай ой, загас агнуурын аж ахуйн мэргэшсэн ажилтан, өрхийн хэрэгцээний шинжтэй фермэрч, загасчин, анчин болон түүн цуглуулагч гэх мэт.
75	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан нь барилга барих, арчлах, металл хэлбэр оруулах, металл бүтээцийг босгох, автомат багаж хэрэгслийг тохируулах, машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хийх, тааруулах, засварлах, хэвлэх ажлын бүтээгдэхүүн гаргах, хүнсний зүйл, нэхмэл эдлэл, модон, металл, бусад эд бараа, түүний дотор гар урлалын зүйл үйлдвэрлэх салбарт мэдлэг, ур чадвараа хэрэглэнэ. Металл, машин, механизм, түүнтэй холбогдох бусад мэргэжлийн ажилтан, гар урлал, хэвлэлийн ажилтан, цахилгаан болон цахим техникч, хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч гэх мэт.
76	Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	Хөдөө аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийг биечлэн жолоодох эсвэл зайнаас буюу алсын удирдлагаар удирдаж ажиллуулах, хянах, галт тэрэг, хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт машин, механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, ажиллуулах, эд анги, хэсгүүдээс бүрдсэн бүтээгдэхүүнийг заавар, журам, стандарт, шаардлагын дагуу угсрах ажил эрхэлнэ. Төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч, жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч гэх мэт.
77	Энгийн ажил, мэргэжил	Энгийн ажил эрхлэгч нь өдөр тутмын, байнга давтагдах шинжтэй энгийн ажил, үүргийг гар багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэх бөгөөд голчлон биеийн хүчний ажил эрхэлнэ. Цэвэрлэгч, туслагч, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил, уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил, хүнс бэлтгэлийн туслах ажил, гудамжин дахь худалдаа, үйлчилгээний ажил, бусад энгийн ажил гэх мэт.
78	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	Зэвсэгт хүчний офицерийн цол бүхий Монгол Улсын Зэвсэгт хүчний зохих албан тушаалд цэргийн алба хаахыг офицерийн алба гэнэ. Зэвсэгт хүчний офицер нь төрөл бүрийн энгийн ажил, мэргэжилд байдаг ижил төстэй үүрэг гүйцэтгэж болно. Энэ бүлэгт Зэвсэгт хүчинд алба хааж байгаа дунд офицер, ахлах офицер, дээд офицерийн нийт бие бүрэлдэхүүн багтана.
ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛЛЫН ТОДОРХОЙЛОЛТ		
79	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Тухайн салбарт мал, амьтны болон ургамлын байгалийн нөөц ашиглалт хамаарна. Энэ салбарт хөдөө аж ахуйн ургамал ургуулах, мал, амьтан, үүний дотор үржлийн мал, амьтныг өсгөн үржүүлэх үйл ажиллагаа, мод бэлтгэл, фермд ч, байгаль орчинд ч бусад ургамал, мал, амьтан буюу мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний бэлтгэл орно.
80	Уул уурхай, олборлолт	Байгалийн хатуу (нүүрс, хүдэр), шингэн (нефть) эсвэл хий (байгалийн хий) зэрэг эрдэс баялгийг олборлох уул уурхайн үйл ажиллагаа багтана. Олборлох үйл ажиллагаа нь далд эсвэл ил уурхай, далайн ёроолын уурхай гэх мэт уурхайгаас төрөл бүрийн аргаар гаргаж авах үйл ажиллагаа байж болно.
81	Боловсруулах үйлдвэрлэл	Боловсруулах үйлдвэрлэл нь түүхий эд, материалыг физик болон химийн аргаар хувиргаж шинэ бүтээгдэхүүн үүсгэх үйл ажиллагаа юм. Боловсруулах үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүн нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, уул уурхай, олборлолтын бүтээгдэхүүнүүд орно. Мөн бусад боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох түүхий эд материал, бодис эсвэл бүтээгдэхүүнийг хувиргахад орох түүхий эд байна. Барааг шинэчлэх, сэргээн босгох, өөрчлөх үйл ажиллагаа нь ихэвчлэн боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа байна.

№	Ойлголт	Тодорхойлолт
82	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Энэ салбарт дэд бүтцийн /сүлжээ/ шугам хоолойгоор дамжуулан цахилгаан эрчим хүч, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах үйл ажиллагаа хамрагдана. Түүнчлэн нэгдсэн сүлжээгүй орон нутгийн чанартай барилга байгууламжийн бие даасан эх үүсвэр бүхий цахилгаан, хий, уур, халуун, хүйтэн усаар хангах, түгээх ажиллагаа мөн багтана.
83	Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	Энэ салбарт өрхийн болон үйлдвэрийн хатуу эсвэл хатуу бус, бохирдсон талбай зэргийн хог, хаягдлыг цуглуулах, ариутгах, боловсруулахтай холбогдох үйл ажиллагаа багтана. Ус хангамжийн үйл ажиллагаа бүгд энэ салбарт орно. Өрх, үйлдвэрлэл, үйлчилгээний усан хангамжийн үйл ажиллагаа ихэнхдээ бохир усыг цэвэрлэх, боловсруулах үйл ажиллагаатай холбоотой байх бөгөөд аж ахуйн нэгжүүд эдгээр үйл ажиллагааг хамтруулан хийдэг байж болно. Хог хаягдлыг боловсруулах, бохир усыг цэвэршүүлэх үйл ажиллагааны үр дүнд ариутгасан эсвэл, цэвэршүүлсэн шинэ бүтээгдэхүүн бий болгох үйл ажиллагаа байж болно.
84	Барилга	Мэргэжлийн гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, инженерийн барилга байгууламжийн угсралтын ажил орно. Энд шинэ барилгын угсралтын ажил, өргөтгөл, шинэчлэлтийн ажил, барилгын засварын үйл ажиллагаа орно. Их барилгад орон сууц, контор, худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуйн барилга, авто зам, гудамж, талбай, гүүр, туннел, төмөр зам нисэх талбай, боомт зогсоол болон цахилгаан, дулаан, усан хангамжийн сүлжээ, дамжуулах хоолой, услалтын систем, үйлдвэрийн байгууламж болон биеийн тамирын талбайн ажил зэрэг иргэний инженерийн барилга байгууламжийн угсралтын ажил орно.
85	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	Бүх төрлийн бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, тухайлбал, хувирган өөрчлөхгүй худалдаалах, барааг худалдан авах явцад гарах үйлчилгээ орно.
86	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	Хий дамжуулах хоолой, төмөр зам, авто зам, усан ба агаарын тээврийн тогтсон хуваарьтай, хуваарьгүй ачаа болон зорчигч тээвэр, агуулах, ачаа, тээшний үйлчилгээ, автомашины зогсоол, гарааш зэрэг үйл ажиллагаа орно. Түүнчлэн тээврийн хэрэгслийг ажиллуулагч хүнтэй нь түрээслэх үйл ажиллагаа энэ салбарт багтана. Мөн шуудан, холбооны үйл ажиллагаа орно.
87	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	Жуулчид, бусад аялагчдыг богино хугацаагаар байр сууцаар хангах, шууд хэрэглэх зориулалттай хоол хүнс, ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа орно. Энэ салбарт хамаарах нэмэлт үйлчилгээний хэмжээ, төрөл нь нэлээд өргөн хүрээтэй байж болно.
88	Мэдээлэл, холбоо	Энэ салбарт мэдээлэл, соёлын бүтээгдэхүүний үйлчилгээ, энэ төрлийн бүтээгдэхүүнийг дамжуулах, тараах үйл ажиллагаа, тухайлбал, холбоо, мэдээллийн технологийн үйл ажиллагаа, мэдээлэл боловсруулах болон мэдээллийн үйлчилгээтэй холбогдох бусад үйл ажиллагаа орно.
89	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагаа, даатгал, давхар даатгал, тэтгэврийн санхүүжилтийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйлчилгээг дэмжих үйл ажиллагаа энэ салбарт орно. Холдинг компанийн үйл ажиллагаа, итгэлцлийн үйл ажиллагаа, сангууд болон бусад ижил төстэй санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа зэрэг хөрөнгө эзэмших үйл ажиллагаа мөн энэ салбарт багтана.
90	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Энд лизингийн үйлчилгээ үзүүлэгч, агент, брокерын үл хөдлөх хөрөнгө худалдах, үл хөдлөх хөрөнгө түрээслэх, үнэлгээ хийх зэрэг үйлчилгээ орно. Энэ салбарын үйл ажиллагаа нь төлбөр болон гэрээнд үндэслэн хийгддэг бөгөөд эзэмшигчийн эсвэл лизингээр авсан өмчийг ашиглах үйл ажиллагаа байж болно. Мөн эзэмшигчийн эсвэл лизингээр баригдаж байгаа барилга, байгууламжийг оруулна. Энэ салбарт үл хөдлөх хөрөнгөтэй холбогдох бүхий л үйл ажиллагаа багтана.
91	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Энэ салбарт мэргэшсэн мэргэжил, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа багтана. Эдгээр үйл ажиллагаа нь ахисан түвшний сургалт, мэргэшсэн мэдлэг олгох, хэрэглэгчдэд ур чадвар бий болгох зэрэг сургалтууд орно.
92	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Бизнесийн үндсэн үйл ажиллагааг дэмжих төрөл бүрийн үйл ажиллагааг энд хамруулна. Эдгээр үйл ажиллагааны анхдагч зорилго нь мэргэшсэн мэдлэгийг олгохгүй.

№	Ойлголт	Тодорхойлолт
93	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Энэ салбарт төрийн удирдлагын үйл ажиллагаа орно. Үүнд хуулийн тайлбар, тогтоол, тэдгээрт зохицуулалт, тэдгээр дээр суурилсан үйл ажиллагааны удирдлага, хууль тогтоох үйл ажиллагаа, татвар, улсын батлан хамгаалах, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаа, цагаачлалын үйлчилгээ, гадаад харилцааны үйл ажиллагаа Засгийн газрын хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа зэрэг орно. Мөн энэ салбарт албан журмын нийгмийн хамгааллын үйл ажиллагаа багтана.
94	Боловсрол	Энэ салбарт албан сургалтын өдөр, орой, эчнээ, экстернат хэлбэрээр болон албан бус боловсрол (бие даан суралцах, зайн, радио, телевизийн, онлайн, дүйцсэн, сургалт, хөтөлбөр гэх мэт)-оор дамжуулан хүүхэд, насанд хүрэгчдэд боловсрол эзэмшүүлэх, мэргэшлээ дээшлүүлэх сургалтын үйл ажиллагаа орно. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй өмчийн бүх хэлбэрийн байгууллагууд хамрагдана.
95	Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	Энэ салбарт хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа орно. Тухайлбал хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлэг, эмнэлгийн мэргэжилтнүүд, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг нийгмийн ажилтны бусад үйл ажиллагаа хамаарна.
96	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Энэ салбарт өргөн хүрээг хамарсан төрөл бүрийн соёлын уулзалт, үзвэр болон олон нийтийг хамарсан сонирхолтой тоглоом наадам, урлагийн тоглолт, музейн үйлчилгээ, мөрийтэй тоглоом, чөлөөт цагийн үйл ажиллагааг хамруулна.
97	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Энэ салбарт гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа, компьютер, өрхийн болон хувийн хэрэглээний барааны засвар, үйлчилгээ, өмнөх бүлэг, ангид ороогүй хувийн хэрэглээний төрөл бүрийн бусад үйлчилгээ орно.
98	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаанд гэрийн үйлчлэгч, тогооч, зөөгч, цэвэрлэгч, барлаг, шивэгчин, угаагч, цэцэрлэгч, манаач, малчин, ногоочин, байнгын харгалзагч, жолооч, хаалгач, гэрийн хүмүүжүүлэгч, хүүхэд асрагч, гэрийн багш, нарийн бичиг зэрэг ажил, үйлчилгээг айл, өрхөд цалин хөлстэйгөөр хийх үйл ажиллагаа орно. Өрхийн өөрийн хэрэглээнд зориулсан хэмжээ, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ энэ дэд салбарт орно.
